

МОНГОЛЫН ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИЛТГЭЛ 2007

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ЯДУУРАЛ



Монгол Улсын
Засгийн газар



Mongolia



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



Шведийн Олон Улсын
Хөгжлийн Агентлаг

Монгол Улсад хэвлэв.

Энэхүү илтгэл нь Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр,
Монгол Улсын Засгийн газрын байр суурийг илэрхийлээгүй болно.
Илтгэлийг ашгийн бус зорилгоор олшруулан хуулбарлаж, тараахыг зөвшөөрнө.

Copyright © 2007 он

ISBN 978-99929-1-248-0

Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
Нэгдсэн үндэстний байгууллагын байр
Нэгдсэн үндэстний гудамж 12
Ш/Х 49/207
Улаанбаатар - 46, Монгол Улс

Электрон шуудан: registry.mn@undp.org
Интернетийн хаяг: <http://www.un-mongolia.mn/undp>

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АНУОУХА	АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг
АТОАТС	Амьжиргааны түвшинг оролцооны аргаар тодорхойлох судалгаа
АХБ	Азийн хөгжлийн банк
БНЛАУ	Бүгд Найрамдах Лаос Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Словек Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНЧУ	Бүгд Найрамдах Чех Улс
БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
БСТ	Бодлого судлалын төв
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ГТТХАА	Германы техник туслалцаа, хамтын ажиллагааны агентлаг
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ДБ	Дэлхийн банк
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
ЖХИ	Жендэрийн хөгжлийн индекс
ЖЭМХ	Жендэрийн эрх мэдлийн хэмжүүр
МАОЭХ	Монголын ажил олгогч эздийн холбоо
МУИС	Монгол Улсын Их сургууль
МУХАУТ	Монголын үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим
МҮЭХ	Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо
МХЗ	Мянганы хөгжлийн зорилтууд
МХХИ	Монголын хүний хөгжлийн илтгэл
МСС	Мянганы сорилын сан
МССЗҮТ	Мэргэжлийн сургалт, сэргээн заслын үндэсний төв
МЭТБҮС	Монголын эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын үндэсний сүлжээ
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮББШУСБ	Нэгдсэн үндэстний байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага
НҮБХАС	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сан
НҮБХС	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сан
НҮБХХ	Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
НҮБЭХС	Нэгдсэн үндэстний байгууллагын Эмэгтэйчүүдийн хөгжлийн сан
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ӨОЗАТС	Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний судалгаа
САШС	Сургуулиас ажилд шилжигсдийн судалгаа
СЯ	Сангийн яам
ТББ	Төрийн бус байгууллага
ТМС	Техник, мэргэжлийн сургууль
ТХЖ	Тэгшитгэсэн хувийн жин
УА	Удирдлагын академи
УИХ	Улсын Их Хурал
УНДЕГ	Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар
ҮСГ	Үндэсний статистикийн газар
ҮХЯ	Үйлдвэр худалдааны яам
ХАССТ	Хүн амын сургалт, судалгааны төв
ХҮИ	Хэрэглээний үнийн индекс
ХХИ	Хүний хөгжлийн индекс
ХХҮИ	Хүний хөгжлийн үндэсний илтгэл
ХХУОУХ	Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр
ХЭХТ	Хүний эрх хөгжил төв
ХЯИ	Хүний ядуурлын индекс
ШОУХА	Шведийн Олон улсын хөгжлийн агентлаг
ЭЗС	Эдийн засгийн сургууль
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
РРР	Худалдан авах чадварын паритет

Эх бичигчид

Док.Ши.Батбаяр, Нийгмийн хамгаалал, мэргэжлийн зөвлөл нийгэмлэгийн тэргүүн

Док.Н.Батнасан, МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга

Док.Я.Долгоржав, Удирдлагын академийн багш, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх

Док.Ч.Хашчулуун, МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн захирал

Док.Л.Мягмаржав, “MCS-Кока Кола” ХХК-ийн гүйцэтгэх захирал

Док.проф.Н.Содномдорж, Олон улс судлалын дээд сургуулийн тэнхимийн эрхлэгч

Редакторууд

Док.Н.Батнасан, МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга

Ноён Билл Бикалис, БНХАУ, Монгол Улс дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн ахлах эдийн засагч

Хатагтай Элизабет Моррис, ОУХБ-ын Зүүн Азийн дэд бүсийн Хөдөлмөрийн зах зээл, хүний нөөцийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн

Зөвлөх

Док.Сиддикүр Р.Османи, Их Британий Нэгдсэн Вант Улсын Уолстерын Их сургуулийн Эдийн засаг, улс төрийн их сургуулийн Хөгжлийн эдийн засгийн профессор

Хянан тохиолдуулсан

Док.Я.Долгоржав, Удирдлагын академийн багш, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх (монгол хэлнээ)

Док.Г.Чулуунбаатар, Шинжлэх ухааны академийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн захирал (монгол хэлнээ)

Кэй Кирбай Доржи, Чөлөөт редактор/сэтгүүлч, АНУ/Бутан (англи хэлнээ)

Зохицуулах баг

Док.Б.Бат, Док.Д.Чимгээ, Б.Лхагва-сүрэн, Д.Нямаа, Б.Эрдэнэсүвд, Б.Ганзориг (МУИС-ийн Эдийн засгийн сургууль)

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам

С.Чинзориг, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжих баг

Шоко Нода, Орлогч суурин төлөөлөгч
Д.Нэргүй, Шадар суурин төлөөлөгч
Ж.Должинсүрэн, Эдийн засагч
Г.Уянга, Эдийн засагч асан
Л.Мөнхжаргал, Хөтөлбөрийн ажилтан

Олон улсын хөдөлмөрийн байгууллага

Бээжин, Бангкок дахь ОУХБ-ын алба

Бэлтгэх баг

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НХХЯ-ны “Ядуурлын судалгаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төсөл: Ц.Эрдэнэчимэг Төслийн үндэсний менежер, П.Болормаа, Төслийн үндэсний менежер асан, П.Цэцгээ, Хүний хөгжлийн үндэсний илтгэлийн зохицуулагч, Э.Солонго, Санхүү, захиргааны туслах ажилтан

Орчуулагчид

Р.Баасан, Б.Баяр, Б.Заяа, Б.Тунгалаг, О.Энхтуяа

Гэрэл зурагчид

Д.Түвшинбаяр, Л.Элбэгзаяа

Хэвлэлийн эх бэлтгэсэн

“Мөнхийн үсэг” ХХК, дизайнер Э.Жимсээ

Монгол Улсын хүний хөгжлийн 2007 оны илтгэлийг олон тооны хувь хүн, байгууллагуудын өгөөмөр тусламж, дэмжлэггүйгээр бэлтгэх боломжгүй байсан юм. Энэхүү илтгэлийг бэлтгэх явцад үнэлж баршгүй санал, нөр их хөдөлмөрөө зориулсан үндэсний зөвлөлдөх хорооны гишүүд, 2005-2007 онд зохион байгуулсан олон удаагийн зөвлөлдөх уулзалтад оролцогчид, илтгэл бичихэд хувь нэмрээ оруулсан бүх хүмүүст ажлын багийнхан гүн талархлаа дэвшүүлж байна.

Үндэсний зөвлөлдөх хороо

Үндэсний зөвлөлдөх хороо нь шинжээчид, олон салбарын төлөөллөөс бүрдсэн бөгөөд илтгэлийг бэлтгэх явцад зөвлөгөө өгөх, удирдан чиглүүлэх зорилгоор байгуулагдсан юм. Үндэсний зөвлөлдөх хорооны гишүүд: Ч.Дагвадорж (дарга), Р.Амаржаргал, Улсын Их Хурлын гишүүн; Х.Ганбаатар, Монголын ажил олгогч эздийн холбоо, Г.Гэрэлт-Од, Үндэсний статистикийн газар; Я.Долгоржав, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх; Ш.Мөнгөнбат, Үйлдвэр худалдааны яам; Шинжлэх ухааны док. Н.Содномдорж, Олон улс судлалын дээд сургуулийн тэнхмийн эрхлэгч; Т.Ундарьяа, МонФемНет, Монголын эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын үндэсний сүлжээ; Г.Уранцоож, Хүний эрх хөгжил төв; М.Чимэддорж, Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо; Н.Энхбаяр, Ерөнхий сайдын зөвлөх; Т.Энхтуяа, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам; Монгол Улс дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Орлогч суурин төлөөлөгч.

Зөвлөлдөх уулзалтууд

Илтгэлийг бэлтгэх явцад зохион байгуулсан зөвлөлдөх уулзалтуудад олон хүн идэвхтэй оролцсон бөгөөд үнэтэй зөвлөгөө, санал өгч мэдээлэл, материалаар хангаж байсан билээ.

2005-2007 онд болсон цуврал зөвлөлдөх уулзалтад оролцогчид: Ц.Адъяасүрэн, А.Бакей, О.Байгалмаа, Г.Батхүрэл, Б.Баясгалан, П.Бямбацэрэн, Д.Бямбацогт, Ж.Бямбацогт, Т.Гантөмөр, А.Дэмбэрэл, С.Дэмбэрэл, Д.Жанцан, Ж.Жаргалсайхан, Б.Зоригт, Д.Зоригт, С.Зүльфикар, Н.Монголмаа, Т.Навч, Д.Намсрай, Н.Наранчимэг, Д.Нармандах, Ц.Нацагдолгор, Р.Ойдовданзан, Н.Оюундарь, Д.Оюунчимэг, Г.Пагма, М.Сарантуяа, Т.Саруул, А.Солонго, Б.Соёлтуяа, Б.Сувд, Б.Сүрэнчимэг, Д.Сэнгэлмаа, У.Тунгалаг, Ю.Туул, Т.Ундарьяа, И.Ханимхан, Д.Хоролсүрэн, Б.Хулдорж, Х.Цэвэлмаа, Г.Чулуунбаатар, Ч.Ундрах, Б.Уранчимэг, Б.Шинэтөгс, О.Энх-Ариунаа, Б.Энхцэцэг, Б.Эрдэнэбаатар.

Мэдээлэл, судалгааны материалаар хангасан байгууллагууд: Үндэсний статистикийн газар, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар, Монголын ажил олгогч эздийн холбоо, Олон улсын хөдөлмөрийн байгууллага.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны хамт олны нягт хамтын ажиллагаанд талархлаа илэрхийлье. Монгол улс дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн газар, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын багт илтгэлийг бэлтгэх явцад байнгын дэмжлэг туслалцаа үзүүлсэнд онцгойлон талархал дэвшүүлж байна. Шведийн олон улсын хөгжлийн агентлагт санхүүгийн дэмжлэг үзүүлсэнд гүн талархалаа илэрхийлж байна.

Ажлын баг

Монгол улс 1997 оноос эхлэн үндэсний Хүний хөгжлийн илтгэлээ НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр боловсруулан гаргаж эхэлсэн бөгөөд эдүгээ дөрөв дэх илтгэлээ “Хөдөлмөр эрхлэлт, ядуурал” сэдэвтэйгээр толилуулж байна.

Энэ илтгэлийн онцлог нь хөдөлмөр эрхлэлтийг улам нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахад Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн үр шимийг чиглүүлэх арга замын талаар дүн шинэжилгээ хийсэнд оршиж байгаа юм.

Дэлхий дахинаа, ялангуяа дэлхийн ажиллах хүчний 60 хувь нь оршин амьдардаг Ази тивийн хувьд хөдөлмөр эрхлэлтээр дамжуулан ядуурлыг бууруулж чадсан стратеги өнөөдөр үр дүнтэйд тооцогдож байна. Улс орны хувьд хамгийн үнэт баялаг болох хүний нөөцөө үр дүнтэй ашиглах, ядуу хүмүүсийн хувьд өөртөө байгаа цорын ганц давуу тал болох ажиллах хүчээ ашиглан орлогоо нэмэгдүүлэх, улмаар эх орныхоо хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулах боломжийг олгодог онцгой шинжээрээ хөдөлмөр эрхлэлтийн зохистой бодлого нь улс орны эдийн засаг, нийгмийг эрчимтэй хөгжүүлэх чухал хөшүүрэг болдог жамтай юм.

Мэдээж хүмүүсийн амьжиргааг дээшлүүлэхэд эдийн засгийн өсөлт хэрхэн яаж нөлөөлж байгаа нь хүний хөгжлийн үзэл баримтлалын тулгуур асуудлын нэг мөн билээ. Иймд улс орны эдийн засгийн өсөлтийн үр дүнд бий болсон баялгийг айл өрх, иргэн бүрт шударгаар хуваарилахад тавих шаардлага өндөрсөх учиртай.

Энэ асуудлыг шийдвэрлэх хамгийн оновчтой гарц болох хүн бүр зохистой, бүтээмж өндөртэй хөдөлмөр эрхлэхийн ач холбогдлыг толилуулж буй энэ илтгэлээс ухааран ойлгож болно. Хүний хөгжилд хөрөнгө оруулалт хийж, хүний нөөцийн зөв зохистой бодлогыг хэрэгжүүлэх, хөдөлмөр дэх жендэрийн ялгааг арилгах, хөдөө орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг түлхүү дэмжих асуудлыг онцгойлон анхаарсны зэрэгцээ хүн амын шилжин суурьших асуудлыг хөдөлмөр эрхлэлт, ядууралтай хэрхэн яаж холбон авч үзэх талаарх саналыг илтгэлд тусгасан байна. Мөн нийгмийн янз бүрийн бүлэг давхарга, тухайлбал залуучууд, хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, малчид, албан бус салбарт ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдалд дүгнэлт хийж, тэдэнд зориулсан ажлын байр бий болгох, ажиллах тааламжтай нөхцөлийг бүрдүүлэх, улмаар ядуурлыг бууруулахад учирч буй элдэв саад бэрхшээлийг арилгах талаар санал, дүгнэлт, зөвлөмж гаргажээ.

Ийнхүү уг илтгэл нь Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилт болон түүнд суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан хүний хөгжлийг бүх талаар хангах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг өсгөн нэмэгдүүлэх, хүн амын ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэсэн бодлого, үйл ажиллагааг төгөлдөржүүлэхэд нэмэр тустай баримт бичиг боллоо гэж үзэж байна.

“Монголын хүний хөгжлийн илтгэл 2007”-г эмхтгэн бичихэд хүчин зүтгэлээ зориулсан гадаад, дотоодын эрдэмтэн, мэргэжилтэн, төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, иргэдэд, түүнчлэн энэхүү ажилд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлсэн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон Олон улсын хөдөлмөрийн байгууллагад Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлье.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
САНЖААГИЙН БАЯР

Монгол улсын Хүний хөгжлийн Үндэсний дөрөв дэх илтгэлийг толилуулж байгаадаа НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага таатай байна. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс Даян дэлхийн хүний хөгжлийн илтгэлийг 1990 оноос эхлэн эрхлэн гаргаж ирсэн бөгөөд уг илтгэл хүний хөгжлийн тухай үзэл баримтлалыг нийтэд түгээн дэлгэрүүлэх ач холбогдол бүхий судалгаа, шинжилгээ, бодлогын арга хэрэгсэл болж ирсэн билээ. 1992 оноос дэлхийн 130 орчим улс орон өөр, өөрийн улс орны өвөрмөц онцлогт тохирсон хүний хөгжлийн үзэл баримтлалыг тусгасан Хүний хөгжлийн үндэсний илтгэлийг (ХХҮИ) гаргаж ирсэн.

Монгол улсын хувьд, 1997 онд бэлтгэн гаргасан Хүний хөгжлийн үндэсний анхны илтгэл шилжилтийн үе дэх хүн амын амьжиргаа, аж байдлын асуудлыг авч үзсэн бол 2000 оны хоёр дахь илтгэлд Монгол улсын төрийн үүрэг, олон түмэн, төр засгаас чухам юуг хүлээж байгаа талаар тусгаж өгсөн юм. Хүний хөгжлийн үндэсний 2003 оны илтгэл нь хот, хөдөөгийн ялгавартай байдалд анхаарлаа төвлөрүүлсэн болно.

Харин энэ удаагийн Хүний хөгжлийн үндэсний дөрөв дэх илтгэл “Хөдөлмөр эрхлэлт, ядуурал” сэдэвтэй бөгөөд энэхүү сэдвийг олон удаагийн зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлгийн дүнд сонгож авсан. Монгол улс эдийн засгийн хөгжлийн шинэ эрин үедээ ирээд байгаа, өөрөөр хэлбэл эдийн засаг өндөр хурдацтай өсч буй хэдий ч орлогын ядуурал хот, хөдөөгийн аль алинд нь өндөр хэвээр, орлогын тэгш бус байдал газар авсан улмаар ядуурлыг бууруулах арга хэмжээ ахиц муутай байгаа өнөө үед энэхүү сэдвийг сонгосон нь туйлын цаг үеэ олсон гэж үзэж байна. Ер нь, 2007 оны Мянганы хөгжлийн зорилтын хэрэгжилтийн хоёр дахь үндэсний илтгэлд дурдсанаар Зорилт 1-ийн дагуу нийт ядуу иргэдийн тоог 50 хувиар бууруулахаар дэвшүүлсэн зорилтод хүрч чадахгүй байх эрсдэл байгаа юм.

Хүний хөгжлийн үзэл баримтлалд зааснаар эдийн засгийн өсөлт нь хөгжлийг хангах зайлшгүй шаардлагатай нөхцөл юм. Гэхдээ эдийн засгийн өсөлт нь шууд ядуурлыг бууруулж, ард түмний амьдралыг сайжруулж чадахгүй. ОУХБ нь Мянганы хөгжлийн нэгдүгээр зорилтыг хангахын тулд “Ажил хийснээр ядуурлаас гарах” аргыг дэмжин сурталчилдаг. Олон улсын туршлагаас харахад эдийн засгийн эрчимтэй өсөлт нь зөвхөн зохистой хөдөлмөрөөр дамжин ядуурлыг бууруулдаг бөгөөд энэ нь бүтээмж өндөртэй ажлын байр шинээр бий болгосноор хэрэгжинэ. Өөрөөр хэлбэл, зохистой хөдөлмөр эрхлэлт нь ядуу хүмүүсийн хувьд өөрийн ганц өмч болох хөдөлмөрлөх хүчээ дээд зэргээр ашиглах боломжийг олгодог.

Иймд ядуу болон анхаарлаас гадна орхигдсон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг эдийн засгийн үйл ажиллагаанд татан оролцуулах, өсөлтийн үр дүнгээс тэгш хүртэх боломжоор ханган ядуурлаас гаргахад хөдөлмөр эрхлэлтийн бодлого, стратегийг чиглүүлэх талаар энэ илтгэл голлон анхаарсан байна. Түүнчлэн, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх гол хүчин зүйлс нь зөвхөн ажлын байр нэмэгдүүлэхээр хязгаарлагдахгүй харин шинээр бий болсон ажлын чанар, байршил, мөн хөдөлмөрийн насны иргэдийн чадавхийг дээшлүүлэх ялангуяа бий болж байгаа ажил эрхлэлтийн боломжийг залуучуудад олгох асуудлыг энэ Илтгэлд онцгойлон авч үзсэн байна.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон ОУХБ энэхүү чухал илтгэлийг сэтгэл гарган бэлтгэсэн эх бичигчид, хянан тохиолдуулагчид болон үндэсний зөвлөлдөх хорооны гишүүдэд талархлаа илэрхийлж байна. Оюуны хувь нэмрээ оруулж үнэтэй зөвлөгөө өгч байсан Их Британий Нэгдсэн Вант Улсын Уолстерын Их сургуулийн профессор доктор С.Р.Османид бид онцгойлон талархлаа илэрхийлэхийг хүсч байна.

Хөдөлмөр эрхлэлт, ядуурлын асуудлыг хөндсөн энэхүү илтгэлд хэд хэдэн чухал зөвлөмж тусгагджээ. Гагцхүү Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газар, ажил олгогчдын байгууллагууд, үйлдвэрчний эвлэлүүд, мөн хөгжлийн бусад түншүүд, төр засгийн бодлогыг боловсруулах, илтгэлд дурдсан зөвлөмжийн хэрэгжилтийг хангахад хүлээсэн үүргээ биелүүлэх явдал туйлын чухал байна. Монгол дахь НҮБ эл зорилгод хүрэх үйлсэд урьдын адил дэмжлэг, туслалцаа үзүүлэхэд бэлэн байна.



Пратиба Мета
НҮБ-ын Суурин зохицуулагч
НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн
Суурин төлөөлөгч



Констанс Томас
Захирал
Бээжин дэх Олон улсын
хөдөлмөрийн байгууллагын алба

Товчилсон үгийн жагсаалт	
Ажлын баг	
Талархал	
Өмнөх үг	
ТОЙМ	13
БҮЛЭГ 1	Монголын хүний хөгжлийн ололт, бэрхшээл 23
1.1	Монголын хүний хөгжлийн шинэ үе 24
1.2	Монголын хүний хөгжлийн өнөөгийн байдал, шинээр үүсч буй хандлага 28
1.2.1	Хүний хөгжлийн индекс (ХХИ) 28
1.2.2	1991 оноос хойшхи ядуурлын хандлага 32
1.2.3	Жендэрийн хөгжлийн үзүүлэлтүүд 34
1.2.4	Хүний хөгжлийн ялгаа: Бүс хоорондын ялгаа, хотын доторх болон хот, хөдөөгийн тэгш бус байдал 35
1.3	Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтууд 37
1.4	Зохистой хөдөлмөр эрхлэлт ба хүний хөгжил 38
1.5	Цаашид хийх алхам: Ядуурлыг хөдөлмөр эрхлэлтээр дамжуулан бууруулах нь 41
БҮЛЭГ 2	Хүний хөгжил, хөдөлмөр эрхлэлт хоёрыг холбогч гүүр нь ажиллах чадвар мөн 43
2.1	Боловсрол ба сургалт 44
2.2	Зан үйлийн асуудал: Хувь хүний араншин ба архидалт 52
БҮЛЭГ 3	Хөдөлмөр эрхлэлт, ядуурлын хоорондын уялдаа холбоо, түүний чиг хандлага, зангилаа асуудлууд 55
3.1	Үндсэн уялдаа холбоо 56
3.1.1	Хөдөлмөр эрхлэлт, ядуурлын хоорондын үндсэн уялдаа холбоог судлах нь 56
3.1.2	Ажилгүйдэл, ядуурал 59
3.1.3	Эдийн засгийн идэвхгүй хүн ам 61
3.2	Хаана, хичнээн, хэдий хэмжээний цалинтай ажлын байр бий болж байна вэ? 64
3.3	Эдийн засгийн гол гол салбар дахь хөдөлмөр эрхлэлт 69
3.4	Эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага 72
3.5	Уул уурхайн салбарт тулгарч буй бэрхшээл – Хэрхэн ядууст хүртээмжтэй өсөлтийг бий болгох вэ? 73
3.6	Орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь: Ядуу малчин айл өрхт хүрч ажиллах нь 76
3.7	Албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан болгох нь 80
БҮЛЭГ 4	Анхаарал зохих ажиллах хүчний өвөрмөц бүлгүүд 89
4.1	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт 90
4.2	Хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүд 96
4.3	Хөдөлмөрийн зах зээл дээр жендэрийн ялгааг багасгах нь 101
4.4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд 103
4.5	Ажиллах хүчний шилжих хөдөлгөөн 106
4.6	Хүүхдийн хөдөлмөр 112
БҮЛЭГ 5	Бодлогын гол гол зөвлөмжүүд, дүгнэлт 119
1	Хөдөлмөр эрхлэлтийн тухай стратегийг Мянганы хөгжлийн зорилтуудад суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын нэг гол бүрэлдэхүүн хэсэг болгох талаар 120
2	Хүний хөгжилд зориулсан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх талаар 120

3	Хөдөлмөрийн зах зээл дэх ур чадварын эрэлт, нийлүүлэлтийн хоорондын зөрүүг арилгах талаар	121
4	Архидалтыг багасгах талаар	122
5	Хөдөлмөрийн зах зээлийн тухай мэдээллийг боловсронгуй болгох талаар	122
6	Эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх замаар ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх талаар	123
7	Уул уурхайн салбарыг түшиглэн хөгжих бусад салбарын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэх талаар	124
8	Хөдөө, орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, сумдын эдийн засгийг сэргээн бэхжүүлэх талаар	124
9	Албан бус салбарыг албан болгох талаар	125
10	Залуучуудад зориулсан зохистой, бүтээмжтэй ажил эрхлэлтийг дэмжих талаар	126
11	Хөдөлмөрийн зах зээлийн жендэрийн тэгш бус байдлыг халах талаар	127
12	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн зах зээлд оролцох бололцоог өргөжүүлэх талаар	128
13	Шилжих хөдөлгөөнд оролцогчдын хөдөлмөр эрхлэх бололцоог өргөжүүлэх, тэднийг хамгаалах талаар	129
14	Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийг устгах талаар	129
	Дүгнэлт: Өргөн хүрээг хамарсан ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх асуудлыг улсын хөгжил, эдийн засгийн өсөлтийг хангах стратегийн гол цөм болгох хэрэгтэй.	

Ном зүй	132
Хавсралт	135
Арга зүйн тэмдэглэл	154
Нэр, томъёоны тайлбар	159

ХҮСНЭГТ

1.1	Хүний хөгжлийн индекс, аймаг, хотоор, Монгол Улс, 1999-2006	24
1.2	Хүний хөгжлийн индекс болон түүний гол үзүүлэлтээр олон улсын түвшинд Монгол Улсын эзэлж буй байр	29
1.3	Хүний хөгжлийн үзүүлэлтүүд, Монгол Улс, 1990–2006	30
1.4	Улсын нэгдсэн төсвийн хандлага, Монгол Улс, 1990-2006, инфляцийг тооцсон 1990 оны үнээр, төгрөгөөр	31
1.5	Хүний хөгжлийн индекс болон үзүүлэлтүүдийн өөрчлөлт, аймаг, хотоор, Монгол Улс, 2000-2006 (аймаг, хотыг ХХИ-ийн өөрчлөлтийн хувиар эрэмблэв)	32
1.6	Ядуурлын байдал, өрхийн тэргүүлэгчийн хүйс, байршлаар, Монгол Улс, 2002-2003	35
1.7	Хэрэглээний тэгш бус байдал: Жини коэффициент, Монгол Улс, 1998, 2002-2005, 2006	36
2.1	Сургуульд хамрагдалт, завсардалтын хувь, Монгол Улс, 2003-2007	45
2.2	15–29 насны боловсролгүй залуучуудын сургуулиас завсардсан шалтгаан, хүйсээр, Монгол Улс, 2006	45
2.3	Бүх шатны боловсролын сургалтын байгууллагыг төгсөгчид (мянган хүн), Монгол Улс, 2005–2006	47
2.4	Ажилгүйчүүдийн боловсролын түвшин, хүйсээр, Монгол Улс, 2002-2003	47
3.1	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн байдлаар, Монгол Улс, 2002-2003	57
3.2	Өрхийн тэргүүлэгч нь хувийн, улсын өмчийн болон төрийн байгууллагад ажилладаг өрхийн ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, Монгол Улс, 2002-2003	58
3.3	Ажилгүйдлийн үзүүлэлтүүд, Монгол Улс, 2002-2003	60
3.4	Ажилгүйдлийн түвшин, ядуурлын байдлаар, Монгол Улс, 2002-2003	60
3.5	15, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвхгүй хүн амын бүлгийн идэвхгүй байгаа шалтгаан, хүйс, байршлаар, Монгол Улс, 2002-2003	63
3.6	Эдийн засгийн өсөлтийн хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмж, Монгол Улс, 1997-2006	65
3.7	Хөдөлмөр эрхлэлтийн өөрчлөлт, салбарын ангилалаар, Монгол Улс, 2000-2006	66
3.8	Шинээр бий болсон ажлын байр (мянгаар), байршлаар, Монгол Улс, 2000-2006	67
3.9	Ажлын байр, бодит цалин, бүтээмж, салбарын ангилалаар, Монгол Улс, 2000-2006	67

3.10	Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагууд, ажиллагчдын тоогоор бүлэглэснээр, Монгол Улс, 2001–2006	69
3.11	Мал болон малчны тоо (мянгаар), Монгол Улс, 1989-2006	76
3.12	Малтай өрх, малын тооны бүлгээр, Монгол Улс, 1999, 2006	77
3.13	“ХААН” банкны сумын төвүүд дэх салбараас малчдын авсан зээл (мянган төгрөгөөр), Монгол Улс, 2002-2007	77
3.14	Хөдөө аж ахуйн бус салбарт ажил эрхэлж байгаа 15, түүнээс дээш насны хүн амын тоо, байгууллагын төрөл, байршлаар, Монгол Улс, 2002-2003	82
3.15	Нийгмийн даатгалын үзүүлэлтүүд, Монгол Улс, 1995, 2000, 2005	86
4.1	15–29 насны залуучуудын ажил эрхлэлтийн байдал, боловсролын түвшингээр, Монгол Улс, 2006	91
4.2	Залуучуудын ажил эрхлэлт, насны бүлгээр, Монгол Улс, 2006	92
4.3	Хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийн хувь, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, Монгол Улс, 2002-2003, 2006	97
4.4	Ажиллагчдын ажил мэргэжлийн ангилал, хүйсээр, Монгол Улс, 2002–2003	97
4.5	Ажиллагчдын ажил эрхлэлтийн байдал, хүйсээр, Монгол Улс, 2002-2003	98
4.6	Ясли, цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоо, Монгол Улс, 1990, 1995, 2000, 2006-2007	99
4.7	Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин, салбараар, Монгол Улс, 2006	102
4.8	15, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын ажил эрхлэлт, ажилгүйдлийн хувь, хүйсээр, Монгол Улс, 2004	103
4.9	БНСУ, БНЧУ болон АНУ-д ажиллаж, амьдарч байгаа хүмүүсийн сарын дундаж орлого, 2004	109
4.10	БНСУ, БНЧУ болон АНУ-д ажиллагчдын боловсролын түвшин, 2004	110
4.11	Албан ёсны сувгаарх ажилчдын мөнгөн гуйвуулга (сая ам.доллар), 2003-2006	110

ДҮРСЛЭЛ

1.1	Хүний хөгжлийн үзүүлэлтүүд, ХХИ, ЖХИ, ЖЭМХ, Монгол Улс, 2000–2006	34
1.2	Ядуурлын түвшин, Улаанбаатар хотоос алслагдалт, бүс нутгаар, Монгол Улс, 2002-2003	37
3.1	Эдийн засгийн идэвхгүй нийт хүн амын дүнд 15, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь, идэвхгүй байгаа шалтгаан, хүйсээр, Монгол Улс, 2002-2003	64
3.2	Хөдөлмөрийн насны нийт хүн амд эзлэх ажиллаагүй болон сураагүй байгаа хүмүүсийн эзлэх хувийн жинг ажил эрхлэлтийн түвшин болон ажилгүйдлийн түвшинтэй харьцуулсан байдал, Монгол Улс, 1992-2006	64
3.3	Голлох салбаруудын ажил эрхлэлтийн хувь, Монгол Улс, 1995-2006	70
3.4	ХАА-н салбарын ажиллагчдын хувь, ДНБ-д эзлэх хувь, Монгол Улс, 1995-2006	70
3.5	Аж үйлдвэрийн салбарт ажиллагчдын хувь, ДНБ-д эзлэх хувь, Монгол Улс, 1995-2006	70
3.6	Аж үйлдвэрийн салбарт ажиллагчдын тоо, Монгол Улс, 1995-2006	71
3.7	Үйлчилгээний салбарт ажиллагчдын хувь, ДНБ-д эзлэх хувь, Монгол Улс, 1995-2006	71
3.8	Үйлчилгээний салбарт ажиллагчдын тоо, Монгол Улс, 1995-2006	71
3.9	Хөдөө аж ахуйн бус албан бус секторын ажил эрхлэлтийн зарим үзүүлэлтүүд, Монгол Улс, 2002-2003	82
3.10	Албан бус секторт ажиллагчдын боловсролын түвшин, хувиар, Монгол Улс, 2002-2003	83
4.1	Ажилгүйдлийн түвшин насны бүлэг, байршлаар, Монгол Улс, 2002-2003	91
4.2	Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйсээр, Монгол Улс, 2002–2003	96
4.3	Ажилгүйдлийн түвшин, насны бүлэг, хүйсээр, Монгол Улс, 2002–2003	100
4.4	Хотын хүн амын хувийн жин, жилийн дундаж өсөлт, хувиар, Монгол Улс, 1990-2006	107
4.5	Улаанбаатар хотын хүн амын тооны өсөлт, ердийн цэвэр болон механик өсөлтөөр, Монгол Улс, 1989-2006	107
4.6	Ажиллах хүчинд ажил хийж байгаа хүүхдийн эзлэх хувь, Монгол Улс, 2002–2003	113

ШИГТГЭЭ

1	Монгол улсын Үндсэн хууль, 16.4-р зүйл	26
2	Ядуурлаас гарах нь	27
3	Хүний хөгжлийн индекс (ХХИ)	28
4	“Хот” ба “хөдөө” - албан ёсны тодорхойлолт	33
5	Эрүүл мэндийн найдвартай үйлчилгээг хүртэх бололцоо орон нутгийн ядуу иргэдэд туйлын хомс байна	40
6	Зохистой хөдөлмөр эрлэлтийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөө (2005 – 2008)	42
7	Ажлын байр нэмэгдүүлэх бодлогын хувилбар ба жижиг дунд бизнес	69
8	Ажил эрхлэлтийг хэрхэн амжилттай нэмэгдүүлж буй талаарх бусад улсын туршлага: Бүгд Найрамдах Энэтхэг Улсын “Хөдөөгийн ажил эрхлэлтийг баталгаажуулах тухай” хууль	79
9	Албан бус секторын тухай төрийн бодлого	85
10	Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкнаас ажил эрхлэлтэд жендэрийн талаас хийсэн үнэлгээ	101
11	Эдийн засгийн идэвх, хүүхдийн хөдөлмөр, аюултай ажил	112

ЗУРАГЛАЛ

1	Хүний хөгжлийн индекс, аймаг, хотоор, Монгол улс, 2006	12
---	--	----

ХАВСРАЛТ


᠋᠋᠋᠋᠋᠋

X1	Хүний хөгжлийн индекс, үзүүлэлтүүд, аймаг, нийслэлээр, Монгол Улс, 2006	135
X2	Хүний хөгжлийн индекс, үзүүлэлтүүд, аймаг, нийслэлээр, Монгол Улс, 2000-2006	136
X3	Хүний хөгжлийн индекс, үзүүлэлтүүд, бүсээр, Монгол Улс, 2000-2006	139
X4	Шилжилтийн эдийн засагтай улсуудын хүний хөгжлийн индекс, үзүүлэлтүүд, 2004	140
X5	Жендэрийн хөгжлийн индекс, үзүүлэлтүүд, аймаг, нийслэлээр, Монгол Улс, 2000-2006	141
X6	Жендэрийн хөгжлийн индекс, аймаг, нийслэлээр, Монгол Улс, 2003-2006	142
X7	Жендэрийн хөгжлийн индекс, иүзүүлэлтүүд, бүсээр, Монгол Улс, 2006	142
X8	Жендэрийн хөгжлийн индекс, бүсээр, Монгол Улс, 2003-2006	143
X9	Жендэрийн эрх мэдлийн хэмжүүр, үзүүлэлтүүд, аймаг, нийслэлээр, Монгол Улс, 2006	143
X10	Жендэрийн эрх мэдлийн хэмжүүр, аймаг, нийслэлээр, Монгол Улс, 2003-2006	144
X11	Жендэрийн эрх мэдлийн хэмжүүр, бүсээр, Монгол Улс, 2003-2006	144
X12	Мянганы хөгжлийн зорилтууд, Монгол Улс	145
X13	Хүн амын үндсэн үзүүлэлтүүд, Монгол Улс, 1989-2006	148
X14	Хот, хөдөөгийн хүн ам, аймаг, хотоор, Монгол Улс, 2006	148
X15	Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, Монгол Улс, 2000-2006	149
X16	Ажиллагчид, салбараар, оны эцэст, Монгол Улс, 1998-2006	150
X17	Ажиллагчдын тоо, аймаг, хотоор, Монгол Улс, 1997-2006	150
X18	Хүн амын ажил эрхлэлтийн үзүүлэлтүүд, Монгол Улс, 1995-2006	152
X19	Бүртгэлтэй ажилгүйчүүдээс ажилд орсон хүний тоо, Монгол Улс, 1995-2006	152
X20	Эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоо, Монгол Улс, 1995-2006	153

᠋᠋᠋᠋᠋᠋

X1.1	Бага, дунд сургуулийн тоо, аймаг, нийслэлээр, Монгол Улс, 2006	146
X1.2	Бага, дунд сургуулийн тоо, сум, дүүргээр, Монгол Улс, 2006	146
X2	Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох) аймаг, хотоор, Монгол Улс, 2006	147
X3	Эхийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох) аймаг, хотоор, Монгол Улс, 2006	147
X4	Ажил эрхлэлтийн түвшин, аймаг, хотоор, Монгол Улс, 2006	151
X5	Ажилгүйдлийн түвшин, аймаг, хотоор, Монгол Улс, 2006	151

Зураглал 1 Хүний хөгжлийн индекс, аймаг, хотоор, Монгол Улс, 2006



Монгол Улсын хүний хөгжлийн шинэ эрин үе: Эдийн засгийн өсөлт хурдасч, төсвийн байдал сайжирсан хэдий ч ядуурлын түвшин өндөр хэвээр байна

Монгол улс хүний хөгжлийн шинэ эрин үедээ орлоо. Монгол Улсын Хүний хөгжлийн индекс (ХХИ) түүхэндээ анх удаа хамгийн өндөр түвшинд хүрч, энэ үзүүлэлт тус улсын бүс нутаг бүрт өсчээ. Сүүлийн долоон жилд эрүүл мэнд, боловсрол, орлогын байдлыг хэмждэг ХХИ-ийн дэд үзүүлэлтүүд тун сайжирч, ХХИ аймаг бүрт нэлээд өсөв. Сүүлийн таван жилд амьжиргааны түвшин ялгаатай аймгуудын ХХИ-ийн ялгаа багасч байна. Түүнчлэн Монгол Улсын Мянганы хөгжлийн ихэнх зорилтуудын биелэлт сайн байна. Эх, нялхсын эндэгдлийг бууруулах зэрэг хэд хэдэн асуудлаар үндэсний хэмжээнд дэвшүүлсэн нийт 22 зорилт 60 хувийн биелэлттэй байна.

Эдийн засгийн байдал эрс сайжирч, сүүлийн дөрвөн жилд эдийн засгийн өсөлт дунджаар 8,7 хувь болсон, төсвийн орлого, зарлага жилд 30 гаруй хувиар нэмэгдсэн, мөн банкны салбар хурдацтай өргөжиж байгаа зэрэг ахиц дэвшил гарч байна. Иймээс эдийн засгийн энэхүү өсөлтийг тогтвортой үргэлжлүүлэх, төр засгаас хүний хөгжлийг дэмжих чиглэлээр нийт улс орон даяар томоохон арга хэмжээ авч хэрэгжүүлэх нөхцөл бүрдээд байна.

Гэхдээ дээр өгүүлсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ юуны өмнө ядуурал Монгол Улсад томоохон бэрхшээлтэй асуудал хэвээр байна гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. 2006 онд улсын хэмжээнд ядуурлын түвшин 32,2 хувь хүртэл тун бага хувиар буурч, хөдөө, орон нутагт 37 хувь хүрсэнд нухацтай дүгнэлт хиймээр байна. Түүнээс гадна өнгөрсөн жилүүдэд сургуульд хамрагдалтын түвшин, бага боловсрол эзэмшилтийн хувь, ХАА-н бус салбарын ажиллагчдын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь, нийт газар нутагт ойт нутгийн эзлэх хувь зэрэг Мянганы хөгжлийн зорилтуудын бусад зарим үзүүлэлтүүд сайжрахгүй харин буурах хандлагатай байгаа нь тухайн

чиглэлээр дэвшүүлсэн зорилтуудын биелэлтийг үлэмж эргэлзээтэй болгож, санаа зовниход хүргэж байна. Орлогын тэгш бус байдлын гол хэмжүүр болох Жини коэффициент сүүлийн үед эрс өссөн нь эдийн засгийн өсөлтийн үр шимийн дийлэнх хувийг амьдралын боломж илүү сайтай хүмүүс хүртэж байгаагийн илэрхийлэл юм. Хэрэв энэ хандлага цаашид үргэлжилбэл, ядуурлыг өргөн хэмжээнд бууруулах зорилтыг биелүүлэхэд ихээхэн хүндрэлтэй байх болно.

Монгол Улсын өнөөгийн эдийн засгийн өндөр өсөлт нь ядуурлыг бууруулахад яагаад дорвитой нөлөөлж чадахгүй байна вэ? Эдийн засаг өсч байхад яагаад тэгш бус байдал газар авч байна вэ? Эдийн засгийн өсөлт, ядуурал хоёрын хооронд шууд холбоо байхгүй ч зохистой ажлын байрыг олноор бий болгож баймааж нь эдийн засгийн хурдацтай өсөлтийг ядуурлыг дорвитой бууруулахад нөлөөлөх хүчин зүйл болгож болдгийг олон улсын туршлага бэлхнээ харуулж байна. Учир нь, ядуу хүмүүст байгаа гол нөөц болох ажиллах хүчээ ашиглах боломжийг хөдөлмөр эрхлэлт л олгодог. Эдийн засгийн өсөлт дээрхүүргийг харахан биелүүлэхгүй байна. Өөрөөр хэлбэл, хангалттай ажлын байр бий болгохгүй, өнөөгийн байгаа дийлэнх ажлын байр ядуурлаас гаргах хэмжээний цалин хөлс олгож чаддаггүй, ажлын орчин нөхцөл хангалтгүй, ядуучуудын амьдардаг газруудад зохистой ажлын байрны боломж байдаггүй, түүнчлэн шинээр бий болж буй ажлын байранд шаардлагатай ур чадвар ихэнх Монгол ажилчдад дутмаг байдаг гэж олон иргэд үзэж байна.

Дээрх шалтгаануудын улмаас зохистой ажлын байрыг дэмжих Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний стратеги боловсруулах нь өнөөгийн байдлаар Монгол Улсын нэн тэргүүний зорилтуудын нэг болжээ. Энэхүү стратегийн зорилго нь эдийн засгийн өсөлтийн үр шимийг хүн амд илүү тэгш

хүртээх, Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан иргэн бүр зохистой хөдөлмөр эрхлэх эрхтэй байх үзэл санааг Монголын бүх иргэд амьдралдаа хэрэгжүүлэх боломжийг олгоход чиглэх учиртай. Монгол Улсын Хүний хөгжлийн дөрөв дэх удаагийн энэхүү илтгэлийн сэдэв бол ядуурлыг бууруулахад чиглэсэн хөдөлмөр эрхлэлтэд суурилсан бодлогын хүрээний асуудлууд юм. Энэхүү илтгэлд хөдөлмөр эрхлэлт нь нэр хүндтэй, үнэ цэнэтэй амьдралын чухал хэсэг бөгөөд хүмүүсийн ядуурлаас гарах гол түлхүүр хүчин зүйл болохын хувьд хүний хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдгийг юуны өмнө онцолж, хөдөлмөр эрхлэлт, хүний хөгжлийн чиг хандлага, тэдгээрийн ядууралтай холбогдох уялдаа холбоо, мөн эдийн засгийн гол гол салбар дахь хөдөлмөр эрхлэлт, хүн амын зарим бүлгийнхэнд тулгараад буй хөдөлмөр эрхлэлттэй холбоотой зарим хүндрэлтэй асуудлын талаар авч үзсэн болно.

Хүний хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь дээр дурдсан стратегийн нэг гол бүрэлдэхүүн хэсэг, чухал хүчин зүйл байх болно. Ядуу сум орон нутаг, бусад газрууд, Улаанбаатар хотын гэр хороолол болон орон сууцны хорооллын хоорондын хөгжлийн зааг ялгааг арилгах нь эн тэргүүний асуудал болоод байна. Учир нь ядуучууд олноор амьдардаг газарт сургууль завсардалтын түвшин улсын хэмжээнд хамгийн өндөр, эрүүл ахуй, эрүүл мэндийн бусад суурь үйлчилгээний хүртээмж хамгийн муу байна. Нийгмийн салбарт хуваарилж буй нийт төсвийн зарлагыг дэс дараатай нэмэгдүүлэх нь нааштай арга хэмжээ байж болох ч үүний хангалттай хувь нь хөрөнгө оруулалт хамгийн их хэрэгцээтэй байгаа газруудын ядуу иргэдэд чиглэж, тэдэнд шууд хүрдэг байх ёстой.

Эдийн засгийн өсөлтийн үр шимийг улам олон Монголчууд хүртэх боломжийг бүрдүүлэхийн тулд өөр юу хийх хэрэгтэй вэ? Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний стратегид дараах хэд хэдэн чухал асуудлыг нарийвчлан авч үзэж тусгах шаардлагатай.

Үүнд:

1. Шинээр бий болсон ажлын байр – Ажиллах хүчинд анх удаа шилжиж буй, одоогоор ажилгүй болон бүрэн бус хөдөлмөр эрхэлж буй, хөдөөнөөс хот руу шилжин суурьшиж буй хүн амд хангалттай хүрэлцэхүйц ажлын байр бий болсон уу?
2. Шинээр бий болсон ажлын байрны чанар – Ядуу хүний хувьд эдгээр ажлын байр нь ядуурлаас найдвартай гарах арга зам болж чадсан уу? Авч буй бодит цалингийн хэмжээ нь ажиллагчид болон тэдгээрийн гэр бүлийнхний хувьд зохистой амьжиргааг хангаж чадах уу?
3. Шинэ ажлын байрны байршил – Ажил хайж буй, тэр дундаа ядуу хүмүүсийн ажил хайж буй газарт ажлын байр шинээр бий болж чадсан уу?
4. Бүтээмж өндөртэй ажил эрхэлж буй хөдөлмөрийн насны хүн амын чадавхи бий болсон боломжийг ашиглах, түүнд тохирсон мэдлэг, туршлага, ур чадварыг эзэмшсэн эсэх, эрүүл мэндийн байдал нь тохирч байгаа эсэх зэрэг асуудлууд болно.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний стратегийг боловсруулан, дээрх асуудлыг тусган хэрэгжүүлэх нь тийм амар хялбар ажил биш юм. Гэсэн хэдий ч Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Албан бус эдийн засгийн талаарх засгийн газрын бодлого болон Зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэг сүүлийн жилүүдэд боловсруулан гаргасан бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөн дээр суурилж, тэдгээрийг эрчимжүүлэх замаар үүнийг хэрэгжүүлэх боломж бий. Олон улсын туршлагаас харахад, бодлогын дэмжлэг чухал байдаг. Тухайлбал, төр, засгаас ажлын байрыг нэмэгдүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудалд тэргүүлэх ач холбогдол өгч чадваас энэ нь ард түмний аж амьдрал сайжрахад хангалттай хэмжээгээр нөлөөлж чаддаг ажээ.

Хүний хөгжил, хөдөлмөр эрхлэлт хоёрыг холбогч гүүр нь ажиллах чадвар мөн

Эмэгтэй, эрэгтэй хэн ч ялгаагүй ажил олох, олсон ажлаа шаардлагын хэмжээнд хийх чадавхийг ажиллах чадвар буюу ажил эрхлэх боломж гэх бөгөөд энэхүү ухагдахуун өөртөө ур чадвар, мэдлэг, хувийн араншин, итгэл үнэмшил хандлага зэргийг багтаасан ойлголт юм. Энэ нь хүний хөгжил, хөдөлмөр эрхлэлт хоёрыг холбогч гүүр учир хөдөлмөрийн зах зээл дэх шинэ эрэлтийг бий болгогч эдийн засгийн ухагдахуун биш харин эрэгтэй, эмэгтэй хэн боловч өөрийн болон гэр бүлийнхээ наад захын хэрэгцээг хангах, хүүхдүүд нь хүүхдийн орчиндоо өсч хөгжих боломж олгох, боловсролтой болох, ядууралд өртөхөөс сэргийлэх бололцоог бүрдүүлэхүйц орлоготой хөдөлмөр эрхлэх, нэр төртэй амьдрах чадавхи юм.

Ажил олгогч нар ажил хийхийг хүссэн иргэдийн чадварт сэтгэл хангалуун бус байдаг нийтлэг дүр төрхийг Монголын ажил олгогч нарын дунд явуулсан судалгааны дүн илтгэн харуулж байна. Монголын ажиллагчдын ажиллах чадварыг дээшлүүлэхийн тулд анхаарвал зохих гол гол асуудлуудыг дурдвал:

А. Суурь боловсрол. Хөдөө, орон нутагт амьдардаг эрэгтэй хүүхдүүд бага сургуулиа дүүргэхгүй орших явдал түгээмэл байгаа тул орон нутагт амьдарч буй хүүхдүүдийн суурь боловсрол эзэмшилтийн түвшинг дээшлүүлэх, сургууль завсардалтыг бууруулах,

Б. Дунд, дээд шатны боловсрол. Сургуулиар олгодог мэдлэг, боловсрол болон хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ шаардлагын хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх шаардлагатай байна. Ингэснээр сургууль төгсөгчид ажил олгогчдын тавьдаг шаардлагуудыг илүүтэй хангадаг болно.

В. Техник, мэргэжлийн сургалт. Энэ тал дээр ч мөн адил, сургалт болон хөдөлмөрийн зах зээлд үнэхээр их эрэлт хэрэгцээтэй байгаа ур чадварын хоорондын

уялдаа холбоог бэхжүүлэх хэрэгтэй. Ажил олгогчид, ажиллагчдын аль аль нь ажил дээр гараад л өнөөгийн сургалтаар олгож байгаа ур чадвар амьдралд хэрхэн нийцэхгүй байгааг мэдэрдэгийг олон судалгааны дүн харуулж байна.

Г. Боловсролын талаарх олон нийтийн санаа бодол. Их, дээд сургуулийн боловсрол нь ирээдүйн ажил мэргэжилд илүү сайнаар нөлөөлнө гэсэн ойлголт залуучууд, тэдний эцэг эхчүүдэд түгээмэл байдаг. Гэтэл одоогийн байдлаар их, дээд сургууль төгсөгчдийн тоо нь тэдэнд зориулсан ажлын байрны тооноос илүү олон байна. Гэтэл уул уурхай, барилга, хүнсний үйлдвэр гэх зэрэг техник, мэргэжлийн сайн боловсрол илүү хэрэгцээтэй байгаа салбаруудын цалин сайтай ажлын байруудад ажиллах хүч хүрэлцээгүй байна.

Д. Архидалт. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас эрхлэн явуулсан нэгэн томоохон судалгаанаас үзэхэд, архидалт нь олон хүний, тэр дундаа ядуу эрчүүдийн хөдөлмөр эрхлэх чадавхид нөлөөлж буй гол саад болоод байна. Архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх явдал нь ядуу эрэгтэйчүүдийг ядуурлын урхинд бүрмөсөн оруулж, тэдний ажил олох, эрхлэх, улмаар ядуурлаас гарах боломжийг үгүй хийж байна.

Төр, засгаас ажил, хөдөлмөр эрхлэх чадавхитай холбоотой асуудлуудыг цогц байдлаар шийдвэрлэх гол түлхүүр нь сургалтын хөтөлбөрийг хянах, стандарт жишиг тогтоох, мөн сургалтанд амжилттай хамрагдсан ажиллагчдад гэрчилгээ олгох зэрэг үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах явдал мөн. Үүнийг хэрэгжүүлэх нэг шууд арга зам бол сургалтын хөтөлбөр, ур чадварын стандартыг тогтоох, хянах, магадлан итгэмжлэх, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, санхүүгийн зохистой механизм бүрдүүлэх, арга зүйн төв байгуулах, арга зүйч багш нарыг бэлтгэх, сургуулийн удирдлагыг бэхжүүлэх зэрэг асуудлыг цогц шийдвэрлэж байх үүрэг бүхий Үндэсний зөвлөлийг байгуулан

сонирхогч талуудтай хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх явдал мөн. Энэхүү зөвлөл нь төр, засгийн байгууллагууд, хөдөлмөр эрхлэгчид, үйлдвэрчний эвлэлүүд, боловсролын байгууллагуудын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй байж, үйл ажиллагааны нэг чиглэл нь дотооддоо болон гадаадад ажил эрхлэхэд хэрэг болох мэргэжлийн ур чадварын стандартыг тогтоох явдал байх юм. Түүнээс гадна дээрх зөвлөл нь мэргэжлийн сургалт, боловсролыг шинэчлэх талаар сонирхогч олон талуудыг оролцуулсан тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх, боловсрол, хөдөлмөрийн зах зээлийн шаардлагын уялдаа холбоог бэхжүүлэхэд чиглэсэн хамтын хүчин чармайлтыг хариуцан ажиллаж болох юм.

Монгол Улсад архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх явдал нийгэм, эдийн засагт үлэмж сөрөг нөлөө үзүүлж байгаа учраас төр, засгаас архидалтын эсрэг сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа явуулах, мөн архи, согтууруулах ундаа хэрэглэхтэй холбоотой зохицуулалт хийх зэргээр архидалтыг таслан зогсоох арга хэмжээг эрчимтэй авч хэрэгжүүлбэл зохино.

Мөн түүнчлэн, төр, засгаас суурь боловсрол эзэмшилтийн түвшинг нэмэгдүүлэх, нийт иргэд, тэр дундаа ядуу хүмүүсийн хүүхдүүд, энэ чиглэлийн хөтөлбөрт хамрагдаж, унших, тоолох болон бусад чухал суурь ур чадваруудыг эзэмшин, хөдөлмөрийн амьдралд хөл тавих боломжийг бүрдүүлэх замаар хүний хөгжилд зориулах хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

Хөдөлмөр эрхлэлт болон ядуурал

Өрхийн тэргүүний ажил эрхлэлтийн байдал, тухайн өрхийн ядуурлын нөхцөл байдал хоёр хоорондоо уялдаа холбоотой байдаг. 2002-2003 оны Амьжиргааны түвшний түүвэр судалгаанд “ядууралд өртөх магадлалын харьцаа”-г өрхүүдээр тооцохдоо тухайн өрхийн тэргүүлэгч ажил эрхэлдэг эсэх, тэдний эрхэлдэг ажлын төрөл, нийт хүн амтай харьцуулсан бүлэг тус бүрийн ядуурлын харьцааг тус тус бүлэглэн гаргажээ. Өрхийн тэргүүлэгч

нь хөдөлмөрийн насны ч эдийн засгийн идэвхгүй, өөрөөр хэлбэл, ажилгүй эсхүл ажил хайхгүй байгаа өрхүүд ядуу байх хамгийн өндөр магадлалтай буюу тэдний ядууралд өртөх магадлалын харьцаа 1.42 байна. Үүнийг өрхийн тэргүүлэгч нь ажилгүй өрхийн ядууралд өртөх магадлалын харьцаа 1.33 байгаатай харьцуулсан ч дээрх бүлгийн ядууралд өртөх магадлал илүү өндөр байна. Өрхийн тэргүүлэгч нь малчин өрхүүдийн ядууралд өртөх магадлалын харьцаа 1.09 байгаа нь нийт хүн амтай харьцуулахад энэ бүлгийн дунд ядуурлын түвшин өндөр байна гэсэн үг.

Өрхийн тэргүүлэгч нь малчин биш бөгөөд хувийн хэвшилд ажилладаг өрхийн ядууралд өртөх магадлалын харьцаа бараг 1 байгаа нь ядууралд өртөх магадлалын хувьд Монголын дундаж өрхтэй ойролцоо байгааг харуулж байна. Өрхийн тэргүүлэгч нь төрийн албан хаагч болон улсын үйлдвэрийн газар ажилладаг өрхүүд дундаж өрхтэй харьцуулахад ядууралд өртөх магадлал бага байна.

Энд зарим чухал тоо баримтыг дурдах хэрэгтэй. Дээрх судалгаагаар Монголын ядуу өрхийн тэргүүлэгчдийн 52 хувь нь ажил эрхэлдэг; тэдний 29 хувь нь малчин, 23 хувь нь хувийн хэвшилд ажилладаг байна. Хэдийгээр өрхийн тэргүүлэгч нь ажилгүй, эдийн засгийн идэвхгүй байгаа олон өрхүүд ядуу байгаа ч дийлэнх ядуу өрхүүдийн тэргүүлэгч нар ажил эрхэлдэг ажээ. Зүгээр л ажлын байрны тоог нэмэгдүүлээд зогсохгүй хүмүүсийн орлогыг нэмэгдүүлэхүйц, хөдөлмөрийн үнэлгээ сайтай ажлын байр бий болгох нь ядуурлыг бууруулахад илүү үр дүнтэй нөлөөлнө.

Ажилгүйдэл

Өрхийн тэргүүн нь ажилгүй өрхүүдийн дунд ядуурал өндөр байгаа нь ажлын байрыг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

Хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн дунд ядуурал өндөр байгаа нь хөдөлмөрийн үнэлгээ өндөртэй ажлын байр бий болгох шаардлагатайг харуулж байна.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газруудын нэгтгэсэн статистик мэдээнээс үзэхэд, сүүлийн таван жилд ажилгүйдлийн түвшин тогтвортой 3,5 хувь орчим байна. Монгол Улсын Статистикийн жилийн эмхэтгэлд гарсан хамгийн сүүлийн үеийн тоо мэдээгээр, 2006 онд 32928 ажилгүйчүүд бүртгүүлсний дотор 43.0 хувь нь эрэгтэйчүүд, 57.0 хувь нь эмэгтэйчүүд байна. Энэ нь ажилгүйдлийн түвшин 3.2 хувь байгааг илэрхийлж байгаа бөгөөд өнгөц харахад ажилгүйдэл Монгол Улсын хувьд тулгамдсан асуудал биш мэт сэтгэгдэл төрүүлэхээр байгаа юм.

Гэхдээ олон улсын стандартын дагуу тухайн судалгаа хийгдэхийн өмнөх долоо хоногт аливаа хүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээнд дор хаяж нэг цаг л ажилласан бол, мөн ажил дээрээ байгаагүй ч “хавсарсан ажилтай” бол түүнийг ажилтайд тооцдог. Энэ нь “ажил эрхлэлт”-ийн талаарх дийлэнх хүмүүсийн өнөөгийн ойлголтоос тун ялгаатай байгаагаас ажилтай эсэх тухай иргэдээс асуулга авдаг судалгаануудын үр дүн ажилгүйдлийн түвшинг голдуу өндөр буюу 30 орчим хувиар илүү мэдээлдэг. Голдуу албан бус секторт долоо хоногт цөөхөн цагаар ажилладаг хүмүүс өөрсдийгөө ажилгүй хэмээн тооцдог ч энэ нь үнэндээ тийм биш юм. Дээр дурдсанчлан, өрхийн тэргүүлэгч нь ажилтай өрхүүд голдуу ядуу байгаа нэг шалтгаан бол тэдний зарим нь долоо хоногт цөөхөн цаг ажилладагтай холбоотой байна.

Шинээр бий болж буй ажлын байр

Хөдөлмөр эрхлэлт дээр суурилсан ядуурлыг бууруулах стратегид дараахи асуудлыг тусган хэрэгжүүлбэл зохино. Үүнд: ажилгүйчүүд, эдийн засгийн идэвхгүй байгаа хүмүүст зориулан ажлын байрыг нэмэгдүүлэх; ажилтай ядуу иргэдийн тоог бууруулах, эдийн засгийн идэвхгүй хүн амын ажил хөдөлмөр эрхлэх явдлыг дэмжих зорилгоор хөдөлмөрийн бүтээмж өндөр, бодит орлогыг нэмэгдүүлэхүйц чанартай ажлын байр бий болгох хэрэгтэй байна. Мөн ядуу

малчин өрхөд зориулан орлогын нэмэлт эх үүсвэр бий болгох зорилгоор хөдөө, орон нутагт ажил, хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх; Монголын ажиллах хүчний үр чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, ингэснээр иргэд хөдөлмөрийн зах зээл дэх шинэ боломжийг ашиглах, өөрөөр хэлбэл, төрийн болон хувийн салбарын аль алинд ажиллахад сайтар бэлтгэгдэж чадна.

Улсын маань эдийн засаг энэхүү дурдсан нөхцөл байдлыг бүрдүүлэхэд хүлээх үүргээ хэрхэн биелүүлж байгаа эсэх талаар одоо авч үзье. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт хурдасч буй хэдий ч ажлын байрны тоо өсөөгүйгээр барахгүй буурсан мэдээ байна. 2000-2003 онд 118000 ажлын байр шинээр нэмэгдсэн бол 2003-2006 онд энэ үзүүлэлт зөвхөн 83000 байсан буюу шинээр бий болсон ажлын байр сүүлийн гурван жилд өмнөх гурван жилтэй харьцуулахад даруй 30 хувиар буурчээ. 2000-2003 онд малчдын тоо 43 мянгаар буурах үед ч ажлын байрны цэвэр өсөлт нэлээд өндөр хувьтай байсан нь анхаарал татууштай асуудал мөн. Гэтэл 2003-2006 онд малчдын тоо 14 хүрэхгүй мянгаар буурсан. Мал аж ахуйгаас бусад салбарт бий болсон ажлын байр 2000-2003 онд 161000-аар, харин 2003-2006 онд 97000-аар тус тус нэмэгдсэнээс үзвэл мал аж ахуйгаас бусад салбарт шинээр ажлын байр бий болох явц ихээхэн удааширсан буюу 40 хувиар буурсан гэсэн үг. Ядуурлын түвшин өндөр хэвээр буйн бас нэг шалтгаан нь ажлын байрууд хэрэгцээтэй газартаа бий болохгүй байгаа явдал гэж үзэж байна. 2000-2003 онд Улаанбаатар хотоос бусад газарт 43000 ажлын байр шинээр бий болсон бол, дараагийн гурван жилд нь энэ үзүүлэлт буурч 14200-д хүрчээ.

Хэдийгээр өндөр цалин хөлс олгодог зарим салбарт ажлын байрны тоо эрчимтэй нэмэгдсээр байгаа боловч бага цалинтай салбаруудад ажиллагчдын эзлэх хувийн жин өндөр хэвээр байна. 2003-2006 онд шинээр бий болсон ажлын байрны 39 хувь нь бага цалинтай бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт нэмэгдсэн нь бусад аль ч салбартай харьцуулахад өндөр үзүүлэлт

юм. Сайны жишээ гэвэл, шинээр бий болсон ажлын байрны 27 хувь нь барилга, 13 хувь нь уул уурхайн салбарт тус тус ногдож байгаа бөгөөд эдгээр салбар дахь бодит цалингийн хэмжээ нэлээд өсөх хандлагатай байна. Гэхдээ дээр дурдсанчлан, адил хугацаанд шинээр бий болж буй нийт ажлын байрны өсөлт нэлээд удааширсан учраас дээрх хоёр салбарт бодитой бий болсон 31000 ажлын байранд нийт ажиллах хүчний 4 хүрэхгүй хувь ажиллаж байна. Цалин хөлсний тухайд, нийт ажиллах хүчний 15 хувийг эзэлдэг боловсрол, эрүүл мэнд, төрийн захиргааны гэх мэт төсвийн байгууллагуудын ажиллагчдын бодит цалин өссөн явдал анхаарал татлаа. 2003-2006 онд өмнө дурдсан салбарын ажиллагчдын бодит цалин дунджаар 35.2 хувиар өссөн нь төсвийн байгууллагуудын ажиллагчдын цалин нэлээд хувиар нэмэгдсэнтэй холбоотой байв¹.

Эдийн засаг хурдацтай өсч байхад шинээр ажлын байр бий болох явц удаашралтай байгаа дүр зургийг хөдөө аж ахуй болон аж үйлдвэрийн салбарын ДНБ, ажил эрхлэлтийн урт хугацааны ерөнхий чиг хандлагыг судлаад хийсэн дүгнэлтээс харж болно. 1999-2006 онд хөдөө аж ахуйн салбарт ажиллагчдын нийт ажиллах хүчинд эзлэх хувь 49.5 байснаа 38.8 хувь хүртэл буюу бараг тавны нэгээр, энэ хугацаанд тус салбарт ажиллагчдын Монгол Улсын ДНБ-д оруулсан хувь нэмэр 37.0-оос 18.8 хувь хүртэл буюу талаас илүү хувиар буурчээ. Үүн дээр үндэслэн ХАА-н салбарт ажиллагч тус бүрийн үйлдвэрлэсэн нэмүү өртгийн хэмжээ эрс буурсан гэж дүгнэж болох юм. Гэтэл энэ хугацаанд уул уурхай зэрэг аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувь 20.6 байснаа 40.3 хувь хүрч хоёр дахин өссөн бол нийт ажиллах хүчинд тус салбарт ажиллагчдын эзлэх хувь 15.5-аас 17.3 хувь болж нэмэгджээ. Аж үйлдвэрийн салбарын ажиллах хүчний бүтээмж эрс нэмэгдсэн ч тус салбар дахь ажиллагчдын тооны өсөлт тун удаан байв. Үүний шалтгаан нь уул уурхайн салбарын өсөлт

хурдацтай явагдаж, 2006 онд тус салбарын ДНБ-д эзлэх хувийн жин гуравны нэгээр нэмэгдсэнтэй холбоотой байв.

Эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх замаар ажил эрхлэлтийг нэмэгдүүлье!

Хоёр үндсэн шалтгааны улмаас Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлснээр ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх боломж байна хэмээн үзэж байна. Нэгд, бусад салбаруудтай харьцуулбал, уул уурхайн салбар хөрөнгийн зарцуулалт ихтэй бөгөөд мөн ДНБ-ний шинээр нэмэгдэж буй нэгж бүрийн хувьд авч үзвэл, цөөн тооны ажлын байрыг бий болгож байна. Хоёрт, сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн өсөлт нь биет бүтээгдэхүүний өсөлтөөс бус, харин Монгол Улсын гол нэрийн экспортын бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн өсөлтөөс үүдэлтэй байсан. Үүнээс шалтгаалан шинээр бий болсон ажлын байрны тоо олигтой өссөнгүй. Байгалийн баялагт тулгуурласан өсөлт буюу олонд “нөөцийн занал” (resource curse) хэмээх нэрээрээ танил болсон байгалийн баялаг ихтэй улс орнууд дахь өсөлт тэсэрч мөн үүнээс үүдэн сүйрч ирсэн туршлагаас үзэхэд эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх явдал хөдөлмөр зарцуулалт ихтэй салбарт ажлын байр олноор бий болгож, улмаар ядуучуудын амьдралыг дээшлүүлэхэд ач холбогдолтой байдаг ажээ.

Уул уурхайн салбарыг хөдөлмөр эрхлэлтийн боломжийг нэмэгдүүлэх суваг болгон ашиглах нь

Хэдийгээр ирэх жилүүдэд ашигт малтмал, уул уурхайн салбар Монголын эдийн засгийн маш чухал хэсэг хэвээр байх нь тодорхой ч тус салбараас хөдөлмөр эрхлэлт, хүний хөгжилд үзүүлж болох нөлөөг аль болох нэмэгдүүлэх байдлаар зохицуулалт хийх нь зүйтэй. Энэ талаар олон арга хэмжээ авч хэрэгжүүлж болно. Хамгийн гол нь, уул уурхайн салбараас төсөвт оруулж буй орлогыг дэд бүтцийн хөгжил, сургалтын хөтөлбөрүүд, хүний хөгжилд хөрөнгө оруулах замаар

¹ *Yiyi* *oyuyad* *caad* *daedai* *noodee* *uzaiyue* *odee* *aaadaaaid* *addad* *iu* *-daae* *aa* *eei* *adaai* *oziz* *naeai* *adn* *naeadd* *ae* *ee* *ee* *ae* *oe* *n* *aa* *-* *aaadaa* *ai* *eei* *o* *o* *-* *edd* *ae*.

өсөлтийн үр шимээс хүн бүр хүртэх боломж бүрдүүлэхэд чиглүүлэх хэрэгтэй байна. Уул уурхайн компаниуд Монгол Улсад боловсруулах үйлдвэрүүд барьж байгуулах, эрчим хүчний болон үйлдвэрлэлийн бусад гол түүхий эд, тоног төхөөрөмжийн хэрэгцээгээ дотоодын ханган нийлүүлэгчдээр дамжин хангуулж байх явдлыг тус тус дэмжих чиглэлээр уул уурхай болон бусад салбаруудын хоорондын уялдаа холбоог сайжруулж болох юм. Түүнчлэн, уул уурхайн албан бус салбар хөдөө, орон нутгийн олон иргэдийн хөдөлмөр эрхлэлт, орлогын чухал эх үүсвэр болж байгаа тул энэ асуудлыг зохицуулж, аажмаар албан ёсны хэлбэрт шилжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлбэл зохино.

Хөдөө, орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэх, ядуу малчин өрхүүдэд хүрч үйлчлэх нь

Монгол Улсын хөдөө, орон нутгийн эдийн засаг нь нийт эдийн засгийн бусад хэсгүүдийн нэгэн адил хурдацтай өөрчлөгдөж байна. Олон малтай малчин өрхийн тоо урьд өмнө байгаагүйгээр олширчээ. Хөдөө, орон нутагт санхүүгийн үйлчилгээ өргөжиж, цахилгаан эрчим хүч, ахуйн гол гол цахилгаан хэрэгслээр хангагдсан, хувийн машин тэрэгтэй малчин өрхийн тоо өмнөхөөсөө ихээхэн нэмэгдлээ. Гэсэн хэдий ч хөдөөгийн хүн амын нэлээд хувь нь хөгжлийн үр шимээс хүртэж чадахгүй байгаа бөгөөд 2006 онд гэхэд хөдөө, орон нутагт ядуурал 37 хувьтай байсан нь хот, суурин газрынхтай (26 хувь) харьцуулахад өндөр үзүүлэлт юм. Малчид, нэн ялангуяа цөөн тооны толгой малтай малчдын дунд ядуурал газар авсан байна. Ядуу малчид малынхаа ашиг шимээр амьдардаг учраас хэрэглээндээ өөрт байгаа цөөн тооны малыг ашиглах тул тоо толгойг нь өсгөх боломж олдохгүй, улмаар ядуурлын урхинд орох талтай байдаг. Үүнээс гадна экологийн саад бэрхшээлийн улмаас нийт улс орны хэмжээнд ч малын тоо толгойг өсгөхөд хүндрэл учирдаг явдал ч үүнд нөлөөлж байна. Эдгээр өрхийн хувьд ядуурлаас гарах хамгийн зөв арга нь орлогын шинэ эх үүсвэртэй болох явдал

юм. Гэтэл өмнө дурдсанчлан, сүүлийн жилүүдэд хөдөө, орон нутагт шинээр бий болсон ажлын байрны тооны өсөлт мэдэгдэхүйц буурч байгаа юм.

Сумын төвд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ үзүүлэх, сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгөх, ажилд зуучлах, мэдээллээр хангах зэрэг үйл ажиллагааг өргөжүүлэх, энэ чиглэлийн тусгайлсан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, хөдөөгийн дэд бүтцийг хөгжүүлэхэд зориулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх зэрэг нь тэдгээр өрхүүдэд хүрч үйлчлэх хамгийн шилдэг арга зам мөн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн нэлээдийг сумын төвийг хөгжүүлэхэд зарцуулж болох юм. Эдгээр үйл ажиллагааг төвлөрлийг сааруулах хөтөлбөрийн хамт хэрэгжүүлбэл үр дүнгээ өгөх болно. Учир нь орон нутгийн засаг захиргаа нутаг дэвсгэрээ хөгжүүлэх санаачлага гарган түүнийгээ ажил болгох, мөн төсвийн эрх мэдэл нь өргөжвөл дээр дурдсан үйл ажиллагааг амьдралд хэрэгжүүлэх боломж бүрдэх болно.

Албан бус салбарыг албан болгох нь

Монгол Улсын албан бус салбарт олон иргэд ажиллаж, орлого олдог. Гэхдээ эдийн засгийн албан бус салбар дахь ажлын байрны чанарын талаар санаа зовних зүйлс их бий. Албан бус салбарын дийлэнх ажлууд бүртгэлгүй, хамгаалалтгүй, зохион байгуулалтгүй байгаагийн зэрэгцээ ажил эрхэлдэг олон ядуу иргэд албан бус салбарт ажиллаж байна. Эдийн засгийн албан бус салбарын талаар баримтлах төрийн бодлого нь төр, ажил олгогчдын байгууллага, үйлдвэрчний эвлэл гэсэн гурван талын оролцоо бүхий хамтын ажиллагааны үр дүнд боловсруулан гаргасан баримт бичиг бөгөөд албан бус салбарт ажиллагчдад төрийн үйлчилгээ үзүүлэх, хууль, эрх зүйн хамгаалалт, баталгааг бий болгох замаар албан бус салбарыг албан ёсны болгоход чиглэгдсэн. Энэхүү хүчин зүтгэлийг цаашид өргөжүүлэн эрчимжүүлэх нь Монголын олон тооны өрх бүлийг

ядуурлаас гарахад нөлөө үзүүлэх боломжтой. Албан бус салбарт ажилладаг иргэдэд зориулан төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах үүднээс тэдгээр иргэдийн бүртгэлийг сайжруулах, албан бус салбарт ажиллагчдын дунд ажлын гэрээ, хөдөлмөрийн эрхийн талаарх ойлголтыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажил явуулах, оролцооны үнэлгээ болон бусад үйл ажиллагаа явуулах замаар албан бус салбар дахь ажлын байрны аюулгүй байдлыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулах, хөдөлмөрийн бүтээмж, орлогоо нэмэгдүүлэх үйл ажиллагааг нь дэмжих үүднээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааг илүү өргөн хүрээнд ашиглах зэрэг чиглэлээр цаашид тодорхой арга хэмжээ авбал зохино.

Ажиллах хүчний өвөрмөц бүлгүүд

Ажлын байр шинээр бий болгох үйл явц түргэсч, хөдөлмөрийн бүтээмж болон хүн амын орлого ерөнхий дүнгээрээ өсч буй ч нийгмийн нэлээд хэсэг ядуурлаас ангид байх, хөдөлмөр эрхлэх боломж олгохуйц боловсрол эзэмшихэд нь саад бэрхшээл тулгарсаар байна. Монголын залуучууд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй тулгарч байдаг хөдөлмөрийн зах зээл дэх хүндрэлтэй асуудлуудад тусгайлан анхаарал хандуулж, тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байна. Түүнчлэн хэдэн зуун мянган монголчуудын хувьд орлогоо нэмэгдүүлэх чухал арга зам болчихоод байгаа дотоод, гадаад шилжих хөдөлгөөний асуудлыг төрийн бодлогоор зохицуулах хэрэгтэй. Төр, засгаас дорвитой арга хэмжээ авах шаардлагатай хөдөлмөрийн зах зээлтэй холбоо бүхий өөр нэг асуудал бол хүүхдийн хөдөлмөрийг ашиглаж буй явдал бөгөөд сүүлийн үед ялангуяа хөдөө, орон нутагт сургууль завсардалтын түвшин нэмэгдсэн нь ядуу өрхүүд хүүхдүүдээ багаас нь ажил хийлгэхээр шийдэх болсныг харуулж байна. Ийм шийдвэр нь хүүхдүүд ирээдүйд сайн ажил олж, эрхлэх чадавхийг хязгаарлахад хүргэж байна.

Залуучуудын ажилгүйдлийн түвшин нийт хүн амын ажилгүйдлийн түвшингээс

хоёр гаруй дахин өндөр буюу 14 хувь байгааг “Сургуулиас ажилд шилжигсдийн судалгаа”-ны дүн харуулж байна. Хот суурин газартай харьцуулахад, хөдөө, орон нутагт залуучуудын ажилгүйдлийн түвшин доогуур байгаа нь мал аж ахуйн салбарт хэдийгээр өндөр бүтээмжтэй биш ч зарим нэг ажил олж хийхэд арай дөхөм байдагтай холбоотой ч хөдөө, орон нутагт урт хугацааны ажилгүйдэл илүү өндөр байна. Хот, хөдөөгийн аль алинд тулгараад буй нэг томоохон асуудал бол залуучуудын сургуулиараа олж авсан ур чадвар ажил олгогчдын тавьдаг шаардлагатай дүйцэхгүй байгаа явдал юм. Ур чадвар, стандарт, гэрчилгээний асуудлаарх Үндэсний зөвлөлийн ажлын хүрээнд нийт улс орны хэмжээнд залуучуудад хэрэгтэй ур чадвар олгоход чиглэсэн сургалтын хөтөлбөрүүд боловсруулах, ажилгүй залуучуудад тулгараад буй тодорхой асуудлуудад анхаарлаа хандуулах чиг үүргийг тусган хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хэдийгээр эмэгтэйчүүд Монголын ажиллах хүчний талаас илүү хувийг бүрдүүлдэг ч эрчүүдтэй харьцуулбал, ижил хөдөлмөрт ижил цалин авахад, мөн өндөр ур чадвараа ашиглан удирдах албан тушаалд дэвших тал дээр илэрхий хүндрэлтэй тулгардаг. Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас саяхан явуулсан судалгаанаас харахад, хэрэв жендэрийн ялгаатай байдал гаргахгүйгээр эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн цалинг гүйцэтгэсэн ажил, туршлага, эзэмшсэн чадвар дээр нь бүрэн үндэслэж тогтоодог байсан бол эмэгтэйчүүдийн цалин одоогийн түвшнээсээ дунджаар 22 хувиар илүү байх байжээ. Бараг бүх салбарт эмэгтэйчүүдэд удирдах албан тушаал тэр бүр олгодоггүйн зэрэгцээ эмэгтэйчүүд уул уурхай зэрэг өндөр бүтээмж, орлоготой салбаруудад ажил олж хийх боломж бага юм. Монгол Улсын ажиллах хүчний тал хэсгийнх нь ур чадвар үр ашигтай ашиглагдахгүй байгаа нь нийт нийгэмд эдийн засгийн алдагдал бий болгож байгаа хэрэг бөгөөд эмэгтэйчүүд өөрсдийн чадавхиа хөгжүүлж, бүрэн дүүрэн сайн сайхан аж төрөх чадварт шууд саад болж байна. Хөдөлмөрийн үнэлгээ өндөртэй

ажил хөдөлмөр эрхлэх талаар эмэгтэйчүүд эрчүүдтэй эн тэнцүү боломж нөхцөлтэй байх явдлыг хангах үүднээс жендэрийн асуудлыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бүхий л санаачлагуудад тусгах талаар төр, засгаас тогтвортой, дорвитой арга хэмжээ авах нь зүйтэй байна. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдалтай тэмцэх тухай хууль, эрх зүйн арга хэмжээг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх хэрэгтэй. Эмэгтэйчүүд ажил төрөл, гэр бүлийн амьдралын нүсэр давхар ачааг нуруун дээрээ үүрч явдаг нь бас нэгэн бэрхшээлтэй асуудал мөн бөгөөд үүнийг хүүхдийн асаргаа, сувиллын үйлчилгээг сайжруулах, гэр орны үүрэг хариуцлагыг илүү зохистой хуваарилах явдлыг дэмжих талаар төр, засгаас тодорхой үйл ажиллагаа явуулах замаар шийдвэрлэх боломжтой.

Үндэсний статистикийн газрын мэдээлснээр, 2006 оны байдлаар хөдөлмөрийн насны нийт 82300 хөгжлийн бэрхшээлтэй хүн бүртгэгджээ. НХХЯ-ны тооцоогоор, эдгээр иргэдийн 80 орчим хувь нь хөдөлмөр эрхлэх чадвартай байгаагийн 13 хувь нь л хөдөлмөр эрхэлж байна. Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд хамрагдах шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвхөн 20 орчим хувь л ийм боломжоор хангагдаж байна. Энэ нь Монголын хөдөлмөрийн насны хүн амын 5 гаруй хувийг бүрдүүлдэг нэг бүлгийн сэтгэл тэнүүн, хэвийн амьдрах эрх, хүний хөгжилтэй холбоотой зарчмын асуудлыг хөндөж буй явдал юм. Хэдийгээр засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтанд хамруулах, ажил хөдөлмөр эрхлэх боломжийг нь бүрдүүлэхэд чиглэсэн хөтөлбөрүүд боловсруулж, олон улсын конвенцуудад нэгдээд байгаа ч нэн ялангуяа хөдөө, орон нутагт санхүүжилтийн эх үүсвэр хомс, иргэдийн хөтөлбөрт хамрагдах боломж хязгаарлагдмал, холбогдох хөтөлбөрийн хэрэгжилт сул байгаа зэрэг нь эдгээр иргэдийн боломжийг бодит амьдрал дээр хязгаарлаж байна.

Сүүлийн жилүүдийн дотоодын шилжилт хөдөлгөөний цар хүрээ Улаанбаатар хотын хүн амын тоо

өөрчлөгдсөн байдлаас тодорхой харагддаг. 1990 оноос хойшхи хугацаанд нийслэл хотын хүн ам 427000 хүнээр нэмэгдсэний 70 орчим хувь нь дотоодын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой байв. Улаанбаатар хотод шилжин суурьшсан иргэдийн амьжиргааны түвшинд хийсэн судалгаануудаас харахад, тэдний шилжин нүүх болсон хамгийн нийтлэг шалтгаан нь ажил олж хийх явдал байжээ. Гэсэн хэдий ч олон иргэд ажил олж хийх, бизнес хөгжлийн үйлчилгээ, сургалтуудад хамрагдах, хүүхдүүддээ зохих боловсрол олгоход ихээхэн бэрхшээлтэй тулгарсан хэвээр байна. Нэг гол бэрхшээл бол шилжин суурьшигч иргэд төрийн үйлчилгээнд хамрагдах эрх олж авахын тулд хотод ирээд хийлгэх шаардлагатай иргэний бүртгэлийн асуудал юм. Иргэний бүртгэлтэй холбогдон гардаг хүндрэл бэрхшээл нь хөдөлмөрийн хүчийг газар зүйн өөр бүсэд шилжүүлэн, ажил үйлчилгээ нь шаардлагатай байгаа салбаруудад ажиллуулах ажиллах хүчний хөдөлгөөнийг хязгаарлаж байна. Монгол иргэд гадаад орнууд руу явж ажиллах нь мөн нэмэгдсээр байгаа бөгөөд гадаадад шилжин суурьшсан иргэдээ хамгаалах үйлчилгээг сайжруулах, гадаадад ажиллаж буй иргэдийн эх орондоо буцаж ирэн, Монголынхоо хөгжилд хувь нэмрээ оруулах явдлыг дэмжин, хилийн чанадад эзэмшсэн ур чадварыг нь бүрэн дүүрэн ашиглах талаар төр, засгийн зүгээс тавих анхаарлаа нэмэгдүүлж гадаад хөдөлмөр эрхлэлтийн менежментийг сайжруулах шаардлагатай байна.

Хэдийгээр Монгол Улс Хүүхдийн хөдөлмөр, түүний дотор хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгахтай холбоотой гол гол олон улсын конвенцүүдэд нэгдэн ороод байгаа ч эдгээр гэрээ хэлэлцээрүүдийг амьдрал дээр хэрэгжүүлэх талаар ажил олгогчдын байгууллагууд, үйлдвэрчний эвлэлүүдтэй хамтран илүү их хүчин чармайлт гарган ажиллах хэрэгтэй байна.


Монгол Улсын сүүлийн арван жилийн нөхцөл байдлаас үүдэн дараах гурван гол дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

- а. Эдийн засгийн өсөлт дангаараа Монголын нийт хүн амд зохистой ажил хөдөлмөр эрхлэх боломж бүрдүүлж чадахгүй байна. Хэдийгээр сүүлийн дөрвөн жилийн туршид эдийн засаг хурдацтай өсч байсан боловч өмнөх жилүүдээсээ ч цөөн тооны ажлын байр бий болгожээ.
- б) Ажил бүхэн адилгүй. Монгол улсад өнөөдөр ажил хөдөлмөр эрхлэгчид орлогын найдвартай эх үүсвэртэй, гэр бүлээ амьжиргааны боломжтой түвшинд аваад явах бололцоо бүхий тав тухтай орчин нөхцөлтэй ажлын байр ихээр шаардагдаж байна. Хөдөлмөр эрхэлж байгаа олон тооны монголчууд ядуурлын түвшинд буюу эл зэрэглэлд хальтран орох эрсдэлтэй байна гэж өөрсдийгөө үзэж байна. Хөдөлмөрийн зах зээл хоёрдмол шинж чанартай байгаа нь туйлын аюултай. Нэг хэсэг нь өндөр хангамжтай, тав тухтай орчинд ажил эрхэлж байхад, нөгөө хэсэг буюу хүн амын олонх хэсэг нь цалин хөлс, үр ашиг муутайд тооцогддог албан бус болон мал аж ахуйн салбарт ажил эрхэлж байгаа нь онцгой анхаарвал зохих асуудал мөн.
- в) Монголын ажилчдад зохих ур чадвар, ажлын байранд шаардагдах бусад чадварыг эзэмшүүлэх талаар дорвитой арга хэмжээ авахгүй бол шинээр бий болж буй найдвартай ажил эрхлэлтийн боломжийг ашиглаж чадахгүйд хүрэх болно. Монголын ажилчид ажил олгогчдын хэрэгцээ шаардлагыг хангахуйц ур чадвартай, эрүүл саруул бие бялдартай, архи согтууруулах ундаанаас татгалзаж чадваас өнөөгийн гадаад ажилчдыг авч ажиллуулж байгаа өндөр цалинтай ажлын байрыг эзлэх боломжтой.

Түүнээс гадна, хөдөлмөрийн зах зээл зохих ёсоор ажиллаж Монголын ард түмэнд эх орныхоо хөгжлийн төлөө бүх хүчээ зориулан ажиллах бололцоогоор хангах ёстой. Өнөөдрийн байдлаар дэндүү олон тооны эмэгтэйчүүдэд энэ

боломж олдохгүй байгаа бөгөөд энэ нь ажлын байр болон нийгмийн хүрээнд тэднийг ялгаварлан гадуурхах үзэл оршсоор байгаатай холбоотой гэж үзэж байна. Монголын залуучууд бүтээмжтэй, цалин сайтай ажил эрхлэхэд шаардагдах бэлтгэлгүйгээр сургуулиа төгсөж байна. Монгол дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэд ч мөн ийм байдалд байгаа бөгөөд энэ нь тэдний эх орныхоо бүтээн байгуулалт, хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулахад нь саад тотгор учирсаар байна. Монголын олон хүүхдүүд өнөөдөр гэр бүлдээ тус дэм болох зорилгоор сургуулиа орхин ажил хийж, ирээдүйгээ золиослосоор байна.

Олон улсын туршлагаас харахад төр, засгийн бодлого оновчтой байх явдал маш чухал байдаг. Төрийн аливаа бодлого, хөтөлбөр дээрх асуудлуудыг шийдвэрлэхэд багагүй хэмжээний нөлөө үзүүлж, улмаар зохистой ажил хөдөлмөр эрхлэх, хүний хөгжлийг эрчимжүүлэх боломж бүрдэхэд хөтлөх залуур нь болж өгнө. Эдийн засгийн өсөлт тогтворжин төсвийн орлого өсөн нэмэгдэж буй энэ үед Монголын ард түмэнд зохистой, найдвартай хөдөлмөр эрхлэх боломж олгох, жендэрийн тэгш бус байдлыг халах, хүүхдийн хөдөлмөртэй холбоотой хүндрэл бэрхшээлийг даван туулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажил олгох зэрэг тодорхой асуудлуудыг өөртөө багтаасан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих стратегийг МХЗ-д тулгуурласан Үндэсний хөгжлийн бодлого, стратегийн нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг болгон амьдралд хэрэгжүүлэх өргөн боломж байна. Монголын Хүний хөгжлийн энэхүү илтгэлд дээрх боломжийг бүрдүүлэхтэй холбоотой зөвлөмжүүдийг тусгаж өглөө. Эдгээр нь эрэгтэй, эмэгтэй бүх хүмүүст үр бүтээлтэй, сайн сайхан амьдрах боломжийг бүрдүүлэх тухай хүний хөгжлийн үзэл баримтлалын үндсэн санаан дээр тулгуурласан болно.



1

БҮЛЭГ

Монголын хүний хөгжлийн ололт, бэрхшээл



Монголын хүний хөгжлийн ололт, бэрхшээл

Илтгэлийн энэ бүлэгт Монголын хүний хөгжлийн ерөнхий төлөв байдал сайжирч, хүний хөгжлийн индекс улсын болон нийт аймгийн түвшинд өссөн тухай дурдаж, 2004 оноос хойш эдийн засаг огцом хурдацтай өсч байхад хүн амын ядуурлын түвшин санаа зовоосоор байгаад дүн шинжилгээ хийсэн болно. Ядуурлын төлөв байдлын талаар онцолж нэлээд дэлгэрэнгүй авч үзлээ. Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн талаар Засгийн газраас бэлтгэн гаргасан үндэсний хоёр дахь илтгэлд дурдсан зарчмын асуудлыг ч бас товч хөндлөө. Мянганы хөгжлийн зорилтуудаас эх, нялхсын эндэгдлийг багасгах зорилт үр дүнтэй хэрэгжиж, ядуурлыг бууруулах, сургуульд хамрагдагсдын тоог нэмэгдүүлэх зэрэг зорилтуудын хэрэгжилт удаашралтай, зарим зорилтын үзүүлэлтээр ухралт гарсан нь МХЗ-ын хэрэгжилт харилцан адилгүй байгааг харуулж байна. Зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь ядуурлыг бууруулах голарга болохыг энэ бүлгийн эхэнд онцолж, бусад бүлгүүдэд нарийвчлан тодруулав. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг хангах нь нийт хүн амын амьдралын түвшинг сайжруулах үндэс суурь болдог байх, ажлын байрыг нэмэгдүүлэх, ялангуяа ядуучууд голлон амьдардаг газар нутгуудад тэдэнд зориулсан ажлын байрыг аль болох олноор бий болгох, чингэхдээ эрэгтэй, эмэгтэй хүмүүст адил боломж олгох, шинээр бий болж буй ажлын байрны шаардлагыг хангахуйц ур чадварыг монгол ажилчид эзэмших нөхцлийг бүрдүүлэх зэрэг асуудлуудыг илтгэлд тодорхой тусгаж оруулав. Монголын хүний хөгжлийн тулгамдсан асуудал, ялангуяа хөдөө орон нутаг, хотын захын гэр хорооллынхонд учирдаг хүндрэл бэрхшээлийг тодорхойлж, зохистой хөдөлмөр эрхлэлт болон хүний хөгжлийн хоорондын уялдаа холбоонд үндэслэсэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн ядуурлыг бууруулах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх нь Монгол Улсын хөгжлийн бодлогод онцгой

чухал болохыг илтгэлийн энэ бүлэгт нэлээд тодорхой тусгасан болно.

1.1 *ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠬᠣᠲᠤ* *ᠬᠡᠭᠢᠯᠢᠯᠢ ᠶᠡᠭᠡᠨ*

Монгол Улс хөгжлийнхээ шинэ үед орлоо. Монголын хүний хөгжлийн индекс сүүлийн жилүүдэд үндэсний болон бүс нутгийн хэмжээнд жил дараалан өсч байна. Хүний хөгжлийн индексийг тооцоолдог 3 гол үзүүлэлт буюу хүн амын эрүүл мэнд, боловсрол, орлогын хэмжээ сүүлийн 7 жилд тасралтгүй дээшилж, нийт индекс аймаг, хот бүрээр нэмэгджээ.

Хүснэгт 1.1 Хүний хөгжлийн индекс, аймаг, хотоор, Монгол Улс, 1999-2006

Аймаг, хот	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006
Архангай	0.637	0.643	0.631	0.625	0.629	0.643	0.660	0.675
Баян-Өлгий	0.627	0.640	0.636	0.629	0.643	0.652	0.677	0.690
Баянхонгор	0.614	0.617	0.636	0.572	0.595	0.617	0.645	0.658
Булган	0.671	0.678	0.666	0.655	0.657	0.670	0.682	0.692
Говь-Алтай	0.620	0.635	0.632	0.588	0.613	0.646	0.659	0.657
Дорноговь	0.637	0.646	0.623	0.630	0.638	0.653	0.662	0.670
Дорнод	0.587	0.595	0.593	0.600	0.617	0.622	0.636	0.648
Дундговь	0.666	-	0.651	0.643	0.665	0.674	0.689	0.701
Завхан	0.622	0.619	0.631	0.614	0.636	0.642	0.664	0.676
Өвөрхангай	0.630	0.605	0.593	0.594	0.613	0.631	0.655	0.668
Өмнөговь	0.656	0.660	0.659	0.631	0.673	0.674	0.710	0.725
Сүхбаатар	0.643	0.651	0.626	0.637	0.661	0.672	0.691	0.701
Сэлэнгэ	0.650	0.645	0.650	0.656	0.660	0.668	0.676	0.689
Төв	0.652	0.646	0.664	0.628	0.654	0.659	0.670	0.680
Увс	0.608	0.605	0.611	0.605	0.627	0.646	0.659	0.672
Ховд	0.633	0.651	0.664	0.632	0.643	0.660	0.676	0.686
Хөвсгөл	0.607	0.614	0.593	0.587	0.599	0.614	0.628	0.643
Хэнтий	0.646	0.655	0.635	0.632	0.647	0.661	0.677	0.683
Дархан-Уул	0.634	0.644	0.666	0.659	0.663	0.664	0.682	0.689
Улаанбаатар	0.705	0.707	0.711	0.722	0.722	0.722	0.734	0.745
Орхон	0.732	0.751	0.700	0.724	0.759	0.793	0.802	0.805
Говьсүмбэр	0.673	0.678	0.689	0.644	0.675	0.709	0.714	0.718
Улсын дундаж	0.661	0.667	0.667	0.667	0.680	0.692	0.707	0.718

ᠶᠡᠭᠡ *ᠠᠶᠢᠮᠠᠭ*: 1999 оны мэдээллийг 2003 оны МХХИ-ээс, 2000-2006 оны үзүүлэлтийг УСГ тооцсон болно.

Орчин үед улс орнуудын хөгжлийн түвшинг тодорхойлохдоо ХХИ-ээс гадна Мянганы хөгжлийн зорилт (МХЗ)-ын үр дүнгийн багц шалгуур үзүүлэлтийг ашиглаж байна. Ядуурал, эх, нялхсын эндэгдлийг бууруулах, хүн амын боловсролыг дээшлүүлэх, жендэрийн тэгш байдал, байгаль орчны тогтвортой байдлыг

хангах, халдварт өвчний тархалтыг зогсоох зэрэг үзүүлэлтүүд энэхүү шалгуурын багцыг бүрдүүлдэг. Монгол Улс 2000 оны Мянганы Тунхаглалыг хүлээн зөвшөөрсөн бөгөөд тэр дагуу өөрийн орны өвөрмөц онцлогт тохирсон зорилго, зорилт, үзүүлэлтүүдийг тогтоож, тэдгээрийг ханган биелүүлэхэд чиглэсэн бодлого, арга хэмжээ, үндэсний хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна². Монгол Улс дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн найман зорилго дээр “Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг бэхжүүлэх” гэсэн ес дэх зорилгыг нэмж өөрийн орны МХЗ-ыг баталсан. Монгол Улсын Их Хурлын тогтоолоор баталсан 2015 он гэхэд хүрэх ёстой МХЗ-ын нийт 22 зорилтын шалгуур үзүүлэлтээс эх, нялхсын эндэгдлийг бууруулах зэрэг нэлээд хэдэн үзүүлэлт биелсэн буюу биелэх боломжтой байгаа билээ.

Ийнхүү ХХИ сайжирч МХЗ-д хүрэх боломж бүрдэж байгаа нь эдийн засгийн хөгжилд гарсан гурван гол нааштай өөрчлөлтөөс хамааралтай байгаа юм (Хавсралт Хүснэгт А15). Нэгд, зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлснээс хойш анх удаа эдийн засаг тогтвортой өсч 2004 – 2006 онд дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ний жилийн дундаж өсөлт 8.7 хувьд хүрсэн; хоёрт, улсын төсвийн орлого, зарлага өсч, 2003-2006 онд зарлагын түвшин бараг хоёр дахин нэмэгдсэнээр нийгмийн салбарт зориулсан зардал огцом өсч ирсэн; гуравт, санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаа өргөжиж 2003-2006 онд жилийн эцсийн зээлийн үлдэгдлийн хэмжээ бараг гурав³ дахин нэмэгдсэн байна. Зээлийг ихэвчлэн Улаанбаатар хотод олгож ирсэн боловч нийслэл хотоос бусад газарт олгосон зээлийн хувийн жин 2004 онд 15.7 хувь байснаас 2006 онд 22.8 хувь болж өсчээ. Улаанбаатар хотоос бусад газарт 2006 онд олгосон зээлийн үлдэгдлийн хэмжээ 2003 оныхоос бараг дөрөв дахин нэмэгдсэн бөгөөд энэ нь 2003 оны улсын нийт зээлийн багцын бараг 60 хувьтай тэнцэх болов.

² I i tai e Oenii Canaeei aacaa. 2007. Iyiaaii o'aaeeei cidde o'aaui o'oyaaeeedei o' aeeai, ia yniee o i, o aadi eeday e.

³ Eei o'iyi a'eyoyayuyud "e'oo 176 daaiw ae aadui a'aa"u 2007 iia yoi ee daaia'eeeeei daai+eeai i'ci'eyeyuyud cy'eeei yiy o'ci ia'oi "e'oo i'day eey' o'aaia' daai' eey'odee'ee' aa'ei.

Ололт амжилт байгаа хэдий ч хүний хөгжлийн талаар сэтгэл түгшээсэн асуудал мөн байсаар байна. МХЗ-г бүрэн хэрэгжүүлж дуусах 2015 он хүртэл долоон жил үлджээ. Зарим зорилт, тухайлбал ядуурлын шугамаас доогуур орлоготой хүн амын хувийн жинг 50 хувиар бууруулах зорилтод хүрэх магадлал тун бага байна. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын ядуу хүн амын тоо бага зэрэг буурч 32 хувьд хүрсэн боловч дорвитой өөрчлөлт гарахгүй байна. Хүн амын орлогын тэгш бус байдлыг харуулдаг Жини коэффициент сүүлийн жилд огцом нэмэгдэж буй нь эдийн засгийн өсөлтийн үр дүнг чинээлэг хүмүүс хүртэж буйг илэрхийлж байна. Энэ хандлага удаан үргэлжилбэл ядуурлын түвшинг огцом бууруулах зорилтод хүрэх боломжгүй. Эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд амьдарч буй хүний тоог нэмэгдүүлэхээр дэвшүүлсэн зорилтод хүрэх явц удаашралтай байгаа бөгөөд зорилт хэрэгжихэд эргэлзээ төрөхөөр байна. Сургуульд хамрагдалтын цэвэр жин, анхан шатны сургууль дүүргэлт, хөдөө аж ахуйн бус салбарт цалинтай ажиллаж буй эмэгтэйчүүдийн хувийн жин, улсын нийт газар нутагт ойн эзлэх хувь зэрэг МХЗ-ын үзүүлэлтүүд хэрэгжих найдвар төрүүлэхгүй байна. Монгол Улсын Засгийн газраас энэ байдалд дүгнэлт хийж МХЗ-ыг хэрэгжүүлэхэд чиглэсэн эдийн засаг, нийгмийн тодорхой бодлого, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлж байна.

Эдийн засагт гарсан ахиц өөрчлөлтүүд нь дангаар нийгмийн салбарын хөгжлийн чухал зорилтыг бүрэн шийдвэрлэж чадахгүйг дээрх баримтууд харуулж байна. Эдийн засгийн өсөлтийн үр дүнд хүн амын амьжиргаа дээшилж буй эсэхийг үнэлэх нь хүний хөгжлийн үзэл баримтлалын гол агуулга юм.⁴ 1980-аад оны сүүлээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр боловсруулсан энэхүү үзэл баримтлал нь орлогоороо архи бус сүү худалдаж авахыг илүүд үзэх, өөрөөр хэлбэл орлогоо зөвхөн зөв зүйлд зарцуулж байвал сайн гэсэн олонхийн төсөөлөл, ДНБ-ний хэмжээ

⁴ O'aaee'aae, "O'ciee o'aaee'aa oi iu, i ei o' iu", Ayee'eei o'ciee o'aaee'eei eeday e, I' A' O' O', 1990.

эрхлэлтийг нэмэгдүүлэх талаар дэвшүүлсэн МХЗ, түүний үзэл баримтлал, хүрэх түвшин нь хөгжлийн гол тэргүүлэх чиглэл байх ёстой. Иргэн бүр зохистой хөдөлмөр эрхлэх ёстой гэсэн Монгол улсын Үндсэн хуулийн үзэл санааг хэрэгжүүлэхэд олон улсын туршлага болон одоо баримталж буй бодлогодоо үндэслэн цаашид тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Шигтгээ 2

Ядуурлаас гарах нь

Зохистой хөдөлмөр эрхлэлтийг Мянганы тунхаглалд дэвшүүлсэн харилцан уялдаа бүхий зорилтыг хангах болон хүний хөгжилд хүрэх арга замыг сонгоход чухал арга хэрэгсэл болгон ашиглаж болно. Дэлхий даяар өрх, гэр бүлд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх дэмжлэг үзүүлэх нь ОУХБ-ын стратегийн тэргүүлэх дөрвөн чиглэлд тусгагдсан бөгөөд энэ нь тухайн байгууллагын гол үүрэг болон стратегийн зорилго мөн юм. Зохистой хөдөлмөр эрхлэлт нь иргэн бүрийн чөлөөтэй хөдөлмөр эрхлэх эрхийн хүрээнд тунхаглагдсан ядуурлаас ангижрах талаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга зам мөн билээ.

᠋᠋᠋᠋᠋᠋᠋᠋᠋ **᠋᠋᠋᠋᠋᠋᠋᠋᠋**. Тухайн эдийн засаг нь хөрөнгө оруулах, бизнес эрхлэх, ажлын байр бий болгох, хүн амын тогтвортой аж байдлыг дээшлүүлэх боломжийг нээж л байвал ядуурлаас гарах боломж бүрдэх юм. Ядуурлаас ангижрах гол арга зам бол ажил хөдөлмөр мөн билээ.

᠋᠋᠋᠋. Өөрийн эрхээ эдлэх, өөрийн хэрэгцээгээ илэрхийлж мэдрүүлэх дуу хоолойтой болох нь ядуучуудад шаардлагатай байна. Тэдгээрт өөрийн төлөөлөл болон оролцоо чухал юм. Мөн ядуучуудын эрх ашиг, сонирхлыг хамгаалах сайн хууль, түүний хэрэгжилт чухал юм. Ядуу хүн тодорхой эрх мэдэл, эрхээ эдлэхгүйгээр ядуурлаас гарах боломжгүй юм.

᠋᠋᠋᠋᠋᠋᠋᠋᠋. Ядуучууд бол хүн амын баталгаагүй хэсэг мөн билээ. Ядуу хүний эрх мэдэл байнга хавчигдаж, тэдгээрийг хамгаалах, дэмжих тогтолцоо хангалтгүй байдаг юм. ОУХБ нь ядуучуудад чиглэсэн нийгмийн хамгааллын шинэ арга барилыг эрэлхийлэхийн зэрэгцээ төр засгийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх талаар ажиллаж байна. Өрхийн хүрээнд гүйцэтгэж буй эмэгтэйчүүдийн цалингүй хөдөлмөрийн хуваарилалтыг дахин авч үзэх нь зайлшгүй шаардлагатай юм. Мөн насны байдал, өвчин бусад хөгжлийн бэрхшээлээс шалтгаалан хөдөлмөр эрхлэх боломжгүй иргэдэд тусгай дэмжлэг үзүүлэх шаардлагатай.

᠋᠋᠋᠋᠋᠋᠋᠋᠋. Асуудлаа шийдэх гол зам бол харилцан ярилцаж зөвшилцөх гэж ядуучууд ойлгох болсон. Ядууст өөрсдийн хүсэл сонирхолоо хамгаалах, шийдвэрлэхийн тулд хэрхэн яаж зөвшилцөх талаар ОУХБ өөрийн хуримтлуулсан туршлагаасаа санал болгож байна. Ядуусын эрх ашиг, сонирхолыг хамгаалах талаар өөрийн хөтөлбөртөө тусгаж байна.

᠋᠋᠋᠋᠋᠋᠋᠋᠋: Хөдөлмөрийн талаарх олон улсын 91 дүгээр чуулга уулзалт дээр ОУХБ-ын Ерөнхий захирлын тавьсан Ядуурлаас ангижрах нь илтгэл, ОУХБ, Женев, 2003

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын хөгжилд ахиц дэвшил гарсаар байна. 1990-ээд оны үед тулгарч байсан эдийн засаг, нийгмийн хөгжил, бүтцийн өөрчлөлтийн олон бэрхшээлтэй асуудал хумигдаж өнөөдөр эдийн засаг, хүний хөгжлийн хүрээнд шийдвэрлэх боломжтой хэдхэн тооны гол зангилаа асуудал үлдсэн бөгөөд эдгээрийг зохицуулах нөөцийн эх үүсвэр ч бүрдсэн байна. Иймээс олсон амжилтаа баяр тэмдэглэх шалтаг болгохоосоо илүү байгаа нөөцөө оновчтой ашиглаж, хийж бүтээхийг эрхэмлэн хөгжлийнхөө ойрын 10 жилийн зорилтоо тодорхойлж ажиллахыг бодлого боловсруулагчид болон нийт иргэдээсээ шаардах нь монголын ард түмний гол уриа байх учиртай.

Нэг дэх зөвлөмж

Хөдөлмөр эрхлэлтийн тухай үндэсний стратегийг МХЗ-д суурилсан Үндэсний хөгжлийн стратегийн нэгэн гол бүрэлдэхүүн хэсэг болгон боловсруулах

- Эмэгтэйчүүд, залуучуудыг оролцуулан иргэн бүрийг бүтээмж өндөр, зохистой, бүрэн хөдөлмөр эрхлэлтээр хангах талаар Үндэсний хөгжлийн стратегидаа тусган, улмаар түүнийг ядуурлыг бууруулахад чиглэсэн арга хэрэгсэл болгох;
- Илүү олон, зохистой ажлын байр, ялангуяа ядуу хүмүүс амьдарч буй газар, нутагт бий болгох, мөн шинээр бий болсон ажлын байранд нийцэхүйц мэдлэг, чадварыг Монголын эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд адил тэгшээр олгоход чиглэсэн Хөдөлмөр эрхлэлтийн тухай үндэсний стратеги боловсруулах;
- Макро эдийн засгийн болон салбарын бодлого, хөтөлбөрүүд ажлын байр илүү олноор бий болгоход чиглэсэн байх явдлыг баталгаажуулах шаардлагатай;

1.2 *ᠶᠡᠨᠢᠯᠡᠭ ᠡᠨᠢ ᠳᠡᠭᠡᠨ* *ᠲᠦᠨᠳᠡᠭᠡᠨ ᠶᠡᠨᠢᠯᠡᠭᠡᠨ ᠡᠨᠢᠯᠡᠭᠡᠨ* *ᠲᠦᠨᠳᠡᠭᠡᠨ ᠶᠡᠨᠢᠯᠡᠭᠡᠨ*

1.2.1 Хүний хөгжлийн индекс (ХХИ)

Хүний хөгжил гэдэг бол хүний хөгжлийн индекс (ХХИ)-ээс илүү өргөн хүрээтэй ойлголт билээ. ХХИ нь хөгжлийн урт хугацааны хандлагыг олон улсын түвшинд харьцуулахуйц байдлаар үнэлэх нэгэн чухал шалгуур мөн. Энэхүү индекс нь тодорхой байх, харьцуулах боломжийг бүрдүүлэх зорилгоор хүний хөгжлийн цөөн үзүүлэлтийг үндэслэж бусад харьцуулах боломжгүй үзүүлэлтийг тооцоолдоггүйгээрээ онцлогтой.

Шигтгээ 3

Хүний хөгжлийн индекс (ХХИ)

Хүний хөгжлийн анхны илтгэлийг хэвлүүснээс хойш олон оронд хүний хөгжлийн түвшинг хүний хөгжлийн индекс (ХХИ)-ээр хэмжих болсон. ХХИ-ийг хүний хөгжлийн дараах гурван гол үзүүлэлтээр хэмждэг. Үүнд:

- Төрөлтөөс тооцсон дундаж наслалт нь урт удаан, энх тунх амьдрахыг илэрхийлнэ;
- Боловсролын байдлыг насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалтын хувь (хувийн жингийн 2/3) болон бага, дунд, дээд боловсролд хамрагдалтын түвшин (хувийн жингийн 1/3)-ээр илэрхийлнэ;
- Зохистой амьжиргаанд шаардагдах нөөцийг нэг хүнд ногдох бодит ДНБ (PPP америк доллар)-ээр орлуулан илэрхийлнэ.

ХХИ-ийг дээр дурдсан боловсрол, эрүүл мэнд болон орлогын индексийн энгийн арифметик дунджаар тооцно. ХХИ нь хүний хөгжлийг хэмжихэд ашиглах нэг чухал үзүүлэлт боловч хүмүүсийн сайн сайхан амьдралын талаар дүгнэлт гаргахын тулд нийгэм, эдийн засгийн үйл явцад дүн шинжилгээ хийсэн тоо баримтаар түүнийг баяжуулах шаардлагатай болно. Жишээ нь, ХХИ нь орлогын ядуурлын хандлагыг илэрхийлдэггүй.

ᠶᠡᠨᠢᠯᠡᠭᠡᠨ: Монгол Улсын Засгийн газар, НҮБХХ, ЭЗС. 2006. Хүний хөгжил сурах бичиг, Монгол Улс, Улаанбаатар хот.

Тухайлбал, индексийн тооцоонд орлогын үзүүлэлтийг хамруулж байгаа боловч цаг хугацааны хувьд болон олон улсын хэмжээнд харьцуулахад бэрхшээлтэй, ядуурлын түвшинг тусга-

Хүснэгт 1.3 Хүний хөгжлийн үзүүлэлтүүд, Монгол Улс, 1990–2006

Он	Дундаж наслалт (төрөлтөөс тооцсон)	15-аас дээш настай бичиг үсэгт тайлагдсан хүн амын эзлэх хувь	Бүх шатны сургуульд суралцагчдын суралцвал зохих насны хүн амд эзлэх хувь	Нэг хүнд ногдох ДНБ (валютын худалдан авах чадварын паритет, ам.доллар)	Дундаж наслалтын индекс	Хүн амын боловсролын түвшний нэгдсэн индекс	Нэг хүнд ногдох ДНБ-ий индекс	Хүний хөгжлийн индекс
1990	63.7	96.5	60.4	1,640	0.645	0.845	0.467	0.652
1992	62.8	97.7	54.3	1,266	0.638	0.824	0.424	0.626
1995	63.8	98.9	57.0	1,267	0.647	0.849	0.424	0.635
1998	65.1	96.5	62.0	1,356	0.669	0.850	0.435	0.651
1999	63.2	97.8	66.0	1,706	0.636	0.872	0.472	0.661
2000	63.2	97.8	69.6	1,783	0.636	0.884	0.481	0.667
2001	63.4	97.8	69.6	1,740	0.639	0.884	0.477	0.667
2002	63.5	97.8	69.7	1,710	0.642	0.884	0.474	0.667
2003	63.6	97.8	76.9	1,850	0.644	0.908	0.487	0.680
2004	64.6	97.8	78.0	2,056	0.660	0.912	0.505	0.692
2005	65.2	97.8	80.4	2,408	0.670	0.920	0.531	0.707
2006	65.9	97.8	79.4	2,823	0.681	0.916	0.558	0.718

*2000-2006 оны ДНБ-ний үзүүлэлтийг Аж ахуйн нэгжийн тооллогын дүнг үндэслэн ҮСГ өөрчилсөн.
 Үг нододөгө: ҮСГ, 2007 оны Монголын хүний хөгжлийн илтгэлд зориулсан тооцоо.

Шилжилтийн эхний үед хүний хөгжлийн ухарсан үзүүлэлтүүд 1990-ээд оны сүүлээр эдийн засгийн өсөлтийн хамт сэргэж, 2004 он гэхэд шилжилтийн өмнөх үеийнхээс зарим талаараа хол давсан байлаа (Хүснэгт 1.3). Сургуульд элсэлт 1990-1995 онд 60.4 хувиас 57.0 хувь болж буурсан боловч 2006 онд 79.4 хувь болж өссөний зэрэгцээ сургууль завсардалт ч багассан байна. Үүний адил 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 1990 онд 64 байснаа 2006 онд 19 болж буурав. Мөн эхийн эндэгдэл 1990-1993 онд 122-оос 259 хүрч өссөн боловч 2006 оны байдлаар 67.2 болов. Ийнхүү хүн амын төрөлт, нас баралтын түвшин буурснаар дундаж наслалт уртасч 2000-2006 оны хооронд 2.65 насаар нэмэгдэж 64-т хүрэв.

Сүүлийн жилүүдэд улсын төсвөөс нийгмийн салбарт зарцуулах хөрөнгийн хэмжээ нэмэгдсэн нь ХХИ-ийг сайжруулахад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн юм. Тухайлбал, 2006 онд ДНБ-ний 9.2 хувь болон улсын төсвийн зарлагын дөрөвний нэгтэй тэнцэх хэмжээний хөрөнгийг эрүүл мэнд, боловсролын салбарын санхүүжилтэд зарцуулсан байна. 1.4-р хүснэгтээс үзэхэд улсын төсвөөс дээрх хоёр гол салбарт зарцуулж буй хөрөнгийн хэмжээг инфляцийг тусгасан үнээр илэрхийлбэл 2006 онд 1990 оны түвшингээс хол давсан байна. Энэ нь социализмын үеийнхээс эрс буурсан ч шилжилтийн үед гарсан томоохон ололт мөн.

Хүснэгт 1.4 Улсын нэгдсэн төсвийн хандлага, Монгол Улс, 1990-2006, инфляцийг тооцсон 1990 оны үнээр, төгрөгөөр

	1990	1995	2000	2006
Төсвийн орлого (сая төгрөг)	5328.7	3009.6	3415.4	8938.8
ДНБ-д эзлэх хувь	50.9	25.6	34.5	42.9
Төсвийн зарлага (сая төгрөг)	6481.5	3072.7	4179.7	8128.0
ДНБ-д эзлэх хувь	61.9	26.1	34.5	39.0
Төсвийн зарлага эрүүл мэндийн салбарт (сая төгрөг)	578.9	426.3	447.0	653.1
ДНБ-д эзлэх хувь	5.5	3.6	4.5	3.1
Төсвийн зарлага боловсролын салбарт (сая төгрөг)	1202.7	502.5	798.8	1271.0
ДНБ-д эзлэх хувь	11.5	4.3	8.1	6.1

ᠣᠶᠢ ᠶᠡᠭᠦᠡ: Орлого, зарлагын үзүүлэлтийг Хэрэглээний үнийн индексийг ашиглан засварлав
ᠶᠣ ᠨᠣᠳᠠᠭᠦᠰᠡ: УСГ-ын Монгол улсын статистикийн эмхтгэлээс тооцсон зохиогчийн тооцоо.

***Аѐᠢᠨᠠᠳᠠᠭᠢ ᠳᠦᠭᠡᠳᠡ ᠳᠡᠭᠡᠳᠡᠳᠡ
 ᠡᠢᠠᠳᠡ ᠨᠡᠡᠢ ᠶᠣᠳᠡ ÷ᠡᠶᠡᠳᠡ***

Аймгуудын ХХИ-ийг 1999-2006 оны байдлаар 1.1-р хүснэгтэд харуулсан. Ерөнхийдөө ХХИ аймаг бүрт сайжрах хандлагатай байгаа бөгөөд индексийн өөрчлөлтийг үзүүлэлт бүрээр хавсралт хүснэгтээс нарийвчлан үзэх боломжтой юм. Хавсралт хүснэгт А1-д, аймаг тус бүрийн ХХИ-ийг үзүүлэлт бүрээр 2006 оны байдлаар задлан харуулж Хүснэгт 1.5-д уг индексийн 2000-2006 оны өөрчлөлтийг аймаг тус бүрээр гаргасан.

Аймгуудын ХХИ ерөнхийдөө нааштай хандлагаар өөрчлөгдөж байна. Нэгд, хүн амын дундаж наслалт 2000 оноос нэлээд уртасч байгаагийн дотор ядуурлын түвшин өндөр байдаг Баянхонгор, Дорнод аймагт энэ үзүүлэлт огцом өсчээ. Сургуульд элсэлтийн хувь бүх аймагт дээшилсэн боловч хөгжлийнхөө түвшингээр харьцангуй дээгүүрт тооцогддог Орхон аймагт энэ үзүүлэлт 2000-2006 оны хооронд 86.41

хувиас 83.8 хувь болж 3.12 хувиар буурсан нь улсын дунджаас ялимгүй өндөр байна. Ерөнхийдөө бусад аймгаас хөгжлөөрөө илүүд тооцогддог Орхон, Улаанбаатар хотын нийгмийн үзүүлэлт зарим аймагтай харьцуулахад доогуур байгаа нь Монгол Улсад хот, хөдөөгийн ялгаа байгаа хэдий ч зургаан жилийн өмнөхтэй харьцуулахад хөгжлийн ялгаа багасч буйг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, хөдөөгийн нийгмийн үзүүлэлт хоттой харьцуулахад илүү сайжирсны жишээ юм. Тухайлбал, Улаанбаатар хотын хүн амын дундаж наслалт 2000-2006 оны хооронд 2.69 жилээр уртассан нь бусад 17 аймгийн энэ үзүүлэлттэй харьцуулахад доогуур байна. Мөн нийслэл хотод сургуульд элсэлт 8.94 хувиар нэмэгдсэн байхад бусад 15 аймагт энэ үзүүлэлт илүү сайжирсан байна.

Аймгуудын хувьд нэг хүнд ногдох ДНБ-ний өсөлтийн хэмжээ их ялгаатай байна. Нэг хүнд ногдох ДНБ-ийг худалдан авах чадварын паритетийн ханшийг ашиглан америк долларт шилжүүлэн харьцуулахад уул уурхай, төмөрлөгийн үйлдвэрлэл хөгжсөн Орхон, Өмнөговь аймагт сүүлийн зургаан жилийн хугацаанд бараг 2 дахин нэмэгдсэн байна. Энэ өсөлт өөр долоон аймагт 50 хувиас дээш, түүний дотор Дундговь аймагт 75.4 хувьд хүрчээ. Бусад аймагт уг үзүүлэлт 10-с доош хувиар нэмэгдэж, Говь-Алтай, Дорноговь аймагт бүр буурах хандлагатай байлаа.

Аймгуудыг харьцуулахад ДНБ-ний өсөлт харилцан адилгүй боловч аймгийн ХХИ нь зөвхөн энэ үзүүлэлтээр тодорхойлогддоггүй. Гэхдээ ДНБ-ний өсөлтийн эрэмбээрээ Орхон аймаг бусдаасаа дээгүүр байгаа нь нийт индекс ч өндөр гарахад нөлөөлсөн байна. ХХИ-ээрээ Улаанбаатар хот хоёр, Өмнөговь аймаг гурав дугаар байрыг тус тус эзэлж байгаа нь мөн л ДНБ-ний өсөлтийн эрэмбээс шалтгаалж байна. Дараагийн байранд Говь-Сүмбэр, Дундговь, Сүхбаатар аймаг орж байгаа бөгөөд эдгээр аймагт ДНБ-ний өсөлт бусад үлдсэн аймгаас хол давуу байна. Нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ 1400–1600 америк долларт хүрсэн аймагт

ХХИ-ийн бусад үзүүлэлтээрээ ч дээгүүр байр эзлэхэд нөлөөлж байна. Нэлээд ядууд тооцогддог бусад аймагт ХХИ доогуур ДНБ-ний хэмжээ өндөр биш байна.

Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотод ДНБ харьцангуй эрчимтэй өссөн боловч ХХИ 5.4 хувиар өссөн нь улсын дунджаас бага байна. Орхон аймагт нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ 2 дахин өссөн боловч сургуульд элсэлтийн индекс доогуур байгаагаас шалтгаалан тус аймаг ХХИ-ийн өсөлтөөрөө есдүгээрт орсон байна. Нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ бага байдгаас шалтгаалан бусад орнуудтай харьцуулахад Монгол Улс ХХИ-ээрээ доогуур байр эзэлдэг юм. Мөн энэ байдал аймагт ч ажиглагддаг бөгөөд орлого харьцангуй өндөр байдаг хоттой харьцуулахад ядуурлын түвшин өндөр ч орлогоос бусад хүний хөгжлийн үзүүлэлт хөдөөд харьцангуй өндөр байх тохиолдол цөөнгүй байна.

Хүснэгт 1.5 Хүний хөгжлийн индекс болон үзүүлэлтүүдийн өөрчлөлт, аймаг, хотоор, Монгол Улс, 2000-2006 (аймаг, хотын ХХИ-ийн өөрчлөлтийн хувиар эрэмблэв)*

Аймаг хот	Дундаж наслалт (2000 оноос хойшхи өөрчлөлтийн хувь)	Бүх шатны сургуульд суралцагчдын суралцвал зохих насны хүн амд эзлэх хувь (2000 оноос хойшхи өөрчлөлтийн хувь)	Нэг хүнд ногдох ДНБ (2000 оноос хойшхи өөрчлөлтийн хувь)	ХХИ, (2000 оноос хойшхи өөрчлөлтийн хувь)
Улсын дундаж	4.19	14.08	58.33	7.65
Увс	4.11	33.69	68.99	11.07
Өвөрхангай	3.99	32.28	68.14	10.41
Өмнөговь	2.43	19.43	112.23	9.85
Завхан	3.95	27.52	51.73	9.21
Дорнод	6.64	15.44	43.65	8.91
Баян-Өлгий	2.35	17.50	69.58	7.81
Дундговь	2.13	14.67	75.39	7.68
Сүхбаатар	3.72	26.50	38.57	7.68
Орхон	3.92	-3.12	117.02	7.19
Дархан-Уул	3.92	8.63	50.99	6.99
Сэлэнгэ	3.79	15.95	36.64	6.82
Баянхонгор	6.69	22.94	4.32	6.65
Говьсүмбэр	2.79	7.20	53.00	5.90
Ховд	3.92	19.14	14.53	5.38

Улаанбаатар	2.69	8.94	45.27	5.37
Төв	3.87	2.95	38.09	5.26
Архангай	3.98	19.22	7.73	4.98
Хөвсгөл	4.18	19.38	2.28	4.72
Хэнтий	3.90	8.10	14.70	4.27
Дорноговь	3.92	19.22	-5.35	3.72
Говь-Алтай	3.97	12.89	-2.08	3.46
Булган	2.43	4.21	4.68	2.06

*Дундговь аймгийг 2001-2006 оноор тооцсон.

Үг нэрлэлт: ҮСГ-ын тоо, мэдээллээс тооцсон зохиогчийн тооцоо.

1.2.2 1991 оноос хойшхи ядуурлын хандлага

Хүний хөгжлийн индекс нь улс орны хөгжлийн хэтийн хандлагыг тодорхойлох чухал хэмжүүр болдог. Нийгмийн салбарт гарч буй ахиц дэвшлийг хүн амын бичиг үсэг тайлагдсан байдал, дундаж наслалт, сургуульд элсэлт зэрэг үзүүлэлтээр илэрхийлдэг. Дундаж наслалт, бичиг үсэг тайлагдсан байдал нь богино хугацааны мэдрэмж багатай үзүүлэлт бөгөөд урьд онуудын хөгжлийн үр дүнгээс ихээхэн хамаарч, нэг жилийн нөлөөллийг бага мэдэрдэг тул үүнийг дагаад ХХИ огцом бус алгуур өөрчлөгддөг онцлогтой. Тухайлбал, социализмын үед бүрдсэн хүний капитал, түүний дотор бичиг үсэг тайлагдсан байдал, дундаж наслалт зэрэг нь урьд жилүүдийн хөгжлийн үр дүн, тийм ч учраас 1990-1995 оны хооронд ХХИ төдийлөн буураагүй юм. Гэхдээ энэ нь шилжилтийн эхний үед хуучин ЗХУ-аас олгодог ДНБ-ний бараг гуравны нэгтэй тэнцэх хэмжээний санхүүгийн дэмжлэг зогссоноор Монголын хүн амын амссан бэрхшээлийн илэрхийлэл биш ээ.⁸

Шилжилтийн үеийн эхний жилүүдэд Монгол Улсын хүн амд учирсан бэрхшээл ямар хүнд байсныг 1996 онд тоогоор илэрхийлэн гаргасныг одоо сонирхоё. Хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлох 1995 оны судалгаагаар нийт хүн амын 36.3 хувь буюу 828000 хүн ядуу, мөн олон хүн ядуурлын шугамд тун ойрхон байна гэсэн дүгнэлтийг гаргасан байдаг. Мөн

⁸ Агуу-Очираагийн түүхчдийн үзэл 2003, 1997-ийн дэддүгээр хэсэг.

энэ үед Жини коэффициент 0.31 байсан нь орлогын тэгш бус байдал төдийлөн гүнзгий биш боловч их олон хүн ядуу байсныг харуулж байв. Социализмын үе буюу 1980-аад оны сүүлээр ядуурлын талаар ямар нэгэн судалгаа хийгдээгүй учраас ядуурал огт байгаагүй эсвэл тун бага түвшинд байсан гэхэд эргэлзээ төрдөг. Хямрал гүнзгийрч таван жилийн дотор ядуурал огцом нэмэгдсэн нь Монголын хүн амд шилжилтийн үеийн дарамт хүндээр туссаны тод жишээ мөн.

Монголчууд 1990-ээд оны сүүлээр өрсөлдөөн, хувийн хэвшил давамгайлсан эдийн засгийн суурийг бүрдүүлснээр шилжилтийн үеийн хүндрэлийг даван туулж эдийн засгаа тогтворжуулж чадлаа. Мөн хүний хөгжлийн үзүүлэлтүүд аажмаар сайжирсаар 1999 онд 1990 оны түвшиндээ хүрсэн. Гэвч хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлох 1998 оны судалгаагаар нийт хүн амд эзлэх хувийн жин нь ялимгүй буурч 35.6 хувь болсон хэдий ч ядуу хүний тоо нэмэгдэж 850000 хүрсэн байв. Энэ үеэс Монгол Улсад ядуурал нийгмийн хамгийн хүнд, эмзэг асуудал болж зах зээлийн тогтолцооны үед бий болсон эдийн засгийн өсөлт нь ядуурлыг бууруулахад хангалттай биш гэдэг нь илэрхий болсон юм.

Хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлох гурав дахь удаагийн судалгааг зудны дараа буюу 2002-2003 онд явуулж энэ судалгаа Монгол Улсад ядуурлын хямрал гүнзгийрч шийдвэрлэхэд улам бүр хүндрэлтэй болоод байна хэмээн дүгнэсэн юм. Энэ үед ядуурлын түвшин 36.1 хувь болж 1998 оноос бараг өөрчлөгдсөнгүй.⁹ Тэр үеийн хатуу хүйтэн өвөл ядуурлын тархалтыг хөдөө рүү чиглүүлсэн нь гайхах зүйл биш бөгөөд ядуурлын түвшин хөдөөд 43.4 хувь, хотод 30.3 хувь болов. Хэрэв ядуурлын шугамыг 25 хувиар дээшлүүлбэл 2002 онд ядуурлын түвшин 51 хувьд хүрнэ гэсэн тооцоогоор бол олон хүн ядуурлын шугамд ойрхон байсан гэсэн үг.

⁹ *Nadaaadaata doea ganai adaa;ei yeaadae ae aaeaaan odoadaae ai Oji aiui aiueedadaaii o;aoeia oi aia diee i o 1995, 1998, 2002-2003 iiu noadaadaaii a;ia oiidiia iu ooba aduudooada ai ei iae;e ai ei a-yaaayy iy ayeye iu ya oadaui o aiae aaii oelaeey o aie zcz;eyeo p i .*

Шигтгээ 4

“Хот” ба “хөдөө” – албан ёсны тодорхойлолт

Монгол Улсын албан ёсны статистикт тодорхойлсноор “хот” гэдэгт тухайн газрын нутаг дэвсгэрийн хэмжээ болон хөдөө аж ахуйн бус үйл ажиллагааг үндэслэн Улаанбаатар хот, аймгийн төвийн сум болон тооллогын зааварт орсон тосгодыг хамруулна.

Хөдөөд аймгийн төвийн бус сумд, дээрх тосгодоос бусад хөдөөгийн бүх газрыг хамруулна.

ᠶᠳᠠ ᠨᠣᠳᠠᠭᠠ: ҮСГ. 2000 оны хүн ам, орон сууцны тооллого: Үндсэн үр дүн.

Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох бүрэн хэмжээний судалгааны бус тооцоогоор ядуурлын түвшин 2006 онд 32.2 хувь болон буурч ядуурлын ялгаа, гүнзгийрэлт бага зэрэг сайжирсан дүр зурагтай байна. Сүүлийн үед эдийн засаг, нийгмийн хүрээний олон үзүүлэлт, тэр дундаа 2004 оноос эдийн засаг тогтвортой өсч, хүний хөгжлийн индекс нэмэгдэж байгаа боловч хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлох 1995 оны судалгаагаар гарсан 36.3 хувийн ядуурал бараг арван жил хадгалагдаж байгаа нь хамгийн түгшүүртэй үзэгдэл хэвээр байна.

ДНБ-ний өсөлт болон ядуурлыг бууруулах явц хоёрын хоорондын уялдаа ийнхүү сул байгаа нь тодорхой шалтгаантай юм. Нэгд, социалист төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн харилцаанд шилжих үеийн турш тэгш бус байдал гүнзгийрсээр ирсэн. Шилжилтийн үедээ яваа бусад орнуудтай харьцуулахад Монголын орлогын тэгш бус байдал төдийлөн их биш боловч, эдийн засгийн өсөлтийн үр дүнг хүн амын бүлгүүд тэгш хүртэхгүй байгаа нь тодорхой байна. Хоёрт, дээр дурдсаны дагуу шилжилтийн үеийн 15 жилийн турш санхүүгийн нөөц

хязгаарлагдмал байснаас шалтгаалан төр засгийн орлого дахин хуваарилах үүрэг нь алдагдсан юм. Гуравт, мал аж ахуйн үйлдвэрлэлийн өсөлтийг ДНБ-ний тооцоонд оруулахдаа мал сүргийг “дуусаагүй үйлдвэрлэл буюу эргэлтийн хөрөнгө” хэмээн үзэж ирсэн. Өнөөгийн мал сүргийн тархалтыг авч үзвэл олон толгой малтай өрхийн тоо эрс нэмэгдэж байхын зэрэгцээ амьжиргаагаа залгуулахад хүрэлцэхгүй цөөн тооны малтай өрхийн тоо ч олширсоор байна. Дөрөвт, капитал зарцуулалт өндөр байдаг уул уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өсөлт нь хөдөлмөр зарцуулалт ихтэй боловсруулах, үйлчилгээ, хөдөө аж ахуйн салбартай харьцуулахад ядуурлыг бууруулахад үзүүлэх нөлөөлөл нь бага юм. Сүүлийн үед Монгол Улсын эдийн засгийн өсөлт нь ихэвчлэн аж үйлдвэр, тэр дундаа уул уурхайн салбарт бий болсон байна.


Энэхүү илтгэлд Монгол Улсын эдийн засгийн өсөлт нь ядуурлыг бууруулахад шаардлагатай тооны болон чанарын хувьд хангалттай ажлын байр яагаад бий болгохгүй байгаад дүн шинжилгээ хийсэн болно. Мөн илтгэлийн ихэнх бүлэгт эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлт болон ядуурал хоорондын уялдааг судалж бодлогын зөвлөмжийг санал болгов.

1.2.3 Жендэрийн хөгжлийн үзүүлэлтүүд

ХХИ нь хүний хөгжлийн ерөнхий түвшин, төлөв байдлыг илэрхийлдэг үзүүлэлт. Түүний зэрэгцээ жендэрийн тэгш байдлыг хэрхэн хангаж буйг судлах зорилгоор бие даасан хоёр өөр индексийг ашигладаг. Үүний нэг нь жендэрийн хөгжлийн индекс (ЖХИ) юм. Уг индексийн шалгуур үзүүлэлтүүд нь ХХИ-г тооцдог гурван үндсэн үзүүлэлттэй ижил бөгөөд ялгаа нь гэвэл эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдтэй харьцуулан судлах боломж олгодгоороо онцлогтой. Хоёр дахь нь эмэгтэй хүний нийгэмд эзэлж буй байр суурийг эрэгтэй хүнтэй харьцуулан илэрхийлдэг жендэрийн эрх мэдлийн хэмжүүр (ЖЭМХ) юм. Монгол Улс бусад

орнуудтай харьцуулахад ЖХИ-ээр 136 орноос 87-р байр, ЖЭМХ-ээр 76 орноос 65-р байрт тус тус орсныг Дэлхийн хүний хөгжлийн 2006 оны илтгэлд дурдсан байна.

Дүрслэл 1.1 Хүний хөгжлийн үзүүлэлтүүд, ХХИ, ЖХИ, ЖЭМХ, Монгол Улс, 2000–2006



Үд *hóðààéce*: 2007 оны Монголын хүний хөгжлийн илтгэлд зориулсан тооцоо.

Монголын ЖХИ 2006 оны байдлаар 0.719 байна гэсэн тооцоо гарсан бөгөөд энэ нь тухайн жилийн ХХИ-тэй яг ижил түвшинд байна (Дүрслэл 1.1). Энэ нь Монгол улсад эмэгтэй хүнийг ялгаварлан гадуурхах явдал анхаарал татсан асуудал биш мэт сэтгэгдэл төрүүлнэ. Үүнийг хөгжиж буй болон дунд зэргийн орлоготой бусад улстай харьцуулахад Монголд жендэрийн асуудал тийм ч хурц асуудал биш гэдэгт эргэлзэх хэрэггүй боловч энэ нь тийм ч чамбай үзүүлэлт хараахан бишээ.

ЖХИ-ийг тооцоход ашигладаг гурван үзүүлэлтийг тус тусад нь авч үзвэл эмэгтэйчүүд зарим талаараа эрэгтэйчүүдээс дутуу зарим талаараа давуу байдалтай харагддаг. Тухайлбал, Монгол эрэгтэй хүний дундаж наслалт 62.6 жил байхад эмэгтэйчүүдийнх 69.4 жил; 7-22 насандаа сургуульд хамрагдаж буй эмэгтэйчүүд 83.2 хувь байхад эрэгтэйчүүд 75.5 хувьтай байна; худалдан авах чадварын паритетийн коэффициентээр тооцсон нэг хүнд ногдох үндэсний орлогын хэмжээ

эрэгтэйчүүдэд 3045.6 америк доллар, эмэгтэйчүүдэд 2611.4 америк доллар байна. Эмэгтэйчүүд нийгмийн байдлын зарим гол үзүүлэлтээрээ эрэгтэйчүүдтэй харьцуулахад давуу боловч эдийн засгийн хүрээнд хоцрох хандлагатай байна.

Эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль нь илүү ядууралд өртсөн байгааг харуулах тоо, баримт мэдээлэл ховор байдаг ч амьжиргааны түвшний 2002-2003 оны судалгаагаар эмэгтэйчүүдийн тэргүүлсэн өрхүүд ихэнхдээ ядуу гэсэн дүгнэлт гарчээ. Нийт ядуу өрхийн 43.8 хувь нь эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байхад 34.8 хувь нь эрэгтэй тэргүүлэгчтэй байв. Өрхийн тэргүүлэгч нь хэн байгаагаас хамааран ядуурлын түвшин нэлээд их ялгаатай байх явдал нэн ялангуяа хот суурин газарт илүүтэй ажиглагджээ. Үүний зэрэгцээ тухайн өрхийн амьдралын хэвийн нөхцөл, наад захын хэрэгцээг хангах зорилгоор эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү олон цагийг гэр орны ажилд зарцуулж байна.¹⁰

Хүснэгт 1.6 Ядуурлын байдал, өрхийн тэргүүлэгчийн хүйс, байршлаар, Монгол Улс, 2002-2003

	Эрэгтэй	Эмэгтэй
Ядуурлын хамралтын хүрээ		
Хот	27.9	41.6
Хөдөө	42.8	48.4
Улсын дундаж	34.8	43.8
Хүн амд эзлэх хувь		
Хот	82.5	17.5
Хөдөө	89.9	10.1
Улсын дундаж	85.8	14.2
Ядуу хүн амд эзлэх хувь		
Хот	75.9	24.1
Хөдөө	88.7	11.3
Улсын дундаж	82.8	17.2

ᠶᠣ нᠣᠪᠠᠭᠠᠭ᠎ᠠ :УСГ, ДБ, НҮБХХ. ӨЗОАТС 2002-2003.

Жендерийн эрх мэдлийн хэмжүүр (ЖЭМХ) 0.42 байгаа нь эдийн засаг, улс төрийн хүрээ болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй байгааг илэрхийлнэ. Албан ёсны

¹⁰ᠣᠷᠠᠨᠢᠨᠭᠡᠢᠰᠢ ᠶᠣᠳᠡᠳᠡᠨ ᠠᠶᠢᠯᠢᠳᠡᠨ ᠶᠢᠵᠡᠨ ᠠᠶᠢᠯᠢᠳᠡᠨ ᠠᠶᠢᠯᠢᠳᠡᠨ ᠠᠶᠢᠯᠢᠳᠡᠨ ᠠᠶᠢᠯᠢᠳᠡᠨ ᠠᠶᠢᠯᠢᠳᠡᠨ 4-᠔ ᠠᠶᠢᠯᠢᠳᠡᠨ ᠠᠶᠢᠯᠢᠳᠡᠨ ᠠᠶᠢᠯᠢᠳᠡᠨ ᠠᠶᠢᠯᠢᠳᠡᠨ ᠠᠶᠢᠯᠢᠳᠡᠨ ᠠᠶᠢᠯᠢᠳᠡᠨ ᠠᠶᠢᠯᠢᠳᠡᠨ.

хөдөлмөр эрхлэлтэд эмэгтэйчүүдийн оролцоо харьцангуй өндөр байдаг ч УИХ-д сонгогдсон эмэгтэйчүүд 1990 онд 25 хувь байсан бол 2000 онд 12 хувь, 2004 онд 7 хувь болж тус тус буурсан бөгөөд энэ хандлага шийдвэр гаргах бүх түвшинд үндсэндээ адил байна. 1992 оны Үндсэн хуулиар эмэгтэйчүүдийн тэгш эрх баталгаажсан боловч шийдвэр гаргах явцад тэдгээрийн оролцоо хязгаарлагдмал байсаар байна. Энэхүү байдлыг харгалзан үзэж Улсын Их Хуралд (УИХ) нэр дэвшиж буй эмэгтэйчүүдийн хувийн жинг 2008 онд 20 хувь, 2012 онд 35 хувьд тус тус хүргэхээр УИХ-аас Монгол Улсын МХЗ-уудыг баталсан тогтоолдоо зорилт болгон дэвшүүлжээ. Мөн 2005 онд шинэчлэн баталсан Сонгуулийн тухай хуулиар тухайн улс төрийн намаас нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байхаар заажээ. Гэсэн хэдий ч уг хуулийн өөрчлөлтийг хэрэгжиж эхлэхээс өмнө буюу 2007 оны 12 дугаар сард энэ заалтыг УИХ-аас хүчингүй болгосон.

Цалингийн хэмжээ, хөдөлмөр эрхлэх нөхцөл, ялангуяа цалингүй ажлын ачаалал зэрэг үзүүлэлтээр эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хувьд нэлээд ялгаа байгаа бөгөөд¹¹ энэ талаар илтгэлийн 4 дүгээр бүлэгт дэлгэрэнгүй авч үзэх болно.

1.2.4 Хүний хөгжлийн ялгаа: Бүс хоорондын ялгаа, хотын доторх болон хот, хөдөөгийн тэгш бус байдал


Монголын хүний хөгжлийн ерөнхий индекс сүүлийн жилүүдэд өсч байгаа боловч хүн амын бүлэг, бүсүүдийн хооронд, хот доторх болон хот, хөдөөгийн ялгаа нэмэгдсээр ирсэн. Гэхдээ бүсийн түвшинд, бүс хоорондын ялгаа багассан нь нааштай хандлага мөн. Газар зүйн байршлын хувьд ХХИ – ийн өсөлт томоохон бүс нутгуудыг хамарч байгаа бөгөөд нийт улсын хэмжээнд ч мэдэгдэхүйц сайжирч байна.

Бүс хоорондын хүний хөгжлийн ялгаа багасч байгаа боловч улсын хэмжээнд

¹¹ᠠᠳᠠ, ᠠᠠ. ᠢ ᠨᠢᠢ ᠰᠡ ᠣᠪᠨ ᠠᠶᠢᠨ ᠡᠮᠡᠮᠡᠨ ᠶᠢᠵᠡᠨ ᠶᠢᠵᠡᠨ ᠠᠶᠢᠯᠢᠳᠡᠨ ᠠᠶᠢᠯᠢᠳᠡᠨ ᠠᠶᠢᠯᠢᠳᠡᠨ 2005.

хотоос алслагдсан зай, босоо У тэнхлэг тухайн бүсийн ядуурлын шугамаас доогуур амьдарч буй хүн амын хувийн жинг илэрхийлнэ. Нийслэл хотоос алслагдах тусам ядуу хүний хувийн жин өндөр байгаа дүр зураг харагдаж байна. Харин дүрслэлд байгаа бөмбөлөгийн хэмжээ тухайн бүсийн хүн амын тоог илэрхийлж байгаа болно.

Дүрслэл 1.2 Ядуурлын түвшин, Улаанбаатар хотоос алслагдалт, бүс нутгаар, Монгол Улс, 2002-2003



ᠶᠡᠨ ᠯᠡᠭᠡᠭᠡᠭᠡ : ᠤᠰᠭ, ᠳᠦ, ᠨᠤᠪᠦᠬᠡ, ᠡ᠋᠋᠋᠋᠋᠋ 2002-2003.

Ядуурлын талаар хийсэн өмнөх судалгааны дүнг хот, хөдөөгийн байдлаар шууд харьцуулах боломжгүй боловч ядуурлын тархалтын ерөнхий хандлага нь хот, хөдөөгийн эдийн засгийн хөгжлийн ерөнхий дүр зурагтай уялдаатай байгаа юм. Социализмын үед улсаас их хэмжээний татаас авч байсан газар тариалан, боловсруулах үйлдвэрлэл, төрийн өмчит үйлдвэр, аж ахуйн газрууд шилжилтийн эхний жилүүдэд олноороо хаагдаж, тэдгээрийн оронд хүн амын орлогын шинэ үүсвэр бий болохгүй удааширнаас хотын хүн ам, тэр дундаа аймгийн төвийн оршин суугчид эдийн засгийн хямралд нэрвэгдсэн юм. Энэ хямрал 1991-1997 оны хооронд хот, суурин газарт инфляцийн өндөр өсөлт, хүнсний бараа, бүтээгдэхүүний хомсдол зэргийг дагалдуулж, хүн амын амьжиргааг

улам доройтуулж байсан. Улаанбаатар хотын хүн ам шилжилтийн үед (1992-1993 оноос бусад) байнга өсч ирсэний зэрэгцээ аймгийн төв, суурин газрын хүн амын тоо буурсан юм (Хавсралт дахь Дүрслэл 1.1-ээс үзнэ үү). Ялангуяа газар тариалангийн аж ахуй эрхэлдэг Сэлэнгэ зэрэг аймагт суурин газрын хүн амын хувийн жин 1989 онд 53.7 хувь байснаа 2006 онд 33.2 хувь болтлоо буурав.

Өөрчлөлтийн ийм хандлагаас улбаалан хот доторх ядуурлын байдал улам гүнзгийрэв. Хөдөөд амьдарч буй хүмүүс амиа аргацаах наад захын боломжтой байсан бол хот, суурин газарт ажил эрхэлдэггүй хүмүүс амьдрах боломж тун хомс болжээ. Чухам энэ үеэс эхлэн хот, суурин газарт ядуурал түргэн газар авч эхэлсэн гэж үзэж болох юм. Хөдөөгийн айл өрхүүд мал, мах болон хөдөө аж ахуйн бусад бүтээгдэхүүнээ хотод амьдарч буй хамаатан садан, найз нөхөд рүүгээ илгээж амьдралаа залгуулах явдал түгээмэл байлаа. 2000-2002 оны хооронд жил дараалан хатуу өвөл, зуд турхан болсноор 11,2 сая мал хорогдож хөдөөгийн хүн амын амьдрал маш их хүндэрсэн. Ийнхүү олон сая мал хорогдож хөдөө дэх ядуурлыг нэмэгдүүлсэн боловч хот, суурин газарт үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжснөөр хотын доторх ядуурлыг бага боловч бууруулж, улмаар Монголын ядуурлын тархалт өөрчлөгдөв.

1.3 ᠶᠡᠨ ᠯᠡᠭᠡᠭᠡᠭᠡ ᠡ᠋᠋᠋᠋᠋᠋ ᠶᠡᠨ ᠯᠡᠭᠡᠭᠡᠭᠡᠭᠡ ᠶᠡᠨ ᠯᠡᠭᠡᠭᠡᠭᠡᠭᠡ

Монгол Улс хүний хөгжлийг хангах бодлогынхоо хүрээнд Мянганы хөгжлийн зорилт (МХЗ)-ыг батлан хэрэгжүүлж байна. Монгол Улсын Их Хурал Мянганы хөгжлийн найман үндсэн зорилго дээр хүний эрхийг хамгаалах, ардчилсан засаглалыг бэхжүүлэх тухай ес дэх зорилгыг нэмж баталсан тухай өмнө дурдсан билээ. 2015 он гэхэд хүрэхээр төлөвлөсөн 22 зорилтоос эх, нялхсын эндэгдэл, жендэрийн тэгш байдлыг хангах зэрэг хэд хэдэн зорилт биелэх боломжтой байна.

Монгол Улсын МХЗ-ын хэрэгжилтийн талаарх үндэсний 2 дахь илтгэлд зорилтуудын хэрэгжилтийг дараах байдлаар гаргасан байна. Үүнд:

1. **ÌŒÇ-ââ ðàíààð ðçâøèü “ýðð ðçðñý” ççççëýëð:**

- Ерөнхий боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа;
- Улаан бурхны эсрэг вакцинжуулалтад хамрагдсан хүүхдийн хувь;
- Нялхсын эндэгдлийн түвшин;
- Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин;

2. **ÌŒÇ-ââ ðàíààð “âí èí îøò íé” ççççëýëð:**

- Тураалтай хүүхдийн хувь;
- Бага боловсрол эзэмшиж байгаа охид хөвгүүдийн тооны харьцаа;
- Их Хуралд нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн хувь
- Эхийн эндэгдлийн түвшин;
- Эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь
- Сүрьеэ өвчнөөс шалтгаалсан нас баралтын хувь
- Оношлогоо, эмчилгээний олон улсын стандартын хүрээнд илрүүлж, эмчилсэн сүрьеэгийн тохиолдлын хувь¹³
- Нэг хүнд ногдох нүүрс хүчлийн давхар исэл;
- Улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн эзлэх хувь;
- Баталгаат эх үүсвэрээс ус хэрэглэж байгаа хүн амын хувь;

3. **ÌŒÇ-âí ðýðýâøèëð “ðâââí” ççççëýëð:**

- Ядуурлын түвшин;
- Дээд боловсрол эзэмшиж байгаа эмэгтэй, эрэгтэйчүүдийн тооны харьцаа;
- Эрүүл ахуйн шаардлага хангахуйц нөхцөлд амьдарч байгаа хүн амын эзлэх хувь;

4. **ÌŒÇ-âí ñí ðçðñý ðçâøèý ñ “ðââðñâí” ççççëýëð:**

- Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин;

- Нэгдүгээр ангид элсэн ороод 5 дугаар анги хүртэл суралцагчдын хувь;
- 15-24 насны залуусын бичиг үсэг тайлагдалтын хувь;
- ХАА-аас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь;
- Их Хуралд сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь;
- Сүрьеэ өвчний тархалт;
- Ойт нутгийн эзлэх хувь;

Хэрэгжилт ийнхүү жигд биш байгаа нь МХЗ-д хүрэх явцад Монгол Улс багагүй бэрхшээлтэй тулгарч байгааг илэрхийлнэ. МХЗ-ын хэрэгжилтийн талаарх үндэсний 2 дахь илтгэлд ядуурлын түвшин буурах явц удааширч байгаад дүн шинжилгээ хийгээд амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур хүн амын тоог 50 хувь, нэн ядуу иргэдийн тоог 25 хувиар тус тус бууруулах зорилт биелэгдэхэд бэрхшээлтэй байгааг дурджээ. Одоо явагдаж байгаа амьжиргааны түвшний 2007 оны судалгааны үр дүн МХЗ-ын нэгдүгээр зорилтын талаар үнэлгээ өгөхөд чухал ач холбогдолтой болно хэмээн найдаж байна. Судалгааны дүнгээр нааштай хандлага гарлаа ч гэсэн дээрх зорилтыг биелүүлэхэд бодит бэрхшээл бий. Энэ зорилтыг бүрэн хэрэгжүүлэхийн тулд ядуу хүний тоог дараагийн арван жилийн турш жил бүр дунджаар 6.7 хувиар бууруулах шаардлага гарна. Эдийн засгийн өсөлт ядуурлыг бууруулахад гол нөлөө үзүүлнэ гэж үзвэл дараагийн арван жилд эдийн засаг 9-10 хувиар тогтвортойгоор өсөх ёстой. Монгол Улсад тэгш бус байдал газар авсанаас үүдэн эдийн засгийн өсөлт ядуурлыг бууруулахад олигтой нөлөөлөхгүй байгааг ч энд дахин дурдах хэрэгтэй.

1.4 Çîðèñð íé ð'â'èì'ð ýððëýëð àà ðçìèè ð'â'èëë

Хүний хөгжилд зохистой хөдөлмөр эрхлэлт чухал байр суурь эзэлдэг тухай дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн билээ. Зохистой хөдөлмөр нь орлогыг нэмэгдүүлээд зогсохгүй нэр төртэй, сэтгэл хангалуун амьдрахын суурь болдог.

¹³ ñíøè ìâí, ý í-èèâýýèè í èí ð èíüí ñò àíààð ð àýàýâ ìü ýìèè ð òí àçðèèâ ýíý ýýâèè àæèèòü ðýìàèð àâ ðýðýâøè àóðó “Œóðâ ðýìàèð àìð ý í-èý ð ñòðàðââè” þ í.

Ажилдаа сэтгэл хангалуун яваа эмэгтэй, эрэгтэй хэн ч ялгаагүй амьдралдаа өөдрөг хандаж чадавхиа байнга дээшлүүлж байдаг. Сайхан амьдралын үндэс суурь болсон эрүүл аж төрөх, сурч боловсрох эрхийн нэгэн адил зохистой хөдөлмөр эрхлэх нь ч хүний эрхийн нэн чухал ойлголт мөн.

Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар ядуурлыг бууруулах бодлого хэрэгжүүлэхийн тулд хүний чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих нь чухал. Ингэснээр хүний хөгжлийн урьдчилсан нөхцөл бүрдэж, тухайн хүн баялагийг бүтээхэд оролцохын хэрээр хөгжлийн явц даган гарч ирж буй боломжийг аль болох бүрэн дүүрэн ашиглах болно. Хэдийгээр эдийн засаг огцом сайжирсан ч ядуу болон эмзэг бүлгийн хүмүүс эрүүл байж, зохих боловсрол эзэмшээгүй тохиолдолд ядуурлаас гарах магадлал багатай байна. Эдийн засаг, нийгмийн салбарт хувийн хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа боловч Монгол Улсын хөгжлийн өнөөгийн нөхцөлд анхан шатны боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн суурь үйлчилгээг нийт хүн ам, тэр дундаа ядуу болон бага орлоготой иргэдэд хүртээмжтэй болгоход зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийн ихэнхийг төр хариуцан санхүүжүүлэх шаардлагатай. Боловсрол, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг ядуучууд олноор оршин суудаг газарт чиглүүлж бодлоготой нэмэгдүүлснээр ядуурлыг бууруулж, тэдгээрийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, оруулах хувь нэмрийг өргөжүүлэхийн зэрэгцээ ажиллах хүчийг нэмэгдүүлж улмаар эдийн засгийн үр өгөөжийг ч дээшлүүлэх болно.

Сүүлийн жилүүдэд гарсан эдийн засгийн огцом өсөлтийг Монголын хүний хөгжил, ялангуяа боловсролын салбар төдийлөн гүйцэхгүй байгаа нь анхаарал хандуулах асуудал мөн. Төр засгаас энэ чиглэлээр тодорхой бодлого боловсруулан хэрэгжүүлэх шаардлага ч бий. Тухайлбал, Үндэсний статистикийн газраас зохион байгуулсан сургуулиас ажилд шилжигсдийн талаарх 2006 оны

судалгаагаар 15-29 насны залуучуудын 3.3 хувь нь анхан шатны сургуулиа дүүргээгүй бөгөөд хөдөөд энэ үзүүлэлт 6.4 хувьтай байв. Улсын нийт дүнгээр охидоосоо (2.1 хувь) бараг 2 дахин олон хөвгүүд (4.6 хувь) анхан шатны боловсрол бүрэн эзэмшдэггүй байна.

Сургууль завсардаж буй хүүхдүүд ихэнхдээ ажилчин-хүүхэд болж хувирах эрсдэл өндөр, хүүхэд насны хэвийн амьдралыг эдлэхгүй, ирээдүйдээ бүтээлч ажиллах хүч, чадавхигүй болж байгаа нь үе дамжсан ядуурлыг үүсгэх аюултай юм. Мянганы хөгжлийн зорилтын хэрэгжилтийн Үндэсний хоёр дахь илтгэлд 5-р ангиа төгсөж буй хүүхдийн тоо буурч байгааг тэмдэглэжээ. Мөн Үндэсний статистикийн газрын мэдээгээр 2006 онд сургууль завсардалтын хувь ч нэмэгдсэн байна.

Хөдөөд ядуурал их байгаа учраас хүүхэд гэр орны ажилд туслах, мал маллахад оролцох зэрэг аар саар ажил хийдэг, түүнчлэн хот, суурин газар ба хөдөөгийн сургуулийн сурах орчин ялгаатай зэрэг хүчин зүйлээс шалтгаалан хөдөөд сургууль засвардалтын хувь өндөр байдаг. Сурагчдын сурлагын дүнг ядуурлын түвшинтэй харьцуулан үзэхэд сумын сургуулийн сурагчийн дүн аймгийн төвийнхөөс сул, тухайн сумын өрх ядуу байх тусам хүүхдийн сурлага мууддаг хандлага ажиглагдаж байна.¹⁴

Хөдөөгийн эрүүл мэндийн салбарт ч мөн иймэрхүү бэрхшээл байсаар ирлээ. Ихэнх эмч, эмнэлэг нь томоохон хот, суурин газар болон аймгийн төвд байрладаг. Сум болон багийн эмнэлгүүд хөрөнгө, нөөцийн хомсдлоос шалтгаалан алслагдсан газар оршин суудаг иргэдэд чанартай үйлчилгээ хүргэж чаддаггүй байна. Тухайлбал, 2001 онд 15 аймгийн 44 суманд их эмч огт байхгүй, 19 аймгийн 77 суманд их эмчийн тоо хангалтгүй тухай мэдээ бий. Нийт сумын түргэн тусламжийн үйлчилгээний 35 хувь болон нийт аймгийн түргэн тусламжийн үйлчилгээний 39 хувь

¹⁴ Агуудэеи ааге. I тит е аади яаооооуи зйеауу. Огееаи ' 35660-Мий, 2006 ии 4-д нэдди 13, ба ооооуа оооооооо, үадеи чанааеи иааи аеаио . Сззззз Асэ, йи ио ии ааэ аеи азн. д. 41.

нь улсын хэмжээнд тавигддаг стандартад хүрдэггүйн зэрэгцээ унаа тэрэг, тоног төхөөрөмж нь үйлчилгээнээс хасагдсан байдаг.¹⁵ Хөдөөгийн ядуу иргэд эмнэлэгийн үйлчилгээ сайтай хот, суурин газарт хүрч эмчлүүлэх бололцоогүй учраас чанартай үйлчилгээнд хамрагдаж чаддаггүй байна. (Шигтгээ 5-ийг үзнэ үү).

Шигтгээ 5

Эрүүл мэндийн найдвартай үйлчилгээг хүртэх бололцоо орон нутгийн ядуу иргэдэд туйлын хомс байна

“Эмнэлгийн үйлчилгээ шаардлагатай болсон тохиолдолд хамгийн түрүүнд багийн сувилагчид ханддаг. Сувилагчийг гэртээ авч ирэхийн тулд мориор дор хаяж 1-2 цаг явах хэрэг гардаг. Багийн сувилагчид унаа машин байхгүй учраас мориороо хамт явах шаардлагатай болно. Сувилагчийн гаргасан оношоос шалтгаалан хэрвээ сумын төвөөс яаралтай эмнэлгийн үйлчилгээ шаардлагатай тохиолдолд сумын төв хүртэл мориор дахиад 4 цаг орчим явах хэрэгтэй болдог. Ингэсээр байтал өвчтөний байдал дордох ч үе гарна. Багийн сувилагч албан ёсны дуудлагын захиалга гаргаж өгөөгүй тохиолдолд сумын төвөөс үйлчилгээ ирэхгүй. Энэ тохиолдолд сумын түргэн тусламжийн үйлчилгээг авна гэвэл өвчтөний гэр бүл хоёр талын тээврийн зардлыг хариуцах хэрэгтэй болдог.”

ᠶᠣ ᠨᠣᠳᠠᠭᠠᠭᠠᠨ: ҮСГ, ДБ. 2001.
Амьжиргааны түвшинг оролцооны аргаар тодорхойлох судалгаа

Хүний хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалт нь хот, хөдөөгийн ялгааг багасгах гол нөхцөл болохын зэрэгцээ хотын гэр хороолол, тэр дундаа Улаанбаатар хотын захын өрхөд тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм. Хотын ядуурал, шилжих

хөдөлгөөний талаарх 2004 оны судалгааны тайланд гэрт амьдардаг өрхийн иргэд болон орон сууцны өрхийн иргэдийн хооронд нэлээд ялгаа байгааг цохон тэмдэглэжээ. Тухайлбал:

- Гэрт амьдардаг иргэдийн 47 хувь нь ядуу байхад орон сууцанд амьдарч буй иргэдийн 16 хувь нь ядуу байна,
- Улаанбаатар хотын 7-18 насны сургууль завсардсан хүүхдийн 86 хувь нь гэр хорооллын хүүхэд байна. Хүүхдийн насны бүлэг бүрээр орон сууцанд амьдарч буй хүүхдийн сургуульд хамрагдалт гэр хорооллынхоос илүү өндөр байна.
- Орон сууцтай харьцуулахад гэр хорооллын оршин суугчид баталгаагүй ундны ус хэрэглэх нь 30 дахин их бөгөөд гэр хорооллын бараг бүх оршин суугчид (97 хувь) гадаа жорлон ашиглаж байна.¹⁶

НҮБ-ын Хүн амын нутагшил суурьшлын хөтөлбөрөөс¹⁷ 2007 оны 9-р сард хийсэн судалгаагаар Улаанбаатар хотын гэр хорооллын нутаг дэвсгэр тэлж нийслэлийн хүн амын 50 гаруй хувь нь гэр хороололд амьдарч байна гэжээ. Гэтэл улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүдэд задлан шинжилгээ хийж үзэхэд гэр хороолол дахь дэд бүтэц, суурь үйлчилгээг хөгжүүлэхэд зориулсан хөрөнгө оруулалтын хэмжээ өчүүхэн хэвээр байна.

Монгол Улсын 2008 оны төсөвт эрүүл мэнд, боловсролын салбарт зарцуулах хөрөнгийн хэмжээ үлэмж нэмэгдсэнийг харахад сайшаалтай боловч түүнийг үнэхээр шаардлагатай газарт нь хүргэж ашиглах талаар анхаарах шаардлагатай. Юуны өмнө хөдөө, хотын хамгийн ядуу хэсэг, төлбөрийн чадвар муутай хүн ам, тэр дундаа нэн ядуу иргэдэд наад захын үйлчилгээг хүргэхийг анхаарах нь чухал. Хүний хөгжилд чиглэсэн улсын хөрөнгө оруулалтыг тогтвортой нэмэгдүүлэхгүйгээр тэгш бус байдал гүнзгийрэх, ядуу

¹⁶ᠶᠢᠲᠠᠢ ᠡ ᠣᠡᠨᠢ ᠴᠠᠨᠠᠳᠡᠢ ᠠᠳᠴᠠᠳ, ᠮᠤᠮᠤᠨᠢ ᠣᠡᠭᠡᠳᠡᠢ ᠰᠣᠳᠣᠭ ᠠᠳᠣ, ᠣᠠᠨᠨᠢ 2004. ᠣᠳᠣᠢ ᠶᠠ ᠣᠳᠠᠭ ᠠᠳ ᠣᠳᠡᠭᠡᠳ ᠰᠣᠡᠭᠡᠳᠣᠨ ᠨ ᠣᠠᠳᠡᠳᠠᠳ.

¹⁷ᠮᠤᠮᠤᠨᠢ ᠣᠲᠣᠢ ᠠᠨᠢ ᠢᠳᠣ ᠠᠡᠭᠡᠳᠡᠢ ᠨᠣᠳᠣᠨᠢ ᠰᠣᠳᠣᠭ ᠠᠳᠣ. 2007. ᠣᠡᠳᠠᠢᠳᠠᠳᠠᠳ ᠠᠳ ᠰᠣᠳᠣᠢ ᠠᠶᠢᠳ ᠰᠣᠳᠣᠢ ᠡᠭᠢᠠ ᠰᠣᠡᠭᠡᠳᠣᠨ ᠰᠣᠳᠣᠳᠠᠳᠠᠳᠡᠢ ᠰᠣᠨᠢᠭᠡ, ᠣᠳᠡᠳᠣᠡ ᠠ, ᠪᠢᠨ ᠣ ᠡᠨ.

¹⁵ᠮᠤᠮᠤᠨᠢ ᠣᠳᠣᠢ ᠡᠭᠡᠳᠡᠢ.

хүний тоо нэмэгдэх хандлагыг өөрчлөх боломжгүй юм.

Хоёр дахь зөвлөмж

Хүний хөгжилд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх талаар

- Боловсрол, эрүүл мэнд, эрүүл ахуй, усан хангамж зэрэг төрийн наад захын суурь үйлчилгээний хот, хөдөөгийн ялгааг багасгах;
- Хотын төв, хотын захад оршин суугчдад үзүүлж буй төрийн үйлчилгээний ялгааг багасгах;
- Төрийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа ядуу иргэд, тэр дундаа хөдөө, хотын захын гэр хороололд оршин суугч иргэдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, төрөл бүрийн сургалт болон ажил хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр үзүүлж буй төрийн үйлчилгээний хамрах хүрээг өргөтгөх;
- Эрүүл мэнд, боловсрол зэрэг төрийн суурь үйлчилгээний хураамж шимтгэлийг төлөхөд ядуу иргэдийн хувьд хөнгөлөлт үзүүлэх журам тогтоох, улмаар чөлөөлөх;
- Нийгмийн салбарт, түүний дотор техник мэргэжлийн боловсрол, сургалтын чиглэлээр оруулах төсвийн хөрөнгө оруулалтыг үргэлжлүүлэн нэмэгдүүлэх зэрэг болно;

1.5 ᠋᠋᠋᠋᠋ ᠋᠋᠋᠋ ᠋᠋᠋ ᠋᠋: ᠋᠋ ᠋᠋᠋᠋᠋ ᠋᠋᠋᠋᠋ ᠋᠋᠋᠋᠋᠋ ᠋᠋᠋ ᠋᠋᠋᠋᠋᠋᠋ ᠋᠋᠋᠋᠋᠋᠋ ᠋᠋᠋ ᠋᠋᠋᠋᠋᠋᠋᠋ ᠋᠋

Ядуурлыг бууруулах талаар дэвшүүлсэн Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд эдийн засгийн өсөлтийн ядууралд үзүүлэх үр нөлөө, мэдрэмжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийн чиг хандлагыг өөрчлөхөд Засгийн газар анхаарлаа хандуулах хэрэгтэй байна. Иймээс эдийн засгийн өсөлтийг түргэтгэх бодлогыг

баримтлахын зэрэгцээ ядууст чиглэсэн өсөлтийг дэмжих стратегийг тууштай хэрэгжүүлэх нь чухал юм. Ядуу хүмүүс хөдөлмөрөө үнэлүүлэх замаар өөрийнхөө амьжиргааг дэмждэг байхын тулд тэдэнд чиглэсэн бодлого нь ядуучуудад ажил эрхлэх боломжийг нь бүрдүүлж, цалин хөлс, урамшуулал бүхий ажлын байр бий болгоход тусгайлан анхаарах ёстой. Өөрөөр хэлбэл, хөдөлмөр эрхлэлт нь эдийн засгийн өсөлт болон ядуурлыг бууруулах хоёрын хоорондын уялдааг хангах гол арга зам болох учиртай. Мянганы хөгжлийн нэг дүгээр зорилгын хүрээнд зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжихийг нэгэн зорилт болгон дэвшүүлсэн нь бүтээлч хөдөлмөр эрхлэх боломжийг хүн бүрт олгох явдал бөгөөд энэ нь дэлхий нийтийн ядуурлыг бууруулах зорилгын нэгэн гол бүрэлдэхүүн хэсэг мөн.

Эдийн засгийн өсөлтийн үр дүнг Монголын аль болох олон хүн ам хүртэх боломжийг бүрдүүлэхийн тулд юу хийх ёстой вэ? Эдийн засгийн өсөлт болон ядуурлыг бууруулах үйл ажиллагааны уялдааг хангах үндсэн гурван хүчин зүйл байдаг талаар доктор С. Р. Османи судалгааны дүгнэлтэндээ дурдсан байдаг. Өөрөөр хэлбэл, энэхүү уялдааг бэхжүүлэхэд өсөлт, мэдрэмж, нийлэмжийн хүчин зүйл нөлөөлдөг байна.¹⁸ Өсөлтийн хүчин зүйл нь эдийн засаг өсөх ёстой, харин мэдрэмжийн хүчин зүйл бол энэхүү өсөлтийн явц нь тооны болон чанарын хувьд хангалттай ажлын байрыг бий болгож буй эсэхийг харуулна. Харин нийлэмжийн хүчин зүйл нь ядуучуудын хичнээн хувь нь эдийн засгийн өсөлттэй хөл нийлүүлэн алхаж чадаж буйг илэрхийлнэ.

Өнөөдөр Монгол Улс эдийн засгийн өсөлтийн эрэлтээ үндсэндээ хангаж ирээдүйд тогтвортой хадгалах хандлагатай болов. Харин мэдрэмж, нийлэмжийн хүчин зүйлийн хувьд бодлого боловсруулах явцад хөдөлмөр эрхлэлттэй холбоотой дараах дөрвөн үндсэн асуудлыг нарийвчлан авч үзэх шаардлагатай байна. Эдгээр нь:

¹⁸Iti eui ieeai eouai o aadaado ayeyoyia,je noaaeaaaaItiaie, 2006 zcye a i eii.

1. Шинээр бий болсон ажлын байр – Ажиллах хүчинд анх удаа шилжиж буй, одоогоор ажилгүй болон бүрэн бус хөдөлмөр эрхэлж буй, хөдөөнөөс хот руу шилжин суурьшиж буй хүн амд хангалттай хүрэлцэхүйц ажлын байр бий болсон уу?
2. Шинээр бий болсон ажлын байрны чанар – Ядуу хүний хувьд эдгээр ажлын байр нь ядуурлаас найдвартай гарах арга зам болж чадсан уу? Авч буй бодит цалингийн хэмжээ нь ажиллагчид болон тэдгээрийн гэр бүлийнхний хувьд зохистой амьжиргааг хангаж чадах уу?
3. Шинэ ажлын байрны байршил – Ажил хайж буй, тэр дундаа ядуу хүмүүсийн ажил хайж буй газарт ажлын байр шинээр бий болж чадсан уу?
4. Бүтээмж өндөртөй ажил эрхэлж буй хөдөлмөрийн насны хүн амын чадавхи бий болсон боломжийг ашиглах, түүнд тохирсон мэдлэг, туршлага, ур чадварыг эзэмшсэн эсэх, эрүүл мэндийн байдал нь тохирч байгаа эсэх зэрэг асуудлууд болно.

Засгийн газар хөдөлмөр эрхлэлтээр дамжуулан ядуурлыг бууруулахыг эрмэлзэж байгаа бол төсөв, төрийн бодлогыг уг асуудалд чиглүүлэн өөрчлөх бодлого, эрх зүйн үндсэн нөхцөл нь бүрдсэн байна. Үүнийг бодит ажил болгохын тулд 2001 онд батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль болон 2007 оны шинэчлэн найруулсан хууль, 2002 онд батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр болон Зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөө (2005-2008) зэрэг баримт бичгийг нягтлан ажил хэрэг болгох шаардлагатай байна. Ер нь

төр засгийн бодлого, тэр дундаа ажлын байрыг бий болгох, зохистой хөдөлмөр эрхлэх талаар дэвшүүлж буй зорилт нь хүн амын амьжиргаанд эерэг нөлөө үзүүлдэг. Олон улсын туршлагааас үзэхэд бодлогын дэмжлэг ихээхэн чухал байдаг. Монгол Улсын төсвийн байдал, эдийн засаг цаашдаа өсөх төлөв ажиглагдаж байгаа зэрэг нь бодлого боловсруулагчдад бодлогын сонголт хийх талаар таван жилийн өмнө байгаагүй асар өргөн боломжийг олгоод байна.

Шигтгээ 6

Зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөө (2005 – 2008)

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Монголын ажил олгогч эздийн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооноос зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөг 2005 онд баталсан. Энэхүү төлөвлөгөөнд зохистой хөдөлмөр эрхлэлтээс гарах үр дүн, түүний санхүүжилт болон хэмжих үзүүлэлтүүдийг тодорхойлжээ. Үүнд:

1. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллыг сайжруулахын тулд хүний үндсэн эрх, хөдөлмөрлөх эрхийг баталгаажуулах,
2. Бүх салбарт ажлын байр, орлогыг нэмэгдүүлэх,
3. Нийгмийн даатгалын тогтолцоог хэрэгжүүлэх,
4. Олон нийтийн хэлэлцүүлэг явуулах механизмыг боловсронгуй болгох.


Үд ноддддддд: Монгол Улсын Засгийн газар. 2005. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөө



БҮЛЭГ

2

**Хүний хөгжил, хөдөлмөр
эрхлэлт хоёрыг холбогч гүүр
нь ажиллах чадвар мөн**



Хүний хөгжил, хөдөлмөр эрхлэлт хоёрыг холбогч гүүр нь ажиллах чадвар мөн

Эмэгтэй, эрэгтэй хэн ч ялгаагүй ажил олох, олсон ажлаа шаардлагын хэмжээнд хийх чадавхийг ажиллах чадвар буюу ажил эрхлэх боломж гэх бөгөөд энэхүү ухагдахуун өөртөө ур чадвар, мэдлэг, хувийн араншин, итгэл үнэмшил зэргийг багтаасан ойлголт юм. Энэ нь хүний хөгжил, хөдөлмөр эрхлэлт хоёрыг холбогч гүүр учир хөдөлмөрийн зах зээл дэх шинэ эрэлтийг бий болгогч эдийн засгийн ухагдахуун биш харин эрэгтэй эмэгтэй хэн боловч өөрийн болон гэр бүлийнхээ наад захын хэрэгцээг хангах, хүүхдүүд нь хүүхдийн орчиндоо өсч хөгжих боломж олгох, боловсролтой болох, ядууралд өртөхөөс сэргийлэх бололцоог бүрдүүлэхүйц орлоготой хөдөлмөр эрхлэх, нэр төртэй амьдрах чадавхи юм. Ийм учраас илтгэлийн энэ бүлэгт ажиллах чадварын хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсэг болох боловсрол, сургалтын төлөв, хандлагад дүн шинжилгээ хийж, тулгарч буй бэрхшээл, түүнийг даван туулах арга замын талаарх санал зөвлөмжийн талаар тусгасан болно. Хамгийн гол шийдвэрлэхүйц асуудлын тоонд ажил олгогчийн зүгээс тавьж буй мэдлэг, ур чадварын хэрэгцээ шаардлага, ажиллагчдын олж авсан боловсрол, техник мэргэжлийн чадварын түвшин хоёрын хооронд маш хол зөрүү байгаа явдал гэж үзэж байна. Ажил хайгчийн хөдөлмөрийн зах зээлээс хүлээж буй хүлээлт, түүний хувийн шинж чанар зэрэг нь тэднийг ажлаа үр дүнтэй гүйцэтгэх боломж олгохгүй байгаа явдал ажиллах чадвартай холбоотой өөр нэгэн хүндрэлтэй асуудал болоод байна. Илтгэлийн энэхүү бүлэгт ажиллах чадвартай холбогдсон өөр төрлийн, нэлээд гүнзгийрэх хандлагатай байгаа асуудал болох архи хэтрүүлэн хэрэглэж байгаа талаар, энэ нь ажил хайгчийн ажил олох боломжийг хязгаарлаад зогсохгүй ажил хөдөлмөр эрхлэгчдийг хүртэл ажлаа шаардлагын хэмжээнд хийж гүйцэтгэх чадварт нөлөөлж буй талаар авч үзэх болно.

2.1. *Áí ěiâ ñòíĕ àà ñóðãàĕò*

Боловсрол, сургалт нь хөдөлмөр эрхлэлт, ядууралтай нягт уялдаатай. Социализмын үеэс уламжлагдсан насанд хүрэгсдийн бичиг үсэг тайлагдсан байдал, боловсролын харьцангуй өндөр түвшин зах зээлийн харилцаанд шилжих эхний жилүүдэд буурсан хэдий ч одоогийн байдлаар хүн амын боловсрол, бичиг үсэг тайлагдсан байдал өмнөхөөсөө ч өндөр түвшинд хүрээд байна. Амьжиргааны түвшний 2002-2003 оны судалгааны дүнгээр насанд хүрсэн хорин хүний нэг нь л анхан шатны сургуулиа дүүргээгүй арван хүний найм нь дор хаяж 8-р анги дүүргэсэн байв. Гэсэн хэдий ч сургуулийн элсэлт, төгсөлтийн хувийн жингийн ялгаа нь газар зүйн байршил, өрхийн ядуурлын түвшингээр бүлэглэсэн бүлгүүд, алслагдсан хязгаар нутаг болон хот суурин, мөн ядуу, чинээлэг өрхөд өөр өөр байна.¹⁹

Ажиллах хүчний боловсрол, ур чадвар, туршлагын байдлаар илэрхийлсэн хүмүүн капитал болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн хооронд зөрүү их байна. Энэхүү зөрүүтэй байдалд олон хүчин зүйл нөлөөлжээ. Олон хүүхэд сургуулиас завсардаж байгаа нь өрхийн ядуурал, газар зүйн байршил, гэр бүлийн байдал зэрэг хүчин зүйлээс шалтгаалж байна. Хөдөөд хөвгүүд сургуулиас завсардах нь окидоос илүү байхын зэрэгцээ ядуу өрхийн хөвгүүдийн дунд сургууль завсардах явдал элбэг тохиолдож байна. 2006-2007 оны хичээлийн жилд сургууль завсардалтын тоо нэмэгдсэн мэдээ байна. Гэхдээ сургуульд дахин элсэх, шилжин ирсэн хүүхэд сургуульд элсээгүй зэрэг мэдээллийг бүрэн хамруулж авч үзээгүй учраас энэ баримтыг зохих тайлбартай ашиглах хэрэгтэй.

¹⁹ *Áyēðēēi ààĕ. Í ñiâ ě ààñi yáòòòēēi çĭyĕāyū. Àĕēēāi ' 35660-ì ĩ ĩ, 2006 ñiū 4-ò ñàðñi 13. Ñà òòòēēià áòòòòēēàò àĭēñi yàĕēi çàñāēēi ñiāā ãēiāò . Çççĭ àĭē ĩ ñ ñò ñi àāēēēi àçñ. òòòàāñ36*

Хүснэгт 2.1 Сургуульд хамрагдалт, завсардалтын хувь, Монгол Улс, 2003-2007

Үзүүлэлтүүд	2003-2004	2004-2005	2005-2006	2006-2007
Сургуульд хамрагдалтын хувь				
Суурь боловсрол		97.6	92.3	93.7
Бага боловсрол	103.5	102.4	93.3	93.5
Бүрэн дунд боловсрол	93.1	93.4	91.2	93.8
Сургуулиас завсардсан 7-15 насны хүүхэд, мян.хүн				
Бүгд	12.0	10.8	9.0	12.3
Үүнээс: эмэгтэй	4.9	4.3	3.6	4.8
Сургууль завсардалтын харьцаа	2.3	2.0	1.6	2.2

Үд нодддддддд: ҮСГ. Монгол Улсын статистикийн эмхтгэл 2006

“Боловсролгүй” хүүхэд олон байгаа нь сэтгэл түгшээсэн үзэгдэл хэвээр байна. Сургуулиас ажилд шилжигсдийн талаарх 2006 оны ҮСГ-аас явуулсан судалгаагаар 15-29 насны залуучуудын 3.3 хувь нь анхан шатны сургуулиа дүүргээгүй бөгөөд хөдөөд энэхүү үзүүлэлт 6.4 хувьтай байна. Монгол Улсын нийт дүнгээр бараг 2 дахин илүү хөвгүүд (4.6 хувь) охидоосоо (2.1 хувь) анхан шатны боловсролоо дүүргэдэггүй байна.²⁰ Эдгээр сургууль завсардсан хүүхдээс 2.3 хувь нь ажил хийх, 26.6 хувь нь мал маллах сонирхолтой байгаа нь сургууль завсардахын үндсэн шалтгаан болжээ. Мөн эдийн засгийн шалтгааны улмаас 9 хувь нь сургуулиа орхисон нь цаашид суралцахад шууд болон ирээдүйд шаардагдах зардлаас хамааралтай байж болох талтай. Мал маллах шалтгаанаар сургууль завсардах нь насны бүтцээс хамааран нэмэгдэж байна. 15-19 насны залуучуудын 20 хувь, 20-29 насны залуучуудын 30 хувь нь тус тус сургууль завсарджээ. Ийнхүү сургууль завсардсан хүүхдүүд ажилчин-хүүхэд болж, жирийн хүүхэд насыг тойрч, ирээдүйдэ сайн ажиллах хүч болох боломж нь хязгаарлагдаж ядуурлыг улам гүнзгийрүүлэхэд нөлөөлдөг байх магадлалтай юм.

²⁰ Odaio anei Ianoio, Nodododean aedeo oedeeanadei nododean. I ODA-ai o aedeadei o'ne, 2007 iiu 6-d n ad

Хүснэгт 2.2 15–29 насны боловсролгүй залуучуудын сургуулиас завсардсан шалтгаан, хүйсээр, Монгол Улс, 2006

Сургуулиас завсардсан шалтгаан	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Шалгалтанд унасан	2.7	2.6	3.3
Сургууль таалагддаггүй	26.6	26.5	26.7
Сургуульд сурах дургүй	2.3	3.4	0.0
Ажил хийх хүсэлтэй	2.3	2.6	1.7
Эцэг/эх сургуульд үргэлжлүүлэн суралцахыг зөвшөөрөөгүй	6.8	3.4	13.3
Эдийн засгийн шалтгаанаар	9.0	11.1	5.0
Мал маллах	26.6	28.2	23.3
Бусад	23.7	22.2	26.7
Бүгд	100.0	100.0	100.0

Үд нодддддддд: Францеско Пастор. 2007. Сургуулиас ажилд шилжигсдийн судалгаа. ОУХБ-ын тайлан.

Эцэг, эхийн болон хүүхдийн боловсрол хоорондоо уялдаатай байдаг.²¹ Боловсрол нимгэн, ядуу эцэг, эх хүүхдээ сургуулиас завсардуулж байгаа нь тэдгээрийг илүү сайхан амьдрах боломжийг хязгаарлаж улмаар үе дамжсан ядууралд өртөх эрсдлийг бий болгож байна. Сургуулиас ажилд шилжигсдийн 2006 оны судалгаагаар монгол хүүхдийн боловсролын байдалд эцэг, эхийн боловсролын түвшин шууд нөлөөлж байна гэж дүгнэжээ. Суралцах нь ирээдүйд оруулж буй хөрөнгө оруулалт хэмээн үзэж сургуульдаа үргэлжлэн суралцах шийдвэр нь эцэг, эхийн боловсролын түвшинтэй эерэг хамааралтайг регресс ашиглаж хийсэн статистик судалгаа нотолж байна. Өөрөөр хэлбэл, хэдийгээр тухайн гэр бүлийн үүсэл гарлаас үл хамааран хүүхдийг сургуульд суралцуулах санаачлага гарч байгаа ч бүх охид, хөвгүүдэд сурах боломж адилхан олдохгүй байна. Тухайлбал, хөдөөгийн хүүхэд зохих боловсрол эзэмшээгүйгээс хөдөлмөрийн бүтээмж доогуур, бага цалинтай хөдөлмөр эрхлэх магадлал нэмэгдэж байна.²²

²¹ Ayedeei aai. I iiai e aadi yadodei iy eayy, Odeai ' 35660, 2006 iiu 4-d nodui 13, dodan39

²² Odaio anei Ianoio, No ododean aedeo oedeeanadei n oadeada. I ODA-ai o aedeadei o'ne, 2007 iiu 6-d n ad

2006 оны Ядуурлыг оролцооны аргаар үнэлэх судалгааны дүнгээр зарим өрх нь хүүхдээ суралцуулахад сургуулийн төлбөр, ном дэвтэр худалдан авах гэх мэтийн шууд зардал байхгүйгээс тухайн өрхийн орлого нэмэгдэх боломж хязгаарлагддагийг дээрх дүгнэлт мөн баталгаажуулж байна. Мөн энэ судалгаанд сургууль завсардах эрсдлийг нэмэгдүүлж буй хүчин зүйлсийн талаар ч дүгнэжээ. Шилжин ирсэн хүмүүст оршин суугаа газрын бүртгэл байхгүйгээс хүүхдээ сургуульд оруулах боломжгүй болдог. Сургууль гэр хоёрын хооронд хол зайтай байх, ялгаварлан гадуурхах, дотуур байр хүрэлцэхгүй, анги дүүргэлт хэтрэх, тоног төхөөрөмж дутагдах зэргийг сургууль завсардахад нөлөөлдөг хүчин зүйлүүд гэж үзжээ. Хөгжлийн бэрхшээлтэй охид, хөвгүүдэд сургуульд суралцахад илүү хүндрэлтэй байна.²³

Монгол Улсад боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд хийгдэж буй өөрчлөлттэй уялдаж хөдөөгийн хүүхэд, залуучууд зарим нэгэн бэрхшээлтэй тулгарч байна. Шинэчлэлийн хүрээнд 1997 оноос хойш жижиг сумдын сургуулийг хаах, сумын сургуульд 9-10 дугаар ангийн сургалтыг зогсоож хот болон аймгийн төвийн сургуультай нэгтгэх бодлого баримталж ирлээ. Ингэснээр 9-10 дугаар ангийн сургалт хөдөөд үгүй болж, аймгийн төвийн сургуулийн ачааллыг хэт нэмэгдүүлжээ. Үүний зэрэгцээ 9-р ангид дэвшин суралцах эсэх нь 8-р ангиа төгсөөд өгдөг элсэлтийн шалгалтын үр дүнгээс хамаарах болов.²⁴

Сургуулийн олдоц, суралцах боломж-оос гадна суурь боловсролын чанарын асуудал мөн гарч байна. Аймгийн төвтэй харьцуулахад сурлагын ерөнхий үзүүлэлт,

танхимын сургалт зэрэг нь сумын сургуульд хамгийн доогуур түвшинд байхын зэрэгцээ ядуурлын түвшинтэй уялдуулан үзэхэд чинээлэг сумыг бодвол ядуу сумдад энэ хандлага бас ажиглагдаж байна.²⁵

Нөгөө талаар сургалтын төрөл, шаардлага, хэрэгцээтэй холбогдох бэрхшээл байсаар байна. Суурь боловсрол бол ирээдүйн амьдралдаа зориулан суралцах, хөдөлмөр эрхлэх боломжийг ашиглахад хамгийн чухал нөхцөл болдогийг олон улсын туршлага харуулж байна. Иймээс хүн бүр тухайн ажлын байранд шаардагдах ур чадвар, харьцааны соёл, суралцах чадвартай байх ёстой бөгөөд эдгээрийн ихэнхийг залуу насандаа эзэмшдэг билээ. Сургуулиас ажилд шилжигсдийн 2006 оны судалгаагаар хөдөлмөр эрхэлж буй залуучуудад зориулсан удирдлага, мэргэжлийн болон биеийн хөдөлмөрийн талаарх асуултуудыг тусгасан тусгай асуулга авчээ. Харин ажил олгогч бол баг болж ажиллаж чадах, хариуцлага хүлээх чадвартай, өөрөөр хэлбэл, бизнесийн орчинг ойлгодог, мэдлэг туршлага хоёрыг хослуульж чадах хүнийг ажилд авах сонирхолтой байдаг. Мөн мэдээлэл, технологийн зохих мэдлэг, харилцааны соёл болон гадаад хэлний бэлтгэлийг мөн шалгуур болгодог байна.²⁶

Суурь боловсролыг чухалчлахын зэрэгцээ мэргэжлийн дээд боловсролыг аль болох практик ач холбогдолтой болгох нь чухал юм. Эцэг эхчүүд, залуучууд өөрсдөө дээд боловсрол эзэмших нь ур чадвар, мэргэжлийн сургалтаас илүү чухал хэмээн үзсээр ирсэн учраас дээд боловсролтой олон хүн ажилгүйчүүдийн эгнээнд орох, эсвэл засвар, худалдаа эрхлэх зэргээр ойр зуурын ажил хийх болжээ.

²³ *ᠨᠠ, ᠠᠳᠠ, ᠠᠠ, βᠠ ᠪᠠᠳᠠᠳᠠ ᠳᠢ ᠠᠳ ᠰᠡᠭᠡ ᠢ ᠳᠨᠠᠠᠭᠠᠳᠠ, ᠐ᠡᠳᠠᠠᠳᠠᠳᠠᠳᠠ ᠠᠳ, 2006*

²⁴ *ᠠᠶᠡᠳᠡᠭᠡᠢ ᠠᠠᠶᠡ, 1 ᠶᠠᠳᠢ ᠡ ᠠᠳᠢᠨ ᠶᠠᠳᠠᠳᠠᠳᠠᠳᠠ ᠵᠢᠶᠡᠭᠠᠶᠢ, ᠳᠡᠭᠡᠳᠠ 1 35660, 2006 ᠶᠢᠰ 4-ᠳ ᠨᠠᠳᠠᠢ 13, ᠳᠠᠳᠠᠳᠠᠨ38*

²⁵ *ᠠᠶᠢᠳᠠᠳᠠᠳᠠᠳᠠ ᠠᠠᠶᠡ, ᠳᠠᠳᠠᠳᠠᠨ41.*

²⁶ *ᠠᠳᠠᠳᠠᠳᠠᠳᠠᠳᠠ ᠠᠠᠶᠡ, ᠨᠠᠳᠠᠳᠠᠳᠠᠳᠠᠳᠠ ᠠᠠᠶᠡᠳᠠᠳᠠᠳᠠᠳᠠ ᠠᠠᠶᠡᠳᠠᠳᠠᠳᠠᠳᠠ, 1 ᠠᠳᠠ-ᠶᠢ ᠳᠠᠶᠠᠳᠠᠳᠠᠳᠠᠳᠠ, 2007 ᠶᠢᠰ 6-ᠳ ᠨ ᠠᠳ.*

Хүснэгт 2.3 Бүх шатны боловсролын сургалтын байгууллагыг төгсөгчид (мянган хүн), Монгол Улс, 2005–2006

Сургалтын байгууллагын ангилал	2005-2006
Ерөнхий боловсролын сургууль	100,4
Үүнээс: эмэгтэйчүүдийн эзлэх хувь	53.0
Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв	7,1
Үүнээс: эмэгтэйчүүдийн эзлэх хувь	47.9
Их, дээд сургууль, коллеж	23,6
Үүнээс: эмэгтэйчүүдийн эзлэх хувь	65.3
Бүгд	131,1
Үүнээс: эмэгтэйчүүдийн эзлэх хувь	54.9

Үд н᠊᠋᠓᠋ᠠᠳ᠋ᠠᠶ᠋ᠢᠰᠡ: ҮСГ, Монгол Улсын статистикийн эмхтгэл 2006.Хүснэгт 19.3, х.291

Ажиллах хүчний 2002-2003 оны судалгаагаар нийт ажилгүйчүүдийн ихэнх нь аль нэг шатны боловсрол эзэмшсэн гэсэн дүн гарчээ. Тухайлбал, эдгээрийн 33.5 хувь нь бүрэн бус дунд, 31.6 хувь нь бүрэн дунд боловсролыг эзэмшсэн бөгөөд бүрэн бус дунд боловсрол эзэмшигчдийн 28.2 хувь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдийн 35.3 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Ажилгүйчүүдийн боловсролын ерөнхий дүр зургийг 2.4-р хүснэгтэд харуулсан боловч эдгээр тоо баримт нь тухайн шатны боловсрол эзэмшсэн хичнээн хүн ажилгүй байгааг илэрхийлдэггүй билээ. Үндэсний статистикийн газраас явуулсан Сургуулиас ажилд шилжигсдийн 2006 оны судалгаагаар 15-29 насны мэргэжлийн боловсролтой залуучуудын дунд ажилгүйдэл 15.3 хувь байгаа нь ерөнхий боловсрол (21.9 хувь)-той хүмүүсээс бага байна. Мөн дээд боловсролтой залуучуудаас (11.6 хувь) техникийн буюу мэргэжлийн дипломтой (8.1 хувь) хүмүүсийн дунд ажилгүйдэл мөн л бага байна.

Хүснэгт 2.4 Ажилгүйчүүдийн боловсролын түвшин, хүйсээр, Монгол Улс, 2002-2003

Боловсролын түвшин	Хувийн жин		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Боловсролгүй	2.6	2.8	2.4
Бага	6.4	7.0	5.8
Бүрэн бус дунд	33.5	38.3	28.1
Бүрэн дунд	31.6	28.3	35.3
Техник, мэргэжлийн	8.2	9.0	7.3
Тусгай мэргэжлийн дунд/бүрэн бус дээд	8.9	6.9	11.1
Дээд	8.8	7.7	10.0
Бүгд	100.0	100.0	100.0

Үд н᠋᠊᠋᠓᠋ᠠᠳ᠋ᠠᠶ᠋ᠢᠰᠡ: ҮСГ, АХБ. Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан 2002–2003, Хүснэгт 19.3, х 41

Техник мэргэжлийн сургалт (ТМС) болон мэргэжлийн боловсролын сургалтын тогтолцоонд тулгарч буй бэрхшээлийг даван туулах талаар төр засаг анхаарч байна. Тоног төхөөрөмж, сургалтын бааз нь хэт хуучирсан ТМС-д оруулж буй төсвийн хөрөнгө оруулалт бага, эдгээр сургуулийн заах арга зүй, бизнесийн ур чадвар, эрэлт, итгэмжлэгдсэн байдал, мэргэжлийн аюулгүй ажиллагаа зэрэгт хувийн хэвшлийнхний оролцох, хяналт тавих эрх зүйн орчин дутмаг учраас тэдний нөлөөлөх боломж хомс юм.²⁷

Шинээр үүсэн хөгжиж буй бизнесийн салбарт сайн ажилчдыг ажиллуулах сонирхол байгаа боловч залуучууд ажлын наад захын ур чадвар эзэмшээгүй байх нь түгээмэл учраас шаардлага хангасан хүнийг олоход бэрхшээлтэй байнга тулгардаг. Хөдөлмөр, нийгмийн халамжийн газраас 2004 онд явуулсан судалгаанд хамрагдсан нийт компанийн 71 хувь нь шаардлагыг хангасан хүнийг олж ажилд авахад бэрхшээлтэй байдаг, ажилд орох өргөдөл гаргасан хүмүүсийн 80 хувь нь мэргэжлийн шаардлагыг хангахгүй, 67 хувь нь туршлага дутмаг хүмүүс байсан гэж судалгааны тайланд дурджээ. Мөн өрлөгчин, засварчин, чимэглэгч, мужаан, будагчин, угсралтын ажилчид гэх мэтийн мэргэжлийн хүмүүс хамгийн эрэлттэй гэсэн байна.²⁸ Нэлээд тооны монголчууд зохистой ажлын байр олж чадахгүй байгаа ч нөгөө талаас эдийн засгийн хөгжилд зайлшгүй чухал гол ажлууд эзэнгүйдэх явдалтай тулгарч байна. Харин энэ орон зайг, тухайлбал сүүлийн жилүүдэд эрчимтэй өсч буй уул уурхай, зам, барилгын салбарт шаардлагатай ажиллах хүчний хэрэгцээг гадаадын ажилчид эзлэх болжээ.

Ажил олгогчид сүүлийн үед бий болгож буй ажлын байрныхаа шаардлагад тохирох хүмүүсийг сургах, дадлагажуулах ажлыг зохион байгуулах болсон нь сонирхол татаж байна. Сургуулиас ажилд шилжигсдийн судалгааны үеэр

²⁷ᠱᠣᠮᠣᠯᠢᠰᠡᠭᠡᠢ ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ ᠵᠢᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ, 2007

²⁸ᠵᠣᠮᠣᠯᠢᠰᠡᠭᠡᠢ ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ, 2005

ажил олгогчоос авсан асуулгад 70 хувь нь шинээр ажилд авсан хүндээ зориулан сургалт зохион байгуулдаг тухай дурджээ. Гэвч ихэнх сургалт нь зөвхөн тухайлсан тэр ажилд нь хэрэгтэй практик ур чадвар олгодог байна. Энэ нь тухайн мэргэжлийн ур чадварыг эзэмшихэд сайшаалтай боловч түүнийг өөр компанид ашиглах боломж муутай тул хязгаарлагдмал хэрэгцээтэй ур чадвар болон хувирах талтай юм.²⁹

Боловсролын үр өгөөжийн тооцоог сүүлийн үед хийгдсэн хоёр ч судалгаанд хөндсөн байна. Үндэсний статистикийн газраас зохион байгуулсан Сургуулиас ажилд шилжигсдийн 2006 оны судалгааны³⁰ тоонд үндэслэн анхны тооцоог Дари ба Суруга³¹ нар, хоёр дахь тооцоог ОУХБ-ын зөвлөх хийжээ. Боловсрол эзэмшихэд зориулан зарцуулсан жил нэмэгдэх тусам ирээдүйн үр өгөөждээшилнэ гэсэн таамаглалын дагуу Минсерийн тэгшитгэлийг ашиглан боловсролын үр өгөөжийг тооцож болно. Энэ арга зүйг ашиглан суралцсан жил нэмэгдэх тусам орлого жилд 7.2 хувиар өснө гэж Дари, Суруга нар тооцжээ. Харин Сургуулиас ажилд шилжигсдийн 2006 оны судалгаанд 19-29 насны бүлгийнхэнд энэ үзүүлэлт 4.2 хувь байв. Ийм зөрүүтэй тооцоо гарч буй нь дараах шалтгаантай юм. Дари, Суруга нарын тухайд нэгд, тооцоог зөвхөн залуу хүмүүсээр хязгаарлаагүй, хоёрт, суралцсан хугацааг илүү “тэнцүүхэн” тархалтаар авсан бөгөөд гуравт, зөвхөн нийслэл хотын хүн амын хувьд тооцоо хийсэн байна.³²

Боловсролын түвшин дээшлэх тусам “цалингийн нөлөө” гарна гэж тооцоолдог өөр нэг арга бий. Ингэж хийсэн тооцоо дээрх таамаглалыг ч мөн баталгаажуулж байна. Дээд мэргэжилтэй хүний боловсролын өгөөж 12.7 хувьтай байна гэж Дари, Суруга нар үзсэн байхад энэ судалгаагаар

9.5 хувь гэсэн тооцоо гарчээ. Тооцооны зөрүүтэй байдал дээрх судлаачид зөвхөн Улаанбаатар хотын хэмжээнд тооцоо хийсэнтэй холбоотойг өмнө дурдсан. Мөн мэргэжилтэй монгол эр хүний хувьд энэхүү өгөөж дунд боловсролтой хүнээс бага байгаа нь мэргэжлийн сургалт ямар нэгэн хэмжээгээр доголдолтой байгааг илэрхийлж байна.

Ерөнхийдөө, боловсролын түвшин нь цалингийн хэмжээг тогтоох нэгэн хүчин зүйл мөн учраас дээд мэргэжилтэй хүн илүү өндөр цалин авах боломжтой юм. Гэхдээ дунд боловсролтой хүн мэргэжлийн боловсролтой хүнээс илүү орлого олох боломжтойг ч бас үгүйсгэж болохгүй. Өөрөөр хэлбэл, сургуулиас ажилд шилжигсдийн судалгаагаар мэргэжилтэй ажилчин хүний хувьд боломж хязгаарлагдмал байгаа бөгөөд бага цалин авч байна.

Аг үгүүд бодөөд

Нэлээд тооны монголчууд зохистой ажлын байр олж чадахгүй байгаа ч нөгөө талаас эдийн засгийн хөгжилд зайлшгүй чухал гол ажлууд эзэнгүйдэх явдалтай тулгарч байна. Харин энэ орон зайг гадаадын ажилчид эзлэх болжээ.

Монголын олон арван залуучуудын эзэмшиж буй боловсрол нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэй уялдахгүй байгаа бөгөөд мэргэжлийн тусгай сургалт ч ажлын байрны шаардлагыг бүрэн хангахгүй байгааг өмнө өгүүлсэн билээ. Энэ хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд төр, засаг, сургууль, боловсролын болон техник мэргэжлийн холбогдох бусад байгуулага, ажил олгогч, хөдөлмөр эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалагч байгууллагын хамтын хүчин чармайлт маш чухал.

Техник мэргэжлийн ур чадварыг доорд үзэх, бага ач холбогдол өгөх нь Монголд нэлээд түгээмэл юм. Ихэнх тохиолдолд дээд боловсролтой хүн илүү сайн хөдөлмөр эрхлэх боломжтой, нэр төрийн хэрэг гэж үздэг нь харамсалтай төдийгүй алдаатай үзэл юм. Иймээс олон

²⁹ *Ódaió ànèi Iànoió. Nòdàdóeàñ àeéèà oéèeèàñàeéi nòdàeèàà. Í ÓÓÁ-àí ò àeéèàdàeéi ò%è, 2007 ìü 6-ò ñ àð*

³⁰ *Àidò e àdààe Àadè, Óidóçàeè Nòdòàà. 2006 ìü 2-ò ñàð. Óeèeèeèdèéi çà àyò ài eí àndíèà ò-ðàð ýàeéi çàñdàeéi í%e^{oo}. Í ìàí eüí eèoyý, Eeòàyè '9, Ie ü eèñüi dàioüi àeéèe àdàaiü nòdàeèàaiü ò%à èndèò òð, Èi ààéi Èò Nò dòóèü.*

³¹ *Ódaió ànèi Iànoió. Nòdàdóeàñ àeéèà oéèeèàñàeéi nòdàeèàà. Í ÓÓÁ-àí ò àeéèàdàeéi ò%è, 2007 ìü 6-ò ñ àð*

³² *“í%òòýé eèeèè*

залуучууд илүү боломж нээгдэж буйг үл харгалзан мэргэжлийн сургалт гэхээсээ илүү дээд боловсрол эзэмшихийг сонгодог юм. Өнөөдөр нийтдээ 140000 хүн их, дээд сургуульд сурч байгаа нь монголын нийт ажиллах хүчний бараг 15 хувьтай тэнцэх бөгөөд эдгээр залуучууд төгсөөд сайн ажлын байр олоход ихэд бэрхшээлтэй тулгардаг. 2006 онд гэхэд нийт сургууль төгсөгчдийн 5.4 хувь буюу 7100 нь техник мэргэжлийн сургууль төгсөгчид, үүний 47,9 хувь нь эмэгтэйчүүд байв.

Цаашлаад, техник мэргэжлийн сургуулийн олгож буй боловсролын чанар болон ажлын байранд тавигдаж буй шаардлагын зөрүүг арилгах зорилгоор техник мэргэжлийн сургалтын тогтолцоог цаг алдалгүй шинэчлэх шаардлагатай байна. Мэргэжилтэй боловсон хүчин шаардагдаж буй салбарт санхүү, аялал жуулчлал орох бөгөөд үйлдвэрлэлийн хүрээнд механик, өрөмдөгч, цахилгаанчин, хүнсний технологич, барилгын инженер, хүнд механизмын жолооч зэрэг мэргэжил эрэлт ихтэй байна. Өнөөдөр Монгол улсын техник мэргэжлийн боловсролын сургалтын арга зүй хуучирсан, хөшүүн хойрго тогтолцоо болж хувирсны зэрэгцээ хөрөнгө оруулалт ч хангалтгүй байна. Эдгээр бэрхшээлийг гадаадын хандивлагчдын төсөл, тусгай ажлын хэсэг байгуулан ажиллаж тодруулсан боловч түүнийг тодорхой нэг байгууллагын хүрээний асуудал гэж үзэж байгаагаас ажлын байртай төдийлөн уялдахгүй хэвээр байна. Юуны түрүүнд, мэргэжлийн сургалтын стандартыг тогтоох, үнэлгээ хийх, сургалтын хөтөлбөр, сурах бичиг, тоног төхөөрөмжийг шинэчлэх шаардлагатай байна. Залуучуудад зориулсан танхимын сургалтыг зохион байгуулахдаа ажлын байртай хамтад нь авч үздэг байх нь чухал.

Аливаа боловсрол, сургалт хөдөлмөрийн зах зээлтэй нягт уялдах ёстой гэсэн нэгдсэн ойлголт бий болжээ. Ингэхдээ ажил олгогчид өөрсдийн ажилчдыг сургалтын хөтөлбөр боловсруулах, мэргэжлийн стандартыг тогтоох, ажлын байран дахь сургалт, дадлагад хамруулах,

түр ажиллуулах зэрэг оролцооны арга барилыг ашиглах нь үр дүнтэй юм. Нөгөө талаар оюутнуудын ажлын байрны талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэхэд чиглэсэн зөвлөгөө өгөх, дасгалжуулах, мэдээллийг цаг тухайд нь түгээх зэргээр хөдөлмөрийн зах зээлийн үйлчилгээг тэдэнд шуурхай хүргэх нь чухал юм. Хөдөлмөрийн зах зээлийн хандлагын талаарх статистик мэдээллийг ажиллах хүчний судалгаагаар гаргаж хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн талаарх мэдээллийн сан бүрдүүлэх талаар ч анхаарал тавих нь зүйтэй юм. Эдгээр асуудал ажлын байраа шинээр сонгох буюу сайжруулахаар төлөвлөж буй насанд хүрсэн бүх хүмүүст хамааралтай юм. Монголын Ажил олгогч эздийн холбооноос явуулсан судалгаагаар мэргэжлийн сургалтын төвүүдийн олгож буй ур чадвар, мэдлэг нь ажлын байрны эрэлт, түүний шаардлагыг үнэхээр хангахгүй байгааг дурдсаныг ч энд бас тэмдэглэж байна.

Дээр дурдсан зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд юуны түрүүнд Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэл, Боловсрол, соёл, шижлэх ухааны яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам болон бусад салбарын яам, төрийн болон төрийн бус байгууллагуудын өргөн оролцоотойгоор үндэсний стратеги боловсруулах, холбогдох хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, энэхүү хүрээнд албан бус хөдөлмөрийг хамруулах нь чухал юм. Боловсрол, сургалтын хоорондын уялдааг хангах зохицуулалтын механизмыг ч бүрдүүлэх шаардлагатай. Техник мэргэжлийн сургалтын талаар хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа нь сайн хэрэг. Хамгийн гол нь энэ хуульд төрийн болон төрийн бус байгууллага, ажил олгогч эздийн байгууллага, үйлдвэрчний эвлэл, хувиараа сургалт явуулж буй байгууллага, иргэд болон бусад түншүүдийн хоорондын уялдааг бэхжүүлэхэд чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг оновчтой тусгах шаардлагатай байна. Боловсрол, мэргэжлийн сургалт нь орлого нэмэгдүүлэх санхүүгийн нэгэн эх үүсвэр болдог. Бусад орны туршлагаас харахад мэргэжлийн

сургалтыг амжилттай зохион байгуулахад оролцогчдын төлбөр, ажил олгогчдын хандив болон төрөөс олгож буй санхүүжилтийг ашигладаг байна.

Сургалтын тогтолцоог боловсронгуй болгох, сургалтын чанарыг иж бүрнээр дээшлүүлэхийн тулд сургалтын хөтөлбөр, ур чадварын стандартыг тогтоох, хянах, магадлан итгэмжлэх, сонирхогч талуудын оролцоог хангасан эрх зүйн орчинг боловсронгуй болгох, санхүүгийн зохистой механизм бүрдүүлэх, арга зүйн төв байгуулах, арга зүйч багш нарыг бэлтгэх, сургуулийн удирдлагыг бэхжүүлэх зэрэг асуудлыг цогц шийдвэрлэж байх үүрэг бүхий Үндэсний зөвлөлийг байгуулах нь зүйтэй юм. Энэ нь сургалтын төвүүдийн чанарыг сайжруулахад ч чухал алхам болно. Энэ талаар авч хэрэгжүүлж буй аливаа арга хэмжээ нь шаардагдаж буй ур чадварын хэрэгцээг тодорхойлж, түүнд нийцсэн сургалтыг албан болон албан бус хэлбэрээр, ажлын байран дахь сургалтаар дамжуулан хүргүүлэхэд чиглэгдэх ёстой юм. Мэргэжлийн боловсролын сургалтын тогтолцоо тухайн ажилчинд өөрийн ур чадвараа байнга, тогтвортой дээшлүүлэх боломжийг бүрдүүлдэг нэгэн гол суваг бөгөөд түүгээр олгогдож буй боломж нь бүх насны ажилчинд нээлттэй байх нь чухал юм. Эдгээр асуудлын ихэнх нь одоогоор боловсруулж буй Мэргэжлийн боловсролын сургалтын тухай хуульд тусгалаа олох ёстой. Мөн дээр дурдсан Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны нэг чиглэл нь дотооддоо болон гадаадад ажил эрхлэхэд хэрэг болох мэргэжлийн ур чадварын стандартыг тогтоох явдал байх болно. Монгол ажилчны мэргэжлийн ур чадварыг дотооддоо болон олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөх нь ажил хайж буй хүмүүст илүү боломжийг нээхийн хэрээр илүү өндөр цалинтай байх нөхцлийг бүрдүүлнэ.

Мэргэжлийн ур чадвар олгох сургалт шаардагдаж буй тэргүүлэх гурван чиглэлд уул уурхай, барилга, аялал жуулчлалын салбарууд зүй ёсоор багтаж байгаа бөгөөд эдгээр салбарт ажлын байрыг шинээр

бий болгосноор ажил идэвхтэй хайж буй хүмүүст сонголтын илүү өргөн боломжтой байх болно. Энэ салбаруудад тохирсон ур чадвартай, түүнийг нь сертификатжуулсан ажилчдыг түлхүү бэлтгэх нь илүү үр дүнтэй байж болох юм.

Боловсрол, ялангуяа техник мэргэжлийн сургуулийн талаарх олон нийтийн санаа бодлын төөрөгдлийг арилгахад чиглэсэн, мэргэжлийн баримжаа олгох зөвлөгөө, суртал нөлөөллийн ажлыг охид, хөвгүүдийн дунд зохион байгуулах хэрэгцээ шаардлага их байна. “Техник мэргэжлийн сургалт нь хүний хөгжлийн хоёрдогч болон гуравдагч сонголт бус харин орчин үеийн техник технологийн хөгжлийн үндсэн суурь мөн билээ.”³³ Иймээс практик туршлага, энгийн арга барил дээр суурилсан техник мэргэжлийн сургалтаар дамжуулан хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцсэн ур чадварыг олж авахын үнэ цэнэ, ач холбогдлыг олон нийтэд сурталчлах кампанит ажил зохион байгуулж мэргэжлээрээ өрсөлдөх нь амжилтын үндэс гэсэн ойлголтыг бэхжүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Зарим залуучууд мэргэжлийн сургалтад хамрагдаж байхад нөгөө хэсэг нь бизнесээ эхлүүлэх боломжийг бүрдүүлэх нь чухал. Дунд болон дээд сургууль, мэргэжлийн сургалтын төвүүдийн сургалтын хөтөлбөрт бизнесийн чиглэлийн суурь хичээлийг оруулснаар залуучууд хөдөлмөрийн зах зээл дээр хөл тавихаасаа өмнө энэ талаар тодорхой ойлголттой болно. Түүнчлэн оюутнуудыг бизнес инкубаторийн үйл ажиллагаанд оролцуулснаар сургалт, бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамруулах, онол, практикийг хослуулах боломжийг тэдэнд нээж өгнө. Монголын бизнесийн манлайлагчид бизнест анхлан суралцаж буй залуучуудыг сургаж, үйл ажиллагааг нь хянан халамжлан хүмүүжүүлэх нь үр дүнд хүргэх талтай. Мөн олон улсын хэмжээнд шалгарсан тэргүүн туршлагыг түгээдэг

³³“ Υπόλοιπες, Οι ίδιες ίδιαι αείει αι ει άνδι ενί ο αείαάδδ άγγά ήγίαιήιέέ δάξαείουί ο άείαι, Άάδίαί άάίάουί άείεί άάάίά άάείάάάάά. ΑΝΘΩΒ, Οεάαίαάά άδ άι δ, 2007

сүлжээнүүд байдгийн нэг нь Принс Траст³⁴ юм. Монголын томоохон бизнес эрхлэгчид энэхүү сүлжээний инкубатор үйлчилгээг өргөжүүлэхэд оролцох боломжтой.

Монголын залуучуудын нэг хэсэг нь малаа өсгөх, малын түүхий эдийг боловсруулах уламжлалт ажлыг орон нутагтаа эрхлэх боломжтой. Тэд мал маллах наад захын мэдлэгтэй болох, техникийн сургалтад хамрагдах, малынхаа үржил шимийг нэмэгдүүлэх чиглэлээр ур чадвар эзэмшдэг. Малчин өрхийн тоо нэмэгдэж, банкны зээлд хамрагдах боломж өргөжиж³⁵ буйтай холбогдуулан залуу малчдад бизнес эрхлэх шинэ ур чадвар эзэмшүүлэх шаардлага чухлаар тавигдах боллоо. Уламжлалт бүтээгдэхүүнээ борлуулах, хөдөө аж ахуйн шинэ бизнес эрэлхийх, амьжиргааны эх үүсвэрээ өргөжүүлэхэд нь залуучуудад дэмжлэг үзүүлэх зорилгоор тэдгээрийг орон нутгийн хөгжлийн стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх явцад татан оролцуулж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон бусад санхүүгийн эх үүсвэртэй нь холбох, бизнесийн удирдлагын чиглэлийн мэргэжлийн сургалтад хамруулахад анхаарах хэрэгтэй байна.

Мэргэжлийн сургалтаар олгож буй мэдлэг, ур чадварыг зах зээлд өрсөлдөгч хувийн хэвшлийнхний хэрэгцээ, шаардлагатай нийцүүлэх зорилгоор залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг үндэсний хөгжлийн стратегид тусгаж хэрэгжүүлэх нь чухал. Чингэхдээ хөдөлмөр эрхлэлтийн бодлогын чиглэл нь залуучуудын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний нэгэн хэсэг болж байхаар стратегид тусгах учиртай.

Гурав дахь зөвлөмж

Хөдөлмөрийн зах зээл дэх ур чадварын эрэлт, нийлүүлэлтийн хоорондын зөрүүг арилгах талаар

- Мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, мэргэжлийн стандарт тогтоох, ажлын байранд нь сургалт зохион байгуулдаг тогтолцоог бүрдүүлэх, ажиллагчдын дадлагажих боломжийг өргөжүүлэх зэрэгт ажил олгогчдын идэвхтэй оролцоог хангах замаар боловсрол, сургалт, хөдөлмөрийн зах зээл дээрх ур чадварын эрэлт хэрэгцээ тэдгээрийн хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх;
- Мэргэжлийн сургалтаар олгож буй мэдлэг, ур чадвар нь зах зээлд өрсөлдөгч хувийн хэвшлийнхний хэрэгцээ, шаардлагатай нийцэхгүй байгаа энэхүү хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхийн тулд боловсрол, сургалтын тогтолцоог шинэчлэхэд чиглэсэн олон талт түншлэлийг дэмжих, үүнд ажил олгогч, үйлдвэрчний эвлэлийн байгууллага, засгийн газар, боловсролын байгууллагуудыг татан оролцуулах;
- Техник мэргэжлийн сургууль, боловсролын талаарх олон нийтийн санаа бодлын төөрөгдлийг арилгахад чиглэсэн, мөн хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцсэн ур чадварыг практик үйл ажиллагаа, энгийн арга барил дээр суурилсан техник мэргэжлийн сургалтаар дамжуулан олж авахын үнэ цэнийн талаар олон нийтэд сурталчлах кампанит ажил зохион байгуулах;
- Техник мэргэжлийн сургалт, ур чадварын стандарт, сертификатжуулалтын асуудал эрхэлсэн Үндэсний зөвлөлийг байгуулж мэргэжлийн сургалтын хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, санхүүжилтийн механизмыг бий болгох, арга зүйн төвүүд

³⁴ <http://www.princes-trust.org.uk> -ᠶᠡᠭᠦᠨ ᠵᠢᠭᠢ ᠵᠢ.

³⁵ ᠓᠔᠗᠗᠗ 77 ᠵᠢᠭᠢ ᠵᠢ.

Санал асуулгад оролцсон хүмүүсийн нэлээд нь архидаг согтуурах явдал нь ажиллах чадвартай холбоотой бас нэг хүндрэлтэй асуудал бөгөөд ажил олгогч, хөдөлмөр эрхлэгчийн аль алинд нь бэрхшээл учруулдаг хэмээн үзэж байв. Сүүлийн үеийн судалгаанаас үзэхэд архидалт нь монголчуудын сайхан амьдрах, ажилд орох, зохистой ажил эрхлэхэд нь маш их сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал:

- ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр Монгол Улсын хүн амын согтууруулах ундааны хэрэглэний талаар явуулсан эпидемиологийн судалгаанд оролцсон эрэгтэйчүүдийн 33.9 хувь, эмэгтэйчүүдийн 11.5 хувь нь өмнөх жилд ажил, сургууль, гэртээ нэгээс дээш удаа согтууруулах ундаа хэрэглэж асуудалд орж байсан гэж хариулжээ.
- Дээрх судалгаагаар архи, согтууруулах ундааны хэрэглээ нь ажилгүйдэл, ядууралтай шууд хамааралтай байна.
- Оролцооны аргаар ядуурлыг тодорхойлох 2006 оны судалгаагаар ядуурлаас гарахад архидалт саад болж байгааг нэг бус удаа дурдсан байна. Архидалт нь хөдөлмөр олох, тууштай ажил эрхлэхэд сөргөөр нөлөөлж, банкны зээл авах боломжийг нь хязгаарлаж, улмаар тухайн хүн өөрийгөө ядуурлаас гарах чадваргүй гэсэн гутрангуй үзэлтэй болоход хүргэдэг. Архидалттай холбоо бүхий иймэрхүү байдал хот, хөдөөгийн ядуучуудын хувьд нийтлэг байдаг.
- Оролцооны аргаар ядуурлыг тодорхойлох 2006 оны судалгаагаар хот болон хөдөө орон нутгийн ядуу иргэдийн аль аль нь архидалт газар авч байгаа гэж үздэг учраас Засгийн газраас архи, согтууруулах ундааны хүртээмжийг багасгах, татварыг нэмэгдүүлэх замаар архи, согтууруулах ундааны үнийг нэмэх, стандартын бус архи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, тэдгээрийн

түүхий эдийн олдоцыг хязгаарлах чиглэлээр бодлого хэрэгжүүлэхийг хүссэн байна.

Ажилгүйдэл, ядуурал, архидалтын харилцан уялдаа холбоо нарийн төвөгтэй учраас дээр дурдсан судалгаанууд дангаараа архидалт бол ядуурал, ажилгүйдлийн шалтгаан болж байна гэдгийг баталж чадахгүй юм. Гэвч архидалт маш олон сөрөг үр дагавартай, ажил олгогчид уг асуудлыг байнга сөхөн тавьдаг зэргээс үндэслэн Засгийн газраас Монгол Улсад архидалтыг багасгах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих кампанит ажлуудыг нэг цогц арга хэмжээ болгон хамтад нь зохион байгуулж болох юм гэсэн дүгнэлт гарч байна.

Монгол Улсад архидалтын сөрөг үр дагаврыг эмэгтэйчүүд хамгийн их амсаж байна. Архидалт нь эрэгтэйчүүдийн дунд түгээмэл боловч нийгэмд үзүүлж буй хор хөнөөл нь эмэгтэйчүүдэд хүндээр тусдаг. Архидалттай холбоотой гэр бүл болон ажлын байранд болдог төвөгтэй асуудлуудад эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс гурав дахин их өртдөг байна.³⁸ ДЭМБ-ын судалгаагаар архидалттай холбоотой асуудал бүрт жендэрийн ялгаа гүнзгий байдаг юм. Тухайлбал, архийг хэтрүүлэн хэрэглэдэг эрэгтэй хүний тоо эмэгтэйчүүдийнхээс 4 дахин их байдаг бөгөөд энэхүү хандлага насны бүлэг бүрт ажиглагдаж байна. Монгол Улсын эдийн засаг, нийгмийн үнэлгээнд жендэрийн талаас нь дүн шинжилгээ хийж үзэхэд эрэгтэйчүүдийн архидалт тэдний хөдөлмөр эрхлэх боломжийг хязгаарлах, эрүүл мэндээр хохироход илүү нөлөөлдөг байна.

³⁸ *Yip, AYLA, NYIO. 2006. I ūai e Ōenui ōji ai aadu nāo ōōōōōōōō ōiāāāiū ōyōyāyū, ōyā iāyā, ōyōōōēēēē yīdā ādē ēi āēēē nōāāēāāiū ōā ēēāi.*

Дөрөв дэх зөвлөмж

Архидалтыг багасгах талаар

- Архидан согтуурахтай тэмцэх үндэсний хэмжээний кампанит ажил зохион байгуулах, үүний дотор архидан согтууралтын улмаас монголчуудад учирч буй нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврын талаар олон нийтэд сайтар таниулах;
- Согтууруулах ундааны хүртээмжийг багасгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- Ажил олгогчид, үйлдвэрчний эвлэлийн болон төр, засгийн байгууллагуудын оролцоотойгоор архидан согтуурахын хор уршгийн талаар мэдлэг олгох ажлын байран дээрх сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;

Ääýýò: Хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэх шаардлага байна.

Энэ бүлэгт Монголын хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт, нийлүүлэлт нь боловсрол, сургалт, ур чадвартай хэрхэн уялдаж байгаад дүн шинжилгээ хийж, ажиллах хүчний ур чадвар, ажил олгогчийн тавьж буй шаардлага хоёрын хоорондын уялдааг зохицуулах талаар зөвлөмж гаргасан болно. Түүнчлэн архидалттай холбоотой үүсч буй тулгамдсан зарим асуудал, ялангуяа олон эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг хязгаарлаж буй талаар зөвлөмжид товч тусгав. Дараагийн бүлэгт хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн талаар өгүүлэх болно.



БҮЛЭГ

**Хөдөлмөр эрхлэлт, ядуурлын
хоорондын уялдаа холбоо,
түүний чиг хандлага,
зангилаа асуудлууд**



Хөдөлмөр эрхлэлт, ядуурлын хоорондын уялдаа холбоо, түүний чиг хандлага, зангилаа асуудлууд

Илтгэлийн энэхүү бүлэгт хөдөлмөр эрхлэлтийн талаарх үндсэн асуудлууд, монголын хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн талаар авч үзэх болно. Эхлээд хөдөлмөр эрхлэлт, ядуурлын хоорондын дараа нь ажилгүйдэл, ядуурлын хоорондын уялдаа холбоонд амьжиргааны түвшний судалгааг ашиглан дүн шинжилгээ хийлээ. Өрхийн тэргүүлэгч нь ажил хөдөлмөр эрхэлж буй айл өрхийн дунд ядуурал их байгаа нь хөдөлмөрийн бүтээмж муу, ажлын цалин хөлс буюу хүн амын бодит орлого бага байна гэсэн дүгнэлт судалгааны дүнд гарсан нь илтгэлийн хамгийн гол дүгнэлтийн нэг юм. Мөн ажилгүйчүүд болон эдийн засгийн идэвхгүй хүн амын тухайд ч дүн шинжилгээ хийв. Түүний дараа хичнээн тооны ажлын байр шинээр бий болсон, шинээр бий болсон ажлын байр хаана, чухам ямар салбарт бий болсон талаар авч үзсэн. Эдгээр нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх талаарх стратегид харгалзан үзэж тусгавал зохих үндсэн асуудлууд юм. Төгсгөлд нь, эдийн засгийн гурван гол салбар болох хөдөө аж ахуй, уул уурхай, албан бус секторын талаар судлан тодорхой хэд хэдэн санал зөвлөмж гаргасан болно.

3.1 *ᠲᠡᠭᠡᠨᠢ ᠶᠡᠭᠡᠨᠡᠳᠡ ᠶᠡᠭᠡᠨᠡᠳᠡ*

3.1.1 Хөдөлмөр эрхлэлт, ядуурлын хоорондын үндсэн уялдаа холбоог судлах нь

2005 оны 9 дүгээр сард болсон Дэлхийн дээд хэмжээний уулзалтын үеэр улс орнуудын тэргүүнүүд ядуурлыг бууруулах зорилгоор хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхийн чухлыг хүлээн зөвшөөрч “Хүн бүрийг түүний дотор залуучууд эмэгтэйчүүдийг бүтээмж өндөртэй хөдөлмөр, зохистой ажлын байраар бүрэн хангах” тухай шинэ зорилт хэрэгжүүлэхийг санал нэгтэй дэмжсэн билээ. Энэхүү шинэ

зорилтыг “Туйлын ядуурал, өлсгөлөнг арилгах” гэсэн мянганы хөгжлийн нэгдүгээр зорилгын хүрээнд хамруулж байгаа юм. Иймд 2015 он гэхэд ядуурлын түвшинг тал хувиар бууруулах зорилгод хүрэхийн тулд зохистой ажлын байр бүхий хөдөлмөрийн насны хүн амын (эрэгтэй, эмэгтэй аль алины хувьд) нийт хүн амд эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх, бий болж байгаа ажлын байрны чанар, бүтээмжийг илүү сайжруулах замаар хөдөлмөрийн нөөцийг дээд зэргийн үр дүнтэй ашиглах шаардлагатай болж байна. Энэ зорилтыг мянганы хөгжлийн наймдугаар зорилгын хүрээнд томъёолсон “хөгжиж буй орнуудтай хамтран залуучуудад зориулсан зохистой, бүтээмж өндөртэй ажлын байр бий болгох стратегийг боловсруулж хэрэгжүүлэх” гэсэн 16 дугаар зорилтын оронд дэвшүүлжээ. Энэхүү шинэ зорилт нь насны ялгаварлалгүйгээр нийт хүн ам, түүний дотор хөдөлмөрийн зах зээл дээр хүндрэл бэрхшээлтэй тулгарч байдаг эмэгтэйчүүд, залуучуудыг зохистой, бүтээмж өндөртэй ажлын байраар хангах тухай юм. Түүнчлэн, энэ нь нийт хүн амыг хамарсан *áçðýí* ажил эрхлэлт бий болгоно гэсэн шинэ ойлголтыг бий болголоо.

Хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн талаарх мэдээллийг хувь хүний эрхэлж буй эдийн засгийн үйл ажиллагаанд тулгуурлан гаргадаг бол ядуурлын талаарх мэдээллийг өрхөд суурилан гаргаж байна. Иймээс өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн байдал, өрхийн ядуурлын түвшин хоёрын хоорондын харилцан холбоог анхааралтай судалж дүгнэлт хийх шаардлагатай. 2002-2003 онд хийгдсэн Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний судалгаа (ӨОЗАТС) нь өрхийн тэргүүлэгчийн талаарх мэдээллийг ашиглан ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн уялдаа холбооны талаар судлах боломж олгож байна. Гэхдээ өрхийн тэргүүлэгч нь өрхийн ядуурлын цорын ганц шалтгаан биш, асуудлыг тодруулах үүднээс тухайн өрх хэдэн гишүүнтэй, тэдгээрийн хэд нь ажил хөдөлмөр эрхэлж байгаа, хичнээн тэжээлгэгч байгаа зэргийг авч үзэх шаардлагатай болдог. Зарим тохиолдолд

өрхийн тэргүүлэгч нь гол тэжээгч биш байдаг. Энэ мэтийн сул талуудыг эс тооцож өрхийн орлого, зарлагын судалгааны мэдээллийг ашиглан ядуурлын байдлыг дараах үзүүлэлтээр харьцуулах боломжтой юм. Үүнд: (1) Өрхийн тэргүүлэгч нь малчин өрх, (2) Өрхийн тэргүүлэгч нь мал маллахаас өөр төрлийн ажил эрхэлдэг өрх, (3) Өрхийн тэргүүлэгч нь хөдөлмөр эрхэлдэггүй өрх³⁹, (4) Эдийн засгийн хувьд идэвхгүй боловч тэтгэвэрт гарсан тэргүүлэгчтэй өрх, (5) Тэтгэвэрт гараагүй боловч эдийн засгийн идэвхгүй тэргүүлэгчтэй өрх тус тус орж байна.

2002–2003 оны АТС-ны мэдээлэлд үндэслэн дээр дурдсан бүлгүүдийн дунд ядуурал ямар түвшинд байгааг 3.1 дүгээр хүснэгтэд үзүүлээ.

бүлэг бүрээр, “Хүн амын хувийн жин” мөрөнд бүлэг бүрт ногдож байгаа нийт хүн амын хувийн жинг тус тус үзүүлсэн болно. Нийт ядуу хүн амын хувийн жинг өрхийн тэргүүлэгчийнх нь хөдөлмөр эрхлэлтийн байдлыг илэрхийлсэн таван бүлгээр авч үзвэл: өрхийн тэргүүлэгч нь малчин өрх – 28.8 хувь, өрхийн тэргүүлэгч нь мал маллахаас өөр төрлийн ажил эрхэлдэг өрх – 37.8 хувь, ажилгүй өрхийн тэргүүнтэй өрх – 4 хувь, өрхийн тэргүүн нь тэтгэвэрт гарсан өрх – 15.6 хувь, эдийн засгийн хувьд идэвхгүй бөгөөд тэтгэвэр авдаггүй өрхийн тэргүүнтэй өрх – 13.8 хувь тус тус байна. Хэдийгээр өрхийн тэргүүлэгч нь ажилгүй өрхийн хүн амын нийт хүн амд эзлэх хувийн жин бага байгаа ч өрхийн тэргүүлэгч нь ажилгүй өрхийн ядуурлын түвшин нь бараг 50 хувь байна.

Хүснэгт 3.1 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн байдлаар, Монгол Улс, 2002-2003

	Улсын дундаж	Ажилтай		Ажилгүй	Ажиллах хүчнээс гадуур	
		Малчин	Бусад		Тэтгэвэр авагчид	Бусад
<i>ᠶ᠋ᠠᠳᠤᠭᠤᠷᠯᠠᠮ ᠬᠠᠮᠷᠠᠯᠲᠤᠨ ᠬᠦᠷᠦᠭᠡ</i>						
Ядуурлын хамралтын хүрээ	36.1	39.2	30.3	48.7	35.7	51.4
Ядуурлын гүнзгийрэлт	11.0	11.4	8.6	16.7	10.9	19.2
Ядуурлын мэдрэмж	4.7	4.5	3.5	7.4	4.7	9.6
<i>ᠶ᠋ᠦ ᠬᠦ ᠡᠳᠦ ᠵᠦᠴᠦᠴᠡᠭᠦᠳᠦᠳᠦᠳᠦ</i>						
Өрхийн ам бүлийн тоо	4.3	4.2	4.4	4.7	3.9	4.6
Хүн ам зүйн ачаалал (%)	43.3	45.0	38.0	42.2	57.0	37.5
Хүүхдийн тоо (өрхийн ам бүлд эзлэх %)	31.2	32.6	34.7	40.9	17.1	34.4
Өрхийн тэргүүлэгчийн нас	44.5	41.1	41.0	37.7	61.9	39.6
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%)	82.5	88.6	85.5	86.3	63.1	86.8
Ядуурлын шугамнаас доогуур хүн ам (%)	100.0	28.8	37.8	4.0	15.6	13.8
Хүн амын хувийн жин (%)	100.0	26.5	45.0	3.0	15.8	9.7
Ядууралд өртөх магадлалын харьцаа		1.09	0.84	1.33	0.99	1.42

ᠶ᠋ᠳᠦ ᠨᠡᠳᠦᠳᠡᠭᠡᠭᠡ: УСГ, ДБ, НҮБХХ. ӨОЗАТС 2002-2003, 27-р хуудасны мэдээллээс тооцсон зохиогчийн тооцоо.

Энэ хүснэгтийн “Ядуурлын гүнзгийрэлт” мөрөнд ядуу өрхийн эзлэх хувийн жин бүлэг бүрээр, “Ядуурлын шугамаас доогуур амьдарч байгаа хүн ам” гэсэн мөрөнд ядуурлын шугамаас доогуур амьдарч байгаа хүн амын хувийн жин

Өрхийн тэргүүлэгч нь мал малладаггүй, бүтэн цагийн ажилтай ядуу өрх нийт өрхийн 37.8 хувь байгаа нь ихээхэн анхаарал татаж байна. Үүнд янз бүрийн хөдөлмөр эрхэлдэг хүмүүс орж байгаа нь ажил олгогчийнх нь төрлөөр нарийвчлан авч үзэх шаардлагатайг харуулж байна. Ийм төрлийн мэдээллийн дүнг 3.2-р хүснэгтэд үзүүлсэн болно.

³⁹ *ᠠᠶᠢᠨᠭᠡᠳᠡᠳᠡᠳᠡᠳᠡ ᠳᠦᠴᠦᠴᠡᠭᠡ ᠨᠠᠭᠠᠭᠡᠳᠡᠳᠡᠳᠡ ᠶᠡᠭᠡᠨ ᠴᠡᠨᠡᠨᠢ “ᠰᠣᠳᠠ”*
ᠳᠡᠶᠡ ᠠᠶᠢᠳᠦ ᠡᠭᠡᠢᠳᠡᠳᠡ ᠠᠶᠢᠳᠡᠳᠡᠳᠡ ᠠᠶᠢ ᠳᠡᠳᠡ ᠨᠢᠶᠢᠳᠡ ᠠᠭᠡᠳᠡᠳᠡᠳᠡᠳᠡᠳᠡᠳᠡ ᠳᠦᠴᠦᠴᠡᠭᠡ
ᠶᠡ 6.6 ᠳᠣᠶᠢ ᠠᠶᠡᠳᠡ (3.3-ᠳᠦ ᠳᠦᠨᠢᠭᠠᠳᠦ)

Тухайн бүлгийн хүн амын ядуурлын хамралтын хүрээг нийт хүн амын ядуурлын хамралтын хүрээнд харьцуулсан харьцаа буюу “ядууралд өртөх магадлалын харьцаа”-г дээрх бүлгүүдээр тооцлоо. Нэгээс бага утга нь тухайн бүлэгт багтаж байгаа өрхүүд дундаж амьдралтай өрхтэй харьцуулахад ядууралд өртөх магадлал багатай байгааг харуулах бөгөөд нэгээс их утга нь тухайн өрх дундаж өрхтэй харьцуулахад ядууралд өртөх магадлал илүү байгааг харуулна.

Ядууралд өртөх магадлалын харьцаа өрхийн тэргүүлэгч нь малчин өрх – 1.09, өрхийн тэргүүлэгч нь бусад ажил эрхэлдэг өрх – 0.84, өрхийн тэргүүлэгч нь ажилгүй өрх – 1.33, өрхийн тэргүүлэгч нь тэтгэвэрт гарсан өрх – 0.99, өрхийн тэргүүлэгч нь эдийн засгийн хувьд идэвхгүй бөгөөд тэтгэвэрт гараагүй өрх – 1.42 тус тус байна.

Дээрх тооцооноос үзэхэд эдийн засгийн хувьд идэвхгүй бөгөөд тэтгэврийн бус өрхийн тэргүүлэгчтэй өрхүүд ядууралд өртөх хамгийн өндөр эрсдэлтэй бүлэг болж байгаа бол өрхийн тэргүүлэгч нь ажилгүй өрхүүд үүнээс арай бага эрсдэлд байна. Малчин тэргүүлэгчтэй өрхүүд дундаж өрхүүдтэй харьцуулахад ядууралд өртөх илүү эрсдэлтэй байхад өрхийн тэргүүлэгч нь мал маллахаас өөр ажил эрхэлдэг өрхүүд дундаж өрхтэй харьцуулахад ядууралд өртөх эрсдэл харьцангуй багатай байна. Гэхдээ энэ бүлгийн хүн ам ядууралд өртөмтгий байгааг тэмдэглэх нь зүйтэй юм.

ӨОЗАТС-ны мэдээллийг үндэслэн “бусад ажил” эрхэлдэг тэргүүлэгчтэй өрхүүдийн ядуурлын түвшинг эрхэлж буй бизнесийнх нь өмчлөлийн төрлөөр судалж дараах хүснэгтэд үзүүлэв.

Төрийн албан хаагч тэргүүлэгчтэй өрхийн ядууралд өртөх магадлалын харьцаа 0.7, улсын өмчийн үйлдвэрт⁴⁰ ажилладаг тэргүүлэгчтэй өрхийн ядууралд өртөх эрсдэл 0.6 байгаа нь дундаж

өрхүүдтэй харьцуулахад ядууралд өртөх эрсдэл бага байна.

Хүснэгт 3.2 Өрхийн тэргүүлэгч нь хувийн, улсын өмчийн болон төрийн байгууллагад ажилладаг өрхийн ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, Монгол Улс, 2002-2003

	Хувийн	Улсын	Төрийн өмчит
<i>βᠠ ᠔᠔᠔ᠡ᠋᠋᠋ ᠠᠠᠡᠡᠠᠡ:</i>			
Ядуурлын хамралтын хүрээ	34.7	25.9	21.6
Ядуурлын гүнзгийрэлт	9.9	7.5	4.9
Ядуурлын мэдрэмж	4.1	3.0	1.7
<i>ᠯᠦ ᠶᠦ ᠡ᠔ ᠵᠴᠵᠵᠡᠬᠦᠡ᠔ᠵᠵᠠ:</i>			
Өрхийн ам бүлийн тоо	4.4	4.5	4.5
Хүн ам зүйн ачаалал (%)	39.4	37.2	32.2
Хүүхдийн тоо (өрхийн ам бүлд эзлэх %)	36.0	33.5	31.6
Өрхийн тэргүүлэгчийн нас	40.0	42.3	41.4
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%)	87.3	82.0	91.6
Ядуурлын шугамнаас доогуур хүн ам (%)	23.2	12.8	1.8
Хүн амын хувийн жин (%)	24.1	17.9	3.0
Ядууралд өртөх магадлалын харьцаа	1.0	0.7	0.6

ᠶᠡ ᠋᠋᠔᠔ᠠᠶᠡᠭᠡ: УСГ, ДБ, НҮБХХ. ӨОЗАТС 2002-2003. x27

Гэхдээ хувийн салбарт ажилладаг тухайлбал, албан буюу албан бус салбарт ажилладаг тэргүүлэгчтэй өрхүүдийн ядууралд өртөх магадлалын харьцаа 1.0 байгаа нь тэдний ядуурлын түвшин улсын хэмжээний ядуурлын түвшинтэй адил байна.

Эдгээр тоо баримтыг үндэслэн хөдөлмөр эрхлэлт, ядуурлын хоорондын уялдаа холбооны талаар дараах дүгнэлтийг хийж болох юм. Өрхийн тэргүүлэгчийнх нь ажил эрхлэлтийн байдлаар ангилан өрхүүдийг дундаж өрхтэй харьцуулж үзэхэд ядууралд өртөх өндөр эрсдэлтэй 3 бүлэг өрх байгаа нь ажиглагдаж байна. Энэ бол малчин өрхийн тэргүүлэгчтэй өрхүүд, эдийн засгийн идэвхгүй бөгөөд тэтгэврийн биш тэргүүлэгчтэй өрхүүд, ажилгүй тэргүүлэгчтэй өрхүүд юм. Дээрх гурван бүлгийн хүн ам нийлээд Монгол улсын нийт хүн амын 39.2 хувийг, ядуучуудын 46.6 хувийг бүрдүүлж байна. Түүнчлэн хувийн салбарт ажилладаг малчин биш тэргүүлэгчтэй өрхүүдийн ядуурлын түвшин харьцангуй өндөр байгаа бөгөөд

⁴⁰ *᠒ᠡᠨᠠᠢ ᠶᠡᠡᠡ᠋ ᠵᠡᠡᠠᠶᠡ᠔ ᠠᠶᠢᠶᠠ᠔ ᠶᠡ᠔ᠠᠶᠢᠲᠡᠡ ᠔᠔ᠡ᠋᠋ ᠠᠠᠶᠠᠳᠡᠳᠡ ᠵᠡᠡᠠᠶᠡ᠔, ᠠ ᠶᠢᠠᠲᠡ ᠡ᠋᠋᠋ ᠲᠡᠶᠢᠳᠡ ᠵᠠᠢ, ᠠ ᠶᠢᠠᠲᠡ ᠡ᠋᠋᠋ ᠠᠠᠠᠠᠳᠠᠳᠠᠳᠠᠳᠠ ᠲᠡᠶᠢᠶᠠᠳᠡ ᠠᠶᠢᠲᠡ ᠶᠡ᠔ ᠠᠠᠨᠠᠠ ᠔ᠡᠨᠠᠢ ᠶᠡᠡᠡ᠋ ᠵᠡᠡᠠᠶᠡ᠔ᠵᠡᠡᠡ᠋ ᠲᠡ ᠔᠔ᠡ᠋᠋.*

нийт хүн амын ядуурлын түвшинтэй ойролцоо байна. Хувийн салбарт хөдөлмөр эрхлэх нь Монгол Улсын олон арван өрхийн орлогын гол эх үүсвэр болж байгаа ч хувийн салбарт ажилладаг нэлээд хэсгийнх нь ядуурлын түвшин өндөр, цалингийн орлого нь тэднийг болон тэдний гэр бүлийг ядуурлаас гаргаж чадахааргүй байна.

2002-2003 оны ӨЗОАТС-гаар төрийн албан хаагч тэргүүлэгчтэй өрхүүдийг дээрх өрхүүдтэй харьцуулахад тэдний ядуурлын түвшин харьцангуй бага ч 21.6 хувьтай байгаа нь Монгол улсад бодит цалин хэтэрхий бага байгаатай холбоотой юм.

3.1.2 Ажилгүйдэл, ядуурал⁴¹

Ажилгүйчүүдийн дунд ядуурал өндөр байгаа нь ажлын байрыг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

Хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн дунджадууралх байгаа нь хөдөлмөрийн үнэлэмж өндөртэй ажлын байрыг бий болгох хэрэгтэй байгааг илэрхийлж байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас гаргасан тоон үзүүлэлтээс харахад сүүлийн 5 жилд ажилгүйдлийн түвшин тогтвортой 3.7 орчим хувьтай байжээ. Монгол Улсын үндэсний статистикийн мэдээллээс үзэхэд 2006 онд нийт 32928 ажилгүйчүүд бүртгүүлсний 43.0 хувь нь эрэгтэйчүүд, 57.0 хувь нь эмэгтэйчүүд байна. Энэ нь нийт ажиллах хүчний 3.2 хувьтай тэнцэж байгаа бөгөөд өнгөц харахад ажилгүйдэл нь Монгол Улсын хувьд тулгамдсан асуудал биш мэт сэтгэгдэл төрүүлж байна.

Азийн бусад олон оронд тохиолдож байгаа бэрхшээлүүдийн нэгэн адил зөвхөн ажилгүйдлийн талаарх хэмжүүрээр дагнан хөөцөлдөх нь хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдалд “онош” тавихад

хангалтгүй юм. Хөгжиж буй орнуудад олонх эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд өөрсдийн наад захын үндсэн хэрэгцээгээ хангахын тулд долоо хоногт ядаж цөөн хэдэн цагаар ч гэсэн ажил олж хийдэг учир тэднийг ажилгүй гэсэн ангилалд биш харин хөдөлмөр эрхэлдэг гэсэн бүлэгт хамааруулж тооцдог тул ажилгүйдлийн түвшин эдгээр оронд маш доогуур гэж гардаг. Монгол Улсад бусад олон орны нэгэн адил ажил хөдөлмөр эрхлэлтийн талаарх албан ёсны тодорхойлолтоор хагас цагаар ажил хийдэг, албан бус салбарт ажилладаг нэлээд хэсгийг “ажил эрхэлдэг” гэсэн бүлэгт хамруулдаггүй учир дээрх бүлгийн хүмүүс өөрсдийгөө “ажилгүй” гэж тодорхойлдог байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас архи, согтууруулах ундааны хэрэглээний талаар 9 аймагт явуулсан түүвэр судалгаанаас гаргасан сонирхолтой жишээ дээр дурдсан байдлыг мөн баталж байгаа юм. Судалгаанд хамрагдсан хүмүүсээс хөдөлмөр эрхлэлтийн байдлыг нь асуухад тэдний 31 хувь нь “ажилгүй” гэж хариулсан нь ажил эрхлэлтийн талаар явуулсан албан ёсны олон судалгааны дүнгээс өндөр байжээ. Энэ шалтгааны улмаас ажиллах хүчний талаарх асуудлыг цаашид судлахдаа илүү өргөн хүрээний тоо баримт болон үзүүлэлтүүдийг ашиглах нь чухал болно.

Ажилгүйдлийн албан ёсны түвшинг ажилгүй, ажил хайж байгаа хэмээн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн байгууллагад албан ёсоор бүртгүүлсэн хүмүүсийн тоогоор тооцож байна. Ажилгүй хүмүүс тэр бүр хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн байгууллагад бүртгүүлдэггүй, зарим хүмүүс ажилтай боловч илүү сайн ажил олох, давхар ажил олж хийх зорилгоор бүртгүүлдэг зэргээс болж энэ мэдээлэл тэр бүр олон улсын стандартад нийцэхгүй байна.

Ажилгүй, ажлын ямар нэг хамааралгүй хүмүүс, ажил хийхэд бэлэн байгаа, ажил идэвхтэй хайж байгаа хүмүүсийн талаарх мэдээлэл буюу хүн амын тооллого, ажиллах хүчний судалгаа,

⁴¹ Үүгээр өөрөөр өгөгдөлүүдийг үндэслэн үзвэл 2002-2003 онд нийт 32928 ажилгүйчүүд бүртгүүлсний 43.0 хувь нь эрэгтэйчүүд, 57.0 хувь нь эмэгтэйчүүд байна. Энэ нь нийт ажиллах хүчний 3.2 хувьтай тэнцэж байгаа бөгөөд өнгөц харахад ажилгүйдэл нь Монгол Улсын хувьд тулгамдсан асуудал биш мэт сэтгэгдэл төрүүлж байна.

өрхийн түвшний судалгаа гэх мэт эдийн засгийн үйл ажиллагааны талаарх асуулт бүхий судалгаа, тооллогоос гаргаж болно. Ажиллах хүчний судалгааг манай улсад анх 2002-2003⁴² онд явуулсан бөгөөд ажилгүйдлийн түвшин 14.2 хувь буюу нэлээд өндөр гарсан байна. Үүний зэрэгцээ үндэсний хэмжээнд төлөөлөх чадвартай Өрхийн орлого зарлага, амьжиргааны түвшний судалгааг мөн онд явуулсан байна. Энэ судалгааны дүнгээр ажилгүйдлийн түвшин 6,6 хувь (2002–2003) байжээ.

Нэг жилийн дотор явуулсан, үндэсний хэмжээнд төлөөлөх чадвартай дээрх хоёр судалгааны дүнгээр ажилгүйдлийн түвшин ийнхүү ялгаатай байгаа нь “ажилгүйчүүдийн” талаарх тодорхойлолт янз бүр байгаагаас үүдэлтэй. Ажиллах хүчний судалгаанд ажилгүйдлийг өргөн хүрээнд “уян хатан” тодорхойлолтоор буюу тухайн үед ажилгүй, ажил эрхлэхэд бэлэн байгаа бүх хүнийг ажил хайж байгаа эсэхийг нь үл харгалзан ажилгүйчүүдэд хамруулж тооцсон. Ажиллах хүчний түүвэр судалгаа нь ажил олж чадах итгэл алдсаны улмаас ажил хайхгүй байгаа ажилгүй бүх хүмүүсийг хамруулахын тулд дээрх тодорхойлолтыг авч хэрэглэжээ. Гэтэл амьжиргааны түвшний судалгаа нь “шууд” тодорхойлолтыг мөрдсөн буюу зөвхөн ажилгүй, ажил хийхэд бэлэн байгаа, ажил идэвхтэй хайж байгаа хүмүүсийг л ажилгүй гэж тооцсон байна. Ажилгүйдлийн ялгаатай түвшин, дээрх судалгаануудын хэрэглэсэн өөр өөр тодорхойлолтуудыг доорх 3.3-р хүснэгтэд нэгтгэн үзүүлээ.

Хүснэгт 3.3 Ажилгүйдлийн үзүүлэлтүүд, Монгол Улс, 2002-2003

Ажилгүйчүүд гэсэн үзүүлэлтийн тодорхойлолт, эх сурвалж	Ажилгүйдлийн түвшин
Хөдөлмөр эрхлэлт,нийгмийн халамжийн байгууллагаас гаргасан албан ёсны статистик-зөвхөн бүртгэгдсэн ажилгүйчүүд	3.4
Амьжиргааны түвшний судалгааны мөрддөг “шууд” тодорхойлолт - ажилгүй, ажил хийхэд бэлэн байгаа, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй хүмүүс	6.6
Ажиллах хүчний судалгааны баримталдаг “уян хатан” тодорхойлолт - ажилгүй болон ажил хийхэд бэлэн байгаа бүх хүмүүсийг тэдний ажил идэвхтэй хайж байгаа эсэхийг үл харгалзан ажилгүйчүүдэд хамруулж тооцдог	14.2

Үд нодоодөө: ᠨᠠ, АОА. Аææëë àð òç-iéë ñòààëääà 2002-2003, ò 62. ᠨᠠ, АА, Г-А ОО, ЧС/А ОН 2002-2003, ä. 60.

Ажиллах хүчний судалгаа ажилгүйдлийн түвшин өндөр байгааг харуулж байгаа ч ажилгүйдлийг Монгол Улсад тулгарч байгаа хамгийн нэн тэргүүний, эсвэл хоёр дахь хүндрэлтэй асуудал хэмээн удаа дараа тодорхойлоод байгаа олон нийтийн үзэл бодол, хандлагыг тандах судалгааны үр дүнтэй дүйцүүлэн үзэхэд хангалттай бус байна. Ажилгүйдлийн түвшний талаар судлах явцад нийт ажиллах хүчний 35 хувийг малчид эзэлдэг гэдгийг санаж байх нь чухал бөгөөд хэдийгээр ядуурлын түвшин малчдын дунд өндөр буюу 39.2 хувь гэдэг боловч малчид заримдаа ажилгүй гэж хариулдагийг анхаарах хэрэгтэй. Хэрвээ нийт ажиллах хүчний тооноос малчдын тоог хасч мал аж ахуй эрхэлдэггүй хүмүүсийн ажилгүйдлийн түвшинг тооцож үзвэл даруй 50 хувь болж нэмэгдэнэ.

Хүснэгт 3.4 Ажилгүйдлийн түвшин, ядуурлын байдлаар, Монгол Улс, 2002-2003

	Ядуу	Ядуу бус	Бүгд
Улсын хэмжээнд	10.2	4.9	6.6
Хот	15.9	6.8	9.1
Хөдөө	6.5	2.6	4.1

Үд нодоодөө: УСГ, ДБ, НУБХХ. ӨЗОАТС 2002-2003.

Монгол Улсад ажилгүйдэл, ядуурлын хоорондын хамаарлыг дараах байдлаар нэгтгэн дүгнэж болох юм. Үүнд:

⁴²Үүд òç-iéë ò àææàì ìù äààæèì ñççèèì çàèéì àññýì ìý àýýèèèä àòæä èàñàì. О᠑᠗᠑᠑᠐᠔᠔᠑ çàðçýýèèì àì èì ì ýäòòèùì òèìæ ð᠑᠗᠗᠑᠐᠔᠔᠑ ð àææàò᠔᠔᠑ ᠑᠔ ðèèì òç-iééèé ìàðèèä-èè ñàì àçì òèìæèèàýýì 2002-2003 ìà ᠨᠠ-ñ ýäòèñàì Àææèè àð òç-iéé ñòààëääà, 2002-2003 ìà ýäòèñàì Àììæèäààìù òç-iééèé ñòààëääà ò òñ ò òñ àòæä èàñàì àì èù. Àì èì ìæòé òì ðèì èàì èà ýäýýð ñòààëääàìòòààì çð àçìᠠ ᠨᠠ-àì ñççèèì çàèéì òñ ìý àýýèèèä ò àðìòòèàì çç ñýì àì èì

ажилгүйчүүд нь ажилтай хүмүүсийг бодвол ядууралд илүү өргөмтгий байгаа хэдий ч тэд ядуучуудын маш бага хувийг эзэлж байна. Хүснэгт 3.4-т үзүүлсэн 2002-2003 оны ӨОЗАТС-аар ажилгүйдлийн түвшин ядуу бус хүмүүсийн дунд 4,9 хувь байхад ядуучуудын дунд 10.2 хувь, мөн энэ үзүүлэлт нь хотод оршин сууж буй ядуу бус хүн амын дунд 6,8 хувь байхад ядуучуудын дунд 15.9 хувь байгаа. Гэвч улсын хэмжээгээр арван ядуу хүний нэг нь ажилгүй байна. Үүнээс үзэхэд хөдөлмөр эрхлэхгүй байх явдал Монгол Улсын хувьд ядуурлын гол шалтгаан биш гэдгийг илэрхийлж байна. Хот, суурин газруудад гэхэд зургаан ядуу хүний нэг нь ажилгүй байгаа бөгөөд ядуучуудын дийлэнх нь ямар нэгэн ажил хийж байна. Ядуурал, ажилгүйдлийн түвшний үзүүлэлтүүдийг хооронд нь харьцуулж харахад Монгол Улсад ядуурал нь ажилгүйдлээс илүү тулгамдсан асуудал болоод байна. Товчоор хэлбэл, Монгол Улсын ядуу хүмүүсийн дийлэнх нь ажилгүйчүүд биш харин “ажилтай ядуучууд” байна.

Тав дахь зөвлөмж

Хөдөлмөрийн зах зээлийн тухай мэдээллийг боловсронгуй болгох талаар

- Бодлого боловсруулагч болон бусад сонирхогч талуудыг хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлын талаарх мэдээллээр тогтмол хангаж байх үүднээс ажиллах хүчний тухай судалгааг олон улсын стандартад нийцүүлэн улирал, жилээр хийж байх;
- Хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээллийг хүйсээр задлан гаргаж, тайлагнадаг болох;
- Тогтмол болон нэг удаагийн судалгаа, тооллогын ажлыг системтэйгээр зохион байгуулах;
- Сургалт зохион байгуулдаг газар, бизнесийн үйл ажиллагаа, малчид, ажил эрхлэлтийн асуудлаар зөвлөгөө өгдөг, мэдээллээр хангадаг, ажил олж өгөх туслалцаа үзүүлдэг байгууллагын талаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн практик амьдралтай холбоотой мэдээлэл цуглуулж, судалж, олны хүртээл болгож байх;

3.1.3 Эдийн засгийн идэвхгүй хүн ам

2002-2003 оны ӨОЗАТС-наас үзэхэд “ажиллах хүчнээс гадуур” тэргүүлэгчтэй өрхүүдийн ядууралд өртөх эрсдэл хамгийн өндөр буюу 9.7 хувь байна. Энэ бүлэг нь Монгол улсын нийт ядуучуудын 13.8 хувийг эзэлж байна. Эдгээр өрхийн шинж байдал, бүтцийг нарийвчлан судлах нь хүн амын орлогыг нэмэгдүүлэх талаар хэрэгжүүлэх бодлогыг тодорхойлоход чухал нэмэр болох юм.

Улс орныхоо дотоодын нийт бүтээгдэхүүнд тооцогдох бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгоход идэвхтэй оролцон хөдөлмөр эрхэлж буй ажиллах хүчинд багтсан эрэгтэй, эмэгтэй хүмүүс, мөн ийм төрлийн ажил хийхэд бэлэн байгаа болон ийм төрлийн ажил хайж байгаа хүмүүсээс бусад дээрх эдийн засгийн үйл ажиллагаанд оролцохгүй байгаа хөдөлмөрийн насны хүн амыг “идэвхгүй хүн ам” гэж үзнэ. Гэхдээ “идэвхгүй байдал”-ыг маш анхааралтай авч үзэх шаардлагатай. Жишээ нь, ямар нэгэн сургуульд үргэлжлүүлэн суралцаж байгаа хөдөлмөрийн насны хүмүүсийг идэвхгүй хүн амд оруулна. Иймд хөгжил дэвшлийн үр дүнд хүүхэд залуус дээд боловсрол эзэмших, төрөл бүрийн сургалтад өргөнөөр хамрагдах зэргээс болж хөдөлмөр оролцооны коэффициент буурах үзэгдэл түгээмэл байдаг. Үүнээс гадна хүмүүс өндөр насны тэтгэвэрт гарах, ажиллахад “дэндүү хөгшиднэ” хэмээн ажил хийхээ зогсоох зэргээс үүдэн идэвхгүй хүн амын тоо нэмэгдэнэ. Энэ бүлгийн хүн амын тоо нийт хүн амын насжилтын үр дагавраар нэмэгдэх бололцоотой. Идэвхгүй хүн амд мөн өвчний улмаас ажил хийхээ “түр” зогсоосон хүмүүс багтана. Ажил хийх боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс идэвхгүй хүн амд мөн орно. “Зүгээр суухаас” бусад ямар нэгэн шалтгаанаар тэтгэвэрээ бүрэн тогтоолгон авч байгаа ч тэтгэвэр тогтоолгох хуулийн насандаа хүрээгүй тэтгэвэрт гарсан хүмүүсийг мөн идэвхгүй хүн амд оруулж болох юм. Монгол Улсад өнөөгийн мөрдөж байгаа хуулиар эмэгтэйчүүд 55 насандаа

буюу эрэгтэйчүүдээс 5 жилээр өмнө тэтгэвэрт гарч байна. Ийнхүү тэтгэврийн нас ялгаатай байгаа нь жендэрийн тэгш байдлын асуудлыг хөндөж байгаа бөгөөд хүмүүс илүү урт хугацаагаар ажилласнаар өөрсдийн орлого олох хугацааг тийм хугацаагаар хадгалах, тэтгэвэрт гарахдаа илүү тэтгэвэр авах боломжийг бүрдүүлж өгдөг. Хүнд хортой нөхцөлд ажиллагчид, цэрэг армид алба хаагчид эрт тэтгэвэрт гарч байна.

Цалин хөлсгүй гэр ахуйн ажил, гэр орныхноо асрамжлах үүрэг гүйцэтгэж байгаа хүмүүс идэвхгүй хүн амд багтаж байна. Эдгээр хүмүүс “эдийн засгийн идэвхтэй” хүн амд тооцогдохгүй боловч гэр бүлийнхэн, хамт олныхоо сайн сайхан амьдрал амжилтад өөрийн хувь нэмрийг оруулж байгаа билээ. Хэрвээ ийм төрлийн ажлыг цалин хөлстэй гүйцэтгүүлбэл тэр нь эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаанд тооцогдох бөгөөд тухайн ажлыг гүйцэтгэж байгаа хүнийг ажиллах хүчинд хамааруулан тооцож болох юм.

Идэвхгүй хүн амын тоо нь ажилгүйчүүдийн тодорхойлолт, хэмжүүрээс ихээхэн хамааралтай. Өмнө өгүүлсэнчлэн ажилгүйдлийн “уян хатан” тодорхойлолтоор авч үзвэл ажилгүй, ажиллахад бэлэн байгаа боловч ажил хайхгүй байгаа хүмүүсийг ажилгүй гэсэн ангилалд хамааруулах бөгөөд ажилгүйдлийн “шууд” тодорхойлолтоор тэднийг идэвхгүй хүн ам буюу “ажил олох итгэл найдвараа алдсан” хүмүүс хэмээн тооцдог. Ажил олох найдвараа алдсан хүмүүс гэдэгт ажлын байр хязгаарлагдмал буюу байхгүй, ажил олдсон ч цалин хөлс, бусад нөхцлүүд нь тэдний хүссэн хэмжээнд байхгүй хэмээн үзэж ажил хайхаа зогсоосон хүмүүсийг багтааж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн талаар мэдээлэл өгч байгаа хүмүүсийн буруу зөрүү ойлголтын улмаас мэдээлэл цуглуулах явцад гарч болох алдаанд анхааралтай хандах нь зүйтэй. Жишээ нь, эдийн засгийн шилжилтийн эхний үед хүмүүс хөдөлмөр

эрхлэлтийг зөвхөн төрийн үйлчилгээний байгууллага, улсын үйлдвэрийн газруудад л цалинтай ажил хийх гэж ойлгож байсан. Хувиараа хөдөлмөр эрхлэх, албан бус эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх шинэ боломжууд бий болсон хэдий ч энэ нь албан хөдөлмөр эрхлэлт гэж үзэгдэхгүй ажиллах хүчинд хамаарч тооцогдохгүй байв. Зарим хүмүүс албан салбараас гарч “ажилгүй” болсон учир түүнийгээ даван туулах гол аргаа албан бус ажил хийх явдал хэмээн үздэг байна.

Ингэхлээр “идэвхгүй” гэсэн ангилалд хамаарагдах хүн амын бүлгийг анхааралтай авч үзэх шаардлагатай. Тэтгэврийн хуулийн нас болох 60 хүрэхээсээ өмнө өөрийн хүсэлтээр хөдөлмөрийнхөө гэрээ, Монгол Улсын мөрдөж байгаа хуулийн дагуу тэтгэвэрт гарсан хүмүүсийн тухайд бодлогын үүднээс авч үзвэл хөдөлмөрийн насны боловч орлогогүй, ажил хайхгүй байгаа хэсгээсээ өөр асуудал юм. Хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдалд итгэл алдарсанаас найдлага тасарч тодорхой хугацаанд ажил хайхаа больсон хүн амын нэг хэсэг байна. Гэхдээ энэ хэсгийг “зүгээр суух”-ыг хүсэгчид гэж үзэж бас болохгүй юм.

Түүнчлэн эмэгтэй, эрэгтэйчүүд ажиллах хүчнээс гадуур үлдэж болох нийгмийн тусгаарлалтын эрсдэл байж болох талтай. Хамгийн сүүлд явуулсан ядуурлыг оролцооны аргаар үнэлэх судалгааны үеэр хийсэн бүлгийн ярилцлагад оролцогчид “залхуу байдал, гутрангүй үзэл, архидалт”-ын талаар санаа зовж байдгаа илэрхийлсэн байна⁴³.

Ажиллах хүчний эгнээнд багтаагүй эмэгтэй, эрэгтэйчүүдийн талаарх статистикийн зарим мэдээллийг хүн амын тооллого, ажиллах хүчний судалгаа хийх явцад цуглуулжээ. Эдгээр мэдээлэл нь тухайн нэг үеийн “ерөнхий дүр зургийг” харуулж байгаа ч цаг хугацааны динамик хандлагыг илэрхийлэх боломжгүй юм. Засаг захиргааны бүртгэл мэдээлэл, хүн ам, хөдөлмөр эрхлэлтийн талаар

⁴³—*N.A., A.O.A., A.A. βα οδοεῖα ἰδι εἰπιῖν ἀδααὰδ δι αἰδ διέε ἰ ο ἠάαεααα, Οεααἰααὰδ ἀδ, 2006, ὀ. 3.*

хэвлэгдсэн тайлан мэдээгээр жил бүрийн тоон мэдээллийг харж болох боловч эдгээр нь эдийн засгийн үйл ажиллагааны талаарх олон улсын стандарт ойлголттой тэр бүр нийцдэггүй.

Ажиллах хүчний талаарх 2002-2003 оны судалгаанд уг судалгааг явуулж эхлэхийн өмнөх долоо хоногт ажил хийгээгүй, ажилгүй байсан хүмүүсийг ажиллах хүчнээс гадуур буюу “одоогоор идэвхгүй” гэж тодорхойлсон. Энэхүү судалгаа нь ажилгүйдлийн “уян хатан” тодорхойлолтыг мөрдлөг болгосон учир тухайн хүнийг ажилгүй гэж үзэхийн тулд заавал түүнийг ажил идэвхтэй хайсан байхыг шаардаагүй. Харин ажилгүй гэдэгт тухайн үед ажил эрхлээгүй байгаа бөгөөд ажил хийх хүсэл эрмэлзэлтэй хүмүүсийг багтаасан байна. Энэхүү тодорхойлолтын дагуу үлдсэн хэсгийг нь “эдийн засгийн идэвхгүй”-д тооцжээ. Ажиллах хүчнээс гадуур нийт 534400 хүн байгаагийн 307400 нь эмэгтэй, 227400 нь эрэгтэйчүүд бөгөөд тэд чухам яагаад ажиллах хүчнээс гадуур байгаа талаар асууж тодруулсныг дараах хүснэгтэд үзүүлжээ. Энд олон улсын стандартын дагуу 15 болон түүнээс дээш насны хүн амыг хамруулсан болно.

гайхах зүйл биш бөгөөд учир нь хөдөө орон нутагт ямар нэгэн ажилтай байх магадлал өндөр байгаатай холбоотой юм. Хөдөөд цаг агаарын бэрхшээлээс болж ажлаа зогсоох болдог ч өөр ямар нэгэн ажил хийх боломжтой. Олон тооны малчид, газар тариалан эрхлэгчид ажиллах хүчний талаарх 2000-2003 оны судалгаа эхлэхийн өмнөх долоо хоногт дор хаяж нэг цагийг малаа маллах, ургацаа арчлах, тоног төхөөрөмжөө засварлах зэрэг ажилд зарцуулсан байна.

Идэвхгүй хүн амын дийлэнх хэсэг буюу 10 хүн тумын 4 нь (42.3 хувь) сургуульд суралцаж байгаа хүмүүс, дөрөвний нэгээс илүү хувийг (28.5 хувь) тэтгэвэр авдаг хүмүүс эзэлжээ. Гэр ахуйн ажил, хүүхэд асрах ажил хийж байгаа хүмүүс 14.8 хувийг эзэлж байв. Идэвхгүй байдлууд мөн хүмүүсийн хүйс, амьдарч байгаа газраас шалтгаалан ялгаатай байна. Эрэгтэй, эмэгтэйчүүд аль нь сургуульд сурч буй болон тэтгэвэрт гарсан шалтгаанаар голчлон идэвхтэй хүн амын тоонд ороогүй байдал ажиглагдсаны сацуу охид, эмэгтэйчүүдийн хувьд хөвгүүд, эрэгтэйчүүдээс илүүтэйгээр гэрийн ажил хийх, хүүхдээ өсгөн

Хүснэгт 3.5 15, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвхгүй хүн амын бүлгийн идэвхгүй байгаа шалтгаан, хүйс, байршлаар, Монгол Улс, 2002-2003

Эдийн засгийн идэвхгүй байгаа шалтгаан	Бүгд			Хог			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Гэрийн ажилтай	10.2	7.1	12.4	8.8	5.6	11.3	13.2	10.7	15.0
Суралцдаг	38.7	42.3	36.0	42.5	46.4	39.5	30.0	32.3	28.3
Тэтгэвэрт, өндөр настан	28.5	26.0	30.4	26.9	24.4	28.8	32.2	29.8	33.9
Хөгжлийн бэрхшээлтэй	5.1	6.4	4.0	4.7	6.2	3.6	5.8	7.0	4.9
Ажил хийхэд бэлэн бус	2.2	3.3	1.4	2.4	3.8	1.3	1.8	2.3	1.5
Хүүхэд асардаг	4.6	0.5	7.6	5.0	0.5	8.4	3.6	0.3	5.9
Өвчтэй байсан	2.9	3.5	2.4	2.8	3.5	2.3	3.0	3.3	2.7
Хөдөлмөрийн насанд хүрээгүй	1.1	1.3	1.0	0.9	1.2	0.6	1.7	1.5	1.7
Бусад	6.7	9.6	4.8	6.0	8.4	4.2	8.7	12.8	6.1
Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	534400	227400	307000	372500	160900	211600	161900	66500	95400


Үг нэрлэлт: УСГ, АХБ. 2004. Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан 2002–2003, хүснэгт 3.8, х 48.

Одоогоор идэвхгүй гэж тооцогдсон хүний тоо хот суурин газруудад (372500) хөдөө орон нутгаас (161900) илүү олон байна. Ийнхүү хөдөлмөр оролцооны түвшин хөдөөд өндөр байгаа нь тийм ч

хүмүүжүүлэх шалтгаанаар ажиллах хүчинд орж тооцогдоогүй байв. Түүнчлэн эмэгтэйчүүдийн тэтгэвэрт гарах хуулийн нас эрт эхлэх боломжтойгоос улбаалан эмэгтэйчүүдийн энэ шалтгаанаар идэвхгүй

хүн амын тоонд орсон хувийн жин эрэгтэйчүүдийнхтэй харьцуулахад өндөр байна. Их, дээд сургуульд эмэгтэйчүүд илүүтэй суралцдаг, хуулиар тэтгэвэрт эрт гарах боломжтой, мөн гэр орны ажил, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд тэд илүүтэй оролцдог зэрэг шалтгааны улмаас эдийн засгийн идэвхгүй хүн амын нийт тоонд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өндөр байна.

Дүрслэл 3.1 Эдийн засгийн идэвхгүй нийт хүн амын дунд 15, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь, идэвхгүй байгаа шалтгаан, хүйсээр, Монгол Улс, 2002-2003




Үг нэрлэл: УСГ, АХБ. 2004. Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан 2002–2003, хүснэгт 38, х 48.

Суралцаж байгаа шалтгаанаар ажиллах хүчнээс гадуур байгаа хүн амын тоо хот суурин газарт хөдөө орон нутгийнхнаас олон байна. Энэ нь ерөнхий боловсролын сургуулиас дээш шатны боловсрол, сургалтын байгууллагууд болох коллеж, их, дээд сургуулиуд ихэвчлэн аймгийн төвүүд, нийслэлд төвлөрсөн байдаг учир нэг их гайхах зүйл биш юм.

Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцохгүй байгаа хүн амын дунд олон төрлийн бүлгүүд багтаж байгаа нь тодорхой харагдаж байна. Иймээс зарим нэгэн нэмэлт мэдээлэл авч шинжилгээ хийхгүйгээр ажиллах хүчнээс гадуур байгаа хүмүүсийг ажиллах хүсэлгүй гэж дүгнэх боломжгүй юм. Хөдөлмөрийн насны боловч хөдөлмөр эрхлэхгүй байгаа, суралцахгүй байгаа хүний тоо 2001-2002 онд нэмэгдсэн боловч түүнээс хойш буурах хандлагатай байна.

Дүрслэл 3.2 Хөдөлмөрийн насны нийт хүн амд эзлэх ажиллаагүй болон сураагүй байгаа хүмүүсийн хувийн жинг ажил эрхлэлтийн түвшин болон ажилгүйдлийн түвшинтэй харьцуулсан байдал, Монгол Улс, 1992-2006



Үг нэрлэл: УСГ. Хүн амын ажил эрхлэлт 2006.

3.2 Өрхийн, өрхгүй, өрхөө өрхгүйгээр олоогийн ажилгүй ажилгүй ажилгүй ажилгүй

Өрхүүдийг тэргүүлэгчийнх нь ажил эрхлэлтийн байдлаар ангилан авч үзвэл дараах гурван бүлгийн өрх ядууралд илүү өртөмтгий байна. Үүнд:

- Өрхийн тэргүүн нь ажилгүй өрхүүдийн ядуурлын түвшин маш өндөр буюу тэдний тал хувь нь ядуу байна.
- Өрхийн тэргүүн нь эдийн засгийн идэвхгүй, тэтгэвэрт гараагүй өрхүүд нь бидний авч үзсэн бусад бүх бүлгүүдийн дотроос ядууралд өртөх хамгийн их магадлалтай байсан буюу тэдний талаас илүү хувь нь ядуурлын шугамнаас доогуур амьдралтай байна
- Өрхийн тэргүүн нь хөдөлмөр эрхэлж байгаа буюу малчин өрхүүдийн ядуурлын түвшин өндөр (39.2 хувь) байхад өрхийн тэргүүн нь малчин бус

буюу хувийн салбарт ажиллаж байгаа өрхүүдийн ядуурлын түвшин 34.7 хувь байна.

Хөдөлмөр эрхлэлтэд суурилсан ядуурлыг бууруулах стратеги нь дараах хэдэн гол асуудлыг багтаан хамарсан байх шаардлагатай. Тухайлбал, ажилгүй болон идэвхгүй хүн амыг хангахуйц илүү олон ажлын байрыг бий болгох; цалин сайтай, бүтээмж өндөртэй илүү сайн ажлын байрыг шинээр бий болгож ажилгүй ядуучуудын тоог бууруулах, эдийн засгийн идэвхгүй хүн амыг ажиллах хүчинд хамруулах, дахин хамруулах явдлыг урамшуулан дэмжих; ядуу малчин өрхүүдийг нэмэлт орлого олох боломжоор хангахын тулд хөдөө орон нутагт хөдөлмөр эрхлэх боломжийг илүү нэмэгдүүлэх; цалин хөлстэй ажил хийх буюу хувиараа хөдөлмөр эрхлэх талаар бий болж буй хөдөлмөр эрхлэлтийн олон шинэ боломжийг бүрэн дүүрэн ашиглахад бэлэн байх ур чадварын суурийг монголын ажиллах хүчинд эзэмшүүлэн бий болгох зэрэг болно.

Эдийн засгийн өсөлтийн үр шимийг ядуу хүн амд хүртээхэд хөдөлмөр эрхлэлт чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг сүүлийн жилүүдэд улам бүр хүлээн зөвшөөрч байна. Гэвч эдийн засгийн эрчимтэй өсөлт, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хоёрын хооронд шууд механик холбоо үгүйг олон судалгаа харуулж байна. Эдийн засгийн өсөлт нь хөдөлмөр эрхлэлтийг өрнүүлж чадахгүй байгаа тохиолдолд ядуурлыг бууруулахад бодитой ахиц гарч чадахгүй.⁴⁴ Монгол Улсын хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмжийн түвшнийг сүүлийн арван жилээр 3.6-р хүснэгтэд судалж үзэхэд нэлээд сонин хандлага ажиглагдаж байна. 1997-2006 онд эдийн засгийн өсөлтийн хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмжийн коэффициент 0.59 байсан нь шинээр бий болж байсан ажлын байр ДНБ-ний өсөлттэй дүйцэж байгаа юм. Гэвч сүүлийн есөн жилийг гурав гурван жилээр авч

үзвэл хандлага мэдрэгдэхүйц өөрчлөгджээ. ДНБ-ний өсөлт нь 2003-2006 оныхтой харьцуулахад нэлээд удаан байсан эхний хоёр үед өсөлтийн хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмжийн коэффициент хамгийн өндөр буюу 2000-2003 онд нэгээс их, ажлын байр бий болох явц ДНБ-ний өсөлтөөс түрүүлж байжээ. 2003-2006 оноос эхлэн ДНБ-ний өсөлт сайжрах тусам өсөлтийн хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмжийн коэффициент буурч эдийн засгийн өсөлт нь нэмэгдэхийн хирээр ажлын байр нэмэгдэх явц хурдасдаг бусад оронтой харьцуулахад нэлээд доод түвшинд хүрсэн байна. Энэхүү эдийн засгийн өсөлт удаашралтай үед өсөлтийн хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмжийн коэффициент өндөр байсан, эдийн засгийн өсөлт нь сайжирсан үед өсөлтийн хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмжийн коэффициент буурч байгаа явдал Монгол Улсын хувьд нухацтай шийдвэрлэвэл зохих асуудал болж байна. Эдийн засгийн өсөлт, түүний хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмжийн коэффициент хоёул өндөр байж гэмээ нь ядуурлыг хурдацтай бууруулах болно. Ядууст хангалттай цалин хөлстэй хөдөлмөр эрхлэх боломж бий болоогүй тохиолдолд хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхүйц хэмжээний эдийн засгийн өсөлт ч ядуурлыг бууруулахад дорвитой нөлөөлж чадахгүй.

Хүснэгт 3.6 Эдийн засгийн өсөлтийн хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмж, Монгол Улс, 1997-2006

	Мэдрэмж	Ажил эрхлэлтийн өсөлт	ДНБ-ний өсөлт
1997-2006 (бүх оноор)	0.59	0.32	0.55
1997-2000	0.72	0.06	0.08
2000-2003	1.28	0.15	0.11
2003-2006	0.31	0.09	0.29

Үд ноддөө: УСГ. Монгол Улсын статистикийн эмхтгэлийн мэдээллийг ашиглан зохиогчдын хийсэн тооцоо.

Хөдөлмөр эрхлэлтийн талаарх сүүлийн үеийн мэдээллээс үзэхэд эдийн засгийн эрчимтэй өсөлт нь ядуурлыг бодитойгоор бууруулж чадах хангалттай тооны, зохистой ажлын байрыг шинээр бий болгож чадахгүй байгаа нь харагдаж байна.

⁴⁴ -с. Дэгэи Энэй: βαρόδαο δέ ούιου δ ίι: Ο'ααεε-Ο'α'ε'ι'ο' γόδεγέοε'ί α'ε'α'ι, Ε'ε'ι' Δ'ε'γ'υ'δ Ο'γ'α'ε'γ'ε'ε'ί α'α'α'δ, Α'ί'δ'ε'α'α'δ, 2006; Γ'Α-ύι' Ο'Δ, Ι'Ο'ΔΑ: 'η'ε'ο' , δ'α'ε'ι'ο' γόδεγέο, γ'α'ό'δ'ε'νι' α'π'ό'ό'α'α'α'δδ' Α'σ'ε'ε'ί' ο'δ'δ'ε' α'α'α'α'ν: σ'α'δ'ε'ι' π'ό'α'α'ε'α'α'ι'ι' δ'δ'ο'ε'ε' α'ζ'ι'α'γ'υ'ν, Ε'ι'ε'ι'ι'α' ι' α'α'δ'ι' Γ'Α-ύι' Ο'Δ-ε'ε'ι' Α'ζ'η'ε'ε'ι' Ο'α', Α'ε'α'α' α' γ'δ' Ι'Ο'ΔΑ, 2007.

3.7-р хүснэгтэд 2000-2006 онд шинээр бий болсон ажлын байрны хандлагыг энэ хугацаанд нэмэгдсэн ажлын байрны тоогоор 2000-2003, 2003-2006 онуудаар тус тус салгаж харууллаа. 2003 оноос эдийн засаг огцом өссөн боловч ажлын байрны өсөлт ойролцоогоор 30 хувиар буурч 2000-2003 онд нэмэгдсэн 118 мянган ажлын байртай харьцуулахад 2003-2006 онд ердөө 83 мянган ажлын байр шинээр нэмэгдсэн байна. Үүнээс гадна 2000-2003 онд малчдын тоо 43 мянгаар буурч байх үед ажлын байрны цэвэр өсөлт нилээд эрчтэй байсан бөгөөд 2003-2006 онд малчдын тоо ердөө 14 мянгаар буурч байжээ. Мал аж ахуйн бус салбарт ажиллагчдын тоо 2000-2003 онд 161 мянгаар нэмэгдсэн байхад 2003-2006 онд 97 мянгаар нэмэгджээ.

Ажлын байр чухал хэрэгцээтэй газраа бий болохгүй байгаа нь ядуурлын түвшин өндөр хэвээр байгаагийн бас нэг гол шалтгаан болж байна. Шинээр нэмэгдсэн ажлын байрны талаарх 3.8-р хүснэгтийн мэдээллээс харахад 2000-2003 онд шинээр нэмэгдсэн ажлын байрны 36.6 хувь нь Улаанбаатараас бусад газарт бий болжээ. Энэ үзүүлэлт 2004-2006 онд талаас илүү хувиар буурч 17.0 хувьд хүрсэн байна. 2000-2003 онд Улаанбаатараас бусад газарт шинээр 43 мянган ажлын байр нэмэгдсэн бол дараагийн гурван жилд энэ тоо буурч 14.2 мянгад хүрчээ. Хөдөлмөрийн бүтээмж муутай, бага цалинтай ажлын байр бий болж байгаагаас хөдөөгийн ядууст ядуурлаас гарахад нь дэм болохгүй байна.

Хүснэгт 3.7 Хөдөлмөр эрхлэлтийн өөрчлөлт, салбарын ангиллаар, Монгол Улс, 2000-2006

Салбарын ангилал	2000-2006		2000-2003		2003-2006	
	Өөрчлөлт (мянгаар)	Өөрчлөлт (%)	Өөрчлөлт (мянгаар)	Өөрчлөлт (%)	Өөрчлөлт (мянгаар)	Өөрчлөлт (%)
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	-2.1	-0.5	-6	-1.5	3.9	1.0
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	23.3	125.3	13.3	71.5	10.0	31.3
Боловсруулах аж үйлдвэр	-7.6	-13.9	0.3	0.5	-7.9	-14.4
Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	12.2	68.5	4.9	27.5	7.3	32.2
Барилга	32.9	140.6	11.7	50.0	21.2	60.4
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	76.7	91.4	45.8	54.6	30.9	23.8
Зочид буудал, зоогийн газар	17.7	133.1	10	75.2	7.7	33.0
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	7.1	20.8	5.4	15.8	1.7	4.3
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	10	147.1	5.8	85.3	4.2	33.3
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	4.8	66.7	2.1	29.2	2.7	29.0
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	12.2	35.2	10.1	29.1	2.1	4.7
Боловсрол	7.6	14.0	0.9	1.7	6.7	12.1
Эрүүл мэнд, нийгмийн халамж	5.8	17.3	3.3	9.9	2.5	6.8
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	-6.1	-21.0	8	27.6	-14.1	-38.1
Бусад	6.4	152.4	1.9	45.2	4.5	73.8
Бүгд	200.9	24.8	117.5	14.5	83.4	9.0

Үд нэмэлт: УСГ. Монгол Улсын статистикийн эмхтгэл 1989-2002, 2006-д үндэслэсэн зохиогчийн тооцоо.

Ийм нөхцөл байдалд хөдөөгийн ядуурал нэмэгдсээр байгаа нь гайхах зүйл биш юм. Ийнхүү ажлын байр дорвитой нэмэгдэхгүй байгаа нь хөдөөгөөс хот руу шилжих хүн амын шилжилт хөдөлгөөний гол шалтгаан болж байна.

Хүснэгт 3.8 Шинээр бий болсон ажлын байр (мянгаар), байршлаар, Монгол Улс, 2000-2006

	Бүгд	Малчин	Малчин бус
2000-2006			
Бүгд	200.9	-57.0	257.9
Улаанбаатар	143.9	0.9	143.0
Бусад	57.0	-57.9	114.9
2000-2003			
Бүгд	117.5	-43.5	161.0
Улаанбаатар	74.7	0.06	74.6
Бусад	42.8	-43.6	86.4
2003-2006			
Бүгд	83.4	-13.6	97.0
Улаанбаатар	69.2	0.9	68.3
Бусад	14.2	-14.4	28.6

Үд нөдөөгөө: УСГ. Монгол Улсын статистикийн эмхтгэл 1989-2002, 2006-д үндэслэсэн зохиогчийн тооцоо.

Хэдийгээр өндөр цалинтай зарим салбаруудад ажлын байр шинээр эрчимтэй нэмэгдсээр байгаа боловч бага цалинтай салбарт ажиллагчдын эзлэх хувийн жин өндөр хэвээр байна. Шинээр бий болж буй ажлын байрны өнөөгийн байдал, байршил, тооны өөрчлөлт, цалин хөлс, хөдөлмөрийн бүтээмжийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар 3.9-р хүснэгтэд үзүүлээ. Цалин, хөлсний талаарх мэдээллийг эдийн засгийн албан секторын багахан хувийг эзэлдэг хөдөө аж ахуй зэрэг салбарт ажиллагчдын цалин, хөлсний тухай мэдээлэл дээр үндэслэн гаргажээ. Тэгэхлээр доорх хүснэгт дэх салбараар үзүүлсэн цалингийн мэдээллийг тухайн салбарын нийт ажиллагчдын дундаж орлого хэмээн ойлгож болохгүй зөвхөн цалинтай ажиллагчдын орлого гэдгийг бодолцох хэрэгтэй юм. Харин шинээр бий болсон ажлын байр, бүтээмжийн үзүүлэлтүүд нь салбарын тогтмол цалинтай болон цалингүй ажиллагчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон бусад нийт ажиллагчдынх гэж ойлгож болно.

Хүснэгт 3.9 Ажлын байр, бодит цалин, бүтээмж, салбарын ангиллаар, Монгол Улс, 2000-2006

Салбарын ангилал	Нийт ажил эрхлэлтийн хувь	Шинээр бий болсон ажлын байрны тоо (мянга)	Шинээр бий болсон ажлын байрны эзлэх хувь	Сарын бодит цалин, мянган төгрөгөөр (2000)		Бодит цалингийн өөрчлөлтийн хувь	Хөдөлмөрийн бүтээмж, одоогийн үнээр (мянган төгрөг)
		2003-2006	2003-2006	2003	2006	2003-2006	2006
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	38.8	3.9	5	41.8	44.5	6.5	1494.12
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	4.1	10	13	77.2	98.8	28.0	23328.90
Боловсруулах аж үйлдвэр	4.7	-7.9	-10	72.0	83.9	16.6	4006.70
Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	3.0	7.3	9	84.5	94.3	11.6	2715.70
Барилга	5.6	21.2	27	74.8	89.8	20.1	1230.50
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	15.9	30.9	39	56.2	57.9	3.1	3973.70
Зочид буудал, зоогийн газар	3.1	7.7	10	76.6	88.4	15.4	886.40
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	4.1	1.7	2	92.3	87.7	-5.0	8271.30
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	1.7	4.2	5	90.3	172.8	91.2	6664.90
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	1.2	2.7	3	56.8	61.9	9.0	3257.30
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	4.6	2.1	3	68.1	95.5	40.4	2177.00
Боловсрол	6.1	6.7	8	67.4	83.6	23.9	1620.60
Эрүүл мэнд, нийгмийн халамж	3.9	2.5	3	52.9	78.8	48.9	1203.10
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	2.3	-14.1	-18	46.7	61.7	32.1	1019.40
Улсын дундаж				70.9	86.3	21.7	3207.4

Үд нөдөөгөө: УСГ. Монгол Улсын статистикийн эмхтгэл 2006-д үндэслэсэн зохиогчийн тооцоо.

Эдгээр тоон мэдээлэл нь хөдөлмөр эрхлэлт, цалин хөлс, хөдөлмөрийн бүтээмжийн талаарх урьд өмнө нь тодорхой бус байсан хэд хэдэн чухал баримтыг дэлгэн харуулах боломж олгож байна. Үүнд:

1. Хөдөө аж ахуйн салбар ажиллагчдын тоогоороо буюу нийт ажиллагчдын 38.8 хувийг бүрдүүлдэг хамгийн томоохон салбар хэвээрээ байна. Гэтэл бүтээмжийн хувьд улсын дунджаас бараг тал хувиар бага бүтээмж доогуур салбарын нэгэнд ордог. Бүтээмж доогуур байдал нь энэ салбарын ажиллагчдынх нь цалингийн түвшинд нөлөөлж тогтмол цалинтай ажиллагчдын тоо нь цөөхөн, дундаж цалин 2003-2006 онд инфляцийн өсөлтийг тооцсоноор дөнгөж 6.5 хувь өссөн нь улсын дундаж буюу 21.7 хувиас нэлээд доогуур байна. Хөдөө аж ахуйн салбарын ажиллагчдын цалин бусад бүх салбарынхаас бага байна.
2. Бөөний болон жижиглэн худалдааны салбарын ажиллагчдын сарын дундаж цалин 85700 төгрөг буюу хамгийн бага цалинтай салбарын нэг. Цалин багатай ч албан бус хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн шинээр бий болгосон ажлын байрыг оруулаад хамгийн олон буюу шинээр бий болсон нийт ажлын байрны 37.1 хувийг бий болгосон салбар юм. Гэхдээ цалингийн судалгаанд албан бус секторын болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн цалингийн мэдээлэл ороогүй. Шинээр бий болсон ажлын байрны 25.4 хувийг барилгын салбарт 12.0 хувийг уул уурхайн салбарт тус тус бий болгосон бөгөөд энэ хоёр салбарын аль алинд нь бодит цалингийн өсөлт өндөр байна. Харин хувийн салбарын дотроос санхүүгийн зуучлалын салбарт, дундаж цалингийн өсөлт хамгийн өндөр (91.2 хувь) байгаа боловч 2006 онд энэ салбарт нийт шинээр бий болсон ажлын байрны дөнгөж 1.7 хувь ногдож байна.
3. Төрийн албан хаагчдын цалинг тодорхой түвшинд хүргэх төр, засгийн газрын бодлогын үр дүнд төрийн албан хаагч-дын цалингийн өсөлт бодит хэмжээгээрээ нэлээд өссөн. 2006 оны хувьд төрийн албан хаагчдын

бодит цалинг хувийн салбарынхтай харьцуулах боломжтой хэмжээнд хүрсэн байна. Хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт ихэвчлэн төрийн захиргаа, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсролын салбар гэх мэт үйлчилгээний салбарт давамгайлжээ.

4. Уул уурхайн салбарын хөдөлмөрийн бүтээмж улсын дунджаас долоо дахин илүү, тээвэр, санхүү зуучлалын салбарт бараг хоёр дахин өссөн байхад хөдөө аж ахуйн салбарын хөдөлмөрийн бүтээмж улсын дунджаас 50 хувиар бага байна. Эдгээр салбаруудын хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлсний уялдаа тодорхой байгаа ч бусад салбарын, ялангуяа хөдөлмөрийн бүтээмж өндөртэй ч дундаж цалин хөлс багатай бөөний болон жижиглэн худалдааны салбар, дундаж цалин хөлс өндөртэй ч бүтээмж муутай барилгын салбарын хувьд илүү нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай байна.

Дээрх хүснэгтэнд тусгагдсан үзүүлэлтүүдээс хөдөлмөрийн зах зээлийн нааштай сайн болон анхааруштай сул талын аль алиныг харж болно. Уул уурхай, барилга, аж үйлдвэр, санхүүгийн зуучлал зэрэг салбар, төрийн албан хаагчдын бодит цалин хөлс ихээхэн өссөн, ажиллах хүчний бараг 33 хувийнхны амьжиргаа дээшилсэн дүр зураг харагдаж байна. Хэрэв эдгээр салбарынхны бодит цалингийн өсөлт энэ хандлагаа хадгалж шинээр олон ажлын байр нэмэгдэх аваас монголын хүн амын нэлээд хувийн амьдралд эерэгээр нөлөөлөх болно. Гэхдээ хүн амын нилээд хувь бүтээмж муутай, цалин багатай салбаруудад ажилласаар байна. Энэ төлөв байдал нэгдүгээр бүлэгт үзүүлсэн 2003-2006 онд Монгол улсад илэрсээр байсан орлогын тэгш бус байдлын төлөв хандлагатай ижил төстэй байгааг анхаарна биз ээ.

Сүүлийн үед шинээр байгуулагдсан буюу өргөтгөл хийгдсэн үйлдвэр аж ахуйн газруудад ажиллагчдын тооны талаарх мэдээлэл шинээр бий болж байгаа ажлын байрны талаарх мэдээллийг баяжуулж байгаа юм. Бизнес бүртгэлийн

мэдээллийн санд 2006 онд нийт 30817 “идэвхтэй байгууллага” бүртгэгджээ. Эдгээрийн тавны дөрөв нь 10-с доош тооны ажилчинтай бичил бизнесийн байгууллагууд байна.

Хүснэгт 3.10 Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагууд, ажиллагчдын тоогоор бүлэглэснээр, Монгол Улс, 2001–2006

Ажиллагчдын тооны бүлэг	Он					
	2001	2002	2003	2004	2005	2006
0-9	19967	20515	21704	20693	17780	24848
10-19	2008	2052	2016	1913	2001	2701
20-49	1913	1896	1806	1751	1782	2139
50+	1066	1060	1026	999	984	1129
Бүгд	24954	25523	26552	25356	22547	30817

Үг нэмэлт: УСГ. Монгол Улсын статистикийн эмхтгэл 2005, 2006.

Жижиг оврын аж ахуйн нэгжийн тооны өсөлт илүү тогтвортой байна. 2006 онд томоохон үйлдвэрүүд ч нэлээд нэмэгджээ. Сүүлийн үеийн аж ахуйн орлогын татварын хувь хэмжээнд орсон нийт үйлдвэр аж ахуйн газарт хамаарах 15 хувийн нийтлэг татварын талаарх өөрчлөлт өмнө нь татвараас зайлсхийхийн тулд аль болох үйлдвэр аж ахуйн газруудыг жижиглэн олноор байгуулж байсан сонирхолд өөрчлөлт оруулж томд тооцогддог цөөн аж ахуйн нэгжүүд том хэмжээний үйлдвэрийн газар олноор байгуулах буюу компаниуд үйл ажиллагаагаа илүүтэй өргөтгөхөд нөлөөлөх магадлалтай юм.

Гэвч жижиг, дунд оврын үйлдвэр аж ахуйн газрууд тооны хувьд томоосоо илүү хурдацтай нэмэгдэж байна. Нийт аж ахуйн нэгжүүдийн 83.3 хувийг 10-с цөөн ажилчинтай газрууд, 95.1 хувийг 20-с цөөн ажилчинтай үйлдвэр, аж ахуйн газрууд бүрдүүлж байна. Үүнээс үзэхэд, ялангуяа хөдөөд жижиг, дунд оврын үйлдвэр аж ахуйн газруудыг дэмжих замаар ажлын байрыг бий болгох асуудлыг хөдөлмөр эрхлэлтэд суурилсан ядуурлыг бууруулах хөтөлбөрийн гол цөм болгох шаардлагатай юм.

Шигтгээ 7

Ажлын байр нэмэгдүүлэх бодлогын хувилбар ба жижиг, дунд бизнес

ОУХБ-ын жижиг дунд бизнесийг дэмжих замаар ажлын байр бий болгох тухай 1998 оны 189 дүгээр зөвлөмж нь засгийн газрууд дараах ерөнхий зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн алхам хийхийг уриалсан. Үүнд: 1) бичил, жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх, өргөжүүлэхийг хөхиүлэн дэмжсэн бодлого явуулах, шаардлагатай хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, 2) шинэ санаачлага, бүтээлч байдал, орчноо хамгаалсан ухамсар, ажлын чанар, зохистой хөдөлмөр, үйлдвэрийн харилцаа, зохистой, шударга, тэгш хүртэхүйц нийгмийн дадал зэргийг дэмжсэн байгууллагын соёлыг бий болгох, 3) тал бүрийн дэмжлэг туслалцааг бий болгох, хүртэх бололцоог дэмжсэн үр нөлөө бүхий үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг болно.


Үг нэмэлт: ОУХБ. Жижиг, дунд оврын үйлдвэрийн газруудад ажлын байр шинээр бий болгох тухай 1998 оны 189 дүгээр зөвлөмж.

3.3 Үүдэл гэрээний нийтлэг үзүүлэлтүүд

Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн жилүүдэд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтэд ихээхэн өөрчлөлт гарсан. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, үйлчилгээний салбарын өсөлт, эдгээр салбар дахь хөдөлмөр эрхлэлтийн төлөв хандлагын талаар дараах дүрслэлд үзүүлсэн байгаа. Түүний дараа хэд хэдэн гол салбарын холбогдох асуудлыг илүүтэй тодруулан авч үзлээ. Дүрслэл 3.3-т хөдөлмөр эрхлэлтийг гол гол салбараар харуулсан бөгөөд үүнээс та бүхэн эдийн засгийн шилжилтийн эхэн үед малчдын тоо нэмэгдсэн, дараа нь аажмаар хөдөө аж ахуйн салбарт ажиллагчдын нийт ажиллах хүчинд эзлэх хувийн жин буурсан болохыг олж харна. Үйлдвэр аж ахуйн газрууд олноор хаагдсан шилжилтийн эхэн үед

аж үйлдвэрийн салбарт ажиллагчдын хувь буурч байв. Энэ хандлага сүүлийн үед эсрэгээр эргэж, ялангуяа барилга, уул уурхай, аж үйлдвэрийн салбарт ажлын байр нэмэгдэх хандлагатай байна. Үйлчилгээний салбарт ажиллагчдын хувийн жин ч мөн тогтмол өсчээ.

Дүрслэл 3.3 Голлох салбаруудын ажил эрхлэлтийн хувь, Монгол Улс, 1995-2006




Үд нөдөөгөө: ҮСГ. Монгол Улсын статистикийн эмхтгэл 2001, 2002, 2006.

Хөдөө аж ахуй

Жил дараалсан зуд зурханы уршгаар газар тариалан, мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл буурч, эдгээр салбарт ажиллагчдын тоо ч мөн цөөрснийг 3.4-р дүрслэлээр үзүүлжээ. 1999-2006 онд хөдөө аж ахуйн салбарт ажиллагчдын тоо бараг 1.5 дахин буюу 40.3 хувиар буурсан бөгөөд 2006 онд ДНБ-ний дөнгөж 18.8 хувийг хөдөө аж ахуйн салбар бүрдүүлж байгаа нь бараг тал хувиар буурсныг илэрхийлж байна. Энэ мэдээлэл мал аж ахуйн салбарт хөдөлмөрийн бүтээмж хэрхэн буурсныг мөн баталж байгаа бөгөөд энэ талаар уг бүлгийн төгсгөлд авч үзэх болно.

Дүрслэл 3.4 ХАА-н салбарын ажиллагчдын хувь, ДНБ-д эзлэх хувь, Монгол Улс, 1995-2006




Үд нөдөөгөө: ҮСГ. Монгол Улсын статистикийн эмхтгэл 2001, 2002, 2006.

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарт ажиллагчдын тоо 1990-д онд буурсан ч сүүлийн үед аажмаар нэмэгдэж 2006 онд нийт ажиллагчдын 17.3 хувийг бүрдүүлж байна. Тус салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2 илүү дахин нэмэгдэж 2006 онд ДНБ-ний 40.3 хувь болжээ. Энэ нь уул уурхайн салбар харьцангуй капитал зарцуулалт өндөр гэдгийг харуулж буй баримт юм.

Дүрслэл 3.5 Аж үйлдвэрийн салбарт ажиллагчдын хувь, ДНБ-д эзлэх хувь, Монгол Улс, 1995-2006




Үд нөдөөгөө: ҮСГ. Монгол Улсын статистикийн эмхтгэл 2001, 2002, 2006.

Уул уурхай, аж үйлдвэр, барилга, нийтийн аж ахуйн салбарын хөдөлмөр эрхлэлтийн төлөв хандлагыг 3.6-р дүрслэлээр үзүүлжээ. Боловсруулах аж үйлдвэрийн салбарт ажиллагчдын тоо 1995 онд 67.3 мянга байсан бол 2006 онд 47 мянга болтлоо буурчээ. Хөнгөлөлттэй нөхцлөөр худалдаа хийж байсантай

холбоотой ноосон болон даавуун эдлэлийн үйлдвэрлэл нэмэгдсэн хэдий ч энэхүү хөнгөлөлттэй худалдааны хэлэлцээр 2004 онд дуусч, Хятад улс Дэлхийн худалдааны байгууллагад элсэн орсон зэргээс хамаарч нөхцөл байдал өөрчлөгдсөн. Энэ нь экспорт буурах, улмаар 2005 онд олон арван үйлдвэрийн газар хаагдан ажилчдыг олноор халахад хүргэсэн. Бүтээгдэхүүний өртөгийг бууруулах зорилгоор импортын бараа, тоног төхөөрөмжид ногдуулах тариф, татварыг өөрчлөх, нийгмийн даатгалын татаасын хувь хэмжээг өөрчлөн тогтоох зэрэг хэд хэдэн бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, мөн АНУ, Хятад улсаас өөрийн оронд оруулах импортыг хязгаарлах зорилгоор явуулсан түр зуурын арга хэмжээнээс хамаарч гадаадын захиалга, улмаар үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн. Гэсэн хэдий ч, Монгол улс хөнгөн үйлдвэрлэлийн экспортын өөр зах зээл олох шаардлагатай гэж үзэж байна.

Дараах дүрслэл барилгын салбарт хөдөлмөр эрхэлж байгаа хүний тоо 2000 онд 29500 байсан бол 2006 онд 56300 болтлоо мэдэгдэхүйц өссөнийг мөн харуулж байна. Мөн хугацаанд уул уурхайн салбарт ажиллаж байгаа хүний тоо 18600-41900 болж өсчээ.

Дүрслэл 3.6 Аж үйлдвэрийн салбарт ажиллагчдын тоо, Монгол Улс, 1995-2006




Үд нөдөдөө: УСГ. Монгол Улсын статистикийн эмхтгэл 2001, 2002, 2006.

Үйлчилгээний салбар

Үйлчилгээний салбарт ажиллагчдын хувь 1995-2006 онд тогтвортой өссөнийг 3.7-р дүрслэл харуулж байна. 2006 онд

хөдөлмөр эрхлэгч 10 хүн тутмын дөрөв нь үйлчилгээний салбарт ажиллаж дотоодын нийт бүтээгдэхүүний 40.9 хувийг бүтээж байжээ.


Дүрслэл 3.7 Үйлчилгээний салбарт ажиллагчдын хувь, ДНБ-д эзлэх хувь, Монгол Улс, 1995-2006



Үд нөдөдөө: УСГ. Монгол Улсын статистикийн эмхтгэл 2001, 2002, 2006.

Салбар дотор нь авч үзэхэд ажиллагчдын дийлэнх хувь нь худалдаа, засвар үйлчилгээний ажил эрхэлж 2006 онд тэдний тоо төрийн захиргаа, батлан хамгаалах, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн даатгалын салбарт ажиллагчдаас олон болсон байна. Бусад салбаруудад арай цөөн хүн ажиллаж байгаа боловч тээвэр, зочид буудал, санхүүгийн салбарт ажиллагчдын тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа талаар ажлын байрны талаарх хэсэгт дурдсан.

Дүрслэл 3.8 Үйлчилгээний салбарт ажиллагчдын тоо, Монгол Улс, 1995-2006



Үд нөдөдөө: УСГ. Монгол Улсын статистикийн эмхтгэл 2001, 2002, 2006.

2006 оны байдлаар нийт ажиллагчдын 38.8 хувь нь хөдөө аж ахуйд, 17.3 хувь

нь аж үйлдвэрийн салбарт, 43.9 хувь нь үйлчилгээний салбарт ногдож байна. 2002-2003⁴⁵ оны ӨОЗАТС-ны дүнгээс харахад ядуучууд хөдөө аж ахуйн салбарт ядуу бус хүмүүсээс илүү олноор ажиллаж байгаа бөгөөд үйлчилгээний салбарт арай цөөн ажиллаж байна. Үйлчилгээний салбарт ажиллаж байгаа эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн нэлээд хувь нь худалдаа, төрийн захиргааны ажил эрхэлж удаагаар нь боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний ажил хийж байна.

3.4 *Yüèéí çàñàèèã*

ò°ò°èæççéýí ò°ãæççéý ò çàìààð àæèýí ààéðüã
íý íýããççéý ò òýðýãüýý
òààð üèàãà

Энэ бүлгийн өмнөх хэсгүүдэд 2004 онд ялангуяа эдийн засаг эрчимтэй өсч эхэлсэн үед ажлын байр шинээр бий болох явдал удааширч байсныг дурдсан билээ. Үүний шалтгааныг ажил эрхлэлтийг салбараар, үйлдвэрлэлийн хэмжээгээр нь авч үзэж харьцуулсан өмнөх судалгааны дүгнэлтээс тодорхой харж болно. ДНБ-ний өсөлтийг салбараар өмнө харьцуулан тодруулж өгүүлсэн билээ. 2003-2006 онд ДНБ-ний 25.4-40.3 хувийг аж үйлдвэрийн салбар бүрдүүлж байхад аж үйлдвэрийн салбарын ажиллагчдын тоо зөвхөн 15.6-17.3 хувиар нэмэгджээ. ДНБ-ний өсөлт нь ажлын байрыг аажмаар бага зэрэг нэмэгдүүлж байгаа уул уурхайн салбарын эрчимтэй өсөлтөөс шалтгаалсан байна. Илүү олон ажлын байр бий болгодог үйлчилгээ, хөдөө аж ахуйн салбар, хөнгөн үйлдвэрлэлийн өсөлт харьцангуй удаан байсан учир ажиллагчдын тоо тогтонги, өсөлт удаан байжээ. Ажил эрхлэлтийн энэ төлөв хандлага илтгэлийн нэгдүгээр бүлэгт өгүүлснээр тухайн жилүүдэд өндөр бүтээмжтэй салбарт цөөн тооны өндөр цалинтай ажлын байр бий болсон, ажиллах хүчний дийлэнх нөгөө л бага бүтээмжтэй, бага орлоготой, удаан өсөлттэй салбарт

ажилласан хэвээр байсан зэрэг орлогын тэгш бус байдал гүнзгийрэхэд нөлөөлсөн гэж дүгнэж болохоор байна.

Сүүлийн үед Монголын эдийн засаг байгалийн баялгийн экспортоос их хамааралтай улс орнуудад тулгардаг эдийн засгийн эрсдэлд орж түүнд төр засаг, олон нийт илүү анхаарлаа төвлөрүүлж ирсэн гэж олон ажиглагчид үзэж байна⁴⁶. “Нөөцийн занал” хэмээх ойлголт энэхүү эрсдлийг илэрхийлэх гол нэр томъёо бөгөөд энэ нь бүтээгдэхүүн үйлдвэрлэдэггүй салбарын өрсөлдөөн сулаас шалтгаалан дотоодын валютын ханш өндөрсөх, дэлхийн зах зээл дэх барааны үнийн хувирамтгай байдлаас хамаарч бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон төсвийн орлого дагаж эрс өөрчлөгдөх, авилга газар авах, давамгайлсан нэг гол салбараас хялбархан аргаар орлого олох боломж бүрдсэнээс зарим хэсэг нь үйлвэрлэлийг сул дорой удирдаж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулдаг зэрэг эрсдлийг дагуулж байдаг. Монгол Улсын экспортын гол нэрийн барааны дэлхийн зах зээлийн үнэ урьд өмнө байгаагүйгээр өссөнөөс шалтгаалж 2004 оноос эхлэн Монгол Улсын эдийн засгийн өсөлт, төсвийн орлого огцом нэмэгдэж байгаа хэдий ч төр засгийн бодлого, хувийн салбарынхны үйл ажиллагаанд дорвитой өөрчлөлт гарсангүй. Нөөцөө ашиглах энэхүү боломж нь бодлого боловсруулагчдад өргөн хүрээнд, тогтвортой өсөлтийг бий болгох нөхцлийг бүрдүүлэх бололцоо олгож байна. Энэхүү олдсон боломжийг бодит ажил болгох нь эдийн засгаа төрөлжүүлэн хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, шинэ санаа санаачлагыг дэмжих, уул уурхайн бус салбарт зориулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зэрэг төр засгийн идэвхтэй үйл ажиллагаанаас ихээхэн хамаардаг болохыг олон улсын туршлага бэлхнээ харуулж байна.

Эдийн засгийн зохистой бодлого явуулахын тулд эдийн засгийн өсөлтийн хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмжийн өнөөгийн бага түвшинг эсрэгээр эргүүлж, монголчууддаа, ялангуяа өсөлтийн үр

⁴⁵ 2002-2003 *íü 'íÇ.À ÒÑ-íü äçíäýý ñ àæèèè äà-äüí òüã äí è ñàèàäàäð äá- ççáý ò°ã° àæ äòðéá - 43 òòäü, àæ çéèäýð ò - 11 òòäü, çéè-èèäýýíèè ñ àèèàäò - 46 òòäü ò òñ òòñ àáéíä.*

⁴⁶ *Àðòäüü ýðèà, Áý èðèéí Áàéè*

шимээс гадуур үлддэг ядуу бүлгийн хүмүүст зориулж илүү олон, илүү чанартай ажлын байрыг бий болгох боломжийг бүрэн дүүрэн ашиглах хэрэгтэй байна.

Зургаа дахь зөвлөмж

Эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх замаар ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх талаар

- Уул уурхайн салбарын орлогыг хүний хөгжил, дэд бүтцийн салбарт илүүтэй хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагааг бүхий л талаар дэмжихэд ашигламаар байна. Мөн эдийн засгаа төрөлжүүлэн хөгжүүлэхэд зориулж дан ганц байгалийн баялгийн экспортоос хэт хараат байдлаа багасгах хэрэгтэй. Түүнчлэн өнөөдөр зохистой, бүтээмжтэй хөдөлмөр эрхлээгүй байгаа олон тооны эрэгтэй, эмэгтэйчүүдэд боломж олгоход уг салбарын орлогоос зориулах явдал чухал байна;
- Үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэхдээ ядуу зүдүү айл өрх амьдарч байгаа газар нутагт тэдгээр хүмүүс хөдөлмөр эрхэлж орлого олох боломж бүрдүүлэх чиглэл баримталбал зохино;
- Уул уурхайн бус салбарын тухайд тэдгээрийн өрсөлдөх чадварыг сайтар хянан зохицуулах, валютын ханшны нөлөөллийг үүнд тооцож үзэх хэрэгтэй;
- Ил тод байдлыг хангах, эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтийг дэмжихийн тулд бизнесийн үйл ажиллагаанд учирдаг элдэв саад тогторыг багасгах, аудитын үйл ажиллагааг боловсронгуй болгох, мөн хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэгдсэн болон татвар төлөгчдөд ээлтэй тагварын бодлого, татвар хураалтын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна;

Энэ бүлгийн дараагийн хэсэгт уул уурхайн салбарын талаар нарийвчлан судалж уг салбарын өсөлтийг ашиглан эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх, улмаар ядууст хүртээмжтэй болгох талаар зөвлөмж гаргасан болно.

3.5 *Óöë óóóðàéí ñàéáàðð ò óéãàð÷ áóé áýððòóýý ë – Õýððýí ýäóóñò ðçððóýýíæðýé ñ"èðèéá áèé á îéãí ò áý?*

Сүүлийн жилүүдэд Монгол улсын гадаад, дотоодын хөрөнгө оруулалт өсөн нэмэгдэж уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж байгаагийн хэрээр уг салбарын үйлдвэрлэл, ажиллагчдын тоо, цалин хөлс хурдацтай өсч байна. Эдийн засгийн өсөлтийн гол хүч болсон уул уурхайн салбар хөгжихийн хэрээр бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлтийг бий болгох асуудал чухал болж байна. 1994-2006 онд уул уурхайн салбарт хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн тоо бусад аль ч салбарынхаас илүү буюу 14600-41900 болтлоо нэмэгдсэн боловч нийт ажиллах хүчний дөнгөж 4,1 хувийг эзэлж байна. Энэхүү өсөлт 2000 оноос эхэлсэн бөгөөд жилийн дундаж өсөлт 20.9 хувь байжээ. Техник технологид түшиглэсэн үйлдвэрүүд уул уурхайн салбарын бүтээгдэхүүний дийлэнхийг буюу 2006 онд гэхэд Монгол Улсын ДНБ-ний 30 хувийг үйлдвэрлэсэн боловч уг салбарт албан ёсны хөдөлмөр эрхлэлт нийт ажиллах хүчний тун бага хувийг эзэлж байна. Уул уурхайн салбарын бүтээмж, цалин харьцангуй өндөр буюу улсын дунджаас хөдөлмөрийн бүтээмж 7 дахин өндөр, дундаж цалин 20 хувиар илүү байна. Гэсэн хэдий ч энэ салбарын хөдөлмөр эрхлэлт ядуурлын түвшинг бууруулахад үзүүлэх нөлөө харьцангуй бага байна.

Уул уурхайн салбар хөгжсөнөөр албан болон албан бус хөдөлмөр эрхлэлтийн аль аль нь хөгжих таатай боломж бүрдэж байгаа гэдэг хэнд ч ойлгомжтой. Албан хөдөлмөр эрхлэлт уул уурхайн салбарт эрчимтэй хөгжихийн зэрэгцээгээр сүүлийн жилүүдэд албан бус хөдөлмөр эрхлэлт ч хурдацтай нэмэгдлээ. Уул уурхайн салбар дахь албан бус хөдөлмөр эрхлэлт нь Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжсэн-ээс хойш нийгэмд гарч ирсэн цоо шинэ үзэгдэл юм. Өмнө нь улсын мэдэлд байгаад үйл ажиллагаа нь зогссон Налайх зэрэг томоохон нүүрсний уурхайнуудад албан

бусаар нүүрс олборлох явдал шилжилтийн эхний жилүүдээс эхэлсэн бол 1998 оноос хойш албан бусаар алт олборлолт өргөн тархсан билээ. Улмаар байгалийн бусад эрдэс баялгийг ч албан бусаар олборлох явдал эрчимтэй нэмэгдсэн. Өнөөгийн байдлаар хүмүүс зөвхөн нүүрс төдийгүй алт, жонш гэх мэт эрдэс баялгийг албан бусаар олборлож байна. Статистикийн зарим мэдээллээс үзэхэд Монгол Улсын уул уурхайн салбар дахь албан бус ажил эрхлэгчдийн тоо нь уг салбарт албан ёсоор ажиллаж байгаа ажиллах хүчний тоонд хүрсэн төдийгүй бараг илүү байна.

Хөдөлмөр эрхлэлтэд суурилсан ядуурлыг бууруулах стратегид уул уурхайн салбарын гүйцэтгэх үүргийг авч үзэхдээ тухайн салбарт ажлын байр бий болж буй эсэх талаас нь авч үзэхээс илүүтэйгээр дараах гурван чиглэлээр асуудлыг бодолцвол зохино. Нэгдүгээрт, уул уурхайн салбар нь төсвийн орлого, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх тул энэ нь өндөр бүтээмжтэй ажил эрхлэлтийг бий болгоход шаардагдах стратегийн нөөц эх үүсвэр юм. Тухайлбал, буй болсон нөөцийг газар тариалан, мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өсгөх гэх мэт хүний хөдөлмөр ихээхэн шаардсан салбарууд, дэд бүтэц, боловсролыг дэмжих, сургалт зохион байгуулах зэрэг чиглэлийн төр засгийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд зарцуулж болно. Хоёрдугаарт, уул уурхай болон бусад салбаруудын өөр хоорондын уялдаа холбоог хангаж байдаг эрчим хүч, эрдэс баялгийг боловсруулах үйлдвэрлэл, хөнгөн үйлдвэр, үйлчилгээний салбарууд гэх мэт том, жижиг бүхий л бизнесийг хөгжүүлэх нь хөдөлмөр эрхлэх нэмэлт боломжуудыг бий болгох юм. Энэхүү илтгэлийг бичихэд зориулсан урьдчилсан зарим тооцоогоор Монгол улсын уул уурхайн салбарын шууд бус нөлөөний жишээ бол уул уурхайд ажиллагч бүр 3.8 ажлын байрыг бусад салбарт шинээр бий болгож байна⁴⁷. Гуравдугаарт, эрдэс баялгийн экспортоос үүдэлтэй зах зээл дээрх эрэлт хэрэгцээ бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хөдөлмөр

эрхлэлтийг нэлээд өргөн хүрээнд нэмэгдүүлнэ. Тэгэхээр уул уурхайн салбар нь хөрөнгө оруулалтыг дуудагч нөөц, зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэгч хүчин зүйл учир бусад салбарын өсөлт, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд гол түлхэгч хүч болж чадна. Иймд уул уурхайн салбарын бий болгож буй нөөц, эрэлтийг ашиглан хөдөлмөр эрхлэлтийг өргөн хэмжээнд нэмэгдүүлэгч бусад салбаруудыг дэмжихэд чиглэсэн цогц, тэнцвэртэй аж үйлдвэрийн стратеги бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх шаардлага гарч ирж байна.

Áí üëïüüí ðóáëëäàð

Уул уурхайн салбар нь Монгол улсын эдийн засгийн цаашдын өсөлтөд чухал түлхэц үзүүлэх гол эх үүсвэр болох нь гарцаагүй. Гэхдээ сүүлийн жилүүдийн туршлагаас харахад дан ганц энэ салбарын хөгжлөөр тус улсын хүн амын дийлэнх хэсгийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах боломжгүй гэдэг нь тодорхой. Иймд уул уурхайн салбарыг хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх илүү сайн эх үүсвэр болгон хөгжүүлэх бодлого маш чухал.

Энэ талаар авч хэрэгжүүлж байгаа зарим нэг чухал алхамуудын жишээ гэвэл гадаадын хөрөнгө оруулалттай уул уурхайн компаниудад монгол ажилчдыг авч ажиллуулах шаардлага тавьж байгаа хэлэлцээрийн төслийг боловсруулсан явдал юм. Уул уурхайн салбар хүн амын ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад дорвитой хувь нэмэр оруулж чадахгүй байгаагийн нэг шалтгаан нь энэ салбарт албан ёсоор хөдөлмөр эрхэлж байгаа 45000 хүний 13 хувь нь гадаадын иргэд байгаа бөгөөд энэ асуудлыг анхаарахгүй аваас байдал улам дордох магадлалтай. Сүүлийн үед авч хэрэгжүүлж байгаа бас нэг сайшаалтай арга хэмжээ нь түүхий эд, эрдэс баялгийг шууд экспортод гаргаж, эрчим хүчийг шууд импортлох биш харин Монгол улсын нутаг дэвсгэр дээр ажлын шинэ байр олноор бий болгож байгаа боловсруулах үйлдвэрлэл, дэд бүтцийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулах явдлыг

⁴⁷ Áíë. ×. Õàø-ðëòóí. Ýíý òíò ñà 'íà'ðñ'í çàëéí 'ñ'èððéí ðàíàë àààà üéíí íà ððéëëéí øéíàëëäýý ðéëà ààðàáíí ð-ëð ðéè ðáððàéí ñàëààðíí ð'á'è'ð ýððëýëðý á ççççëýð í'è'è'èëéí ðýò ééí ðíò ñàà ðóáà ðýðýäýà áí éí ðàçé.

хөхиүлэн дэмжих санаачлага юм. Гэсэн хэдий ч цаашид анхаарвал зохих зүйл, хийх ажил олон байна.

Уул уурхайн салбараас олж байгаа орлогыг ирээдүйд чиглэсэн, тухайлбал, хүний хөгжил, дэд бүтцийн хөгжилд хөрөнгө оруулалт хийх улмаар хөдөлмөр эрхлэлтийг илүү нэмэгдүүлэх чиглэлд аль болох анхаарах нь чухал. Уул уурхайн салбарын хувьд тус улсын олон арван ядуу, ажилгүй иргэдэд хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, мэргэжилтэй ажиллах хүчнийг бэлтгэх асуудал нэн чухал болж байна. Ажил олгогчид ажилчдаа ажлын байранд дагалдуулан сургах зарим нэг сургалт явуулдаг ч уул уурхайн шинэ шинэ салбар нээгдэх бүрт эрэлт хэрэгцээнд нийцсэн ур чадварын мэргэжлийн сургалт тун шаардлагатай байна. Энэ эрэлт хэрэгцээг Монгол Улсын боловсролын тогтолцоогоор хангаж чадахгүй бол гадаадын ажиллах хүч ихээр орж ирэхэд хүрнэ. Уул уурхайн салбараас олж байгаа орлогыг ашиглан Монгол Улс өөрийн хүчээр дэлхийн стандартын түвшинд хүн амаа сурган, боловсрол олгож чадвал уул уурхайн салбараас Монгол Улсын хөгжилд оруулж буй хувь нэмэр улам өсөн өргөжих болно.

Өнөөдөр Монгол Улсын олон мянган айл өрхийн хөдөлмөр эрхлэлт, орлогын эх үүсвэр нь уул уурхайн салбарт албан бусаар ажиллахаас хамааралтай байна. Гэтэл энэхүү албан бус хөдөлмөр эрхлэлт нь эрүүл мэндэд хортой, эрсдэлтэй орчинд явагддаг бөгөөд насанд хүрээгүй хүүхдүүд энэ орчинд олноор ажиллаж байна. Иймээс уул уурхайн салбарын албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан ёсны болгох шаардлага байгаа бөгөөд өөрөөр хэлбэл, эдгээр албан бус хөдөлмөр эрхлэгчдийн татвартай холбоотой асуудлуудыг шийдвэрлэх, зөвшөөрөл олгох, нийгмийн даатгал, эрүүл мэндийн халамж үйлчилгээ хүртээх зэрэг хууль эрх зүйн олон асуудлаар зохицуулалт хийж тэдний ажиллах нөхцлийн аюулгүй байдлыг хангах, тэдэнд аюулгүй орчинд алт, эрдэс баялаг олборлох боломжийг олгох зэрэг асуудлыг цогцоор шийдвэрлэх нь чухал байна. Энэ зохицуулалт нь уул

уурхайн салбарт насанд хүрээгүй хүүхдүүд олноор ажиллаж байгааг таслан зогсоох, олон тооны хүүхдүүдийг ирээдүйдээ боловсролгүй, ур чадваргүй иргэд болон төлөвших эрсдлээс хамгаалахад ч үр дүнгээ өгөх учиртай.

Уул уурхайн салбарын бий болгож буй орлого, нийгмийн баялгийг бусад салбаруудыг хөгжүүлэхэд үр дүнтэй ашиглахын тулд Монгол Улсын олон мянган компаниуд уул уурхайн салбарт ажиллахад шаардлагатай машин, техник, тоног төхөөрөмж үйлдвэрлэх ажлыг өөрсдөө эрхлэх хэрэгтэй юм. Ингэсэн тохиолдолд Монгол Улсын үйлдвэрлэгчид уул уурхайн салбарыг хангагч болон хөгжиж улс орныхоо хөдөлмөр эрхлэлтэд хувь нэмрээ оруулж үйлдвэржилт эрчимжих болно.

Долоо дахь зөвлөмж

Уул уурхайн салбарыг түшиглэн хөгжих бусад салбар дахь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэх талаар

- Боловсруулах үйлдвэр байгуулж ажиллуулах, эрчим хүчний хэрэгцээгээ дотоодын эх үүсвэрээр хангах зэргээр уул уурхай болон түүнийг дагаж хөгжих том, жижиг бусад салбарын бүхий л үйл ажиллагаа хоорондын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ авах;
- Уул уурхайн салбар дахь ажлын байрны шаардлагыг хангахуйц ур чадварыг бий болгоход чиглэсэн сургалт зохион байгуулахыг хөхиүлэн дэмжих;
- Уул уурхай дахь албан бус секторыг албан болгоход чиглэсэн хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зэрэг болно;

**3.6 *Iðú íðààð ð°ü°è°ð*
ýððëýðèèä ü ýìæð ü:
βä óó àè ÷èì àéè °ð ð°ü ð¿ð ÷
*àæèèèð ü***

Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн эхний арван жилд хөдөө аж ахуйн нэгдэл, хоршоо, улсын газар тариалангийн аж ахуйг татан буулгасан, засаг захиргаа, сургууль, эмнэлэг, дэд бүтцийг хөгжүүлэхэд зарцуулж байсан улсын төсөв их хэмжээгээр буурсан зэргээр Монгол Улсын хөдөөд томоохон өөрчлөлт гарсан. Малын хувьчлал орон нутагт эхэн үедээ өрхүүдийн орлого олох, хөдөлмөр эрхлэх шинэ боломжуудыг бий болгож байсан. Олон арван иргэд аймаг, сумын төвүүдэд ажилтай болсон. 1993-1999 онд мал сүргийн тоо толгой өсч байсны зэрэгцээ малын бүтцэд ч өөрчлөлт орж ноолуурын үр ашгаас шалтгаалан ямааны тоо толгой нэлээд нэмэгдсэн. Малын тэжээл, хашаа саравчны өртөг өндөрсөнөөс малчид цөөн малыг эрчимтэй үржүүлэхийг зорьж эхэлсэн. Гэвч 1999-2002 онд дараалан тохиосон ган гачиг, зуднаас болж олон арван айл өрх мал сүргээ алдсан.⁴⁸

Малчдын тоо мал сүргийн тооноос илүү хурдацтай өссөнөөс 1990-д онд мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн бүтээмж, орлого эрс буурсан. 3.11-р хүснэгтэд үзүүлсэнээр малын тоо бодод шилжүүлсэнээр 1989 онд 64.4 байсан бол 1993 онд 24.5 хүртэл буюу 62.2 хувиар буурчээ. Энэ нь малчин өрхийн орлогод сүрхий нөлөөлсөн бөгөөд олон тооны судалгаагаар малчны орлого, малын тоо толгой нягт хамааралтай гэдгийг нотолж байна.⁴⁹

Дараах хүснэгтээс үзэхэд, зудаас хойшхи гурван жилийн хугацааны малжуулах үйл ажиллагаа нь зудын өмнөх үеийн буюу 1990-д оны малын тоо толгойн өсөлтийн үетэй харьцуулахад мал сүргийн хуваарилалтанд мэдэгдэхүйц өөр дүр зургийг бий болгожээ.

⁴⁸ *Yēēcāāāo I idēn, Iē à Áóóí. I ñāí ē ðēñú ð°a°a ð°a°è°ð ýððëýðèèä äí èí ìæèä äýìæð ü:* *Óððø äàà, I ÓÓÁ-üí ðàìæ äàà, I ÓÓÁ Ç¿¿. Áçèè Áý à á¿ñèè Áè äà, Áàìäèé, 2005.*
⁴⁹ Ç. *ÁÁ 2006*

Хүснэгт 3.11 Мал болон малчны тоо (мянгаар), Монгол Улс, 1989-2006

	Малын тоо (бодод* шилжүүлсэнээр)	Малчны тоо	Нэг малчинд ногдох бодын тоо
1989	8723.0	135.4	64.4
1990	9067.5	147.5	61.5
1991	8901.5	245.0	36.3
1992	8782.3	330.1	26.6
1993	8529.5	347.9	24.5
1994	9163.5	377.1	24.3
1995	9865.5	390.5	25.3
1996	10182.9	395.4	25.8
1997	10680.5	410.0	26.1
1998	11148.8	414.4	26.9
1999	11430.1	417.7	27.4
2000	9836.7	421.4	23.3
2001	7875.5	407.0	19.4
2002	7165.4	389.8	18.4
2003	7269.2	377.9	19.2
2004	7707.4	369.7	20.9
2005	8177.9	364.3	22.5
2006	9061.7	364.4	24.9

* 0.67 тэмээ, 1 морь, 1 үхэр, 6 хонь, 8 ямааг тус бүр нэг бод болно.

Ýð ñòðààèæ: *ÝСГ. Монгол Улсын статистикийн эмхтгэл 1989-2002, 2006-д үндэслэсэн зохиогчийн тооцоо.*

Зудын өмнөхөн үе болох малын тоо толгойн 1999 оны оргил үеийг 2006 онтой харьцуулахад малчин айл өрхийн тоо цөөрсөн бөгөөд нийт малчин өрхийн дунд олон толгой малтай айл өрхийн эзлэх хувийн жин нэмэгдсэн байна. 100-аас цөөн толгой малтай өрхийн тоо 1999 онд 58.5 хувь байсан бол 2006 онд 52.1 хувь болсон байна. Мөн хугацаанд 200-аас дээш толгой малтай өрхийн тоо 16.4 хувиас 24.3 хувь болтлоо нэмэгджээ.

Нийт малтай өрхөд малчин бус өрхийн эзлэх хувийн жин 1999 онд 29.7 хувь байсан бол 2006 онд 24.2 хувь болж буурчээ.⁵⁰ Тэгэхлээр бид эдгээр өрхийг бүгд 100-с доош тооны малтай гэж үзвэл энэ тооцоо өнөөгийн нөхцөлд тун ойртож ирэх бөгөөд бусад өрхийн эзлэх хувийн жин, малчин өрхийн хувийн жин дараах байдлаар илэрхийлэгдэж болох юм. Үүнд:

Хувийн жин	1999	2006
100-с дээш малтай өрх	59.0%	63.2%
200-с дээш малтай өрх	23.3%	32.5%
500-с дээш малтай өрх	3.5%	6.3%

⁵⁰ *I äéü öü öí ääíéí ü ýýýèèèä íæ öü èèäüí æèèèí ü ýýýýý ñ ääñäí. Ýýý ü ýýýýýð íæ ÷èí, íæ ÷èí äóñ °ð ö äýæ ýèäæ äàðàäà¿é ö-èð íæ ÷èí äóñ °ð ö äýýýäö °ð ðèèí °ð ö°ð èèèí íð èíäíðíé äí èí ä-ð°í íæð äé °ð ðèèä íð öèèäí ä í èí.*

Энэ баримтаас үзэхэд малчин өрхийн тоо зудын өмнөх үеэс олон байгаа боловч 100-аас цөөн толгой малтай өрхийн тоо 36.8 хувь байгаа нь анхаарал татаж байна. Энэ байдал нь ҮСГ-аас орон нутгийн ялгаатай, тэгш бус байдал нэмэгдэж байгаа тухай мэдээлж байгаатай таарч байна. Орон нутагт орлогын хуваарилалтын Жини коэффициент 2003-2006 онд 0.313-с 0.360 хүртэл нэмэгдсэн байна. Харин сумын төвийг хасч тооцвол хөдөөд энэ коэффициент 0.309-0.346 болж нэмэгджээ.

Хүснэгт 3.12 Малтай өрх, малын тооны бүлгээр, Монгол Улс, 1999, 2006

Малын тооны бүлэг	1999			2006		
	Өрхийн тоо	Эзлэх хувь	Өсөн нэмэгдэх хувь	Өрхийн тоо	Эзлэх хувь	Өсөн нэмэгдэх хувь
10, түүнээс доош	28669	10.62	10.62	21710	9.63	9.63
11-30	35970	13.32	23.94	27791	12.33	21.96
31-50	31874	11.81	35.75	24175	10.73	32.69
51-100	61347	22.73	58.48	43687	19.38	52.07
101-200	67840	25.13	83.61	52445	23.27	75.34
201-500	37635	13.94	97.55	44765	19.86	95.21
501-999	5438	2.01	99.56	8458	3.75	98.96
1000-1499	1061	0.39	99.96	2024	0.90	99.86
1500-2000	75	0.03	99.98	182	0.08	99.94
2001, түүнээс дээш	41	0.02	100.00	129	0.06	100.00
Дүн	269950	100.00		225366	100.00	
Үүнээс малчин өрх	189900			170755		

Үд нододдөө: ҮСГ. Монгол Улсын статистикийн эмхтгэл 1989-2002, 2006.

Аi äëïäüi ðáàèëäàð: Ñó ìüi ð°äëéí ý äëéí çàñàëëä ñýðäýýð çàìààð ìðü ìóðààð ð°ä°ëì°ð ýððëýðèëä äëé á î ëäì õ

1991-2001 онд буюу шилжилтийн эхний арваад жилд Монголын хөдөөгийн хөгжлийн асуудал нь бараг тэр чигээрээ газар тариалангийн хөгжлийн асуудал байлаа. Цаг агаар таатай байсан жилүүдэд орон нутгийн ард иргэд сайхан амьдарч харин цаг агаарын хүнд хэцүү жилүүдэд тэд зовж зүдэрч байлаа. Орон нутгийн мал аж ахуйн бус болон газар тариалангийн бус үйлдвэрлэл харьцангуй хязгаарлагдсан

төдийгүй төсөв, санхүүгийн бэрхшээлийн улмаас засгийн газрын гол үйлчилгээ ч нэлээд нь зогссон. Төлөвлөгөөт эдийн засгийн үед нэгдэл, хоршоолол, сангийн аж ахуйн удирдлага төвлөрч эдийн засгийн чухал нэгж болж байсан сумын төвүүдийн үйл ажиллагаа ч бүрхэг болсон.

Сүүлийн жилүүдэд дараах нэлээд хэдэн хүчин зүйлийн үр нөлөөгөөр сумын төвүүдийн эдийн засгийн үйл ажиллагаа сайжрах байдал ажиглагдаж байна. Нэгдүгээрт, Монгол Улсын санхүүгийн салбар эрчимтэй сэргэсэн нь сумын төвүүдэд санхүүгийн нөөцийг бодитойгоор нэмэгдүүлэхэд хүргэсэн. Сүүлийн үеэс буюу гурав дөрвөн жилийн өмнөөс Монгол Улсын хөдөөгийн эдийн засгийг мөнгөн бус буюу худалдаа, арилжааг бартерын үйлчилгээнд суурилсан хэмээн тодорхойлж байсан ч нөхцөл байдал маш их өөрчлөгдөв. Дараах хүснэгтэд монголын хөдөөд хамгийн далайцтай үйл ажиллагаа явуулдаг ХААН банкны сумын төвүүд дэх салбараас “малчдад олгосон зээл, малчдын хадгаламж”-ийн⁵¹ талаарх мэдээллийг үзүүлээ.

Хүснэгт 3.13 “ХААН” банкны сумын төвүүд дэх салбараас малчдын авсан зээл* (мянган төгрөгөөр), Монгол Улс, 2002-2007

	Зээлийн тоо	Зээлийн хэмжээ	Дундаж хэмжээ	Малчдын нийт хадгаламж
12/31/2002**	3,081	2,874,357	933	
12/31/2003	6,065	5,886,933	971	
12/31/2004	13,265	12,329,815	929	
12/31/2005	32,366	32,442,271	1,002	8,793,387
12/31/2006	52,022	62,788,963	1,207	15,372,211
9/30/2007	59,655	89,341,432	1,498	16,366,462

* “ХААН” банкны мэдээлэл
 ** 2003 оны дунд хүртэл ХААН банк нь Хөдөө аж ахуйн банк нэртэй улсын өмчийн банк байсан. Тэр үед бусад арилжааны банкууд хүрээгээ хөдөөд тэлж байсан хэдий ч тус банк нь хөдөөгийн сум бүрт хүрдэг ганц банк байсан.

Хөдөөгийн хүн амд чиглэсэн санхүүгийн үйлчилгээнд гарч буй эдгээр өөрчлөлт нь жижиг бизнесүүдэд чиглэсэн шинэ шинэ боломжуудыг бий болгох, шинэ шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтийг бий болгох зэргээр хөдөөгийн

⁵¹ ãë-ããä çìðéò èñàì ñüüi ð°à à ñóððëèñàì ð°ð°è á°ð äáëäãä. Õýäëäýýð ð òñ äàìè çìðëèòì ã¿ëäëëä òì àìð òìèè ì çàãããã¿çè ñüüi ð°à à ðýðýã¿ç¿ýð çýý, ðããããèìäëéí ð°ð°è á°ð ðýé ð°à°äëéí á òñàà ð¿¿¿ñ à ýýðð ð°ð°è á°ð ð ìðì èòì ð äì èì ìæìè.

эдийн засагт томоохон өөрчлөлт гарахад нөлөөлжээ. Орон нутгийн эдийн засгийн үйл ажиллагааны түвшинг нэмэгдүүлэх бусад олон үзүүлэлт бий. Тухайлбал, цахилгаан эрчим хүчээр хангагдсан малчин өрхийн хувийн жин 2003 онд 28.9 хувь байсан бол 2006 онд 78.7 хувь болсон⁵² бөгөөд үүний үр дүнд зурагт радио үздэг малчин өрхийн тоо ч ихээр нэмэгдсэн байна. Монголын хөдөө орон нутагт гар аргаар байгалийн баялгийг олборлох явдал нэмэгдсэн нь бодлогын хувьд олон хүндрэл бэрхшээлийг бий болгохын сацуу сумын төвийн эдийн засгийн үйл ажиллагаа хөгжих, бэлэн мөнгөний урсгал нэмэгдэх зэрэгт нөлөөлсөн байх талтай.

Хэдийгээр иймэрхүү эерэг төлөв байдал илэрч байгаа боловч хөдөө орон нутагт ялангуяа цөөн малтай, ядууралд өртөх өндөр эрсдэлтэй хүн ам олноор амьдарч байна.⁵³ Дэлхийн банкны “Монгол Улсын Ядуурлын үнэлгээ” тайланд дурдсанаар Монгол улсын малчин өрхийн 67 хувь нь архаг ядуу байдалд эсвэл ядууралд орох эрсдэлд амьдарч байгаа ажээ.⁵⁴ Дэлхийн банкны уг тайланд⁵⁵ малын даатгалыг бий болгох замаар малчдын өрхийн орлогыг нэмэгдүүлэх, тэдний эрсдэлтэй эмзэг байдлыг нь өөрчлөх арга замуудыг эрэлхийлэх, мөн мал маллахаас өөр хөдөлмөр эрхлэх, орлогоо нэмэгдүүлэх эх үүсвэрийг бий болгох талаар яаралтай арга хэмжээ авах нь юунаас илүү чухал гэжээ. Мөн орон нутгийн олон арван ядуучууд сумын төвд амьдарч байгаа бөгөөд ӨЗОАТС-аар тэдний ядуурлын түвшин 44,6 хувь байгаа нь судалгаанд хамрагдсан хүн амын бусад бүх бүлгийнхнээс, тухайлбал,

малчид, аймгийн төв, Улаанбаатар хотын оршин суугчдынхаас өндөр байна.

Амьжиргааны доод түвшнээс доогуур амьдарч байгаа хөдөөгийн нийт хүн амын 37 хувийн амьжиргааг сайжруулахад хөдөөд ажлын байр бий болгож байгаа өнөөгийн явц хэтэрхий удаан байна. Ядуучуудын дийлэнхийг цөөн тооны малтай малчид эзэлж байгаа учир тэдний гэр бүлийн ядаж нэг хэсэг нь орлогын ямар нэг нэмэгдэл эх үүсвэртэй байх шаардлагатай байна. Хөдөлмөр эрхлэлтэд суурилсан стратегийг орон нутагт хэрэгжүүлэх боломж бүрдүүлж болохуйц хамгийн тохиромжтой газар бол сумын төв юм. Цөөн тооны малтай малчид зах зээлийн эдийн засгийн гадуур үлдэж байгаа төдийгүй тэд шилжин суурьших, мэргэжлийн ур чадвар эзэмших сургалтад хамрагдах боломжийг бүрэн дүүрэн ашиглах боломжгүй байгааг олон тооны судалгааны дүн харуулж байна. Төрөл бүрийн үйлчилгээг тэдэнд аль болох ойртуулах нь чухал юм.⁵⁶ Хөдөөд эдийн засгийн өсөлтийг тогтворжуулах, хөдөлмөр эрхлэлтийг бий болгоход сумын төвийг гол тулгуур цэг болгон хөгжүүлэх талаар төр засгаас идэвхтэй бодлого явуулах шаардлагатай байна. Сумын төвүүд хүн амдаа санхүүгийн үйлчилгээ үзүүлэх гол төв болж байгаад түшиглэн тэнд арилжаа, нийгмийн үйлчилгээ явуулах боломжийг өргөжүүлвээс хөдөөд зах зээлийн эдийн засгийг үндсэн утгаар нь хөгжүүлэх бололцоо бүрдэнэ. Харин үүнд засгийн газрын зүгээс хэд хэдэн чиглэлээр тодорхой дэмжлэг туслалцаа үзүүлэх хэрэгтэй байна.

⁵² *N.A. I i tai e Oenii no aadendeeei yidoo y e 2006, o. 189, dzhiyao 10.17*

⁵³ *A.A. 2006. “I i tai e oen aadu yaooeui zhy eayy” o aeeitaei 3-d azeyao yaao lae -aii anbaadao ideyu a iadeeae-ee nai noaadaa deehui.*

⁵⁴ *ni ooye aae*

⁵⁵ *ni ooye aae.*

⁵⁶ *A-ii Oaeeei ooe a, i iai e Oenii Canaei aacaa. “Noaadaaii o aeeai: I ae-aui ooiadee yaeei canaa azoyi dz oadao ae aoea ead iu”, 2004.*

Шигтгээ 8

Ажил эрхлэлтийг хэрхэн амжилттай нэмэгдүүлж буй талаарх бусад улсын туршлага: Бүгд Найрамдах Энэтхэг Улсын /БНЭУ/-ын “Хөдөөгийн ажил эрхлэлтийг баталгаажуулах тухай” хууль

БНЭУ-ын “Хөдөөгийн ажил эрхлэлтийг баталгаажуулах тухай” хуулийг тус улсын Парламент 2005 онд батлан хэрэгжүүлж эхэлсэн нь ядуурлыг бууруулахад чиглэгдсэнээр үл барам ажил эрхлэлтийг хууль ёсны эрх болгон зөвшөөрсөн. Энэ хуулийн дагуу хөдөө, орон нутгийн нийт өрхийн ажилгүй гишүүдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх цалин хөлстэй, мэргэжлийн ур чадвар үл шаардах ажлаар жилийн 100 хоногт нь баталгаатай хангах ёстой. Түүнчлэн баталгаат хөдөлмөрийн зэрэгцээ хүүхдээ асран хүмүүжүүлж буй эхчүүд, тогтвортой хөрөнгийн эх үүсвэр, бусад заалтууд уг хуулинд мөн тусгагдсан байна. Одоогийн байдлаар энэхүү хуулийг тус улсын 7 мужийн 200 дүүрэгт хэрэгжүүлж байна.

ᠶᠳᠠ ᠠᠨᠠᠭᠠᠭᠠᠨ: П.Чакраборти. 2007. Энэтхэг улсын “Хөдөөгийн ажил эрхлэлтийг баталгаажуулах тухай” хуулийн хэрэгжилт, Леви эдийн засгийн институт

Шигтгээ нэгд дурдсанчлан, төвлөрлийг сааруулах өргөн хүрээний асуудлыг хамарсан тодорхой хөтөлбөрийн хүрээнд сумдын иргэдийн төлөөлөгчдийн

хурал, Засаг дарга нарт орон нутгаа хөгжүүлэх санаачлага гарган төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх илүү эрх мэдэл олгох замаар орон нутгийг хөгжүүлэх нь үр дүнтэй байх болно. Өнөөдрийн байдлаар орон нутгийн хурал, Засаг дарга нар орон нутгийн түвшинд шийдвэр гаргах эрх нь хязгаарлагдмал, үүрэг хариуцлага тодорхойгүй, төвөөс гарсан бодлого шийдвэрийн дагуу өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэгчид, төсвөөс хуваарилсан төсвийг зарцуулдаг үүрэг төдий хүмүүс болоод байна. “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” 2002 оны хуулинд тусгасан санхүүгийн зохицуулалтууд нь сүүлийн таван жилийн Монгол улсын санхүүгийн гүйцэтгэлд эерэгээр нөлөөлж үр дүнгээ өгч байгаа нь гарцаагүй юм. Гэсэн хэдий ч Засгийн газрын эрх мэдэлд илүү их санхүү, хөрөнгө төвлөрч байгаа энэ үед, орон нутгийн түвшинд бий болоод байгаа шинэ шинэ бэрхшээл, түүний хажуугаар гарч ирж байгаа боломжуудыг ашиглахын тулд нөхцөл байдлыг эсрэгээр эргүүлж орон нутгийн засаг захиргаанд орон нутгаа хөгжүүлэх, хүн амынхаа хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөгжүүлэх эрх мэдэл, чадавхийг бий болгох шаардлагатай байна. Тухайлбал, байгаль орчныг хамгаалах татварын орлогыг орон нутгийн засаг захиргаанд нь үлдээх гэх мэт боломж байна. Уул уурхайн олборлолтыг албан бусаар боловч өргөн хэмжээнд явуулж байгаа сумдын захиргаад эдгээр үйл ажиллагааг орлого олох шинэ боломжоо болгон ашиглах боломжтой бөгөөд олсон орлогоо дэд бүтэц, үйлчилгээний үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулж болох юм.

Найм дахь зөвлөмж

Хөдөө, орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, сумдын эдийн засгийг сэргээн бэхжүүлэх талаар

- Төвлөрлийг сааруулах өргөн хүрээтэй, зоримог алхмын хүрээнд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нарт орон нутгийнхаа онцлогт тохирсон орон нутгийн хөгжлийн стратегийг боловсруулан хэрэгжүүлэх, санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн зарцуулах эрх мэдлийг нь өргөжүүлэх;
- Сумын төвд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ үзүүлэх, сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах зэрэг үйл ажиллагааг өргөжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас сумын түвшинд зарцуулах хэмжээг нэлээд бодитой нэмэгдүүлэх, түүнчлэн уг сангийн хөрөнгийг аль болох бүрэн дүүрэн ашиглахад чиглэсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
- Орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн сацуу боломжтой гэж үзсэн газар бүрт орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх үүднээс хөдөлмөр шингээлт ихтэй ажлын байр бий болгох стратегийг иргэдийн оролцоотойгоор боловсруулан хэрэгжүүлэх;
- Малчдыг бизнес эрхлэгч хэмээн үзэж дэмжих үүднээс сумын төвд жижиг бизнесийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хөдөө аж ахуйн явуулын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр туршилтын арга хэмжээг зохион байгуулах;
- Хөдөө, орон нутаг дахь хөдөлмөр эрхлэлт, олон нийтийг хамарсан ажил үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор төр-хувийн хэвшлийнхний энэ чиглэлийн хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих;

3.7 *Áëááí áóñ ð'ä'èì'ð ýððëýëðèéã àëááí á î'äã ð ïü*

Албан бус эдийн засаг нь ажилгүй, цомхтголд өртсөн, улирлын чанартай ажилгүй хүмүүс, ажиллах хүчинд шинээр орж ирж байгаа зэрэг олон мянган хүмүүст ажлын байрыг бий болгосноороо зах зээлийн шилжилтийн үед чухал үүрэг гүйцэтгэсэн. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн өсөлтөд улсын өмчийн үйлдвэр аж ахуйн газруудын хувьчлал, орон тооны цомхотгол, нийгмийн үйлчилгээний хязгаарлалт, эдийн засаг, үйлдвэрлэлийн бүтцийн өөрчлөлт, өргөн хэрэглээний барааны дотоодын эрэлт хэрэгцээнд гарсан өөрчлөлт, хөдөө орон нутгаас аймгийн төвүүд рүү чиглэсэн хүн амын дотоод шилжих хөдөлгөөн зэрэг олон хүчин зүйлс нөлөөлсөн. Зарим иргэд гадаадад ажиллаж байгаа гэр бүлийн гишүүнийхээ илгээсэн мөнгө, гэр бүлийн хадгаламжийн хөрөнгөөрөө жижиг бизнес, “ганзагын наймаа” эрхлэх болсон. Зах зээлийн үед цайны газар, жижиг мухлагууд Улаанбаатар, бусад хотууд, аймаг сумын төвүүдэд олноор бий болсон. Том хотуудад зарим иргэд албан бус таксиний үйлчилгээ эрхлэх, хот хооронд нийтийн тээврийн үйлчилгээ явуулах замаар хөдөлмөр эрхлэх боломжуудыг ашиглах болсон. Гэхдээ бизнес эрхлэх тохиромжтой нөхцөл бүрдээгүй нь санаа зовоосон асуудлын нэг төдийгүй албан бус салбарт бизнес, хөдөлмөр эрхлэх лиценз, эрх авах, түүнийгээ хүчинтэй байлгах зэрэг нь өндөр өртөгтэй байдгийн зэрэгцээ зарим бэрхшээл хүндрэл учирч байдаг. Түүнчлэн албан бус эдийн засгийн салбарт санхүүгийн үйлчилгээ, маркетингийн дэмжлэг, ажлын нөхцөл байдал, ажлын байрны аюулгүй байдал, нийгмийн даатгалын үйлчилгээтэй холбоотой хүндрэлүүд ч урган гарч ирсэн юм.⁵⁷

Уул уурхайн албан бус сектор Монгол Улсын олон арван ажилчдын сонирхлыг ихээр татаж эхлээд байна. Эхний үед албан бусаар уул уурхайн салбарт хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь улсын уул уурхайн

⁵⁷ *Үгээрээдээ* *l* *iddeh*. *l* *itai e Oeh aadu aëääi áóñ ð'ä'èì'ð ýððëýëð: ð'è'ä ääéääë, ð ýðýäýý, ñðäàäàäë, l OÐÁ, Áitãäë, 2001.*

үйлдвэрүүд хаагдсанаас ажилгүй болсон геологчид, инженерүүд, тогооч, жолооч нар болон тэдний гэр бүлийн гишүүд байсан. 1990 оны дунд үеэс уул уурхайд албан ёсны хөдөлмөр эрхлэлт хөгжихийн хирээр эдгээр ажилчдын зарим нь ашигт малтмалын хайгуулын компаниудад ажилтай болсон. Албан бус аргаар уурхайд хөдөлмөр эрхлэх ажлаа үргэлжлүүлэн гэр бүлдээ орлого олох арга замыг эрэлхийлсэн хүмүүсийн дийлэнх нь тариаланчид, хотын ядуу иргэд, малчид байлаа.⁵⁸

Тодорхойлолт ба хэмжүүр

ОУХБ-ын зохион байгуулсан Хөдөлмөрийн статистикчдийн олон улсын бага хурал дээр албан бус эдийн засгийн хэд хэдэн статистик хэмжүүр дэвшүүлэн тавьсан билээ. Нэгдүгээрт, албан бус сектор нь үйлдвэрлэлийн нэгжид тулгуурласан байдаг бөгөөд энэ салбарын үндэсний үйлдвэрлэлд оруулж буй эдийн засгийн хувь нэмрийг нь үнэлэх замаар үндэсний тооцоонд тусгадаг байна. Дүрэм журам нь тодорхойгүй, бэрхшээлтэй байдаг тул энэ үйл ажиллагаа нь өрхийн түвшний, зохион байгуулалтгүй, тусдаа ямар ч бүртгэл тооцоогүй явагдаж байна. Албан бус секторын нэгжүүд нь ихэнхдээ бүртгэлгүй, тогтмол ажилладаг цөөн тооны ажилчинтай байдаг. Эдгээр нь нэг бол өөрийн данс тооцоотой аж ахуйн нэгж хэлбэрээр, эсхүл албан бус ажил олгогчдын аж ахуй байх жишээтэй.

Өөрийн гэсэн данс тооцоотой аж ахуйн нэгж нь тухайн нэг гэр бүлийн эзэмшлийнх бөгөөд өөрийн ажилчинтай, тэр нь дангаараа буюу өөрийн гэр бүлийн гишүүд эсвэл өөр гэр бүлийн гишүүдтэй хамтран үйл ажиллагаагаа явуулдаг. Эдгээр аж ахуй нь гэр бүлийнхээ бусад гишүүдийг ажиллуулдаг, заримдаа түр хугацаагаар байнгын бус ажилчин хөлсөлж ажиллуулдаг байна.

Албан бус ажил олгогчдын аж ахуйн нэгж нь тухайн ажил олгогчийн өмч байдаг бөгөөд түүнийгээ дангаараа буюу

хэн нэгэнтэй хамтран эзэмшиж нэг буюу түүнээс дээш тооны байнгын ажилчдыг ажиллуулдаг. Үйл ажиллагааны хувьд албан бус аж ахуйн нэгжийн хөдөлмөр эрхлэлтийн түвшинг бүртгэлтэй ажиллагчдын тоогоор тодорхойлж болох юм.


“Өөрсдийн ахуйн хэрэглээнд” зориулан үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа өрхийн аж ахуйг албан бус секторт хамааруулж болохгүй. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, албан бус секторын хооронд тодорхой ялгаа зааг тогтоохын тулд хөдөө аж ахуйн бус үйл ажиллагааг оруулахгүй байхаар журамд заасан байдаг. Монгол Улсад 2002–2003 онд явуулсан ажиллах хүчний талаарх судалгаанаас харахад хөдөө аж ахуйн бус хөдөлмөр эрхэлж байгаа хүний тоо 460300 буюу нийт ажиллагчдын 53.4 хувийг эзэлж байна. Хөдөө аж ахуйн бус хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь буюу 80 хувь нь хот суурин газарт, цөөнх нь буюу зөвхөн 20 хувь нь хөдөө орон нутагт байна. Хөдөө аж ахуйн бус үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж болон ажиллагчдын тоог дараах 3.14-р хүснэгтэд үзүүлээ.

Ажиллах хүчний талаарх судалгаагаар хөдөө аж ахуйн бус үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн ажиллагчдын тоог хувийн аж ахуй, хамтарсан, хувиараа хөдөлмөр эрхлэх гэх мэт төрлөөр, хот, хөдөө орон нутгийн гэсэн ангиллаар судалжээ. Хөдөө аж ахуйн бус үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйд хөдөлмөр эрхэлж байгаа 125100 хүний 86.7 хувь нь бизнесийн салбарт буюу хувиараа хөдөлмөр эрхлэх гэсэн ангилалд багтжээ. Хөдөө аж ахуйн бус үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нийт нэгжийн 10 хувь нь 1-4 цалинтай ажилчинтай, бусад ангилалд багтсан аж ахуйн нэгжүүд нь түүнээс цөөн ажилчинтай байна. Хувиараа хөдөө аж ахуйн бус үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн ажиллагчдын тоо хотод хөдөөгөөс арай цөөн байна. Хувийн гэсэн ангилалд орсон аж ахуйн нэгжүүд нийт ажиллагчдын дөнгөж 11.5 хувийг бүрдүүлж байна.

⁵⁸ *ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠲᠤᠮᠤᠨ*

ахуйн бус салбараар хязгаарлан авч үзсэн бөгөөд үйл ажиллагаа явуулагсдын талаас илүү хувь нь эрэгтэйчүүд, арван хүний долоо нь хот суурин газруудад ажиллаж, дийлэнх хувь нь худалдаа үйлчилгээ, зах дээр үйл ажиллагаа явуулж байжээ.

Дүрслэл 3.10 Албан бус секторт ажиллагчдын боловсролын түвшин, хувиар, Монгол Улс, 2002-2003



Үгс: ҮСГ, АХБ. Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан 2002-2003, х 82.

Албан бус хөдөлмөрийг үйлдвэрлэлийн зохион байгуулалтаас илүү тухайн ажлын мөн чанарт тулгуурлаж ойлгоно. Энэ нь ажилчин хөдөлмөрийн гэрээтэй эсэх, цалинтай амралттай эсэх, нийгмийн даатгалтай эсэх зэрэг шинж чанаруудаар тодорхойлох боломжтой. Албан бус хөдөлмөр эрхэлж байгаа ажилчдад ихэнхдээ хөдөлмөрийн хууль үйлчилдэггүй.

Цалин, хөлстэй ч тухайн ажлыг “албан бус” гэдгийг нь тухайн ажилчин хөдөлмөрийн гэрээтэй эсэхээр тодорхойлох бас нэг арга байж болно. Энэ асуулт ажиллах хүчний талаарх судалгаанд орсон. Судалгаанаас харахад хөдөлмөр эрхэлж байгаа хүн амын 39.4 хувь нь 2002–2003 онд цалин, хөлстэй ажилласан байна. Эдгээр хүмүүсээс 312000 нь хөдөлмөрийн гэрээтэй, 26700 нь “иргэний хуулиар” хөдөлмөр эрхэлж байгаа буюу нийт хөдөлмөр эрхлэгчдийн 3.1 хувийг эзэлж байгаа юм. Хэрвээ хөдөлмөрийн гэрээтэй ажиллагчдыг албан ёсны хөдөлмөр эрхлэгчид гэж үзээд хөдөлмөрийн гэрээгүй ажиллагчдыг хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоон дээр нэмбэл нийт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тоо 550500 болж байна. Энэ нь 2002–2003 онд хөдөлмөр эрхэлж

байгаа нийт хүмүүсийн 63.7 хувь болох бөгөөд тэд хөдөлмөр эрхэлж байгаа нийт эрэгтэйчүүдийн 65.9 хувь, эмэгтэйчүүдийн 65.1 хувийг тус тус бүрдүүлж байна. Ижил аргаар тооцоолж үзэхэд нийт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 46.2 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Сургуулиас ажилд шилжигсдийн талаар ҮСГ-аас явуулсан судалгаанд 15-29 насны 808800 залуучуудыг төлөөлөх чадвар бүхий нийт 4600 өрхийн 6100 залуучууд түүвэрлэлтэд хамрагдсанаас 15-29 насны 124200 залуучуудын 112200 нь цалинтай хөдөлмөр эрхэлж байсны 108600 нь бичгээр үйлдэгдсэн хөдөлмөрийн гэрээтэй, 3700 нь аман хэлбэрээр байгуулсан ажлын гэрээтэй ажиллаж байсан байна. Харин 164200 нь цалинтай боловч хөдөлмөрийн гэрээгүй эсвэл хувиараа хөдөлмөр эрхэлж байсан байна. Хэрвээ эдгээр хэлбэрийн хөдөлмөр эрхлэлтийг “албан бус хөдөлмөр эрхлэлт”-д тооцвол залуучуудын 59,4 хувь нь энэ ангилалд багтаж байна. Ижил тодорхойлолт, ижил эх сурвалжийн тоо баримт ашиглаж үзэхэд албан бус хөдөлмөр эрхэлж байгаа 15-29 насны залуусын гуравны хоёр нь мал маллаж байгаа бөгөөд тэдний дийлэнх буюу 78.7 хувь нь хөдөө орон нутагт, 21.3 хувь нь хот суурин газарт ажиллаж байна.

Ажиллагчдын боловсрол

Эдийн засгийн шилжилтийн эхний үеэс албан бус эдийн засгийн салбарын үр дүн, хөдөлмөр эрхлэлтийн талаар янз бүрийн тооцоо гарч байсан хэдий ч албан бус салбар нь олон арван монголчуудад хөдөлмөр эрхлэх, орлого олох боломж бий болгож байсан нь гарцаагүй. Үүнтэй зэрэгцэн үйлдвэрлэлийн нөхцөл байдал, ажлын чанар зэрэгтэй холбоо бүхий хүндрэлтэй асуудлууд ч гарч ирсэн. Албан бус салбарт ажиллаж байгаа дийлэнх ажилчид бүртгэл тооцоогүй, хамгаалалтгүй, зохион байгуулалтгүй явж ирлээ. Засгийн газар, ажил олгогчид, ажилчид бүгд л “албан бус байдлыг албан ёсны” болгохын төлөө ажиллаж байна. Асуудлын гол нь энэхүү боломжийг ашиглахад л байна.

Алтны уурхайд албан бус хөдөлмөр эрхлэх нь олон нийтийн сонирхлыг ихээр татах болсон. Хүнд хортой нөхцөлд насанд хүрээгүй хүүхдүүд ажиллаж байгаа нь шийдвэрлэвэл зохих нэг асуудал болж байна. Монголын ажил олгогч эздийн холбоо хүүхэд залуучуудад албан бус боловсрол, мэргэжлийн ур чадвар олгох сургалтаар дамжуулан ажил хийх, орлого олох өөр боломжуудыг бий болгохын төлөө ажиллаж байна. 2005 онд явуулсан судалгаагаар Хөдөлмөрийн хуулийн заалтууд зөвхөн бичгээр байгуулсан хөдөлмөрийн гэрээтэй ажиллаж байгаа хүмүүст хамаарч байгааг харуулжээ. Гар аргаар алт олборлох асуудлыг зохицуулах тухай хуулийн төсөл боловсруулалт, хэлэлцүүлгийн шатандаа байна.

Сүүлийн жилүүдэд зарим төрийн бус байгууллагууд, үйлдвэрчний эвлэлүүд албан бус эдийн засгийн салбарт хөдөлмөр эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Зохистой ажлын байрыг бий болгох явдлыг зөвхөн эдийн засгийн өсөлт, албан секторт найдаж орхих боломжгүй учраас албан бус эдийн засгийн салбарт хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс буюу гар аргаар эрдэс баялаг олборлогчид, такси болон жижиг оврын автобусны жолоочид, зурагчид, гудамжны наймаачид, захын худалдаачид зэрэг тодорхой бүлгийн хүмүүсийн эрх ашгийг хамгаалах зорилготой шинэ холбоо, эвсэлүүд ч байгуулагдаж байна.⁶⁰

Зах зээлийн эдийн засагт шилжсэн эхний жилүүдээс эхлэн Монгол Улс албан бус эдийн засагтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэхийн тулд төрөл бүрийн арга хэмжээг авсаар ирсэн. 2001 оны Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний чуулганы дараагаас буюу 2002 онд Засгийн газар албан бус эдийн засгийн асуудлаарх үндэсний чуулган зохион байгуулсан. 2006 онд Монгол Улсын Их Хурлаар баталсан албан бус хөдөлмөр эрхлэлтийн тухай бодлогын

баримт бичиг нь төр засгаас ОУХБ-ын зохистой ажлын байрны талаарх ойлголтыг үндэслэн боловсруулсан үйл ажиллагааны төлөвлөгөө юм.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам 2007 онд аймаг, дүүргүүдийн хэмжээнд албан бусаар хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн дунд тусгайлан боловсруулсан маягтаар бүртгэл, тооллого явуулах ажлын удирдамжийг баталж бүртгэлийн ажилд зориулсан төсвийг аймаг дүүргүүдэд хуваарилсан байна. Албан бусаар хөдөлмөр эрхлэгч бүр бүртгэлийн дугаар, гэрчилгээтэй болох юм. Үүнээс гадна хандивлагчдын санхүүжилтэй хоёр ч төслийн хүрээнд албан бусаар уурхайд хөдөлмөр эрхэлж байгаа насанд хүрэгсэд болон хүүхдүүдийн дунд бүртгэл тооллого явуулахаар төлөвлөжээ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тусламжтайгаар хувийн секторын үйлдвэрчний эвлэлүүд албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаарх төр засгийн газрын бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийн талаар олон нийтийн ойлголт ухамсрыг дээшлүүлэхэд чиглэсэн ажлуудыг зохион байгуулж байна. Мөн уг сангийн санхүүжилтээр жижиг бизнес эхлэх буюу бизнесийн үйл ажиллагаагаа өргөтгөх сэдвээр сургалт зохион байгуулж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулинд орсон нэмэлт өөрчлөлт нь албан бусаар хөдөлмөр эрхлэгчдэд зээл авах, сургалтад хамрагдах, бизнес хөгжүүлэх инкубатор үйлчилгээг хүртэх зэрэг боломжуудыг олгож байгаа юм. Ийнхүү цаашид хүн амын амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн аливаа үйл ажиллагаа, албан бус бизнес, бичил аж ахуйн нэгжүүдийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төрийн бодлого, хууль эрх зүйн орчин бүрдүүлэх замаар байнга дэмжих бөгөөд доорх шигтгээнд үзүүлсэн удирдамжийн дагуу үйлдвэр аж ахуйн газрууд, үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

⁶⁰ *Oñweii, Aããã, ðõñã: Aããã ðõñ yããã çãñããã ðªªªª ðããããããã ðªªªªªªª ñyí íú: Aãããã ðeññú ð õðøe äãããñ, "Í ñãã e ðeñ äããu äeããã ðõñ ñãeãããñ ðªªªªªªª yððeýeððeë ðõãeñ yðð çããeã ãeë äí eããõ íú." A.Ìãð ìããããð, Í ÕÕÄ-íí Çããí Açeëí Ayã äçñeëí Aããã (õãããã:ãããããã), ðð. 108-109.*

Шигтгээ 9

Албан бус секторын тухай төрийн бодлого

Хуулинд албан бус салбарыг хөдөө аж ахуйн бус, хуулиар хориглоогүй бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг албан бүртгэл, статистик мэдээлэл, нийгмийн хамгааллын тогтолцоонд бүрэн хамрагдаагүй аж ахуйн нэгжүүдийг албан бус салбарт хамруулан авч үзнэ хэмээн тодорхойлжээ. Энэхүү тодорхойлолтын дагуу авч үзвэл албан бус хөдөлмөр эрхлэлт нь зохион байгуулалтанд ороогүй байдаг гэсэн ойлголт төрүүлнэ. Уг бодлогын гол зорилго нь албан бус салбарыг төрийн үйлчилгээнд хамруулах, хууль эрх зүй, хөдөлмөр, нийгмийн хамгааллын баталгаа гаргах замаар албан болгох, улмаар эдийн засгийг өсөлтийг хангах, албан бус салбарт ажиллагчдийн эрх ашгийг хамгаалах явдал юм⁶¹. Энэхүү бодлого гурван үе шаттай хэрэгжих ба эхний үе шат нь 2005-2007 онд, хоёр дахь үе шат нь 2008-2011 онд, гурав дахь үе шат нь 2012-2015 оныг хамарна. Хэрэгжүүлэх стратеги нь макро эдийн засгийн бодлоготой уялдах бөгөөд хууль эрх зүйн үндэс болон нийгмийн хамгааллын тогтоолцоог сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлоготой уялдуулах, түүнчлэн олон нийтийн яриа хэлэлцүүлэг, оролцоог өргөжүүлэх арга замаар тус салбарынхантай хамтран ажиллах явдал юм.

ᠶᠣ ᠨᠠᠯᠠᠭᠠᠭᠢ: Монгол Улсын Засгийн газар. 2006. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаарх Монгол Улсын засгийн газрын бодлого.

Сүүлийн үед албан бус салбарынхны нийгмийн даатгал анхаарал татаж байна. Өнөөгийн мөрдөж байгаа хуулиар бол албан бус хөдөлмөр эрхлэгчид, малчид сайн дурын үндсэн дээр нийгмийн даатгалд хамрагдах боломжтой. Гэвч тэдний тун бага хувь нь нийгмийн даатгалд хамрагдаж байгаа учир олон арван монголчууд тэтгэвэр авах боломжгүй болж мэдэхээр

⁶¹ ᠶᠢ ᠨᠠᠯᠠᠭᠠᠭᠢ ᠴᠠᠨᠠᠳᠦᠯᠠᠭᠠᠳ.2006. ᠠᠭᠠᠢ ᠠᠨᠢᠨᠠᠭᠠᠭᠢᠯᠠᠭᠠᠳᠦ ᠶᠠᠳᠢᠬᠡᠭᠡᠳᠡᠳᠡᠰᠡ ᠠᠨᠠᠯᠠᠭᠠᠭᠢ ᠠᠨᠠᠭᠠᠭᠢᠯᠠᠭᠠᠳᠦ ᠠᠨᠠᠭᠠᠭᠢᠯᠠᠭᠠᠳᠦ 2005 ᠶᠢᠰᠡ 12-ᠳᠠᠨᠠᠳᠦ ᠠᠨᠠᠭᠠᠭᠠᠭᠢ ᠶᠠᠭᠠᠭᠠᠭᠢᠯᠠᠭᠠᠳᠦ, 2006 ᠶᠢᠰᠡ ᠠᠨᠠᠭᠠᠭᠠᠭᠢᠯᠠᠭᠠᠳᠦ.

байгаа юм. Бас нэг чухал асуудал бол эрүүл мэндийн даатгал. ОУХБ-аас Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотуудад жижиг наймаачдын дунд хийсэн судалгаанаас үзэхэд эдгээр хүмүүс нийгмийн даатгалд хамрагдахгүй байгаа, тэдний 88 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй явдлыг хамгийн ноцтой асуудал, гол бэрхшээл хэмээн тодорхойлсон. Мөн уг судалгааг албан бус хөдөлмөр эрхлэгчид, малчид, ажилгүйчүүдийн дунд явуулахад үндсэндээ ижил дүн гарчээ.⁶² Үүнээс үзэхэд нийгмийн даатгалын асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай юм.

Эдгээр арга хэмжээг цогцоор хэрэгжүүлэхийн тулд ажил олгогчид ажиллагчдаа улсын нийгмийн даатгалд хамруулах асуудлыг дэмжих шаардлагатай. Олон салбарын төлөөлөлтэй хийсэн хэд хэдэн хэлэлцүүлгийн үеэр ажил олгогчдоос нийгмийн даатгалд төлөх хураамж өндөр учир ихэвчлэн ажил олгогч нар ажилчдаа албан бүртгэлд бүртгүүлэх дургүй байдаг гэж байлаа. Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хувь 19 хувь байгаа нь өндөр хувь бөгөөд шинэ ажлын байрыг бий болгоход гол саад учруулж байгаа болохыг Монголын олон бизнесменүүд байнга дурьдаж байгаа бөгөөд энэ нь ажил олгогчид цөөн тооны ажилтантай байхыг хүсэх, эсвэл ажилчдаа нийгмийн даатгалд хамруулахгүйгээр албан бусаар ажилуулах, түр гэрээгээр зохицуулалт хийх зэргийг илүүд үзэх явдлыг өөгшүүлэхэд хүргэж байна. Монголын ажил олгогч эздийн холбооны гишүүдийнхээ дунд явуулсан судалгаагаар нийгмийн даатгалын шимтгэлийн хувийг бууруулах нь тэдний нэн тэргүүнд тавьж байгаа хүсэлт болохыг тэмдэглэжээ. Нийгмийн даатгалд хамрагдахгүй байдлыг харуулсан 3.15-р хүснэгтийн мэдээлэл асуудлын цар хүрээ ямар байгааг харуулж байна.

⁶² ᠶᠢ ᠨᠠᠯᠠᠭᠠᠭᠢ. “ᠠᠨᠠᠯᠠᠭᠠᠭᠢ, ᠶᠢ ᠨᠠᠯᠠᠭᠠᠭᠢ, ᠠᠨᠠᠯᠠᠭᠠᠭᠢ ᠶᠠᠳᠢᠬᠡᠭᠡᠳᠡᠳᠡᠰᠡ ᠠᠨᠠᠯᠠᠭᠠᠭᠢᠯᠠᠭᠠᠳᠦ” 2006, ᠔. 17

Хүснэгт 3.15 Нийгмийн даатгалын үзүүлэлтүүд, Монгол Улс, 1995, 2000, 2005

Үзүүлэлтүүд	1995	2000	2006
Нийт ажилчид	767.6	809.0	1009.9
ХАА газар тариалан эрхэлдэг	354.2	393.5	391.4
ХАА газар тариалангийн бус ажил эрхэлдэг	413.4	415.5	618.5
Нийгмийн даатгал төлдөг ажилчдын тоо	14069.0	13017.0	18535.0
Ажилгүйдлийн, үйлдвэрийн ослын ба тэтгэврийн даатгалтай иргэдийн тоо /мян.хүн/	409.1	381.4	427.8
Үүнээс:			
Албан журмаар/ Заавал даатгалд даатгагдсан	395.4	363.9	401.4
Сайн дураар даатгуулсан	13.7	17.5	26.4
Ажилгүйдлийн, үйлдвэрийн ослын ба тэтгэврийн даатгалд бүртгэгдсэн ажилчид	53.3	47.1	42.4
Ажилчдын тоо өмнөх үеэс өссөн байдал		41.4	200.9
зөвхөн ХАА газар тариалангийн бус		2.1	203.0
Нийгмийн халамжинд бүртгэгдсэн ажилчдын тоо өмнөх үеийнхээс өссөн байдал		-27.7	46.3

Үд нодбайгэе: Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээ.

Монголд шинээр бий болж буй ажлын байрны дийлэнх хувь нь ажиллагчдаа улсын тэтгэврийн, ажлын байран дахь осол гэмтлийн даатгал, ажилгүйдлийн даатгал төлөхгүйгээр ажиллуулдаг байна. Энэ тооцоонд малчдыг оруулахгүйгээр зөвхөн хөдөө аж ахуйн бус ажиллах хүчнийг авч үзэхэд нэлээд анхаарал татсан дүн гарч байна. 2000-2006 онд хөдөө аж ахуйн бус чиглэлээр нийт 203000 ажлын байрыг шинээр бий болгожээ. Гэвч мөн хугацаанд тэтгэврийн даатгалын санд хамрагдагчид зөвхөн 46300-аар нэмэгджээ. Үүнээс үзэхэд шинээр ажлын байртай болсон ажилчдын дийлэнх нь нийгмийн даатгалын үндсэн хөтөлбөрт хамрагдаж чадахгүй байгаа нь анхаарал татах асуудал мөн.

Цалингаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хувийг бууруулах асуудлыг дэмжигчид нь татварын хэмжээг бууруулсны үр дүнд хүн амын орлогын татварын хураасан хэмжээ нэмэгдсэн

байдлыг жишээ болгон ярьж байгаа бөгөөд нийгмийн даатгалын төлбөрийн хэмжээг бууруулах нь ажилчдын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бөгөөд ямар нэг алдагдалд хүргэхгүй гэж үзэж байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээг бууруулах нь нийгмийн даатгалын санд хувь нэмрээ оруулах ажилчдын тоог нэмэгдүүлэх боломжтой боловч ялангуяа шимтгэлийн хэмжээг бууруулсны эхэн үед нийгмийн даатгалд төлөгдөх нийт шимтгэлийн хэмжээг нилээд хэмжээгээр бууруулах талтай гэдэг нь тодорхой юм. Ийм учраас татварын хувийг тогтоох, улсын нийгмийн даатгалын сангийн нөөц багасах зэрэгтэй холбоотой асуудлыг зөвхөн хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх үр нөлөөг авч үзсэн байр сууринаас хандаж болохгүй. Нийгмийн даатгалын бодлого нь хүн амд хангалттай, найдвартай нийгмийн халамж, тусламжийг үзүүлж түүнийг баталгаажуулах үндсэн зорилготой бөгөөд бидний авч үзэж байгаа асуудлын хувьд энэ нь хүн амын өндөр настай бүлгийн хэрэгцээг хангахад зориулагдах ёстой. Даатгалын санд орох хөрөнгө, мөнгөний хэмжээ багассанаар ирээдүйд монгол ажилчдын авах тэтгэврийн хэмжээг бууруулахад хүргэж болохгүй.

Монгол Улсын Их Хурлаар хэлэлцэж эхлээд байгаа хуулинд ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал нэлээд нухацтай яригдаж байна. Ажлын байр нь гарч болзошгүй аюулыг урьдчилан тодорхойлох, осол гарч мэдэх эрсдэлийг бууруулах алхам хийх гэх мэтээр албан бус секторын ажлын байрны аюулгүй байдлын талаарх асуудлыг шийдвэрлэсэн байх ёстой. 2007 оны 11-р сард болсон Хөдөлмөр эрхлэлтийн талаарх үндэсний чуулганд оролцогчид оролцооны аргаар судалгаа хийх, хөдөлмөрийн хяналт, нийгмийн түншлэлийг хангасан аюулгүйн ажиллагааны кампанит ажил зохиох хэрэгтэйг уриалж байсан.

Тодорхойлолт, хэмжүүрийн талаар авч үзсэн энэхүү хэсэгт албан бус

салбарын үйл ажиллагаа, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой статистик мэдээлэл дутмаг талаар дурдлаа. Албан бус эдийн засаг нь ажил олгогч, ажилчин аль алиных нь асуудлыг хамруулдаг. Хөдөлмөрийн харилцаа нь албан ёсны салбараас арай өөр. Хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн эрхийн талаарх ойлголт муу байгаа учир ажил олгогчид, ажилчдад зориулсан тэдний эрх, үүргийн тухай сурталчлан ойлгуулах шаардлагатай байна. Ажлын нөхцөлийн талаарх янз бүрийн хэлэлцүүлэгт ажил олгогчид, ажилчдын төлөөлөгчдийг оролцуулж байвал аль альд нь ашиг тустай байх. Албан бус секторт ажиллагчид өөрсдийн сонирхлыг илэрхийлэгч гишүүнчлэлийн байгуулагад нэгдэх нь тэдэнд эрх ашгийг нь хөндсөн бодлого, хөтөлбөрийн талаарх мэдээллийг авах боломжийг нь өргөтгөх юм. Иймд ажил олгогчдын нийгэмлэг, үйлдвэрчний эвлэл, холбоо, бусад бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжвэл зохилтой.

Ес дэх зөвлөмж

Албан бус салбарыг албан болгох нь

- Эдийн засгийн албан бус салбарын үйл ажиллагааг нэгдсэн бодлого, гурван талт хамтын ажиллагаагаар дамжуулан зохицуулах төрийн өнөөгийн бодлого, арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;
- Албан бус салбарт ажил эрхлэгчдэд үзүүлэх төрийн үйлчилгээ, эдийн засгийн дэмжлэгийг өргөжүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулсан хууль, эрх зүй, нийгмийн баталгааг нь хангах замаар албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан болгох үйл ажиллагааг үргэлжлүүлэн өргөжүүлэх;
- Албан бус секторт ажиллагчдыг төрийн үйлчилгээ, түүний дотор бодлого, хөтөлбөрийн талаарх болон ажил олгогч, ажиллагчдын байгууллагуудад гишүүнчлэлтэй болох, хөдөлмөрийн эрхийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх асуудлаарх ярилцлагуудад оруулж байх;
- Албан бус секторт ажиллагчдын дунд ажил эрхлэх гэрээ хэлцэл байгуулах, хөдөлмөрлөх эрхийн талаар мэдлэг, мэдээлэлтэй болгох зорилгоор энэ чиглэлээр сурталчилгаа явуулах кампанит ажил зохион байгуулах, тэдний эрх ашгийг хөндөж буй асуудлаарх төсөл, хөтөлбөрийн тухай хэлэлцэхдээ урьж оролцуулж байх;
- Эдийн засгийн албан бус үйл ажиллагаа эрхэлж буй иргэдийг зээл, тусламж, сургалт, бизнес инкубаторын үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх, түүний дотор Засгийн газрын болон хандивлагчдын хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт хамруулах;

- Уурхайчид, жолооч, жижиг оврын автобус, такси эзэмшигчид, гэрэл зурагчид, жижиг худалдаа наймаа эрхлэгчид зэрэг албан бус салбарт ажиллаж буй янз бүрийн бүлгийнхний эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, холбоод шинээр байгуулахыг хөхиүлэн дэмжих;
- Ажил олгогчдоос төлдөг нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг зохих түвшинд хүртэл бууруулах, гэхдээ нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхыг анхаарах;
- Оролцооны аргаар судалгаа хийх, хөдөлмөрийн хяналт шалгалтыг сайжруулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны кампанит ажилд олон нийтийг өргөн оролцуулах зэргээр албан бус сектор дахь ажлын байрны аюулгүй ажиллагааг хангах;
- Хот, хөдөө орон нутагт албан бус секторын бүтээмж, орлогыг нэмэгдүүлэх, түүний дотор техник мэргэжлийн, бизнесийн, бизнес инкубаторын сургалт явуулахад зориулж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг өргөнөөр ашиглах;

Дүгнэлт

Энэ бүлэгт Монгол улсын хөдөлмөр эрхлэлтийн төлөв хандлага; хөдөлмөр эрхлэлт, ядуурлын хоорондын уялдаа холбоо; сүүлийн 6 жилд шинээр бий болсон ажлын байрны байршил, хэв шинж, тоо; хөдөлмөрийн зах зээл, мал аж ахуй, уул уурхайн салбар, албан бус секторт тулгамдаж буй асуудлын талаар дүн шинжилгээ хийлээ. Монгол улсад өнөөгийн байдлаар ажилгүй ядуучуудаас илүү олон ажилтай ядуус байна гэсэн гол дүгнэлтийг хөдөлмөр эрхлэлтэд суурилсан ядуурлыг бууруулах стратегийн төвд тавих шаардлагатай гэж үзэж байна. Эдийн засгийн өсөлтийн хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмжийг нэмэгдүүлэхийн сацуу түүнтэй тэнцэхүйц хэмжээнд эхлэн хөдөлмөр эрхлэгчид, ажилгүй байгаа хүмүүс, бүрэн бус ажил эрхэлж байгаа хүмүүс, эдийн засгийн идэвхгүй байгаа хүмүүсийг чанартай, зохистой ажлын байраар хангах, улмаар хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд нэн тэргүүний ач холбогдол өгөх, сайн цалинтай, чанартай ажлаар ажиллагчдыг хангах явдал нэн чухал байна. Малчин түмний тухайд гэхэд тэдэнд мал аж ахуйн бус хөдөлмөр эрхлэх боломжийг, ялангуяа сумын төвүүдэд бий болгох нь зүйтэй гэсэн гол зөвлөмж гаргаж байна. Техник технологид түшиглэсэн, хүний хөдөлмөр зарцуулалт багатай уул уурхайн салбарыг өргөн хүрээтэй хөдөлмөр эрхлэлтийг бий болгох эх үүсвэр болгон ашиглахад чиглэсэн бодлогын өөрчлөлт хийхийг мөн зөвлөмж болгож байна. Олон арван монголчуудын хөдөлмөр эрхлэлтийн гол эх үүсвэр болдог албан бус эдийн засгийн хүрсэн түвшинг илүү ахиулж улмаар нийгмийн хамгаалал, сургалт, санхүүгийн үйлчилгээтэй нягт холбож дэвшил гаргахыг зөвлөж байна



4

БҮЛЭГ

Анхаарвал зохих ажиллах хүчний өвөрмөц бүлгүүд



Анхаарвал зохих ажиллах хүчний өвөрмөц бүлгүүд

Гуравдугаар бүлэгт хөдөлмөр эрхлэлт болон ядуурлын хоорондын уялдаа холбоо, хөдөлмөр эрхлэлтийн ерөнхий чиг хандлага, эдийн засгийн үндсэн салбар дахь хөдөлмөр эрхлэлтийн талаар тусгайлан авч үзсэн билээ. Энэхүү дөрөвдүгээр бүлэгт хөдөлмөр эрхлэлт, ядуурлын хоорондын уялдаа холбооны өөр нэгэн өвөрмөц асуудлыг судалж үзлээ. Ажлын байр шинээр бий болгох үйл явц түргэсч, хөдөлмөрийн бүтээмж болон хүн амын орлого ерөнхий дүнгээрээ өсч буй ч нийгмийн нэлээд хэсэг ядуурлаас ангид байх, хөдөлмөр эрхлэх боломж олгохуйц боловсрол эзэмшихэд нь саад бэрхшээл тулгарсаар байна. Эдгээр эрэгтэй, эмэгтэй хүмүүс бусдын адил ижил тэгш бололцоогоор хангагдах нөхцлийг бүрдүүлэхэд төр засгийн газраас тусгайлсан бодлогоор дэмжиж өгөх хэрэгтэй байна. Хүн амын дотор хурдацтай нэмэгдэж буй настайчуудын талаар энэхүү илтгэлд дурдаагүй боловч ирэх жилүүдэд энэ талаар тодорхой судалгаа явуулах болно.

Илтгэлийн энэ бүлэгт хүн амын бусад хэсэгтэй харьцуулахад ажилгүйдлийн түвшин маш өндөр, хөдөлмөрийн зах зээлд нэвтрэн ороход шаардагдах ур чадвар дутмаг залуучуудын талаар авч үзсэн. Монгол Улсад эмэгтэйчүүдийг хөдөлмөрийн зах зээл дээр эрэгтэйчүүдтэй ижил тэгш авч үздэггүй байна, жишээлбэл, эмэгтэй хүн өөрийн эзэмшсэн боловсрол, мэргэжилдээ дүйцэхүйц өндөр цалинтай ажил тэр бүр эрхэлж чадахгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй болон хөдөө орон нутгаас шилжин ирэгсдэд зохистой хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг хэрэгтэй байна. Эдгээр бүлгийн хөдөлмөр эрхлэх нөхцөлийг сайжруулах талаарх тодорхой санал зөвлөмжийг уг илтгэлд мөн тусгав. Түүнчлэн хүлээн зөвшөөрөхөөс аргагүй олон тооны хүүхдүүд ирээдүйд өөрсдөд нь хэрэгтэй боловсрол олж чадахгүй байдалд хүрч хэтэрхий эрт ажил эрхэлж байгаатай холбогдсон багц асуудлыг энэ бүлэгт хөндөнө. Улмаар бүлгийн төгсгөлд Монгол Улсад хүүхдийн хөдөлмөрийг

бууруулах, яваандаа бүрмөсөн арилгахад чиглэсэн бодлогын хувилбаруудыг санал болгосон болно.

4.1 *ᠴᠠᠡᠪᠣᠨᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ ᠳᠠᠨᠠᠨᠢᠨᠠᠨᠢ* *ᠶᠡᠳᠡᠭᠡᠭᠡᠳᠡ*

Залуучуудын дүр төрх

НҮБ болон ОУХБ залуучуудад 15-24 насныхныг хамруулж үүнийгээ ч дотор нь өсвөр насныхан (15-19 насныхан) насанд хүрсэн залуучууд (20-24 насныхан) гэж хуваадаг. Гэтэл Монгол Улсын албан ёсны тодорхойлолт, стандартаар залуучуудад 15-35 насныхныг хамруулан авч үздэг. Хөдөлмөр эрхлэх насыг 16 гэж тогтоосон учраас Үндэсний статистикийн газраас жил бүр гаргадаг хүн амын талаарх мэдээлэлд эдийн засгийн идэвхтэй хүн амын хэсгийг тооцохдоо хөдөлмөр эрхлэлтийг уг наснаас эхлүүлэн тооцдог байна. Гэхдээ хүн амын 2000 оны тооллого, 2002-2003 онд явуулсан ажиллах хүчний судалгаа болон 2002-2003 онд явуулсан өрхийн орлого зарлага, амьжиргааны түвшний судалгааны үеэр гаргасан статистик баримтад 15 болон түүнээс дээш насныхныг оруулан тооцжээ. Сургуулиас ажилд шилжигсдийн талаарх 2006 онд явуулсан судалгаанд 15-29 настай залуучуудыг хамруулан судалсан байна. Ийнхүү өөр өөр судалгаанд янз бүрийн бүлгийг залуучуудад хамруулсан байх тул шинжээчид насны хувьд ижил бус бүлгүүдээр ангилан хөдөлмөрийн зах зээл дэх залуучуудын дүр төрхийг гаргах шаардлагатай болж байна.

Монгол Улсын хүн ам залуу, жил бүр залуучууд олноор зах зээлд орж байгаатай холбогдуулан залуучуудын хөдөлмөр эрхлэлт тулгамдсан гол асуудал болж байна. 2006 онд нийт хүн амын бараг тал хувь (48.7 хувь) 25-аас доош насны залуучууд байлаа. Мөн жилд 16-24 настай залуучууд нийт ажиллах хүчний 22 хувийг эзэлж байжээ. Сургуулиас ажилд шилжигсдийн талаарх судалгааг 2006 оны 11, 12 дугаар саруудад залуучуудын дунд явуулсан билээ.


Хүснэгт 4.1 15–29 насны залуучуудын ажил эрхлэлтийн байдал, боловсролын түвшингээр, Монгол Улс, 2006

	Ажиллах хүчний оролцооны түвшин	Ажилгүйдлийн түвшин	Ажил эрхлэлтийн түвшин	Илэвхгүй байдлын түвшин
Боловсролгүй	57.9	8.1	53.3	42.1
Бага	50.2	7.7	46.3	49.8
Бүрэн бус дунд (8 анги төгссөн)	26.2	14.9	22.3	73.8
Бүрэн дунд (10 анги төгссөн)	28.4	21.9	22.2	71.6
Техник, мэргэжлийн	65.4	15.3	55.4	34.5
Тусгай мэргэжлийн дунд	67.8	8.1	62.3	32.2
Бакалаврын зэрэгтэй дээд	77.5	11.6	68.5	22.5
Магистр ба түүнээс дээш зэрэгтэй дээд	79.2	5.4	74.9	20.8
Бүгд	39.7	14.0	34.2	60.2

Үд ноддддддддд: Франческо Пастор. 2007. Сургуулиас ажилд шилжигсдийн судалгаа. ОУХБ-ын тайлан.

Насанд хүрэгчдийн ажилгүйдэлтэй харьцуулахад залуучуудын дунд ажилгүйдэл нэлээд өндөр байна. Хот суурин газрын залуучуудын ажилгүйдэл анхаарал татахуйц хэмжээнд хүрчээ. Ажилгүйдлийн ерөнхий жишгийн нэгэн адилаар хөдөөгийн залуучуудын дунд ажилгүйдэл нь хот суурингийнхныг бодвол харьцангуй бага байгаа ба хөдөөгийн ихэнх залуучууд долоо хоногт наад зах нь нэг цаг мал маллах, тариа ногоо тарих зэргээр хөдөлмөр эрхэлдэг байна.

Дүрслэл 4.1 Ажилгүйдлийн түвшин насны бүлэг, байршлаар, Монгол Улс, 2002-2003



Үд нодддддддд: ҮСГ, АХБ. Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан 2002-2003.

2002-2003 онд явуулсан ажиллах хүчний судалгаанаас үзэхэд, 39900 хүн

буюу 15-24 настай эдийн засгийн идэвхтэй залуучуудын 5 хүний нэг нь ажилгүй байлаа. Нийт 15-24 насны хүн амын 8.7 хувь нь ажилгүй залуучууд байсны 9.4 хувь нь эрэгтэй, 8.1 хувь нь эмэгтэйчүүд байв. Ажилгүйдэл нь хөдөөгөөс хотод илүү бэрхшээл үүсгэж байна. Судалгаа явуулж байх үед 14-19 насны буюу өсвөр насны хүүхдүүдийн 44.6 хувь, залуучуудын (20-24 насны) 33.6 хувь нь хот суурин газарт ажилгүй буюу ажил эрхлэх боломжтойд тооцогдсон байна. Залуучуудын 56.3 хувь нь ажил хийгээгүй буюу ажилгүй, эсвэл идэвхгүй байгаа боловч ажиллах хүчний тоонд орохгүй байгаа нь эдгээр залуучуудын ихэнх нь сургуульд сурч байсантай холбоотой байжээ.

Сургуулиас ажилд шилжигсдийн талаарх судалгаанаас үзвэл 15-29 насныхны дунд зөвхөн 39.7 хувь нь эдийн засгийн идэвхтэй, ажилгүйдлийн түвшин тэдний дунд 14 хувь байжээ. Ажилгүйчүүдийн дотор эрэгтэйчүүд (55.4 хувь) эмэгтэйчүүдийг (44.6 хувь) бодвол илүү байжээ. Ажил хөдөлмөр эрхэлж байгаа залуучуудын дотор 53.7 хувь нь эрэгтэйчүүд, 46.3 хувь нь эмэгтэйчүүд байв. Залуучуудын 40.6 хувь нь мал аж ахуй дээр ажиллаж байна. Харин хөдөөгийн залуучуудын 90.5 хувь нь мал аж ахуй дээр ажиллаж байжээ. Мөн залуучуудын 23.5 хувь нь төрийн байгууллага, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн салбарын ажил эрхэлж байсан бол 7.6 хувь нь худалдаа наймаа эрхэлж байв. Сургуулиас ажилд шилжигсдийн судалгаагаар хөдөлмөрийн “идэвхтэй”, “идэвхгүй” залуучуудын талаар зарим ялгааг ч тодруулжээ. Хөдөлмөр эрхлээгүй залуучуудын дийлэнх нь сургууль завсардсан бус сурч байгаа залуучууд байна.

Мөн судалгаагаар сургуулиас ажилд шилжих шилжилтийн төгсгөлийн шатанд яваа залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийн байдал болон эрхэлж байгаа ажлынх нь төрлөөр нь ангилсан байна. 15-29 насныхны бараг тал хувь нь (46,1 хувь нь) ямар нэг цалинтай ажил хийж байв. Мөн гуравны нэг нь (32.4 хувь) гэр бүлийнхээ аж ахуйд

цалингүй ажиллаж байжээ. Тавны нэг нь (19.4 хувь нь) өөрийн аж ахуйг эрхэлж байв. Үлдсэн хэсэг нь ажил эрхэлж байгаа гэсэн боловч хагас цагаар ажил хийж байсан буюу судалгааны үед ажил дээрээ байгаагүй байна.

Хот хөдөөгийн оршин суугчдын хооронд болон насны бүлгийн хооронд томоохон ялгаа байгаа нь анхаарал татаж байна. Ажил хийж байгаа өсвөр насныхны гуравны хоёр нь гэр бүлийнхээ аж ахуйд цалингүй ажиллаж байв. 4.2 дугаар хүснэгтэд үзүүлснээр 15-19 насныхантай (23.9 хувь) харьцуулахад 25-29 насныхан (51.5 хувь) цалинтай ажил хийх нь элбэг байна. Энэ хандлага оршин суугаа газраасаа хамааран ялгаатай байна. Тухайлбал, хот суурин газар оршин суугчдын 64.4 хувь нь цалинтай ажил эрхэлж байсан бол хөдөө орон нутгийнхны 68.7 хувь нь хувийн аж ахуй эрхэлж байв. Гэр бүлийнхээ аж ахуйд хөлсгүй ажиллаж байгаа залуучууд бараг бүгдээрээ (95.3 хувь) хөдөө оршин сууж байлаа.

Хүснэгт 4.2 Залуучуудын ажил эрхлэлт, насны бүлгээр, Монгол Улс, 2006

	Насны бүлэг			
	15-29	15-19	20-24	25-29
Цалин, хөлстэй ажил эрхэлдэг	46.1	23.9	45.3	51.5
Хувиараа бизнес эрхэлдэг	19.4	8.3	17.7	23.2
Гэрийн цалин, хөлстэй ажил хийдэг	32.4	66.1	35.1	23.0
Цагийн ажил хийдэг	1.2	0.9	1.5	1.0
Ажил эрхэлдэг гэхдээ ажилдаа ирээгүй	0.8	0.9	0.4	1.2

Үд нододдөг: УСГ. 2007. Сургуулиас ажилд шилжигсдийн судалгаа.

Ажиллах хүчний дотор хөвгүүд, залуучууд нь тоогоороо охид, эмэгтэйчүүдээс илүү байна. Тэдний дунд гэр бүлийнхээ мал маллах эсвэл өөр ажил хайхаар сургуулиас завсардах магадлал нь өндөр байна. Хөдөөд бага насны хөвгүүдийн сургуульд хамрагдах явдал эрс буурсан ба цаашдаа бүх түвшинд охидуудтай

харьцуулахад бага хэвээр байх хандлагатай байна. Малчдын дунд хийсэн судалгаанаас харахад олон малтай чинээлэг малчид ядуу өрхийнхөнд түшиглэж аж ахуйгаа авч явж иржээ. Зарим нь шилжилтийн насны хөвгүүдийг гэртээ байлгаж хооллож хувцаслаад хөлсгүй ажиллуулдаг байна. Хөвгүүд, залуучуудын иймэрхүү маягийн албан бус хөдөлмөрийн зах зээл нь хөлсгүй ажилладаг охид, залуу эмэгтэйчүүдэд нэмэлт дарамт үүсгэх магадлалтай юм.

Хот суурин газар, ялангуяа Улаанбаатар хотод боловсрол эзэмшихээр ирсэн олон залуус хөдөөдөө буцаж очих дургүй болдог байна. Мэдээллийн технологиор дамжин глобал эдийн засагтай холбогдсон нь мал маллагааны уламжлалт амьдралын хэв маягийг тэдний хувьд сонирхолгүй болгож байж болох юм. Даяаршил, хотжилт хүн амын уламжлалт амьдралын хэв маягт нөлөөлж Монгол Улс соёл иргэншлийн шилжилтийн үед оршин тогтнож байна.

Сургуулиас ажилд шилжигсдийн судалгааны хүрээнд 15-29 насныхны дунд тэдний амьдралын гол зорилготой холбоотой хэд хэдэн асуудлыг хөнджээ. Тэд ажил албан тушаалд хүрэхийг (17.0 хувь), “мэргэшихийг” (19.8 хувь), “аз жаргалтай байхыг” (18.9 хувь) хамгийн чухал гэж тус тус үзсэн байна. Сургуульд сурч байгаа хэсгийнхний 60.7 хувь нь үргэлжлүүлэн суралцах төлөвлөгөөтэй гэжээ. Тэдний дийлэнх нь сургуулийн хөтөлбөрт хичээл болон гадаад хэл сурахыг илүүд үзжээ.

Сургуульд суралцах хүсэлтэй залуучуудын багахан хувь нь техникийн мэргэжил (7.0 хувь), бизнес, худалдааны чиглэлээр (4.2 хувь) суралцах сонирхолтой байна. Хот суурин газрын албан секторт дээд боловсролтой залуучуудыг бүрэн хангачих ажлын байр хангалттай биш байна. Иймд сургууль төгсөгчдийг ажлаар хангах асуудал тун чухал болоод байна. 2005–2006 оны хичээлийн жилд 131100 залуучууд бүрэн дунд болон дээд сургууль төгссөний 72000 нь эмэгтэйчүүд байна. Тэдгээрийн дийлэнх (100400) нь ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль төгсөгчид юм. Мөн хугацаанд

23600 залуучууд их сургууль, коллеж, дээд боловсрол олгодог бусад сургуулийг төгссөн байна. Ердөө 7100 залуучууд техник мэргэжлийн сургууль төгсчээ.

Хөдөлмөрийн зах зээлд шинээр орж буй залуучуудад бэлэн орон тоон дээр шууд ажиллах, эсвэл өөрөө бизнес эхлүүлэх боловсрол, мэдлэг, ур чадвар дутмаг байдаг. Зарим нь гадаадад өндөр орлоготой ажил хийхийг сонирхдог боловч өөрсдийнх нь сурсан сургууль, дипломын мэргэжлийнх нь түвшинд тохирсон тийм ажил бараг олддоггүй. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамныхны нэрлэснээр “оюуны дайжилт” гэгдэх үзэгдэл ч мөн явагдаж байгаа ажээ.

Орчин үеийн бизнес, аж ахуйн байгууллагуудын хэрэгцээ шаардлагыг хангахуйц мэргэжил, ур чадвар эзэмшсэн хүмүүсийг өнөөгийн улсын болон хувийн сургуулиуд бэлтгэн хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэхэд бэрхшээлтэй байгаа гэдгийг Засгийн газар, хувийн хэвшлийнхэн, ажилчид өөрсдөө ойлгож байна. Залуучуудын хувьд энэ бол үнэхээр чухал асуудал юм. Гэтэл одоогийн сургалтын байгууллагуудын олгож буй мэдлэг, чадвар болон ажлын байранд шаардагдаж буй чадварын хоорондох ялгаа улам нэмэгдэх хандлагатай байна. Даяаршиллын үр нөлөө, технологийн хурдацтай өөрчлөлт, ажил явуулж буй өнөөгийн арга барил зэрэг нь энэхүү ялгаа нэмэгдэхэд нөлөөлж байна. Төрийн өмчийн боловсролын байгууллагуудад өнөөгийн ажлын байрны шаардлага хангасан сургалт явуулах нөөц бололцоо дутмаг байна. Урьд нь төрийн өмчид байсан аж ахуйн байгууллагууд хувьчлагдаж, тоног төхөөрөмж нь шинэчлэгдсэнээр ажилчдаас тусгай мэргэжил, мэдлэг шаардах болжээ.

Аг үеийн дорнод

Сургуулиас ажилд шилжигсдийн талаарх судалгааны тоо баримтад дүн шинжилгээ хийснээр хэд хэдэн бодлогын зөвлөмж гаргах боломжтой болж байна. Залуучууд боловсролоо дээшлүүлж дахин суралцах зардлыг бууруулах

чиглэлээр, ялангуяа хөдөө орон нутгийн ядуу өрхийнхөнд зориулж тусгайлан арга хэмжээ авах шаардлагатай байна. Зөвхөн төр засаг төдийгүй хувийн хэвшлийн болон иргэний нийгмийн байгууллагууд, түүний дотор нийгмийн салбарт хамтран ажиллагсад санаачлага гарган боловсролын тогтолцоог зах зээлийн эдийн засгийн шинэ эрэлт шаардлагад нийцүүлэн өөрчилж боловсронгуй болгох талаар идэвхтэй ажиллах шаардлагатай байна. Төрийн байгууллага, үйлдвэрчний эвлэл болон ажил олгогч эздийн байгууллагууд хамтран ажиллах нь ажилчдын ур чадвар, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэхгүй байгааг арилгахад чухал ач холбогдолтой.

Бидний хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд хот хөдөөгийн хооронд олон хэлбэр бүхий өвөрмөц ялгаа байгаа нь харагдлаа. Хөдөө орон нутгийнхан боловсролын түвшин доогуур байдгаас хөдөлмөрийн нөхцөл нь төдийлэн сайнгүй байдаг. Хөдөө дахь боловсролыг дээшлүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн тусгай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх нь чухал.

Бусад орны туршлагаас үзэхэд ажлын байран дээрээ сургалтанд оролцож буй залуучуудын цалин хөлснөөс сургалтын төлбөр гаргуулж авах маягаар суутгал хийн шийтгэх нь зохистой биш юм. Ажил олгогчид уг сургалтыг явуулахад мөнгө төлж буй учраас ажилчдын цалинг бууруулж уг сургалтын зардлыг гаргадаг. Ингэх нь томоохон сургалтын хөтөлбөрийг үр бүтээлтэй явуулахад саад болдог. Ийм нөхцөлд ажилчиддаа зориулан үр дүнтэй сургалт явуулж буй компаниудад төрөөс санхүүгийн тусламж эсвэл татаас өгч болох юм. Ажил олгогчид өөрсдөө ч хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн байгууллага, мөн боловсролын байгууллагуудтай хамтран сургалтын чанар, үр нөлөөг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах ёстой. Түүнчлэн компани аж ахуйн нэгжүүд өөрсдийнхөө сургагчийн үүрэг, сургалтын үр дүнгээр хөдөлмөрийн бүтээмж эрс дээшилж, ашиг орлого нэмэгдэхийг ойлгодог болох хэрэгтэй байна. Ийм ойлголтоор асуудалд

хандвал сургалтад хөрөнгө оруулснаа нөхөх гэж ажилчдын цалинг бууруулдаг явдал аяндаа зогсох болно.

Залуучууд албан бус шугамаар ажилтай болох явдал нэлээд тохиолддог. Харин ажил олгогчид ийм байдлаар ажилд авсан хүн шаардлага хангадаггүй гэж үздэг. Ингэж ажилд орсон хүмүүсийн цалин ч олигтой нэмэгддэггүй байна. Иймээс хөдөлмөрт зуучлах байгууллагын ажлыг сайжруулах, эрэлт хэрэгцээтэй байгаа ажил, түүнд тохирох ур чадварын талаар хүмүүст мэдээлэл өгч, санал солилцох явдлыг эрчимжүүлэх шаардлага байна.

Эдийн засгийн өсөлт, хөдөлмөрийн зах зээл дэх ерөнхий нөхцөл байдлаас залуучуудын хөдөлмөр эрхлэлт нэлээд хэмжээгээр шалтгаалдаг. Зохистой, үр бүтээлтэй хөдөлмөр эрхлэх бололцоог бүрдүүлэхийн тулд үүнд чиглэсэн макро эдийн засгийн болон салбарын бодлогыг тусгайлан боловсруулах хэрэгтэй. Түүнчлэн залуучуудын хөдөлмөр эрхлэх чадавхийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бодлогын арга хэмжээ ч бас хэрэгтэй. Сургуулиас ажилд шилжигсдийн талаарх судалгааны үр дүнгээс үзэхэд хөдөлмөр эрхлэлтийн талаарх тодорхой бодлогод тусгах шаардлагатай хэд хэдэн бүлэг асуудал байгаа нь харагдаж байна. Үүнд:

- Хот суурин газрын өсвөр насныхныг ажилд авахад хамгийн бэрхшээлтэй байдаг тул тэдэнд зориулан сургалтад хамруулах болон нийлүүлэлт талаас нь анхаарсан арга хэмжээ авах хэрэгтэй.
- Хот суурин газарт оршин сууж буй боловсрол нимгэнтэй хүн амын цөөн хэсэг нь хувийн аж ахуйг эрхэлж байна. Хэрэв аж ахуй эрхлэх талаар сургалт зохион байгуулах арга хэмжээ авбал хөдөлмөр эрхлэх хүний тоо нэмэгдэх боломжтой юм.
- Хөдөө орон нутагт ажилгүй байгаа залуучууд, ялангуяа эмэгтэйчүүдийн хувьд ажилгүй байх нь алс холын уршиг бүхий үр дагавартай байдаг.

Иймд хөдөлмөрийн зах зээлийн гадна удаан хугацаагаар байж ирсэн залуучуудад зориулсан боловсрол, сургалтын хөтөлбөр бий болгож тэднийг хамруулах, ажлын байр нэмэгдүүлэх, тэр дундаа төрийн санхүүжилттэй олон нийтийг хамарсан ажилд оролцуулах нь чухал байна.

- Тусгай мэргэжлийн дипломтой залуучуудад учирч буй бэрхшээлийг хэд хэдэн судалгаа ил гаргаж тавьсан байна. Тэдний хувьд ажил олоход хэцүү байдгаас гадна ажил олсон ч бүрэн дунд боловсролтой залуучуудтай харьцуулахад бага цалин авах талтай юм. Гэтэл ажил олгогчид техник мэргэжлийн ур чадвартай хүмүүс хэрэгтэй байна гэж ярьдаг. Иймд бүх шатны бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид нухацтай бодож шийдвэрлэх ёстой чухал асуудал бол энэ мөн. Үйлдвэрлэлийн шинэ, илүү үр бүтээлтэй тогтолцоог буй болгох нэг чухал бүрэлдэхүүн хэсэг бол техник мэргэжлийн сургалт юм. Нөгөөтэйгээр их, дээд сургуульд суралцахыг хүсэхгүй байгаа залуучуудад сонголтын нэг хувилбар буй болгож өгдөгөөрөө чухал ач холбогдолтой. Шийдвэр гаргагчид техник мэргэжлийн сургалтын чанарыг сайжруулах явдлыг бодлогын тэргүүлэх чиглэл болгон тодорхойлж, түүнийгээ орон нутгийн үйлдвэрлэлийн тогтолцооны эрэлт хэрэгцээтэй илүү сайн уялдуулахын тулд компани, үйлдвэрчний эвлэлийнхэнтэй нягт хамтран ажиллах хэрэгтэй байна. Сургуулийг хөдөлмөрийн зах зээлтэй болон боловсрол, ажлын байран дахь сургалттай уялдуулан хослуулах оновчтой механизм энд маш чухал. Ажил дээр болон ажлаас гадуур зохиогдох сургалтын хөтөлбөр, дадлагажих ажилтны хэлбэрээр сургах хөтөлбөр зэргийг буй болгож дэмжих чиглэлээр төр,

нутгийн захиргааны байгууллагууд, аж ахуйн нэгж, үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд өөр өөрийн хувь нэмрээ оруулахын зэрэгцээ хамтран ажиллах нь үр дүнтэй. Ер нь ажилд орохоор сонирхож буй залуучуудын ур чадварт ажил олгогчид туйлын сэтгэл ханамжгүй байгаа нь боловсролын чанар агуулгыг сайжруулах шаардлага байгааг харуулж байгаа юм.

Арав дахь зөвлөмж:

Залуучуудад зориулсан зохистой, бүтээмжтэй ажил эрхлэлтийг дэмжих талаар

- Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор сургуулиас ажилд шилжигсдийн талаарх судалгааны үр дүнд тогтоосон залуу хүмүүсийн тодорхой зорилтот бүлгүүдэд чиглэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх,
- Залуучууд хөдөө аж ахуй, аж үйлдвэр, үйлчилгээний зэрэг салбарт хөдөлмөр эрхлэхийг дэмжсэн бодлогыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих стратегийн нэг бүрэлдэхүүн хэсэг болгох,
- Хувиараа хөдөлмөр эрхэлж буй залуучууд, түүнчлэн боловсрол багатай залуу иргэдэд зориулсан хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх,
- Өндөр боловсрол эзэмшсэн боловч хөдөлмөрийн зах зээлд хөдөлмөр нь дутуу үнэлэгдэж буй залуу эмэгтэйчүүдэд тусгайлсан дэмжлэг туслалцаа үзүүлэх,
- Удаан хугацаагаар ажил эрхлээгүй залуу иргэд, түүний дотор хөдөөгийн залуучуудад зориулж олон нийтийг хамарсан ажлын байр бий болгох зэрэг арга замаар тэдгээрийн боловсролоо дээшлүүлэх, сургалт, ажил эрхлэлтэд хамрагдах боломж

боллоцгоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах,


- Ажлын байран дээр нь дадлагажуулах сургалтын зохистой арга хэлбэрийг эрэлхийлж буй ажил олгогч эздийн болон үйлдвэрчний эвлэлийн байгууллагын хүчин чармайлтыг дэмжихийн зэрэгцээ энэ чиглэлийн сургалт зохион байгуулдаг, сургууль завсардсан болон дөнгөж төгссөн залуучуудад эдийн засгийн урамшууллын хөшүүрэг хэрэглэн ажил эрхлэх боломж олгож буй ажил олгогчдыг хөхиүлэн дэмжих,
- Хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдлын тухай бодит мэдээлэлд үндэслэн хүсэл эрмэлзэл, мөрөөдлөө дахин нэг эргэн харж буй залуучуудыг дэмжих,
- Боловсруулах үйлдвэр, барилга, эрчим хүч зэрэг өсөлт өндөртэй салбарт залуучууд ажиллахыг дэмжих үүднээс тэднийг сургаж дадлагажуулах ажлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэх,
- Бизнесийн сургалт, бичил зээл, залуучуудын сүлжээ, үндэсний кампанит ажил, бизнесийн үйл ажилагааны талаарх мэдээлэл, мөн бизнес эрхлэх орчныг сайжруулах, албан бус секторт дэмжлэг үзүүлэх зэргээр залуучууд бизнес эрхлэх явдлыг хөхиүлэн дэмжих,
- Залуу малчдад өөрсдийн бизнестэй, өөрсдөө мөн сургалт явуулдаг, бизнес хөгжүүлэх үйлчилгээ үзүүлдэг болоход нь зориулж бизнесийн инкубаторыг туршилтын журмаар ажиллуулах,
- Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн асуудлаарх Засгийн газар, ажиллагчид, ажил олгогчид, төрийн бус байгууллагууд, хандивлагчдын хамтын ажиллагааг өргөжүүлж, төлөвлөлтийг сайжруулах зэрэг орно.

4.2 Өвөрмөц байдлыг хангах үйлдвэр

Энэхүү илтгэлийн хэсэг бүрт хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг жендэрийн талаас нь задлан шинжлэхийн тулд тоо баримт, үзүүлэлтүүдийг бололцооныхоо хэрээр эрэгтэй, эмэгтэйгээр ялгаж харуулав. Тухайн бүлгийн энэ хэсэгт монголын эмэгтэйчүүдийн өмнө тулгарч буй зарим бэрхшээлүүдийг авч үзнэ.

Монгол Улсын эдийн засгийн хөгжилд эмэгтэйчүүд чухал үүрэгтэйгээр оролцож байна. ҮСГ-аас хамгийн сүүлд гаргасан баримтаас үзвэл 2006 онд эдийн засгийн идэвхтэй хүн амын 51.4 хувь, хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн 51.3 хувь эмэгтэйчүүд байлаа. 4.2-р дүрслэлээс үзвэл ажиллах хүчинд эмэгтэйчүүдийн оролцоо эрэгтэйчүүдтэй үндсэндээ адил түвшинд байна.

Дүрслэл 4.2 Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйсээр, Монгол Улс, 2002–2003



Үг нэрлэлт: ҮСГ, АХБ. 2004. Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан 2002–2003, хүснэгт 36, х 46.

Гэвч эмэгтэйчүүд Монголын нийгэмд болон хөдөлмөрийн зах зээл дээр тодорхой саад бэрхшээлтэй тулгардаг бөгөөд илтгэлийн тус бүлэгт энэ талаар задлан шинжлэв. 2006 онд нийт өрхийн 11.4 хувь буюу 72219 өрхийг эмэгтэйчүүд толгойлж байв. 2004 онд явуулсан Оролцооны аргаар ядуурлын байдалд хийсэн судалгаагаар эмэгтэйчүүдийн дангаар толгойлсон өрхийнхөн нэлээд эмзэг байдалд хэвээр

байгаа ажээ. Ихэнх тохиолдолд нөхөр нь нас барсан буюу салсан шалтгаанаар эмэгтэйчүүд хүүхдүүдтэйгээ үлддэг байна. Малчдын хувьд хүүхдийн сургуульд болон эмнэлгийн үйлчилгээнд ойр байх зорилгоор эмэгтэйчүүд нь тусдаа амьдарч байна.

Ядуурал улам нэмэгдэж буй учраас илүү орлого сайтай ажил олох гэж хүмүүс идэвхтэй ажил хайх болов. Эдийн засгийн байдлаас шалтгаалан эмэгтэйчүүд өрхийнхөө гол тэжээгч эсвэл нэмэгдэл орлого оруулагчийн хувьд ажил хайх шаардлагатай болдог. Гэтэл социализмын үе шиг цэцэрлэг, ясли байхгүй учраас ажил, гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүргийг хослуулан биелүүлэхэд улам л хүндрэлтэй болж иржээ. Бүтцийн өөрчлөлт, цомхотголд өртсөн эмэгтэйчүүд энэхүү хүндрэлтэй байдлаас гарах өөр өөр арга замыг сонгож байна. Цөөн бус эмэгтэйчүүд албан бус салбарт хөдөлмөр эрхлэх болов. Мөн олон тооны эмэгтэйчүүд хөдөө орон нутгаас хот суурин газар руу шилжин суурьшжээ. Үүнээс улбаалан эмэгтэй, эрэгтэйчүүдийн хувьд ялгаатай байдал үүсч байна. Эрч хурдтай өргөжин тэлж, өндөр цалин олгож байгаа салбарт эрэгтэйчүүд голлох хандлагатай байна. Зарим салбарт эрэгтэй, эмэгтэйчүүдийн харьцангуй тэнцвэртэй байдал хадгалагдаж байгаа боловч уламжлалт үүрэг бүхий ажлыг эмэгтэйчүүд эрхэлсэн хэвээр байх магадлал өндөр байна.

4.3 дугаар хүснэгтэд хөдөлмөр эрхлэлтийг аж үйлдвэрийн салбараар ангилснаас харахад эрэгтэйчүүд эмэгтэйчүүд үндсэндээ ижил тэнцвэртэй байгаа мэт боловч энэ нь гол төлөв хөдөө аж ахуй, арилжааны салбарт эмэгтэйчүүдийн ихэнх нь ажиллаж байгаагаас шалтгаалсан дүр зураг юм. Гэхдээ эрэгтэй эмэгтэй хүмүүсийн аль нэг нь илүү давамгайлсан салбарууд бас байна. Ажиллах хүчний талаарх 2002–2003 онд явуулсан судалгаанаас харахад эмэгтэйчүүд нийгмийн ажил, боловсрол, эрүүл мэнд, зочид буудал, ресторан зэрэг газруудын ихэнх ажлын байрыг эзэлж

байсан бол эрчүүд гол төлөв уул уурхай, барилга, тээвэр болон төрийн захиргааны салбарт ажиллаж байв. ҮСГ-аас 2006 онд гаргасан мэдээнээс үзэхэд эмэгтэйчүүдийн хувь хэмжээ нь яльгүй өөр боловч салбарын хувьд үзүүлэлт ижил байв.

Хүснэгт 4.3 Хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийн хувь, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, Монгол Улс, 2002-2003, 2006

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Эмэгтэйчүүдийн эзлэх хувь	
	Ажиллах хүчний судалгаа 2002-2003	Хүн ам ба ажил эрхлэлт 2006
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	46.3	47.1
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	26.6	36.0
Боловсруулах аж үйлдвэр	54.6	54.5
Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	28.8	45.6
Барилга	26.0	44.3
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	56.1	59.8
Зочид буудал, зоогийн газар	66.4	66.8
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	26.0	37.4
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	52.5	59.7
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	41.0	50.1
Төрийн удирдлага, баглан хамгаалах, албан журмын даатгал	33.3	44.2
Боловсрол	68.0	67.2
Эрүүл мэнд, нийгмийн халамж	77.3	68.5
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	50.1	48.5
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй	46.0	52.0
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа	34.5	53.6
Дүн	48.0	51.3

Үд нөдөөгөө: ҮСГ, АХБ. 2004. Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан 2002-2003, хүснэгт 41, х 52; ҮСГ. 2007. Хүн амын ажил эрхлэлт 2006.

4.4 дүгээр хүснэгтэд үзүүлсэн хөдөлмөр эрхлэлтийг мэргэжлээр ангилсан байдлаас эрэгтэй эмэгтэйчүүдийн нилээд хэсэг нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа нь ажиглагдаж байна. Тэдний дийлэнх нь малчид байна. Гэхдээ төрийн албаны бага тушаалын ажилтнууд, үйлчилгээний салбар, хувийн аж ахуй эрхлэгчид болон техникийн ажилтан дотор эмэгтэйчүүд дийлэнх хувийг эзэлж

байсан. 2002-2003 оны судалгаанаас үзэхэд эмэгтэйчүүд машин тоног төхөөрөмжийн оператороор ажиллах нь багасчээ. Хууль тогтоогчид, менежерүүд болон төрийн албан хаагчдын зөвхөн гуравны нэг нь эмэгтэйчүүд байлаа. Гэхдээ 2006 оны тоо баримтаас үзэхэд эмэгтэйчүүд эдгээр ажлыг эрхлэх явдал өсч 38.6 хувьд хүрээд байна. Харин засвар үйлчилгээний салбарын хувьд ажилчдын гуравны хоёр нь эрэгтэйчүүд байв.

Хүснэгт 4.4 Ажиллагчдын ажил мэргэжлийн ангилал, хүйсээр, Монгол Улс, 2002-2003

Ажил мэргэжлийн ангилал	Ажиллагчдын хувь		Эмэгтэйчүүдийн эзлэх хувь
	Эрэгтэй	Эмэгтэй	
Хууль тогтоогч, удирдах ажилтан, менежер	5.0	2.6	32.4
Мэргэжилтэн	8.2	16.1	64.4
Инженер, техникийн ажилтан	3.5	6.0	61.2
Бичиг хэргийн туслах ажилтан	1.1	3.1	72.2
Үйлчилгээний ажилтан ба дэлгүүр зах зээл дээр худалдаа эрхлэгч	8.0	14.9	63.2
ХАА ба загасны аж ахуйн мэргэшсэн ажилтан	47.0	43.8	46.2
Үйлдвэрийн ба худалдааны ажилтан	9.9	5.7	34.7
Машин, тоног төхөөрөмжийн операторч, угсрагч	11.6	1.1	8.0
Энгийн ажил	5.3	6.6	53.4
Бусад	0.4	0.1	18.7
Дүн	100.0	100.0	48.0
Тоо	448,900	413,600	862,500

Үд нөдөөгөө: ҮСГ, АХБ. 2004. Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан 2002-2003, хүснэгт 42, х 53.

Ажиллах хүчний талаарх судалгааны дүнгээс (4.5-р хүснэгт) үзэхэд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүүгээр цалин хөлсгүй гэрийн ажил эрхэлж байсан бол хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн бараг гуравны хоёр нь эрэгтэйчүүд байжээ. Ажил олгогчтой холбоотой статистик мэдээлэл хэдий найдвартай бус, эргэлзээтэй боловч 2002-2003 онд 10 ажил олгогчийн 7 нь эрэгтэйчүүд байсан байна.

Хүснэгт 4.5 Ажиллагчдын ажил эрхлэлтийн байдал, хүйсээр, Монгол Улс, 2002-2003

Ажил эрхлэлтийн байдал	Хүйс		Эмэгтэйчүүдийн эзлэх хувь
	Эрэгтэй	Эмэгтэй	
Хөдөлмөрийн болон иргэний гэрээгээр ажиллагч	37.1	41.8	50.9
Ажил олгогч	0.7	0.4	34.5
Хоршооллын гишүүн	0.3	0.2	58.1
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	43.4	25.7	35.3
Өрхийн бизнест цалин, хөлсгүй оролцогч	18.4	31.7	61.4
Бусад	0.1	0.2	64.8
Дүн	100.0	100.0	48.0
Ажил эрхэлсэн хүний тоо	448900	413600	862500

Үд н᠔᠔᠗᠗ᠭᠡ: УСГ, АХБ. 2004. Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан 2002-2003, хүснэгт 10, х 116.

Ажил эрхлэх явдал ийнхүү аж үйлдвэрийн салбар болон мэргэжлээр ялгаатай байгааг харгалзан үзвэл Монгол Улсад цалингийн зөрүү бий болсон нь төдийлөн гайхах зүйл биш юм. Арай илүү цалинтай салбарт эмэгтэйчүүдийн төлөөлөл бага байна. Боловсролын түвшин өндөр байдаг ч аль ч салбарт эмэгтэй хүн менежерийн албан тушаалд цөөн томилогддог. 2006 онд боловсролын салбарт ажиллагчдын 68 хувь нь эмэгтэйчүүд байв. Бага сургуулийн багш нарын 94 хувь, дунд сургуулийн багш нарын 71 хувь, ахлах ангийн багш нарын 68 хувь нь эмэгтэйчүүд байна. Тусгай мэргэжлийн сургуулийн багш нарын 60 хувь, их, дээд сургуулийн багш нарын 52 хувь нь эмэгтэйчүүд байна. Гэтэл сургуулийн захирлуудын дийлэнх нь эрэгтэйчүүд ажээ.

Үндэсний статистикийн газраас явуулсан сургуулиас ажилд шилжигсдийн талаарх судалгааг тулгуурлан Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас цалингийн ялгаанд жендэрийн үүднээс статистикийн дүн шинжилгээ хийжээ. Дунджаар авч үзвэл эмэгтэйчүүдийн цалин эрэгтэйчүүдийнхээс тийм ч доогуур биш байжээ. Гэхдээ эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдтэй харьцуулахад хөдөлмөрийн илүү өндөр бүтээмжтэй байх шинжүүдийг

агуулж байгаа нь цалингийн энэ үзүүлэлт эмэгтэйчүүдийг ялгаварлах далд хэлбэрийг агуулж байж болох юм. Энэхүү судалгааны дүн шинжилгээгээр хэрэв эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн цалинг жендэрийн ялгаа байхгүй буюу ижил ажилд ижил цалин авна гэж үзвэл эмэгтэйчүүд хэрэг дээрээ 11.7 хувиар өндөр цалин авахаар байна гэж дүгнэжээ. Үүнээс гадна эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бусад ялгаатай шинжийг нөлөөлөхгүй гэж үзвэл эмэгтэйчүүдийн цалин эрэгтэйчүүдийнхээс дунджаар 22 хувиар өндөр байхаар байжээ.

УСГ-аас 2000-2002 онд явуулсан ажил эрхлэлтийн судалгаанаас үзэхэд судалгаанд оролцогчдын 48 хувь нь эмэгтэйчүүд байсан боловч тэдний зөвхөн 35 хувь нь удирдах албан тушаалд ажиллаж байжээ. Түүнээс гадна адил түвшний удирдах албан тушаалд ажиллаж байгаа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн цалингийн хэмжээг харьцуулахад эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс бараг 2 дахин илүү цалин авч байгаа нь судалгаагаар ажиглагдсан байна.

НҮБ-ын Эмэгтэйчүүдийн хөгжлийн сангаас 2002⁶³ онд явуулсан судалгаагаар жендэрийн талаарх хэвшмэл ойлголт, цалингийн ялгаа байгаа хэдий ч хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн ялгавартай байдал ажиглагдахгүй байгааг тогтоосон байна. Гэхдээ залуучуудын дунд явуулсан өөр нэг судалгаагаар арван хүн тутмын нэг нь тэднийг ажилд сонгон шалгаруулах явцад ямар нэг хэмжээгээ жендэрийн улмаас ялгаварлан гадуурхах байдалд өртөж байсан гэжээ. Үүнээс гадна нас болон гадаад дүр төрхөөр нь ялгаварлан гадуурхах явдал байдаг аж⁶⁴.

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулинд иргэдийг нас, хүйсээр ялгаварлан гадуурхахыг хориглосон тодорхой заалт бий. Харин энэ зарчмаас гажсан нэг зүйл бол эмэгтэйчүүдийн тэтгэвэрт гарах насыг 55, эрэгтэйчүүдийнхийг 60 хэмээн ялгаатай тогтоосон явдал юм. 1990 онд тэтгэврийн хуулинд орсон нэмэлт өөрчлөлтөөр 4 болон

⁶³ I-A-iii Y iyādöyè+ᠵ᠗᠑᠑ᠡᠢ ᠔᠗᠗᠑᠑ᠡᠢ ᠨ ai. I iiāi eui y iyādöyè+ᠵᠵ᠗: Öðᠡᠡᠡᠡᠡᠡᠡᠡ ᠵ᠗᠑᠑ᠡᠢ ᠵᠡᠡ yā᠗᠗᠗ ᠸ ᠔᠔᠗᠗᠗᠔ iu, Iuᠮ Èᠶ᠔᠙, 2002

⁶⁴ А.О.А., А.А. 2005. Аᠡᠶ᠋ᠠᠨ ᠶ᠔᠑᠑ᠡᠢ aᠨ᠔᠔᠗᠗ᠡ i iiāi è Öᠡᠨ᠗᠗ ᠔.22.

түүнээс олон хүүхэдтэй эмэгтэйчүүдийг “нийгмийн халамж” үзүүлэх зорилгоор эрт тэтгэвэрт гарч болно гэж заасан. Энэхүү заалтыг хэдийгээр тухайн ажиллагчтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр хэрэгжүүлэх ёстой боловч эмэгтэйчүүдийн өөрсдийнх нь саналыг үл харгалзан шууд “тэтгэвэрт гаргах” нөхцөл буй болсон байна. Нэгэнт тогтоосон тэтгэвэр нь амьдралд хүрэлцдэггүй учраас тэтгэвэрт гарсан эмэгтэйчүүд ихэвчлэн хаа нэгтээ өөр ажил хайхад хүрдэг байна.

Албан бус салбарт ажиллаж байгаа эмэгтэйчүүд хүнд нөхцөл байдалтай байнга тулгарч байна. Монгол Улсад эмэгтэйчүүдийн боловсролын түвшин эрчүүдтэй харьцуулахад нэлээд дээгүүр бөгөөд албан бус салбарт ажиллаж буй эмэгтэйчүүдийн нэлээд хэсэг нь эзэмшсэн боловсролоосоо доогуур түвшинд ажиллаж байна. Албан бус үйл ажиллагааг хэрхэн тодорхойлсон судалгаа ямар хүрээг хамарсан, мэдээллийн эх үүсвэр нь ямар байсан зэргээс шалтгаалж албан бус салбар дахь эмэгтэйчүүдийн тоог янз бүрээр тогтоож байна. Тухайлбал, үүнийг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн 1999 онд хийсэн судалгаагаар 69 хувь, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн 2004 онд гаргасан тайлангаар 54 хувь, 2002-2003 онд явуулсан ажиллах хүчний талаарх судалгааны тайланд⁶⁵ 45 хувь хэмээн дурджээ.

Эмэгтэйчүүд эдийн засгийн албан бус салбарт гол үүрэгтэй байдаг хэдий ч гэр бүлийн өмнө өвөрмөц үүрэг хүлээдэг, мөн зээл авахад хүндрэлтэй байдаг гэх мэтийн бэрхшээлтэй тулгарч ирсэн. Үүнээс үүдэн ажил эрхлэх, орлого олох талаар эмэгтэйчүүдийн хийх сонголт нэлээд хязгаарлагдмал болдог талтай. Төрийн өмч, түүний дотор мал, орон сууцыг хувьчлах үед өрхийн тэргүүний нэр дээр буюу гол төлөв эрэгтэйчүүдийн нэр дээр хувьчлал зохион байгуулагдсанаар шилжилтийн үед эмэгтэйчүүдийн өмчлөх эрх зарим талаар хязгаарлагдмал байсан гэж үзэж байна. Ингэснээрээ өрхийн

тэргүүн эрэгтэйчүүдээс зөвшөөрөл аваагүй бол эмэгтэйчүүдэд зээл авах барьцаа хөрөнгө байхгүй болж улмаар аж ахуйн үйл ажиллагаа эхлүүлэх, өргөжүүлэхэд саад тотгор учирч байгаа бөгөөд албан ёсны салбараас илүү эдийн засгийн албан бус салбарт эмэгтэйчүүдийг илүүтэйгээр ажиллахад хүргэсэн байж болох талтай⁶⁶. Нэгэнт бизнес эрхлэх сонголт нь бэл бэнчингээр хязгаарлагдаж байгаа нөхцөлд эмэгтэйчүүд голдуу худалдаа наймаа хийх, эсвэл ахуйн үйлчилгээ үзүүлэх зэрэг үйлчлэгээний салбарт илүүтэй ажиллаж байна.

Сургуулиас ажилд шилжигсдийн талаарх судалгааны үеэр залуу эмэгтэйчүүд хэдийгээр боловсролын түвшин өндөр ч хөдөлмөрийн зах зээл дээр тодорхой бэрхшээлтэй тулгардаг тухай дурджээ. Тэд эрчүүдтэй адилхан ажил хайдаг боловч нэгэнт ажилгүй болсон бол харьцангуй удаан ажилгүй байдаг, дахиад ажил олоход гол төлөв бага цалинтай ажил олддог байна. Энэ нь эмэгтэйчүүдийн хүсэл мөрөөдөлд нийцэхгүй нь ойлгомжтой. Үүнээс үүдсэн аливаа асуудлыг зохистой шийдэхгүй бол гэр бүл, улмаар нийгмийн тогтвортой байдалд нөлөөлж болзошгүй юм.

4.6 дүгээр хүснэгтээс үзэхэд өнөөдөр социализмын үеийнхээс илүү олон хүүхдийг цэцэрлэгт хамруулах болсон нь амжилт юм. Харин яслид хамрагдаж байгаа бага насны хүүхдийн тоо цөөн хэвээр байгаа нь олон эхчүүдэд хөдөлмөрийн зах зээлд орж ажиллахад нь шууд саад болж байна.

Хүснэгт 4.6 Ясли, цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоо, Монгол улс, 1990, 1995, 2000, 2006-2007

Хүүхдийн тоо	1990	1995	2000	2006-2007
Яслийн	21600	4000	1900	4400
Цэцэрлэгийн	97200	64100	79300	94700

Үс нэмэлт: УСГ, Монгол Улсын Статистикийн эмхтгэл 1999, 2003, 2006.

⁶⁶ Г.А. Г.А-ий О'аөөөөи о өнөөөөөи д,дүү, I i iai ea: 2002-2006 о'нөөөи дүүөө,д,дүү, Оөääiäää ää, 2001, ä.14; Үөөçääää I äää, I i iai e Оөñ äädu ääüai ä öñ ñäöiä, I ОДА, Ääiää, ä.73

⁶⁵ А.О.А.А. 2005. Ääiä ýäöëi äñöääe'ì üäi e öñää ä.26.

стратеги баримталж болох юм. Ингэхдээ, а).эрэгтэй эмэгтэйчүүдийн нэн тэргүүний зорилго, эрэлт хэрэгцээг харгалзан үзэж бүх бодлого хөтөлбөр, төсөл, төсөвт хүйсийн асуудлыг тусгаж өгөх, б). аль нэг хүйсийнхэнд илүү эрх олгосон тусгайлсан арга хэмжээ авах, дандаа биш ч гэсэн ер нь эмэгтэйчүүд жендэрийн улмаас нийгэмд, улс төрд болон эдийн засгийн хувьд дорой байдалд орох хандлагатай байдаг. Дээрх арга хэмжээний хүрээнд эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд болон удирдах албан тушаалд томилох талаар дэмжиж ажиллах хэрэгтэй.

Шигтгээ 10

Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкнаас Ажил эрхлэлтэд жендэрийн талаас хийсэн үнэлгээ

Хөдөлмөрийн зах зээл дээр тэнцвэргүй байдал байгаагаас үүдэн боловсролд хийсэн хөрөнгө оруулалт үр дүнгүй болох, эмэгтэйчүүдийн эдийн засгийн өсөлтөд оруулах хувь нэмрийг үгүйсгэж байна. Жендэрийн ялгааг арилгахын тулд дараах арга хэмжээг авч болох юм. Үүнд: 1) Хөдөлмөр эрхлэх, цаашид өсөн тэлэх бололцоотой салбарт эмэгтэйчүүдийг ажиллуулахад чиглэсэн сургалт явуулах зэргээр тодорхой мэргэжилтэй холбоотой жендэрийн талаарх тогтсон төсөөллийг өөрчлөх, 2). ялгаварлан гадуурхахыг хориглосон хууль тогтоомж хэрэгжүүлэх, 3).эмэгтэйчүүдийг ажлын байран дээр дарамтлахтай холбоотой асуудлыг шийдэх талаар мэдлэг олгох нөлөөллийн ажил явуулах, 4). Засгийн газрын эдийн засгийн бодлого хөтөлбөрт жендэрийн талаас нь дүн шинжилгээ хийж хяналт тавих ур чадвар бий болгох.

Ýò ñóðààëäè: Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк: Монгол Улс дахь жендэрийн асуудлаар хийсэн дүгнэлт, Манила, 2005 он.

Эмэгтэйчүүд мэргэжлийн ажлаа алдахгүй, албан бус эдийн засгийг албан ёсны болгоход эрх тэнцүү оролцох, мөн жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх талаар тусгай арга хэмжээ авах хэрэгтэй байна. Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкнаас хийсэн үнэлгээнд дурдахдаа бичил аж ахуйг жижиг дунд үйлдвэр болгон хөгжүүлэхэд эмэгтэйчүүд бизнес эрхлэгчийн хувьд үр шимийг нь хүртэж чадахгүй байх магадлалтай гэжээ. Монгол Улс болон бусад орнуудад хийсэн судалгаанаас харахад аж ахуйн нэгжийн овор хэмжээ болон түүнд ажиллах эмэгтэйчүүдийн тоо хоёрын хооронд урвуу харьцаа байдаг байна. Иймд цаашид бүтээгдэхүүн үйлдвэрлэх түүхий эд олж авах, сургалт явуулах болон бизнесийг хөгжүүлэх үйлчилгээний хувьд эрэгтэй, эмэгтэй хүмүүс ижил тэгш боломжтой байх явдлыг хангах нь зүйтэй байна. Дээрх жендэрийн судалгаагаар мөн эмэгтэйчүүдийн болон эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль алиныг нь хамарсан бизнесийн холбоод үр нөлөөтэй байдаг гэжээ.

Дээр дурдсан хөдөлмөрийн зах зээл дээрх залуу эмэгтэйчүүдийн хувьд тэдний харьцангуй муу нөхцөл байдлыг сайжруулах хэд хэдэн арга хэмжээ авч болно. Эдгээр арга хэмжээ нь ажиллах хүчний бүрэлдэхүүнд буй бусад эмэгтэйчүүдэд ч хамаатай. Нэгдүгээрт, ижил тэгш цалин төлж байх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх. Хоёрдугаарт, эдгээр арга хэмжээг үр дүнтэй байлгахын тулд хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх явдлыг хүчтэй болгож ажил олгогчид ялгаварлан гадуурхаж байгаа тохиолдолд энэ талаар мэдээлэх, гомдол гаргахдаа эмэгтэйчүүд эрх зүйн туслалцаа хялбархан авах явдлыг хангах хэрэгтэй. Орон нутгийн захиргааны байгууллагууд энэ туслалцааг үзүүлэх боломжтой. Мөн эмэгтэйчүүдийн өмнө тулгардаг саад бэрхшээлүүдийг даван туулж илүү сайн ажилтай, ирээдүйтэй, хүүхэд төрүүлсэн бол хүүхэд асрах талаар илүү сайн заалт бий болгох Урт хугацаагаар ажилгүй байгаа эмэгтэйчүүдэд дэмжлэг үзүүлэхийн тулд ясли, цэцэрлэгийг байгуулах зэргээр дэмжсэн арга хэмжээ авах хэрэгтэй байна.

Залуу эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүд ажил амьдралаа зохицуулахын тулд түр цагаар ажиллах бололцоо олгох талаар судлах нь зүйтэй.

Санхүү, уул уурхай болон төрийн захиргааны хурдтай өсөж буй, сайн цалинтай ажилд эмэгтэйчүүд орох явдлыг хангасан арга хэмжээ авах ёстой (4.7-р хүснэгтийг харна уу). Гэхдээ ойрын нэг хэсэг хугацаанд хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийн нэлээд хэсэг нь мал аж ахуй дээр ажилласан хэвээр байх бололтой. Хөдөө орон нутгийн эдийн засгийн хөгжилд эрэгтэй, эмэгтэй хүмүүс ижилтэй шоролцоо, охид хөвгүүдийг мал аж ахуйгаас гадна мал аж ахуйн бус салбарт хөдөлмөр эрхлэхэд нь зориулж дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна. Хот, хөдөөд төрийн санхүүжилттэй дэд бүтцийн ажил хийх, мөн нийгмийн халамжийн чиглэлээр эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудыг оролцуулах, тэдний дэмжлэгийг авах чиглэлээр ажил хийж болно. Эцэст нь гэр бүл дотроо үүрэг хариуцлагаа тэнцүү хуваах, ясли, цэцэрлэг байгуулах болон бусад арга хэмжээ авснаар эмэгтэйчүүдийг эдийн засгийн үйл ажиллагаа болон гэр бүлийн ажил хийх давхардмал үүргээс чөлөөлөх хэрэгтэй байна.

Хүснэгт 4.7 Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин, салбараар, Монгол Улс, 2006

Салбарын ангилал	Мянган төгрөг 2006	Дундаж өөрчлөлтийн хувь 2003-2006
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	65.8	1.7
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	146.1	7.0
Боловсруулах аж үйлдвэр	124.1	4.2
Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	139.5	3.0
Барилга	132.8	5.1
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	85.7	0.8
Зочид буудал, зоогийн газар	123.6	6.0
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	129.7	-1.2
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	255.5	22.9
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	91.6	2.3
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	141.3	10.2
Боловсрол	123.6	6.0
Эрүүл мэнд, нийгмийн халамж	116.5	12.3
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	91.3	8.1

Ойр зураг: Жилийн дундаж өсөлтийн хэмжээг тооцохдоо төгрөгийн тогтмол ханшгүйгээр тооцсон болно (2006=100).
 Үг лодог: УСГ. Монгол Улсын статистикийн эмхтгэл 2006, хүснэгт 4.7, 115-р хуудасны мэдээллээс тооцсон зохиогчийн тооцоо

Арваннэг дэх зөвлөмж:

Хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн тэгш бус байдлыг халах талаар:

- Аливаа тоон мэдээллийг хүйсээр ангилан, ялгаж гаргадаг болох, төлөвлөлт, хяналт үнэлгээ хийхдээ тэгш бус, ялгаатай байдлыг тусгасан жендэрийн дүн шинжилгээг багтаан авч үзэж байх,
- Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийн асуудалд нөлөөлөхүйц бодлого, хөтөлбөр боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхэд жендэрийн асуудлыг тусгаж байх,
- Ижил тэгш эрхтэй, боломж бололцоотой, ижил түвшний ажил эрхлэхэд адил хэмжээний цалин урамшуулал авах, шийдвэр гаргах түвшний болон удирдах албан тушаалын ажилд эмэгтэйчүүдийг дэвшүүлэн ажиллуулах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх
- Хүүхдийн хөдөлмөр, сургууль завсардалт, архи дан согтууралт, түүнчлэн Монголын эрэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн боломж бололцоо, тэдний орлогын түвшин буурахад нөлөөлж буй бусад саад тотгорыг арилгахад чиглэгдсэн энэхүү илтгэл болон бусад баримт бичигт тусгагдсан санал зөвлөмжийг даруй амьдралд авч хэрэгжүүлэх,
- Эдийн засгийн өсөлттэй холбоотойгоор өргөжиж буй санхүү, уул уурхайн салбар болон төрийн албаны шинээр бий болж буй өндөр цалинтай ажлын байранд эмэгтэйчүүд илүүтэйгээр ажиллах боломж, бололцоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах,
- Хот, хөдөөд хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилго бүхий олон нийтийг хамарсан ажил болон иргэдэд нийгмийн үйлчилгээг хүргэх үйл ажиллагааг зохион

Дээрх конвенцид Монгол Улс нэгдэж соёрхон батлаагүй байгаа боловч энэ үзэл санаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хууль зэрэг төрийн бодлого баримт бичигт тусгалаа олжээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр мөн Сэргээн засалтын үндэсний төвийн менежментийг сайжруулах стратеги зэрэг нааштай туршлага Монгол Улсад байна.

Аг үеийн өдөөгдөөдөө

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн эрх зүйн үндсэн механизм бол Хөдөлмөрийн тухай хуульд заасан квотын систем юм. Энэ нь 50 болон түүнээс олон ажилчинтай аж ахуйн нэгжид үйлчлэх ажээ. Тусгай санд хуримтлуулж буй хураамжийг зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сургах, хөдөлмөр эрхлэхэд нь зориулж зарцуулах ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хуульд зааснаар техник мэргэжлийн сургалтад хамруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж буй аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих заалт оржээ. 2001 онд батлагдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд ажил хайж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэргэжлийн сургалт, хувийн аж ахуй хөгжүүлэх сургалт, бизнесийн инкубатор, төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх дэд бүтцийн болон нийтийг хамарсан ажилд хамруулах болон ажилгүйдлийн тэтгэлэгт хамруулах зэрэг арга хэмжээг тусгаж өгчээ. Гэвч хөгжлийн бэрхшээлтэй иргэд эдгээр хөтөлбөр сургалтад хамрагдаж байгаа эсэхийг хянах, үнэлэх цэгцтэй арга механизм өнөөдөр үгүйлэгдэж байна.

Хөдөө орон нутагт амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг шийдэхийн тулд Сэргээн засалтын үндэсний төвийг өөрчлөн шинэчлэх ажлын хүрээнд тус төвд орон нутгийг хөгжүүлэх албыг байгуулахаар төлөвлөж байна⁷¹. Энэхүү шинэ албаны нэг үүрэг бол орон нутагт түшиглэсэн сэргээн засалтын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж хөгжлийн

бэрхшээлтэй иргэдтэй ажиллах ур чадварыг орон нутгийн байгууллагуудад буй болгох явдал юм. Нөгөөтэйгүүр Сэргээн засалтын үндэсний төв нь барилгадаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тохирсон нөхцөлийг бий болгох засвар хийж техникийн хүчин чадлаа нэмэгдүүлснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалт явуулахад нь оролцогч байгууллагуудад үйлчилдэг болохоор төлөвлөжээ. Засгийн газар энэ чиглэлээр чадавхиа нэмэгдүүлэхийн тулд олон улсын дэмжлэг туслалцаа авахыг эрмэлзэж байна.

2006 онд батлагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлт, сургалтын талаар тодорхой зорилтууд тусгагдсан. Энэ хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хүндэтгэсэн, тэдний хөгжих боломжийг өргөтгөсөн, нийгмийн бүтээн байгуулалтад төр, иргэний нийгэм болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах тухай 2000 оны Бивакогийн тунхаглалын үзэл сананд нийцэж байгаа юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөр эрхлэх тэгш боломжоор хангах 2007-2008 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дараах арга хэмжээ тусгагджээ. Үүнд: (1) хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаарх хууль эрх зүйн орчинг бүрдүүлж хэрэгжүүлэх, (2) хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд адил тэгш боломж олгох, (3) хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний төлөөллийн байгууллагын ур чадвар, чадавхийг сайжруулах, (4) мэдээлэл сурталчилгааг нэмэгдүүлэх гэсэн зорилтууд тусгагдсан байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны дэргэдэх Хөдөлмөр, нийгмийн халамжийн газар нь хөдөлмөр эрхлэхтэй холбоотой хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх, хяналт тавих мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих тусгай санд хураамж төвлөрүүлэх үүрэгтэй юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг зохицуулах үндэсний хороо байгуулагдсан боловч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг сайжруулах чиглэлээр ажилладаг байгууллага,

⁷¹ *ᠶᠡᠭᠡᠢᠳᠡᠭᠡᠢ ᠳᠡ ᠠᠶᠢᠳᠠᠭᠡ ᠠᠭ, ᠳᠠᠳᠠᠭᠡᠳᠡᠭᠡᠢ ᠨᠡ ᠠᠭᠡᠳᠠᠶᠢ 2006 ᠶᠡᠮᠤ 8-ᠳᠡ ᠨᠡ ᠠᠳᠠᠶᠢ 4-ᠶᠡᠳᠡ 81-ᠳᠡ ᠳᠡ ᠳᠡᠳᠠᠭᠡ, ᠳᠡᠳᠠᠳᠠᠭᠡᠳᠡ 1.*

агентлагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах ажил хангалтгүй байна.

Ерөнхийдөө Монгол Улс өөрийн өмнөх туршлагадаа тулгуурлан шинэ бодлого боловсруулж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөр эрхлэх болон хөдөлмөрийн зах зээлд ажиллах чадвартай болгоход чиглэгдсэн хөтөлбөрт тэднийг хамруулах, мэдээлэл үйлчилгээгээ сайжруулах талаар онцгой анхаарах шаардлагатай байна. Цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоод, төрийн бус байгууллагуудыг хөгжүүлэхэд анхаарлаа төвлөрүүлж эдгээр хүмүүсийн зохистой ажил олж хийх чадварт нөлөөлөх, шийдвэр гаргахад тэднийг өөрсдийг нь оролцуулдаг болгох хэрэгтэй байна. Ажил олгогчдын байгууллага, үйлдвэрчний эвлэл, төрийн бус байгууллага болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хэрэгцээтэй хөтөлбөр, арга хэмжээнд тэднийг өргөн хамруулах зорилгоор өөрсдийн чадавхийг бэхжүүлэх, үйлчилгээгээ шинэ шатанд гаргах шаардлага байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэхийн тулд ажил олгогчид, ялангуяа квотод хамрагддаггүй ажил олгогчдод туслах, мэдээлэл хүргэх явдал чухал юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувиараа хөдөлмөр эрхлэх болон албан бус салбартажиллахыг дэмжсэн стратеги боловсруулах шаардлагатай байна. Аль ч салбарт амжилтад хүрэхийн тулд ур чадвар хэрэгтэй бөгөөд одоогийн мэдээллээс үзэхэд ур чадвар хөгжүүлэх сургалтад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцох боломжийг адил тэгш олгох талаар шийдвэрлэх арга хэмжээ авах шаардлагатай байна.

Арван хоёр дахь зөвлөмж

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн зах зээлд оролцох бололцоог өргөжүүлэх талаар

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон хөдөлмөрлөх чадавхийг нь нэмэгдүүлэх зорилго бүхий хөтөлбөрүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулж, энэ талаарх мэдээлэл, үйлчилгээг тэдэнд хүртээмжтэй болгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалж тэдэнд үйлчилдэг холбоод, төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих, үүгээр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэд зохистой хөдөлмөр эрхлэх асуудлаар шийдвэр гаргахад оролцох бололцоог бүрдүүлэх;
- Нэн ялангуяа хөдөө орон нутагт амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байдал илүү хүндрэлтэй нөхцөлд байдгийг харгалзаж тэдний хөдөлмөр эрхлэлтэд онцгой анхаарал хандуулах;
- Ажил олгогч эздийн болон үйлдвэрчний эвлэлийн байгууллага, холбоодтой хамтран ажиллах замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлдэг төр, нийгмийн үйлчилгээг боловсронгуй болгох, ялангуяа төрийн бодлого, хөтөлбөрт тэднийг хамруулах зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэд бусадтай адил тэгш эрхтэйгээр ур чадвар, чадавхиа дээшлүүлэх сургалтад хамрагдах боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн бүхий л талын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

4.5 *Àæèëàð ð¿÷ìèè* *øèèæèð ð°ü°èü°í*

Орлого нь хомсдохын хирээр монголчууд улс дотроо болон гадаад орнууд руу ажил хайн шилжих хөдөлгөөнд орж байгаа нь тэдний амьжиргаагаа дээшлүүлэх гол арга болж байна.

ажил олж хийх гэж нүүж ирсэн шилжигсдийн хүслийг мохоож байна. Улаанбаатар хотын гэр хороолол дахь шилжин ирэгсдийн судалгаанд хамрагдагсдын дөнгөж 32 хувь нь цалин, тэтгэвэр гэсэн тогтмол орлогоор амьдардаг байна. Эдгээр хүмүүсийн дийлэнх нь тэтгэврээрээ амьдардаг настайчууд юм. Судалгаанд хамрагдагсдын 53 хувь нь өөрсдийгөө ажилгүй гэж үзсэн бол 80 хувийнх нь гэр бүлд наад зах нь насанд хүрсэн нэг ажилгүй хүн байгаа гэжээ⁷⁴. Судалгааны тайланд эдгээр хүмүүс бүгдээрээ ажилгүй биш байсан тул тэднийг хөдөлмөр эрхэлдэггүй гэж үзэх нь учир дутагдалтай, гэвч бүтэн цагийн ажил, цалин зэрэг тогтмол орлого байхгүй учраас тэд өөрсдийгөө ажилгүй гэж үздэг байна. Өөрөөр хэлбэл, тэд ямар нэг байдлаар хөдөлмөр эрхэлж байгаа боловч тэр нь тоо, чанарын хувьд ажилтай гэж үзэх хэмжээний шаардлага хангадаггүй байна⁷⁵.

Сургуулиас ажилд шилжигсдийн талаарх 2006 оны судалгаагаар 15-29 насны шилжин суурьшигчдийн талаар нилээд дэлгэрэнгүй мэдээлэл олж харах боломж олгов. Нийт шилжин суурьшигчдын 17.1 хувь нь залуучууд байна. Улаанбаатар (21.2 хувь), аймгийн төв рүү шилжигчдийн хувь ойролцоо байна. Үүний зэрэгцээ сумын төв рүү шилжсэн хүмүүс 16 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд, үүнээс хөдөөд шилжигсэд нь 8 хувь болж байна. Ажил олох боломжтой, цалин хөлс ахиутай учраас хот суурин газар руу зорин нүүж байгаа хүмүүс тэдний гэр бүлийнхэнд шилжин суурьших нь ашигтай байж болох ч орон нутгаас боловсролтой залуучууд нь нүүж явснаас орон нутагт сөрөг нөлөөтэй байна. Шилжих хөдөлгөөнд оролцогсодыг боловсролын түвшингээр нь ангилахад, сургуульд сурч байгаагүй 12.6 хувь, бага боловсролтой 9.6 хувь, их, дээд сургуулийн дипломтой 26.7 хувь, магистрын зэрэгтэй хүмүүс 25 хувь тус тус байна. Эндээс хөдөөнөөс хот руу шилжин суурьшиж буй хүмүүсийн боловсролын түвшин харьцангуй өндөр, хөдөө орон нутгаас “оюуны дайжилт” үүсэх эрсдэл байгааг илэрхийлж байна.

⁷⁴ *ᠨᠠ, ᠣᠵᠢᠶᠡᠭ ᠶᠣᠳᠤ ᠳᠠᠭᠠᠭᠡ ᠳᠠ. ᠋᠋ᠠᠶᠢᠠᠶᠢᠠᠳᠤ ᠠᠳᠤ ᠳᠢᠨᠢ ᠠᠶᠢᠳᠤ ᠳᠢᠨᠢ ᠭᠡᠨᠢ ᠶᠠᠳᠠᠳᠠᠳᠤ ᠶᠢᠳᠤ ᠭᠡᠨᠢᠨᠢ ᠠᠳᠠᠳᠠᠳᠤ ᠳᠢ ᠠᠶᠢᠳᠤ ᠳᠢᠶᠡᠭ ᠢ ᠳᠢᠨᠢ ᠨᠣᠠᠳᠠᠳᠠᠳᠤ, 2005.*

⁷⁵ 59-60 *ᠳᠣᠪᠠᠨᠠᠳᠠᠳᠤ ᠠᠶᠡᠭᠡᠭᠡᠳᠡᠳᠡ ᠵᠢᠴᠢ ᠵᠢ.*

Шилжих хөдөлгөөнд оролцох болсон хамгийн нийтлэг шалтгааныг (64 хувь) гэр бүлтэйгээ хамт байх явдал гэж судалгаанд хамрагдагсад нэрлэжээ. Эмэгтэйчүүдийн дунд энэ хариулт (68.9 хувь) илүү түгээмэл байна. Ихэнх тохиолдолд өрхийн тэргүүн цалин орлого сайтай ажил эрхлэхээр нүүж улмаар гэр бүлийн гишүүд нь дагалддаг байна. Сургуулиас ажилд шилжигсдийн талаарх судалгаанд хамрагдсан залуучуудын хариултад дурдсан дараагийн нэг гол шалтгаан бол боловсрол эзэмших ямар нэг сургалтад хамрагдах явдал байсан бөгөөд энэ шалтгаан эрэгтэйчүүдийн хувьд 17.2 хувь, эмэгтэйчүүдийн хувьд 14 хувь байжээ. Үүний дараа ажлын байрны санал ирсэн гэх хариулт орж байгаа бөгөөд эрэгтэйчүүдийн 14 хувь, эмэгтэйчүүдийн 8.9 хувь нь ийм хариулт өгчээ. Үлдсэн хэсэг нь ямар ч урьдчилж тохиролцсон зүйлгүйгээр ажил олж хийхээр шилжсэн байна.

ᠠᠶᠢᠠᠶᠢᠠᠳᠤ ᠠᠶᠡᠭᠡᠭᠡᠳᠡ ᠳᠠᠶᠢᠠᠶᠢᠠᠳᠤ

Улаанбаатарт шилжин суурьшихаас гадна сүүлийн жилүүдэд Монголчууд гадаадад ажиллахаар их явдаг болов. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт түргэсч байгаа хэдий ч Монголчууд ажил эрхлэх зорилгоор гадаадад шилжин суурьшсан хэвээр байна. Монгол Улсад гадаад хүмүүсийг ажиллуулах, гадаадад монголчуудыг ажиллуулах асуудлын талаар хууль эрх зүйн зохицуулалт болгож Монгол Улсын Засгийн газар 2001 онд “Гадаадаас ажиллах хүч авах, гадаадад ажиллах хүч гаргах” тухай хууль баталж гаргасан бөгөөд энэхүү хуулинд зарим нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Ингэснээр Засгийн газар хоорондын хэлэлцээр болон байгууллага хоорондын гэрээгээр монголчуудыг бусад оронд ажил эрхлэхэд тус дөхөм болохуйц тогтолцоог бүрдүүлжээ. Энэхүү хууль тогтоомжийн зорилго нь гадаадад монголчуудын хөдөлмөр эрхлэх асуудлыг удирдан зохицуулах, гадаадад ажиллаж байгаа иргэдээ хамгаалахад оршиж байна.

Албан ёсны шугамаар буюу эрх бүхий бүртгэлтэй агентлагийн үйлчилгээний хүрээнд зарим монголчууд гадаадад хөдөлмөр эрхэлж байгаа боловч олон тооны хүн хувийн зуучлагчдаар дамжин гадаад орнууд руу ажил хийхээр явж байна. Эдгээр хувийн зуучлагчид нь орон нутгийн хэвлэл мэдээллээр үйлчилгээгээ сурталчилж буй томоохон компаниуд, мөн албан бус хэлбэрээр хууль бус үйл ажиллагаа явуулж буй байгууллага, хүмүүс байна.

Зарим тооцоогоор гадаадад ажиллаж буй монголчуудын тоог 100 мянга орчим байна гэжээ. Олон монголчууд БНСУ, АНУ, Япон, Тайвань болон Европын холбооны улсуудад ажиллаж амьдарч байна. Олон хүчин зүйлээс шалтгаалдаг цогц асуудал учир гадаад шилжих хөдөлгөөний талаарх бодитой олон жилийн динамик мэдээлэл одоогоор байхгүй байгаа бөгөөд ихэвчлэн гадаад шилжих хөдөлгөөнд оролцогчид жуулчны болон оюутны визээр аялалаа эхэлдэг байна. Гэхдээ НҮБ-ын Хүн амын сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Монголын Хүн ам, Хөгжил нийгэмлэгээс Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны удирдлага дор гурван оронд явуулсан судалгаанаас нилээд мэдээлэл авч болно. Энэ судалгаагаар 2004 онд монголчууд олноор ажилладаг гурван орныг хамруулан гадаадад ажиллаж амьдарч байгаа монголчуудыг шилжих хөдөлгөөнд орсон байдал, эрхэлж байгаа ажлынх нь шинж байдлаар нь судалсан байна.

Өөр өөр оронд, өөр өөр шинж байдалтай гажиллаж амьдарч байгаа хүмүүсийг хамруулсан уг судалгааны дүнгээр ерөнхийлөн улсын хэмжээнд дүгнэлт гаргахад төвөгтэй юм. Гэхдээ л уг судалгаагаар гадаад орнууд руу шилжих хүмүүсийн тоо өсөн нэмэгдэх шинжтэй байгааг дүгнэлт болгожээ. Монголчууд гадаад оронд очиж ажил хийх шийдвэр гаргахад олон хүчин зүйл нөлөөлдөг хэдий ч гол хүчин зүйл бол цалин орлогоо нэмэгдүүлэх явдал байна. Эх орондоо ажилгүйдэл, ядуурлыг амсаж буй монголчууд гадаадад гарч ажил хийж орлого, боловсрол, ур чадвараа нэмэгдүүлэхийг зорьж байна. Дээрх судалгаанаас үзэхэд гадаадад ажиллаж амьдарч байгаа хүмүүс сард дунджаар 1115

ам.доллар авч байгаа буюу эрэгтэйчүүд (1395 ам.доллар) эмэгтэйчүүдийг (827 ам.доллар) бодвол илүү цалин авч байна. 4.9 дүгээр хүснэгтээс харахад дээрх тоо нь судалгаанд хамрагдсан гурван улсад өөр өөр байна. Мөн тухайн судалгаа явагдаж байх үед хүмүүсийн авч байсан цалин болон зуучлагчдад төлж байсан төлбөрийн хэмжээ сонирхол татаж байгаа юм. БНСУ-д явахад дунджаар 4000 ам.доллар буюу түүнээс дээш, БНЧУ-д явахад 1000-1500 ам.доллар, харин АНУ-д 4000 ам.доллар төлж байсан гэж судалгаанд оролцогчид хариулсан байна.

Хүснэгт 4.9 БНСУ, БНЧУ болон АНУ-д ажиллаж амьдарч байгаа хүмүүсийн сарын дундаж орлого, 2004

Сарын дундаж орлого, ам.доллар-аар	Сонгогдсон улсууд					
	БНСУ		БНЧУ		АНУ	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
<250	0	0.0	46	24.9	0	0.0
250-500	12	3.2	120	64.9	0	0.0
500-750	111	29.3	9	4.9	4	4.5
750-1000	139	36.7	4	2.2	3	3.4
1000+	100	26.4	4	2.2	82	92.1
Хариулах-аас татгалзсан	17	4.5	2	1.1	0	0.0
Бүгд	379	100.0	185	100.0	89	100.0
Сарын дундаж орлого	1238.5		418.5		2037.6	

Үг нэрэмжлэг: НХХЯ, НҮБХАС, Монголын хүн ам, хөгжил нийгэмлэг, 2004. Монгол иргэдийн гадаадад хөдөлмөр эрхлэлтийн байдал судалгаа, хүснэгт 5.7, х. 42.

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн дийлэнх бүрэн дунд боловсролтой залуучууд байна. Тэдний олонх нь гэр бүл болон найзуудынхаа холбоо сүлбээнд найдсан, оршин суух албан ёсны зөвшөөрөлгүй байна. Цөөхөн хэд нь гадаадад гарч ажиллахын тулд зуучлагчдын туслалцаа авчээ. Мөн нөгөө нэг цөөн хэсэг нь төрийн бус байгууллага, шашныханд найдаж гадаадад гарсан байна. Очих газар болон зуучлагчаас шалтгаалан зуучлалын төлбөр өөр өөр байна. Зуучлагчид амласан үйлчилгээгээ тэр бүр үзүүлдэггүй, ажиллаж амьдрах орчныг тэр бүр бүрдүүлдэггүй байна. Гадаадад ажиллаж байгаа монголчууд үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, барилгын болон бусад олон

салбарт ажиллаж байна. Амьдрах нөхцөл байдал өөр өөр боловч ихэнх тохиолдолд ажиллах орчин нь аюулгүй байдалыг хангаагүй, амьдрах байр сууц нь наад захын шаардлага хангаагүй байдаг байна.

Хүснэгт 4.10 БНСУ, БНЧУ болон АНУ-д ажиллагчдын боловсролын түвшин, 2004

Боловсролын түвшин	БНСУ			БНЧУ			АНУ		
	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм
Бага, түүнээс доош	2.8	2.8	2.8	1.0	0.0	1.5	2.9	1.5	5.7
Бүрэн бус дунд	10.7	12.7	8.3	3.5	5.7	2.3	2.9	4.5	0.0
Бүрэн дунд	24.7	27.2	21.7	47.0	48.6	46.2	30.5	34.3	22.9
Техник, мэргэжлийн	12.5	11.8	13.3	22.0	20.0	23.1	5.9	7.5	2.9
Бүрэн бус болон бүрэн дээд	49.4	45.5	53.9	26.5	25.7	26.9	57.8	52.2	68.5
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Үг нэрлэлт: НХХЯ, НҮБХАС, Монголын хүн ам, хөгжил нийгэмлэг. 2004. Монгол иргэдийн гадаадад хөдөлмөр эрхлэлтийн байдал судалгаа.

Гадаадад ажиллаж байгаа монголчуудын нэлээд хэсэг нь тухайн улсдаа ажиллаж амьдрах зохих виз зөвшөөрөлгүй байна. Ийнхүү хууль бус байгаагаас тэд эрсдэлд өртөх магадлал өндөртэй, нийгмийн халамж хамгаалал, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй шахам амьдарч байна. Хүлээн авагч орнууд зарим төрлийн хамгаалалт үзүүлдэг боловч олон ажиллагчид өөрсдийн эрх, хангамжийн талаар мэддэггүй байна.

Гадаадад ажиллагчдын мөнгөн гуйвуулга нь Монголд суугаа тэдний гэр бүлийнхэн, орон нутгийнхан болон тус улсын эдийн засагт тодорхой хувь нэмэр оруулж байна. Гадаадад ажиллаж байгаа бараг бүх хүн ар гэртээ мөнгө илгээж байна. БНСУ-д ажиллагчдын 87 хувь, БНЧУ-д ажиллагчдын 76.5 хувь, АНУ-д ажиллагчдын 62.8 хувь нь тус тус ар гэртээ мөнгө илгээдэг ажээ. Гэвч тэдний илгээсэн мөнгөний ихэнхийг ашигтай хөрөнгө оруулалтаас илүү өдөр тутмын хэрэглээ, зээл буцааж төлөхөд зориулдаг ажээ. Гэхдээ зарим гадаадад ажиллагчид

боловсролд хөрөнгө оруулахаар мөнгө шилжүүлдэг байна. БНСУ-д ажиллагчдын 23.4 хувь, БНЧУ-д ажиллагчдын 5 хувь, АНУ-д ажиллагчдын 13.7 хувь ийм зориулалтаар мөнгө илгээжээ. Зарим гадаадад ажиллагчдад Монгол руугаа мөнгө шилжүүлэхэд хүндрэл гардаг байна. Албан шугамаар шилжүүлсэн мөнгөний хэмжээ нь 2006 онд 153.6 сая ам.доллар болсон тооцоо байна. Мөн Монгол улсад ажиллаж байгаа хүмүүс гадагш нь 76.6 сая ам.долларыг шилжүүлсэн тооцоо ч гарчээ.

Хүснэгт 4.11 Албан ёсны сувгаарх ажилчдын мөнгөн гуйвуулга (сая ам.доллар), Монгол улс, 2003-2006

	2003	2004	2005	2006
Ажилчдын гуйвуулга	74.3	146.3	133.8	77.1
Хүлээн авсан	128.6	195.4	174.2	153.6
Шилжүүлсэн	54.3	49.1	40.4	76.6

Үг нэрлэлт: ҮСГ. Монгол Улсын статистикийн эмхтгэл, 2006, хүснэгт 14.13, х.255

Дээрх судалгаанд гадаадад ажиллаж амьдрахын ач холбогдлыг орлого нэмэгдэх, олон улсын туршлага хуримтлуулах, боловсролоо дээшлүүлэх, шинэ ур чадвар олж авах явдал гэж дүгнэсэн байна. Судалгаанд хамрагдагсад гадаадад ажиллаж амьдрахын сул талуудын тухайд боловсрол олох, гэр бүлтэй болох талаар боломж алдсан, гэрээ санах, стресст орох зэргийг дурджээ. Шилжин суурьшигчид архи, тамхи, мансууруулах бодис ихээр хэрэглэх, бэлгийн замын халдварт өвчин авах зэргийг мөн сөрөг тал хэмээн дурдсан байна.

Тодорхой тоо хязгаар, шимтгэлтэйгээр Монгол Улсад гадаадын иргэдийг ажиллуулж болох талаар заасан 2001 оны Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадын иргэдийг ажиллуулах тухай хуулинд өөрчлөлт оруулах талаар судалж байна. Одоогийн байдлаар барилга, зам, уул уурхай зэрэг салбарт тухайн салбаруудад шаардлагатай ур чадвар, мэргэжил бүхий гадаадын ажилчдыг, түүний дотор Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Улсаас авч ажиллуулж байна. Монголд ажиллах эрх авсан буюу эрхээ сунгуулсан гадаад иргэдийн тоо 2005 оны байдлаар

14210 байжээ⁷⁶. Монгол дахь ажлын байрыг гадаадын хүмүүс эзэлж байгаа талаарх мэдээлэл нь техник мэргэжлийн сургууль, сургалтын хөтөлбөрийг шинэчлэхэд тэргүүлэх ач холбогдол өгөх шааардлагатайг харуулж өгч байна. Гадаадын иргэнийг ажиллуулж буй ажил олгогч бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр нугалсантай тэнцэх хэмжээний шимтгэлийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлөх ёстой. Ийнхүү шимтгэл тогтоосон явдал нь аль болох монгол ажилчдаа ажлын байртай болгох гол зорилго агуулсан. Олон улсын туршлагаас харахад, өөрийн орны ажиллах хүчин болон гадаадын ажиллагчдын зохистой харьцааг барих бодлого баримталдаг ажээ. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан мэдээллээс үзвэл, гадаадын зарим ажиллагч ажлын долоо хоног, өдөрт дунджаар 10 цаг ажилладаг байна⁷⁷. Хэрвээ гадаадын ажиллах хүчин зөвхөн хуулийн дагуу, албан шугамаар орж ирэхийг дэмжих, тэдэнд хөдөлмөрийн хууль үйлчлэх нөхцлийг бүрдүүлэх аваас монгол ажилчид ажлын цаг болон ажиллах орчин нөхцлийн хувьд гадуурхагдахгүй байх боломжтой болно.

Áí äëíäüí ðóáðëäáððóóü

Шилжин суурьшигчдын хувьд хөдөлмөр эрхлэлт хамгийн төвөгтэй асуудал юм. Монгол Улсын Их сургуулиас дотоод шилжих хөдөлгөөний талаар судалгаа хийж бэрхшээлийг хөнгөлөх хэд хэдэн зөвлөмж гаргажээ. Үүнд: Хөдөлмөрийн зах зээлийн үйл ажиллагааг сайжруулах, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, хувиараа хөдөлмөр эрхлэх явдлыг дэмжих, зөвлөгөө өгөх, мэдээлэл түгээх төв байгуулах, хувийн хэвшлийн боловсролын байгууллагуудыг дэмжих зэрэг арга хэмжээ орсон байна. Мөн албан бус эдийн засгийг албан ёсны болгоход чиглэсэн арга хэмжээ ч шилжин суурьшигчдад ашигтай байх болно.

⁷⁶ *Áÿedëéí Ááíë. Øëíý ý äëéí çàí äáð ðáðð äáááðð ä -ääááðüä äëé äí äáíð üü, Óáëëáí 1 401 18, Ó¿íëé ð"áæëëéí íýáæ, Ç¿¿í Áçë, Íí íð ü ääë äëí áçí, 2007 üü 6-ð ñ äð, ð.15.*

⁷⁷ *Æíí Ááðüä ðë. 2007 üü 8-ð ñáðüí 13. Óýò äááðááí äí,ð äáðü äááäëäáá, Ñëáíáë, "á è"íëé Á äðäëä*

Гэвч шилжин суурьшсан хүн амын хувьд нэг чухал асуудал бол бүртгэлийн тогтолцоо юм. Социализмын үед шилжин суурьших явдлыг зориудаар хязгаарлаж байсан ба хөдөө орон нутгийн иргэд хот суурин газарт нүүж ирэхийн тулд орон нутгийн захиргаанаас “зам явах хуудас” шилжсэн тухай тодорхойлолт авахыг шаарддаг байв. Ийм бичиг баримт байхгүй бол тэднийг хот суурин газрын албан ёсны оршин суугчид гэж үздэггүй байсан бөгөөд нийгмийн бүх үйлчилгээ, албан ёсоор хөдөлмөр эрхлэх явдал хаалттай байв. 1992 оны Үндсэн хуулиар үүнийг өөрчилж хүн хаа дуртай газраа ажиллаж, амьдрах эрхтэй болсон. Гэвч хуучин тогтолцооны үлдэгдэл одоо хүртэл хэвээр байна. Жишээлбэл, Улаанбаатар хотын гэр хороололд нүүж ирэгсдээс судалгаа авахад хөдөөгийн ядуу шилжин суурьшигч шилжих бичиг баримт байхгүй учраас ажил олж хийхэд нэмэлт хүндрэл учирдаг байна. Тэртээ тэргүй бэрхшээлтэй энэ асуудлыг улам хүндрүүлэхгүй байхын тулд шилжин суурьшигчдын хөдөлмөрийн зах зээл дээр ажил олж хийх чадварт тавьсан хиймэл саад бэрхшээлийг арилгах хэрэгтэй.

Цаашид гадаадад гарч ажиллах сонирхолтой ажилчдын тоо нэмэгдэж байгаа учир энэ асуудлыг удирдан зохицуулах, гадаадад ажиллаж амьдарч байгаа иргэдээ хамгаалахад чиглэсэн ажлыг үргэлжлүүлэх хэрэгтэй. Үүнд: ажилд зуучлах агентлагийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, хөдөлмөрийн гэрээ байгуулахад нь туслах, гадаад оронтой хоёр талын гэрээ байгуулах, явахаас нь өмнө сургалтад хамруулах, мөнгө шилжүүлэх сувгийг сайжруулах, статистикийн бүртгэл, мэдээллийг сайжруулах, хөдөлмөрийн атташе болон гадаадад суугаа элчин сайдын ямаараа дамжуулан тусламж үзүүлэх, дахин очих үйл явцыг энгийн болгох зэрэг чиглэлээр дэмжих хэрэгтэй байна. 2001 онд баталсан Гадаадад ажилчин гаргах, гадаадаас ажилчин ажиллуулах тухай хуульд (2007 онд үүнд нэмэлт өөрчлөлт оруулахаар судалж буй) Монголын ажилчид ямар нөхцөлд гадаадад ажил хийх болон Монголын ажил олгогчид гадаад иргэн ажиллуулах

нөхцөлийг нарийвчлан заажээ. Үүнд: тусгай зөвшөөрөл олгох, ажилд зуучлах агентлагийн төлбөр болон удирдлага, төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг уялдан зохицуулах, гадаад дахь ажил олгогч болон монгол ажилчдын хоорондох гэрээ, монголын ажил олгогч болон гадаад ажилчдын хооронд байгуулах гэрээ, гадаадын мэргэжилтнийг ажиллуулах зэрэг асуудлууд орсон. Цаашид мэдээллийг сайжруулах, судалгаа хийх, бодлого боловсруулагчид, төрийн албан хаагчид болон зуучлалын байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Арван гурав дахь зөвлөмж

Шилжих хөдөлгөөнд оролцогчдын хөдөлмөр эрхлэх бололцоог өргөжүүлэх, тэднийг хамгаалах талаар

- Дотооддоо шилжин суурьшигчдын иргэний бүртгэлтэй холбогдсон элдэв саад бэрхшээлийг арилгаж, тэдний ажил хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд хамрагдах бололцоог бүрдүүлэх;
- Хөдөөгөөс шилжин суурьшигчдын дийлэнх нь оршин суудаг Улаанбаатар хотын гэр хорооллын иргэдэд зориулсан ур чадварын сургалт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх замаар тэдгээрийг хот суурин газрын эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох боломжийг нэмэгдүүлэх;
- Хотод оршин суугчид, шилжин суурьшигч иргэдэд үзүүлж буй төр, нийгмийн үйлчилгээний хүртээмжийн ялгаатай байдлыг арилгах;
- Гадаадад ажил эрхлэгч иргэдийн асуудлыг зохицуулах механизм бүрдүүлж хэрэгжүүлэх, тэдэнд үзүүлдэг дэмжлэгээ нэмэгдүүлж, эрх ашгийг нь хамгаалах;
- Иргэдийнхээ гадаадад ажил хөдөлмөр эрхлэн байж олж авсан мэдлэг, ур чадвар, арга туршлагыг улс орныхоо хөгжилд ашиглах боломж бүрдүүлэх;

4.6 *ᠣᠵᠢᠵᠢᠳᠠᠭᠦᠢᠳᠦᠭᠦᠢᠳᠦ*

Хүүхдийн хөдөлмөрийн асуудал Монгол Улсын анхаарлын төвд байсан хэвээр байна..

Олон арван хүүхэд сургууль завсардаж, биеийн эрүүл мэнд болон оюуны хөгжилд нь сөрөг нөлөөтэй орчинд удаан хугацаагаар, бага цалинтай ажиллаж хүүхэд насаа хэвийн нөхцөлд өнгөрөөж чадахгүй байна.

Шигтгээ 11

Эдийн засгийн идэвх, хүүхдийн хөдөлмөр, аюултай ажил

НҮБ-ын Үндэсний тооцооны системд тодорхойлсноор **эдийн засгийн идэвхтэй хүүхдүүд** тухайн хугацаанд эдийн засагт бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгож байдаг. Тус үндэсний тооцооны системд эдийн засгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээ гэдэгт: (i) зах зээл, арилжаа солилцоо, өөрийн хэрэглээ гэх мэт зорилгоор үйлдвэрлэж юм уу боловсруулж байгаа анхан шатны бүтээгдэхүүн, (ii) зах зээлд зориулан бүтээж байгаа бүх төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, (iii) өрхийн аж ахуйн хүрээнд зах зээл болон өөрийн хэрэглээнд зориулан бий болгож бүтээж байгаа бүх төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ зэргийг хамруулдаг. Эдийн засгийн идэвхтэй хүн ам гэдэгт ажил эрхэлж байгаа болон ажилгүй байгаа хүмүүсийг хамруулна. “Ер нь эдийн засгийн идэвхтэй” гэсэн ойлголтод удаан хугацааны туршид буюу арван хоёр сарын турш дахь тухайн хүний эдийн засгийн идэвхийн байдлыг харгалзан хамруулна. “Одоогоор эдийн засгийн идэвхтэй” гэдэгт богино хугацааны турш дахь өөрөөр хэлбэл сүүлийн долоо хоногийн байдлаар тодорхойлно. Тайлангийн хугацаанд цагаар ажиллаж байгаа

хүмүүсийг одоогоор эдийн засгийн идэвхтэй ангилалд хамруулна.


Хүүхдийн хөдөлмөр гэсэн ойлголт нь хөнгөн ажлыг цагаар хийхийг зөвшөөрдөг 12 болон түүнээс дээш насны бүх хүүхдүүд, аюултайд тооцогдоогүй ажил хийдэг 15-с дээш насны бүх хүүхдийг хамруулдаггүй бөгөөд “эдийн засгийн идэвхтэй хүүхдүүд” гэсэн ойлголтыг бодоход нилээд нарийн. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын хүүхдийн хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарыг тогтоосон 1973 оны конвенцид (№ 138) “хүүхдийн хөдөлмөр”-ийн талаарх ойлголтыг тодорхой заасан байдаг бөгөөд үүгээр хүүхдийн ажил, хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарын талаарх олон улсын цогц, эрх зүйн хувьд хамгаалсан ойлголтыг бий болгож “эдийн засгийн идэвх”-ийн талаар ч тодорхойлж өгсөн.

Хүүхдийн аюултай ажил гэдэгт байгаа байдлаараа хүүхдийн аюулгүй байдлыг хангаагүй, хүүхдийн биеийн болон оюун санааны эрүүл мэнд, үзэл бодол, ёс зүйн хөгжилд хортойгоор нөлөөлөхүйц аливаа ажил, мэргэжлийг хамруулна. Мөн хэт ачаалал, ажлын хүнд нөхцөл, “аюулгүй ажилд тооцогддог хэдий ч” тухайн ажилд хэт урт хугацаагаар хүүхдийг ажиллуулах зэрэг хамаарна. Ийм төрлийн ажлын жагсаалтыг тухайн улс орнууд гурван талын хэлэлцээрийн түвшинд тодорхойлдог.

Үд ноддэйгэ: Олон улсын хөдөлмөрийн статистикчдийн 13-р бага хурлаар баталсан Эдийн засгийн идэвхтэй хүн ам, ажилгүйдэл, бүрэн бус ажил эрхлэлтийн талаарх тогтоол. 1982 оны 10-р сар ОУХБ. Хүүхдийн хөдөлмөрийн төгсгөл: Ерөнхий захирлын тайлан. Ажлын үндсэн зарчим, эрхийн талаарх ОУХБ-ын тунхаглалын хэрэгжилтийн талаар гарсан дэлхийн илтгэл. Женев. 2006.

Хүүхдийн хөдөлмөрийг хэрхэн тодорхойлох тухай асуудлыг дэлхий дахинаа одоо ч хэлэлцэж байна. 2008 онд болох хөдөлмөрийн статистикийн ажилтнуудын олон улсын 18 дугаар бага хурал энэ талаар хэлэлцэхээр төлөвлөжээ. Монголд хүүхдийн хөдөлмөрийг хөдөлмөр оролцооны түвшин, хүүхдийн ажлын түвшин гэсэн 2 үзүүлэлтээр хэмжиж байна. Эхний үзүүлэлтээр тухайн насны бүлгийн хүн амын доторх хөдөлмөр эрхэлдэг болон ажилгүй хүмүүсийг хэмждэг бол хоёр дахь үзүүлэлтээр тухайн насны бүлгийн дотор хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн эзлэх хувийн жинг хэмждэг. Ажиллах хүчний талаарх 2002-2003 оны судалгаанаас харахад 5-17 насны хүүхдүүдийн 10.8 хувь нь ажил хийж байна. 4.6 дүрслэлээс харахад ажил хийж буй хүүхдүүдийн дотор 15-17 настай хүүхдүүдийн эзлэх хувийн жин 5-9 болон 10-14 настай хүүхдүүдтэй харьцуулахад өндөр байна.

Дүрслэл 4.6 Ажиллах хүчинд хүүхдийн эзлэх хувь, Монгол Улс, 2002–2003



Үд ноддэйгэ: УСГ, АХБ. Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан 2002-2003.

Хүүхдийн хөдөлмөр оролцооны түвшин Монгол Улсад 10.1 хувь байна. Энэ бол тухайн насны бүлгийн нийт хүн ам, түүний дотор ажилгүй хүүхдүүдийг хамруулсан тооцоо юм. Аль ч насны бүлгийг аваад үзсэн хөвгүүдийн хөдөлмөр эрхлэх түвшин охиуддаас өндөр байна. Ажилласан цагийн хэмжээг үндэслэн хүүхдийн хөдөлмөрийн цаг, хүрээг хэмждэг бөгөөд эдийн засгийн идэвхтэй хүүхдүүдийн 59,1 хувь буюу 5-17 насны хүүхдүүдийн 5.7 хувийг хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд гэж тооцжээ. Гэхдээ гэр бүлийн түвшинд явуулсан энэ судалгаанд цагдан хоригдож буй болон гудамжны

гэгдэгч хүүхдийг хамруулаагүй учир хүүхдийн хамгийн хүнд хөдөлмөрийг оруулж тооцоогүй гэсэн үг.

Өрхийн орлого зарлага, амьжиргааны түвшний судалгаанд 1998, 2002 онд ажил хийж сургуулиас завсардсан хүүхдийн талаар нэмэлт мэдээлэл тусгагджээ. Эндээс үзэхэд 10-14 настай ажил хийдэг хүүхдийн хувийн жин 1998 онд 9.3 хувь байсан бол 2002 онд 2.8 хувь болж буурсан байна. Ажиллах хүчний талаарх судалгаагаар 2002-2003 онд 10-14 насны ажил хийж буй хүүхдийн тоог 7.3 хувь, түүний дотор хөдөө орон нутагт ажиллагчдын эзлэх хувийг 14.7 хувь гэж гаргасантай харьцуулбал энэ тоо бага байгаа юм. Өрхийн хамгийн ядуу 20 хувийн дотор дээрх тоо 5.3-аас 4.7 хувь хүртэл, хамгийн ядуу 40 хувийн тухайд энэ нь 10.9-өөс 4.6 хувь болж дурдсан хугацаанд буурсан байна.

Зарим ахиц байгаа боловч чинээлэг өрхтэй харьцуулахад ядуу өрхийн хүүхдүүд сургуулиас завсардах явдал илүү хэвээр байна. Мөн Оролцооны аргаар ядуурлын байдалд хийсэн судалгаагаар ядуу өрхийн охид, хөвгүүд гэр бүлдээ туслах зорилгоор сургуульдаа түр очихгүй байх тохиолдол их байдгийг тогтоожээ. Энэ нь цаашдаа амьдралд хэрэгтэй боловсрол, ур чадвар эзэмшихэд нь ч нөлөөлдөг байна. Аймаг, сумын зарим албан тушаалтнууд хүүхдийн хөдөлмөрийг ашиглахын хор уршиг, алдаа дутагдлын талаарх иргэдийнхээ мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр хүчин чармайлт гаргаж байгаа боловч зарим гэр бүл орлого олж амьжиргаагаа залгуулахын тулд хүүхэддээ найдах сэтгэлгээ хэвээр байна. Гэтэл алтны уурхайд ажиллах, хүнд ачаа зөөх зэрэг ажлууд нь хүүхдийн бие махбодын өсөлт, сэтгэцийн эрүүл мэндэд онцгой хохирол учруулдагийг эцэг эхчүүд ойлгодог ч болиулж чадахгүй байна.

Ажил хийж байгаа хүүхдүүдийн олонх буюу 55,2 хувь нь гэр бүлийн орлогодоо хувь нэмэр оруулахын тулд арга буюу ажил хийхэд хүрдэг байна. Ажил хийх өөр нэг шалтгаан нь ажлын дадлага туршлага олж авах явдал байсан гэх ба нийт ажиллаж

байгаа хүүхдийн 22 хувь нь л ингэж үзэж байна.

Мал маллахад туслах зорилгоор хөдөө орон нутагт олон хүүхэд сургууль завсардаж байна. Тусгайлан явуулсан судалгаанаас үзэхэд мал маллаж, гэр орны ажилд тусалж буй хүүхдүүдийн 30 хувь нь ойрын хамаатан садныхаа гэр бүлд ажилладаг. Үлдсэн 70 хувийн 42 хувь нь холын садангийндаа, харин 28 хувь нь хамаатан садан биш айлд ажиллаж байв. Бусад өрхөд ажиллаж байгаа хүүхдүүдийн гуравны хоёр нь хөвгүүд байв. Бусад өрхөд ажиллаж байгаа хүүхдүүд өглөө үдэшгүй мал хариулах, услах, ноос хяргах, хашаа хороо цэвэрлэх, сүү цагаан идээ бэлтгэх, алдсан мал хайх, ус барих, аргал түүх, хувцас, сав суулга угаах, хоол хийх, хүүхэд харах болон эзэд нь эзгүй байгаа айлыг харах зэрэг ажил хийдэг байна. Өдөрт дунджаар 9.4 цаг ажиллаж байна. Бусад өрхөд ажил хийж байгаа 7-15 насны хүүхдүүдийн 47 хувь нь сургуульд огт яваагүй ба дөрвөн хүүхэд тутмын зөвхөн нэгд нь ажлын хөлсийг бэлэн мөнгөөр олгожээ.

2004 оны 7-8-р сард Төв аймгийн Борнуур болон Заамар суманд алт олборлох ажил хийж буй хүүхдийн талаар Монгол Улсын Их сургуулийн Хүн амын сургалт судалгааны төвөөс судалгаа явуулсан байна. Үндсэн ордын үйл ажиллагаа бол нүх ухаад, хад буталж ачаа зөөхийг шаарддаг. Харин шороон ордтой газар ажиллаж буй хүүхдүүд нүх ухах, алт угаах, ачаа зөөх зэрэг ажил хийдэг байна. Зарим ажлыг газар доор хийх шаардлагатай байдаг. Бусад нь цаг агаарын хүнд нөхцөлд усан дотор зогсож ажилладаг. Судалгаагаар хүүхдүүдийн дундаж нас 15 болохыг тогтоожээ. Ихэнх нь эрэгтэй хүүхэд байв. Тэдгээрийн дөрөвний гурав нь сургуульд явж байсан байна. Харин гуравны нэг нь жилийн турш сургуульд явалгүй алтны уурхайд ажиллажээ. Хүүхдүүдийн тал нь зуныхаа амралтаар уурхай дээр ажилласан бол үлдсэн хэсэг нь хааяа нэг ажилладаг гэжээ. Судалгаанд хамрагдсан хүүхдийн гуравны нэг нь судалгааны өмнөх долоо

хоногт нэг ч өдөр амралгүй ажилласан байна. Мөн судалгаанаас үзэхэд 8 хүүхдийн нэг нь хонгил нурах, жалга руу унах зэргээр осолд орж байсан байна.

Сүүлийн жилүүдэд анхаарал татах болсон бас нэг асуудал бол уламжлалт наадмаас гадна олон янзын баяр ёслол, тодорхой бизнесийг сурталчлах зорилгоор морины уралдаан зохион байгуулж бага насны хүүхдээр уралдааны морь унуулж буй явдал юм. Гэмтэх, бэртэх, амь насаа алдах тохиолдол гарснаас үүдэн нүүдлийн соёл иргэншлийн энэхүү уламжлалт уралдаанд хүүхэд ямар хэмжээтэй оролцох вэ? гэдэг асуудлаар олон түмний дунд маргаан өрнөхөд хүрсэн байна. Морь уралдуулах нь сахилга бат сайжруулж, тэвчээрт сургаж, мал маллах ур чадварыг амьдралын турш буй болгодог сайн талтай. Гэвч үүнийг илүү бизнесийн шинжтэй болгож уяачдын болон морин спортын холбоо зэрэг байгууллагууд, хурдан морины баян эздийн зохион байгуулж буй бизнесийн үйл ажиллагаанд хүүхдийг ашиглах асуудал анхаарал татаж байгаа юм. Нэг судалгаагаар жилд 500 гаруй уралдаанд нийтдээ 30 мянган бага насны хүүхэд морь унаж уралдсан тооцоо гарчээ.

Өрхийнхөө хүрээнд мал маллах, өрхийн аж ахуйд туслах явдал нь өнөөдөр монголчуудын хувьд эрэлт хэрэгцээтэй байгаа “хөдөлмөрийн ёс зүй”-д хүүхдүүд суралцах боломж олгож байна. Хүүхдийн хөдөлмөрийн талаасаа анхаарал татах үндсэн асуудал бол эдгээр ажлыг хийхээр охид, хөвгүүд сургууль завсардахгүй байх явдал юм. Нөгөөтэйгүүр хүүхдийн хөдөлмөрийн хүнд хэлбэрээс болж тэдний биеийн болон сэтгэцийн эрүүл мэнд хохирохгүй байх ёстой. Одоогийн байдлаар бичил уурхай, морь уралдуулах, мал маллах болон албан бус эдийн засагт ажиллах зэрэг хүүхдийн хөдөлмөр олон нийтийн анхаарлын төвд байна. “Гудамжны” гэгдэх хүүхдүүд бол тусдаа асуудал юм. Бэлгийн мөлжлөгө болон хүн худалдах явдал хүүхдийн эрхийн ноцтой асуудал болж болзошгүй байна.

Сургуулиас ажилд шилжигсдийн судалгааны үеэр Монголд нэн чухал болоод байгаа өөр нэг асуудлыг дэвшүүлэн тавиад байна. Энэ бол сургуульд хамрагдахгүй байгаа хүүхэд залуучуудын тухай асуудал юм. Ер нь хүүхдийн хөдөлмөр, ядуурлын тухай асуудлыг түүний хэтийн үр дагавартай холбож авч үзвэл зохино. Хөдөө орон нутгийн ядуу өрхүүд богино хугацаанд ашиг олох эсвэл урт хугацаанд алдагдал хүлээх хоёроос сонголт хийх хэрэгтэй болж байна. Богино хугацаанд өрхийн аж ахуйг үр дүнтэй явуулахад бусад бага насны хүүхэд болон өндөр настай хүнийг асрахад хүүхдийн тусламж хэрэгтэй болдог. Харин урт хугацаанд сургууль завсардсан хүүхэд бүх насаараа бүтээмж багатай ажил хийж улмаар үе дамжсан ядууралд автахад хүрдэг байна. Хүүхэд нь сургууль завсардсан ядуу өрхөд нэмэлт орлого олоход дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авах шаардлагатай байна. Бага насны хүүхдэд зориулсан ясли, цэцэрлэг байгуулах, настайчуудад нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг өргөтгөснөөр охидууд суралцах боломж сайжирна. Нөгөөтэйгүүр хөдөө орон нутгийн сургуулийг бэхжүүлэн сургуулиас завсардсан хүүхэд дахин суралцах боломжийг нэмэгдүүлэх хэрэгтэй байна. Үүний тулд дахин суралцах нэг хүүхдэд ногдох сургуулийн болон дотуур байрны зардлыг төр тогтмол олгодог байх ёстой.

Сургуулиас ажилд шилжигсдийн судалгаанд сургуулиас завсардсан хүүхдийн боловсролын түвшинг тодорхойлоход ядуурал түүнтэй холбоотой бусад хэмжүүрүүд, тухайлбал өрхийн орлого, хүүхдийн тоо, хамаатан садны тоо, тухайн гэр бүлийн боловсролын байдал, орлого болон мэргэжил, гэр бүлтэй эсэх зэрэг үзүүлэлтүүдийг гол болгожээ. Боловсролын тогтолцоо нь орлого, оршин суугаа газар, хүйсийн байдлаас үл хамааран сурч боловсрох бололцоог бүх хүүхдэд ижил тэгш олгох ёстой. Үүний тулд шууд зардлаас гадна ядуу өрхийн шууд бус зардал, хүүхдээ сургаснаас гарах алдагдлыг тооцох шаардлагатай байна.

Монгол Улсын төр засгаас орон нутгийн иргэд болон тухайн гэр бүлд хүрэлцэхүйц цалин хөлс бүхий үр бүтээлтэй хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг шийдэхэд чиглэсэн арга хэмжээ авч байна. Засгийн газар хүүхдийн хөдөлмөрийг устгах талаар бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх тодорхой алхамууд хийж байна. Хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг үндэсний болон салбарын бодлогын нэг хэсэг болгон шийдэх талаар тодорхой ахиц гарч байна.

Засгийн газар “хүн бүрийг боловсролтой болгох” зорилтын хүрээнд боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах үндэсний хөтөлбөр боловсруулж, албан бус боловсролын тогтолцоог буй болгон түүнд сургуулиас завсардсан хүүхдүүдийг хамруулж байна. Эдийн засгийн шилжилтийн эхний жилүүдэд сургуулиас завсардах явдал өндөр байсан бол одоо их багассан байна. Харин бүх хүүхдэд чанартай, хүртээмжтэй боловсрол олгох, хот хөдөө болон охид хөвгүүдийн хоорондох ялгааг арилгах нь чухал сорилт хэвээр байна.

Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийг (2002-2010 онд) хэрэгжүүлж байгаа бөгөөд үүгээр хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжүүлэх ерөнхий зарчмыг тодорхойлж өгсөн ба хүүхдийн хөдөлмөрийн хамгийн хүнд хэлбэрийг 95 хувь бууруулах зорилт тавьжээ. Монгол Улсын Засгийн газар 2005 онд хүүхдийн мөнгөний хөтөлбөрийг эхлүүлсэн бөгөөд 18 нас хүртэлх бүх хүүхдэд сар бүр тодорхой хэмжээний мөнгө олгож байна. Энэхүү хөтөлбөрийг нийгмийн хамгааллын бодлогын нэг шинэ чиглэл болгон хэрэгжүүлж байгаа юм.

Саяхан батлагдсан бэлгийн мөлжлөгө болон хүүхэд худалдах явдалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хүн наймаалах асуудлаас урьдчилан сэргийлэх, хүүхдийг бэлгийн мөлжлөгт татан оруулах явдлыг устгах болон хохирогч хүүхдийг эмчлэх талаар уялдаа холбоотой олон

талт арга хэмжээ авахаар төлөвлөж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар богино хугацааны ур чадварын сургалтад хамрагдах зэрэг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний хүрээнд сургуульд завсардагсадад шинэ боломж олгож байна. Ур чадвар олгох сургалт курсын хугацааг уртасгах, хүн амын эмзэг хэсгийн суралцагчдад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас татаас өгөх чиглэлээр Засгийн газар ажиллаж байна. 2005-2008 онд хэрэгжүүлэх чанартай ажлын байр бий болгох үндэсний хөтөлбөрөөр ажлын байранд тавигдах үндсэн шаардлага, зарчмыг тодорхойлж, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж нийгмийн даатгал болон хөдөлмөр хамгааллын үйл ажиллагааг өргөтгөж нийгмийн түншлэлийг бий болгох зорилт тавьжээ.

Монгол Улсын ажил олгогчдын болон үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд хүүхдийн хөдөлмөрийн эсрэг арга хэмжээнд идэвхтэй оролцож ирсэн. Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо болон Монголын ажил олгогч эздийн холбоо хүүхдийн хөдөлмөрийн хамгийн хүнд хэлбэртэй тэмцэх стратеги боловсруулж мэдлэг олгох чадавхи бий болгох, бусад тодорхой арга хэмжээ авах чиглэлээр ажиллаж байна. 2005 оны 6 дугаар сард Монгол Улсын Засгийн газар, МҮЭ-үүдийн холбоо, Монголын ажил олгогч эздийн холбоо 2015 он гэхэд уул уурхайн салбарт хүүхдийн хөдөлмөрийг арилгах Хамтын ажиллагааны гурван талын уриалгад гарын үсэг зурсан бөгөөд мөн энэ зорилгод хүрэхэд чиглэсэн хөтөлбөр боловсруулжээ.

Дээрх санаачлагууд байгаа боловч мэдээлэл цуглуулах, төлөвлөх, хүүхдийн хөдөлмөрт хяналт тавих, чадавхи бий болгох зэрэг сорилт, бэрхшээл байсаар байна. Түүнээс гадна уялдаа холбоог сайжруулж, сонирхогчдын хүрээг өргөжүүлж, бодлого эрх зүйн орчинг төгөлдөржүүлж, хуулийн биелэлтийг хангаж, мэдлэг түгээх арга барилыг сайжруулж, Монгол Улсын өргөн уудам нутагт таран суурьшсан

иргэддээ хүрч ажиллаж, улмаар хүүхдийн хөдөлмөрийн хамгийн хүнд хэлбэрийг устгах, урьдчилан сэргийлэх талаар арга хэмжээг улс даяар авах хэрэгтэй байна.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас хүүхдийн хөдөлмөрийн талаар гаргасан илтгэлд дурдсанаас үзэхэд нийт хүүхдийн 10-20 хувь хөдөлмөрийн зах зээлд оролцож байгаа үед хүүхдийн хөдөлмөрийг устгах боломж гардаг. Энэ тохиолдолд заавал боловсрол эзэмшсэн байх шаардлагыг ч хялбархан хэрэгжүүлж болдог ажээ. Монгол Улсад хүүхдийн хөдөлмөрийн оролцоо 10.1 хувь байгаа учраас хэрэв зохистой хөдөлмөр эрхлэлтийн болон нийгмийн бодлого хэрэгжүүлж чадвал хүүхдийн хөдөлмөрийг устгах талаар амжилт гаргах бололцоотой байна.

Монгол Улс Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 138 тоот Хөдөлмөр эрхлэх доод насны тухай болон 182 тоот Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай конвенциудыг соёрхон баталсан байна. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн заалтууд нь олон улсын хөдөлмөрийн байгууллагын дээрх конвенцитай нийцэж байгаа бөгөөд ажлын төрөл, чанараас шалтгаалан насны өөр стандарт тогтоож ажиллах цагийг хязгаарлажээ. Гэхдээ хууль тогтоомж дангаараа хүүхдийн хөдөлмөрийн ээдрээтэй асуудлыг шийдвэрлэхэд хангалтгүй юм. Насанд хүрсэн хүмүүс болон залуучуудын хөдөлмөр эрхлэлт, ядуурал, тэгш бус байдлыг шийдэх талаар өргөн хүрээтэй нийгэм, эдийн засгийн арга хэмжээ авах явдал чухал юм. Монгол Улсын хууль тогтоомжийг эргэн харж “цоорхой байгаа бол нөхөх”, шинээр гарч буй асуудлыг зохицуулах, хууль хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх шаардлагатай байна.

Бүх нийтийг боловсролтой болгох болон Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд мэдэгдэхүйц ахиц гаргаснаар хүүхдийн хөдөлмөрийг устгах, урьдчилан сэргийлэх чухал нөхцөл бүрдэнэ. Боловсролын чанарыг сайжруулах, нүүж шилжихээс шалтгаалж нийлүүлэлт эрс хомсдсон газар боловсролыг хүртээмжтэй

болгох, сургуулиас завсардсан эмзэг бүлгийн хүүхдүүдэд хүрч ажиллах тодорхой стратеги хэрэгтэй байна. Бүх хүүхдэд анхан шатны боловсрол олгоход чиглэсэн, тодорхой хүн амд зориулагдсан арга хэмжээг үр бүтээлтэй нийгмийн халамжийн бодлогоор дэмжиж өгөх хэрэгтэй байна.

Мал аж ахуйгаас гадна хүүхдүүд гол төлөв албан бус эдийн засгийн салбарт бага буюу ямар ч ур чадвар шаарддаггүй ажлыг аюултай нөхцөлд нийгмийн хамгаалалтгүйгээр хийж байна. Хүүхдийн хөдөлмөр нь яваандаа залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн асуудал болон хувирч байна. Учир нь тэд насанд хүрсэн үедээ шаардлагатай боловсрол, ур чадварыг олж авч чадахгүй болж байгаа юм. Монголд ажил хийж байгаа хүүхдүүд ажлын дадлага туршлагатай болохыг хүсч байгаа нь ойлгомжтой. Боловсролын талаарх бодлогоо өөрчлөн шинэчлэхээр ажиллаж байгаа өнөө үед залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөдөлмөрийн зах зээлд ороход шаардлагатай мэдлэгээр хангах явдлыг бодлогынхоо өөрчлөлтөд тусгах хэрэгтэй байна. Ингэснээр ажил хийж буй хүүхдүүдийн тодорхой эрэлт хэрэгцээг ч боловсролын бодлогод тусгах шаардлагатай болно.

Хүүхдийн хөдөлмөрийн талаарх арга хэмжээг тухайн орон нутгийн онцлогт тохируулах нь чухал юм. Ялангуяа, иргэдийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, сургуулиас завсардсан хүүхдэд зориулан тухайн хүүхдийг хөдөлмөрийн зах зээлээс холдуулах, дахин сургах, нийгэмшүүлэх зэрэг арга хэмжээг тусгайлан авч хэрэгжүүлэх, мөн холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг чангатгах шаардлагатай юм. Энэ чиглэлээр зарим ахиц гарч байна. Гэвч хүүхдийн хөдөлмөрийг арилгахад нутгийн захиргааны байнгын тогтвортой үйл ажиллагаа, түүнийг нь дэмжсэн үндэсний бодлогын уялдаа их чухал.

Эцэст нь, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой аливаа салбарын нэгэн адил хүүхдийн хөдөлмөрийг арилгахад ажил

олгогчдын болон ажилчдын байгууллагуудтай хамтарч ажиллах нь үр дүнтэй байдаг билээ.

Дүгнэлт

Илтгэлийн энэ бүлэг хөдөлмөрийн зах зээлийн зарим нэгэн онцгой нөхцөл байдал, монголын залуучууд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, шилжин суурьшигчид, мөн хүүхдийн хөдөлмөртэй холбоотой хүндрэл бэрхшээлийн талаар авч үзлээ. Хэрвээ хүн амын томоохон бүлгийнхэн зохистой хөдөлмөр эрхэлж чадахгүйн улмаас өөрсдөд байгаа чадвар чадавхиа бүрэн дүүрэн ашиглахгүй байх аваас нийт эдийн засгийн бүтээмжид сөргөөр нөлөөлөх үр дагавартай тул эдгээр бүлгүүдийг нэг бүрчлэн болон хамтатган авч үзэхэд асуудлын нэгэн гол ач холбогдол оршсон болно. Нөгөөтэйгүүр, асуудлыг хүний хөгжлийн үүднээс авч үзвэл, эдгээр бүлгийн хүмүүс тогтвортой өсч буй эдийн засгийн үр шимээс хүртэх нөхцлийг бүрдүүлэх, тэдэнд бусадтай л адил сонголт хийх бүрэн эрх, боломж бололцоо олгох явдал Монгол Улсын хүний хөгжлийн хамгийн гол зорилт байх учиртай

Арван дөрөв дэх зөвлөмж

Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийг устгах талаар


- “Бүх нийтээрээ боловсрол эзэмшсэн байх” зорилгын хүрээнд боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулахад чиглэсэн үндэсний хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх;
- Хөдөө орон нутагт сургууль нэмж барьж, ажиллаж байгаа сургуулиудын орчин нөхцлийг нь сайжруулах, сурч боловсрохтой холбогдсон тухайлбал, элдэв төрлийн сургуульд төлдөг

мөнгөн бус төлбөрүүд, дотуур байрны болон тээврийн гэх зэрэг зардлыг багасгах замаар сургууль завсардаж буй хүүхдийн тоог цөөрүүлж, хүүхдийн хөдөлмөртэй холбогдсон эрсдлийг бууруулах;

- Уул уурхайн албан бус салбарын үйл ажиллагааг зохицуулсан хууль, эрх зүйн орчинг тодорхой болгож, уул уурхайд хүүхэд ажиллуулахыг эрс хориглох. 2005 оны 6 дугаар сард Засгийн газар, Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, Монголын ажил олгогч эздийн холбоо хамтран гаргасан 2015 он гэхэд уул уурхайн салбар дахь хүүхдийн хөдөлмөрийг устгасан байх тухай гурван талт хамтын уриалга, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх;
- 2007-2011 онд хэрэгжүүлэхээр баталсан “Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийн бүхий л хэлбэрийг устгах талаар сурталчилгаа явуулах тухай” хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг үндэсний болон салбарын бодлого, хөтөлбөрт тусгаж байх, мөн энэ талаар бүхий л түвшинд ойлголттой болгох арга хэмжээ авах;
- Холбогдох хууль, эрх зүйн актын хэрэгжилт, гарч буй хүндрэл, бэрхшээлүүд болон бодлого хэрэгжүүлэхэд шаардлагатай чадавхийг бэхжүүлэх ажлын явц зэргийг үнэлж дүгнэж байх;
- Дээр дурдсан бүхий л асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн орон нутгийн түвшний тогтвортой үйл ажиллагааг дэмжих, түүнийг үндэсний хэмжээний бодлогоор хангаж өгч байх;

БҮЛЭГ

Бодлогын гол гол ЗӨВЛӨМЖҮҮД, ДҮГНЭЛТ



Бодлогын гол гол зөвлөмжүүд, дүгнэлт

Хөдөлмөр эрхлэлтээр дамжуулан ядуурлыг хэрхэн бууруулж болох тухай асуудал энэхүү илтгэлийн гол сэдэв бөгөөд түүнийг тойрсон бодлогын хэд хэдэн зөвлөмжийг санал болгож байна. Илтгэлийн энэ бүлэгт эдгээр зөвлөмжүүдийг нэгтгэн хураангуйлж оруулсан болно. Үүнд:

Нэг дэх зөвлөмж:

Хөдөлмөр эрхлэлтийн тухай стратегийг Мянганы хөгжлийн зорилтуудад суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын нэг гол бүрэлдэхүүн хэсэг болгох талаар

2005 оны 9 дүгээр сард болсон Дэлхийн Дээд хэмжээний уулзалтын үеэр ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн хооронд маш нарийн, олон талын уялдаа холбоо байгааг хүлээн зөвшөөрсөн бөгөөд үүний дагуу дэлхийн улс гүрний тэргүүнүүд “Мянганы Тунхаглал”-ын зорилтууд дээр шинээр нэмж дөрвөн зорилт батлаад байна. Эдгээрийн дотор “Хүн бүрийг, түүний дотор эмэгтэйчүүд, залуучуудыг бүтээмж бүхий, зохистой бүрэн ажил эрхлэлтээр хангана” гэсэн зорилго багтжээ. Нэмж орсон энэхүү зорилт нь “Туйлын ядуурал, өлсгөлөнг арилгах” гэсэн мянганы хөгжлийн нэг дэх зорилгын нэгэн чухал зорилтот үзүүлэлт бөгөөд үндсэн санаа нь зохистой хөдөлмөр эрхлэлтийг ядуурлыг бууруулах хамгийн гол хүчин зүйл гэж үзсэнд оршиж байгаа болно. Монгол улс хэрэв өнөөдөр хүчин төгөлдөр хэрэгжүүлж буй бодлого, олон улсын шилдэг туршлагад үндэслэсэн зохистой ажил эрхлэлтийн стратегийг боловсруулж бодлогын тэргүүлэх чиглэл болгон хэрэгжүүлвээс, энэ нь эдийн засгийн өсөлтийг нийт эрэгтэй, эмэгтэй хүмүүст тэгшээр хүртээх, улмаар Монгол Улсын иргэд Үндсэн хуульд заасан хүн бүр зохистой ажлын байраар хангагдах эрхийг амьдралд бодитойгоор хэрэгжүүлэх боломж бүрдэнэ. Энэхүү стратеги нь Монгол Улсын МХЗ-д суурилсан Үндэсний хөгжлийн бодлогод тусгагдсанаар мянганы

хөгжлийн нэг дэх зорилго болох ядуурлыг бууруулж чадах үндэс бий болно. Энэ зорилгоор:

- Эмэгтэйчүүд, залуучуудыг оролцуулан иргэн бүрийг бүтээмж өндөр, зохистой бүрэн хөдөлмөр эрхлэлтээр хангах тухай Үндэсний хөгжлийн бодлого, стратегид тусган, улмаар ядуурлыг бууруулахад чиглэсэн арга хэрэгсэл болгох,
- Илүү олон, зохистой ажлын байр, ялангуяа ядуу хүмүүс амьдарч буй газар, нутагт бий болгох, мөн шинээр бий болсон ажлын байранд нийцэхүйц мэдлэг, чадварыг Монголын эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд адил тэгшээр олгоход чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн тухай Үндэсний стратеги боловсруулах,
- Макро эдийн засгийн болон салбарын бодлого, хөтөлбөрүүд ажлын байр илүү олноор бий болгоход чиглэсэн байхыг баталгаажуулах шаардлагатай.

Хоёр дахь зөвлөмж:

Хүний хөгжилд зориулсан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх талаар

Эрүүл мэнд, боловсрол, төрөл бүрийн сургалтууд, төрийн анхан шатны бусад үйлчилгээний болон бусад холбогдох салбарт, өөрөөр хэлбэл хүний хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг үргэлжлүүлэн нэмэгдүүлэх нь Монгол Улсын хөгжлийн стратегийн үндсэн тулгуур зарчим байх ёстой. Энэхүү илтгэлд хөдөлмөр эрхлэлтэд суурилсан стратегитай байхын ач холбогдол, түүнээс ч илүүтэйгээр хүний хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалт зайлшгүйг дурдсанчлан ядуу зүдүү амьдарч буй эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувьд ажлын байртай болох эсэх нь тэдгээрийн боловсрол, мэдлэг чадвар, эрүүл мэндийн байдлаас голчлон хамаарч байна.

Хүний хөгжилд зориулсан хөрөнгө оруулалт нь зөвхөн нийгмийн салбарт хөрөнгө оруулснаар хязгаарлагдах ёсгүй

бөгөөд уг хөрөнгө оруулалт ядуу хүмүүс, нийгмийн эмзэг хэсэг, нийгмийн болон аливаа бусад үйлчилгээнд хамрагдаж чадахгүй хэсэг бүлэг хүмүүс, түүнчлэн бүтээмж бүхий ажлын байртай болж чадахгүй байгаа хүмүүст тус нэмэр болохуйц зорилго агуулсан байх ёстой. Хүний хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалтын зарим нэгэн тэргүүлэх ач холбогдол бүхий жишээнээс дурдвал:

- Боловсрол, эрүүл мэнд, эрүүл ахуй, усан хангамж зэрэг төрийн наад захын суурь үйлчилгээний хот, хөдөөгийн ялгааг багасгах,
- Хотын төв, хотын захад оршин суугчдад үзүүлж буй төрийн үйлчилгээний ялгааг багасгах,
- Төрийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа ядуу иргэд, тэр дундаа, хөдөө, хотын захын гэр хороололд оршин суугч иргэдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, төрөл бүрийн сургалт болон ажил хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр үзүүлж буй төрийн үйлчилгээний хамрах хүрээг өргөтгөх,
- Эрүүл мэнд, боловсрол зэрэг төрийн суурь үйлчилгээний хураамж шимтгэлийг төлөхөд ядуу иргэдэд хөнгөлөлт үзүүлэх журам тогтоох, улмаар чөлөөлөх,
- Нийгмийн салбарт, түүний дотор техник мэргэжлийн боловсрол, сургалтын чиглэлээр оруулах төсвийн хөрөнгө оруулалтыг үргэлжлүүлэн нэмэгдүүлэх зэрэг болно.

Гурав дахь зөвлөмж:

Хөдөлмөрийн зах зээл дэх ур чадварын эрэлт, нийлүүлэлтийн хоорондын зөрүүг арилгах талаар

Бүтээмж өндөртэй, цалин хөлс сайтай ажлын байр шинээр бий болголоо ч гэсэн, хэрвээ ажил олгогчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн ур чадвартай эрэгтэй, эмэгтэй монголчуудын тоо нэмэгдэхгүй тохиолдолд тэрхүү арга хэмжээ монголчуудын амьдралын түвшинг

дээшлүүлэх хэмжээний хүссэн үр дүнд хүрч чадахгүй. Өнөөдөр Монголд бодит байдал ямар байна вэ гэвэл, ажил олгогч, ажил эрхлэгч аль аль нь энэхүү ур чадварын эрэлт нийлүүлэлтийн хооронд зөрүүтэй байгааг олж харж чадаж байгаа бөгөөд ажил эрхлэгчдийн эзэмшсэн боловсрол, техник мэргэжлийн сургалтаас олж авсан ур чадвар нь ажил олгогчийн тавьж буй шаардлагыг хангахгүй байгаа юм. Энэхүү хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд төр засаг, сургууль, боловсролын болон техник мэргэжлийн холбогдох бусад байгууллага, ажил олгогч, ажил эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалагч байгууллагын хамтын хүчин чармайлт маш чухал. Энэхүү хамтын хүчин чармайлтыг амьдралд хэрэгжүүлэхтэй холбогдох хэд хэдэн санал зөвлөмжийг дор сийрүүлээ. Үүнд:

- Мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, мэргэжлийн стандарт тогтоох, ажлын байранд нь сургалт зохион байгуулдаг тогтолцоог бүрдүүлэх, ажиллагчдын дадлагажих боломжийг өргөжүүлэх зэрэгт ажил олгогчдын идэвхтэй оролцоог хангах замаар боловсрол, сургалт, хөдөлмөрийн зах зээл дээрх ур чадварын эрэлт, хэрэгцээ хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх,
- Мэргэжлийн сургалтаар олгож буй мэдлэг, ур чадвар нь зах зээлд өрсөлдөгч хувийн хэвшлийнхний хэрэгцээ, шаардлагатай нийцэхгүй байгаа энэхүү хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхийн тулд боловсрол, сургалтын тогтолцоог шинэчлэхэд чиглэсэн олон талт түншлэлийг дэмжих, үүнд ажил олгогч, үйлдвэрчний эвлэлийн байгууллага, засгийн газар, боловсролын байгууллагуудыг татан оролцуулах,
- Техник мэргэжлийн сургууль, боловсролын талаарх олон нийтийн санаа бодлын төөрөгдлийг арилгахад чиглэсэн, мөн хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцсэн ур чадварыг практик үйл ажиллагаа, энгийн арга барил дээр суурилсан техник мэргэжлийн сургалтаар дамжуулан

олж авахын үнэ цэнийн талаар олон нийтэд сурталчлах кампанит ажил зохион байгуулах,

- Техник мэргэжлийн сургалт, ур чадварын стандарт, сертификат-жуулалтын асуудал эрхэлсэн Үндэсний зөвлөлийг байгуулж мэргэжлийн сургалтын хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, санхүүжилтын механизмыг бий болгох, арга зүйн төвүүд ажиллуулах, техник мэргэжлийн стандарт тогтоох, заах арга болон сертификат олгох дүрэм журмыг боловсруулах, багш нарын сургалт, сургуулийн менежмент, сургалтанд ашиглах техник тоног төхөөрөмж зэрэг асуудлаар хамтран ажиллах сонирхогч талуудыг бүрэлдэхүүнд нь оруулах,
- Дотооддоо болон гадаадад ажиллахаар ажил хайж буй иргэддээ зориулсан мэргэжлийн ур чадварын стандартыг шинээр байгуулагдах энэхүү зөвлөлөөс эрхлэн тогтоох нь зүйтэй.

Дөрөв дэх зөвлөмж:

Архидалтыг багасгах талаар

Архидалт, архидан согтуурах явдал өнөөдөр Монгол Улсын хувьд эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар бүхий хамгийн ноцтой бэрхшээлүүдийн нэг болоод байгаа бөгөөд нийт хүн ам, нэн ялангуяа ядуу иргэдийг хөдөлмөрийн зах зээлд оролцоход нь илүү их хүндрэл бэрхшээл учруулж, улмаар хөдөлмөр эрхлэлтээр дамжуулан ядуурлыг бууруулахад чиглэсэн төр, засгийн хүчин чармайлтад сөргөөр нөлөөлж байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр Монгол Улсын согтууруулах ундааны хэрэглээний талаар хийсэн эпидемиологийн судалгаанд хамрагдсан нийт эрэгтэйчүүдийн 33.9 хувь, эмэгтэйчүүдийн 11.5 хувь нь өмнөх жилд гэхэд дор хаяж нэг удаа архи хэтрүүлэн хэрэглэсэн буюу ажил, сургууль, гэртээ согтууруулах ундаа хэрэглэсэнээс үүдэлтэй асуудалд орж байсан гэж хариулжээ. Архидан согтуурахтай тэмцэх арга хэмжээ дор дурдсан алхмуудаас бүрдвэл зохино. Үүнд:

- Архидан согтуурахтай тэмцэх үндэсний хэмжээний кампанит ажил зохион байгуулах, үүний дотор архидан согтууралтын улмаас монголчуудад учирч буй нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврын талаар олон нийтэд сайтар таниулах,
- Согтууруулах ундааны хүртээмжийг багасгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх,
- Ажил олгогчид, үйлдвэрчний эвлэлийн болон төр, засгийн байгууллагуудын оролцоотойгоор архидан согтуурахын хор уршгийн талаар мэдлэг олгох ажлын байран дээрх сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх.

Тав дахь зөвлөмж:

Хөдөлмөрийн зах зээлийн тухай мэдээллийг боловсронгуй болгох талаар

Энэхүү илтгэлийг бэлтгэх явцад учирч байсан хамгийн гол хүндрэлтэй асуудал нь шаардлагатай тоо баримт, мэдээлэл хэт хуучирсан буюу олон жилийн өмнөх тоо мэдээлэл байх юм уу, өөр бусад тохиолдолд мэдээлэл байсан ч тэдгээр үзүүлэлт нь олон улсын стандартад нийцээгүй байх, эсвэл нэн шаардлагатай тоон мэдээлэл огт байхгүй байх жишээтэй. Монгол Улсын Үндэсний статистикийн газар бүс нутагтаа гэхэд мэргэжлийн чадавхи, хамтран ажиллах талаараа хамгийн сайнд тооцогддог бөгөөд илтгэлийг бэлтгэх явцад бидэнтэй байнга нягт хамтран ажиллаж байсан энэ байгуулагынханд энэ завшааныг ашиглан гүн талархал илэрхийлэх нь зүйтэй гэж үзэж байна. Хөдөлмөр эрхлэлт, ядууралтай холбоотой төлөв хандлагыг сайтар хянан судлах, улмаар бодлогыг оновчтой болгох зорилгоор энэ асуудлаарх тоон мэдээллийг боловсронгуй болгох, сайжруулахад чиглэсэн дараах хэдэн зөвлөмжийг санал болгож байна. Үүнд:

- Бодлого боловсруулагч болон бусад сонирхогч талуудыг хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлын талаархи мэдээллээр тогтмол хангаж байх үүднээс ажиллах хүчний тухай судалгааг олон

улсын стандартад нийцүүлэн улирал, жилээр хийж байх;

- Хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээллийг хүйсээр задлан гаргаж, тайлагнадаг болох;
- Тогтмол болон нэг удаагийн судалгаа, тооллогын ажлыг системтэйгээр зохион байгуулах;
- Сургалт зохион байгуулдаг газар, бизнесийн үйл ажиллагаа, малчид, ажил эрхлэлтийн асуудлаар зөвлөгөө өгдөг, мэдээллээр хангадаг, ажил олж өгөх туслалцаа үзүүлдэг байгууллагын талаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн практик амьдралтай холбоотой мэдээлэл цуглуулж, судалж, олны хүртээл болгож байх;

Зургаа дахь зөвлөмж:

Эдийн засгийн төрөлжүүлэн хөгжүүлэх замаар ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх талаар

Монголын экспортын хамгийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох зэс, алт, нүүрсний дэлхийн зах зээлийн үнэ өсч ирсэн сүүлийн жилүүд буюу 2004 оноос эхлэн уул уурхайн салбар тус улсын эдийн засгийн өсөлтийн хамгийн гол хүчин зүйл болж байв. Уул уурхайн салбар капитал зарцуулалт ихтэй байдаг тул энэ салбарын сүүлийн жилүүдэд гарсан өсөлт зөвхөн үнийн өсөлтөөс улбаатай бөгөөд биет бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдсэнтэй холбоотой байгаагүй юм. Тийм ч учраас үүнийг дагаж ажлын шинэ байр харьцангуй цөөн тоогоор нэмэгдэж 2004 оноос хойшхи хугацаанд эдийн засгийн өсөлтийн хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмж буурсан байна. Мөн энэ хугацаанд орлогын тэгш бус байдал өссөнийг ч үүгээр тайлбарлаж болох юм. Өндөр цалин хөлстэй ажил эрхэлж чадсан цөөн тооны хүн л эдийн засгийн өсөлтийн үр шимийг хүртсэн гэсэн үг.

Өөрийн орны бодит нөхцөл байдал болон байгалийн баялаг ихтэй хөгжиж буй улс орнуудын өндөр хурдацтай өсөлтөө тогтворжуулж чадахгүй байгаа туршлагаас санаа аван дүгнэлт хийх хэрэгтэй. Монгол улс эдийн засгаа цаашид ч цэцэглүүлэн хөгжүүлэхийн тулд эдийн засгаа төрөлжүүлж хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд тэргүүлэх ач холбогдол өгвөл зохино.

- Уул уурхайн салбарын орлогыг хүний хөгжил, дэд бүтцийн салбарт илүүтэй хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагааг бүхий л талаар дэмжихэд ашигламаар байна. Мөн эдийн засгаа төрөлжүүлэн хөгжүүлэхэд зориулж дан ганц байгалийн баялгийн экспортоос хэт хараат байдлаа багасгах хэрэгтэй. Түүнчлэн өнөөдөр зохистой, бүтээмжтэй хөдөлмөр эрхлээгүй байгаа олон тооны эрэгтэй, эмэгтэйчүүдэд боломж олгоход уг салбарын орлогоос зориулах явдал чухал байна.
- Үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэхдээ ядуу зүдүү айл өрх амьдарч байгаа газар нутагт тэдгээр хүмүүс хөдөлмөр эрхэлж орлого олох боломж бүрдүүлэх чиглэл баримталбал зохино.
- Уул уурхайн бус салбарын тухайд тэдгээрийн өрсөлдөх чадварыг сайтар хянан зохицуулах, валютын ханшны нөлөөллийг үүнд тооцож үзэх хэрэгтэй.
- Ил тод байдлыг хангах, эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтийг дэмжихийн тулд бизнесийн үйл ажиллагаанд учирдаг элдэв саад тотгорыг багасгах, аудитын үйл ажиллагааг боловсронгуй болгох, мөн хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэгдсэн болон татвар төлөгчдөд ээлтэй татварын бодлого, татвар хураалтын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

Долоо дахь зөвлөмж:

Уул уурхайн салбарыг түшиглэн хөгжих бусад салбарын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэх талаар

Сүүлийн дөрвөн жилд уул уурхайн салбар Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангахад гол үүрэг гүйцэтгэсэн салбар байж ирсэн бөгөөд цаашдаа ч тодорхой хугацаанд энэхүү төлөв байдал үргэлжлэхээр байна. Гэтэл, уул уурхайн нийт бүтээгдэхүүний 99 хувийг үйлдвэрлэж буй хөрөнгө оруулалтын шингээлт ихтэй уул уурхайн албан сектор хангалттай хэмжээний ажлын байр бий болгохгүй, эдийн засгийн өсөлтийг ядуурлыг бууруулахад чиглүүлэхэд уул уурхайн салбарыг ашиглах боломж олгохгүй байгаа. Уул уурхай дахь албан бус салбар хөдөөгийн олон мянган ядуучуудыг орлоготой болгож буй хэдий ч тэр нь эргээд тэнд ажиллагчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, байгаль орчны, нийгмийн болон хүүхдийн хөдөлмөртэй холбогдсон олон тооны хүндрэл бэрхшээлтэй асуудлуудыг бий болгож байна. Иймд төр, засгаас юуны түрүүнд уул уурхайн салбар, боловсруулах үйлдвэр, дэд бүтэц болон бусад холбогдох салбарын үйл ажиллагаа хоорондын уялдаа холбоог сайжруулах, уул уурхай дахь албан бус салбарын үйл ажиллагааг үр ашигтайгаар дэмжих замаар уул уурхайн салбарын өсөлтөөр дамжуулан ажлын байр олноор бий болгох нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ чиглэлийн арга хэмжээ дараах алхмуудаас бүрдэж болох юм. Үүнд:

- Боловсруулах үйлдвэр байгуулж ажиллуулах, эрчим хүчний хэрэгцээгээ дотоодын эх үүсвэрээр хангах зэргээр уул уурхай болон түүнийг дагаж хөгжих том, жижиг бусад салбарын үйл ажиллагаа хоорондын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ авах,
- Уул уурхайн салбар дахь ажлын байрны шаардлагыг хангахуйц ур

чадварыг бий болгоход чиглэсэн сургалт зохион байгуулахыг хөхиүлэн дэмжих,

- Уул уурхай дахь албан бус секторыг албан болгоход чиглэсэн хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зэрэг болно.

Найм дахь зөвлөмж:

Хөдөө, орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, сумдын эдийн засгийг сэргээн бэхжүүлэх талаар

Банк, санхүүгийн үйл ажиллагаа өргөжин хөгжиж, цахилгаан эрчим хүчээр хангагдсан, хувьдаа автомашин, мотоциклтой малчин өрхийн тоо өссөн, амьжиргаагаа аргацаах хэмжээнээс хол давсан, аж ахуйгаа бүтээмжтэйгээр эрхлэх боломжтой хэмжээний малтай өрх олширсон зэрэг хөдөө орон нутагт эдийн засгийн үйл ажиллагаа нэлээд идэвхжиж буйг харуулсан олон тоо баримт бий. Гэсэн хэдий ч хөдөө орон нутаг дахь ядуурлын түвшин 2006 оны байдлаар 37 хувьтай байгаа нь хот суурин газрынхаас хамаагүй өндөр хэмжээнд, мөн цөөн тооны малтай малчдын дунд ядуурал их байсаар байна. Хөдөө орон нутаг дахь ядуурлыг бууруулах хамгийн зүй зохистой арга нь сумдын төвийг үйлдвэрлэл, эдийн засгийн төв болгох замаар ядуу зүдүү амьдарч буй малчин иргэд мал маллахтай нь холбогдсон шаардлагатай тусламж дэмжлэгийг авах, түүнлэн зөвхөн мал аж ахуйн гаралтай бус мөн өөр бусад орлогын эх үүсвэртэй болох бололцоог бүрдүүлнэ. Энэхүү чиглэлд хийх алхмын тоонд дор дурдсан арга хэмжээ багтаж болох юм. Үүнд:

- Төвлөрлийг сааруулах өргөн хүрээтэй, зоримог алхмын хүрээнд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нарт орон нутгийнхаа онцлогт тохирсон орон нутгийн хөгжлийн стратегийг боловсруулан хэрэгжүүлэх, санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн зарцуулах эрх мэдлийг нь өргөжүүлэх,

- Сумын төвд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ үзүүлэх, сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах зэрэг үйл ажиллагааг өргөжүүлэх, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас сумын түвшинд зарцуулах хэмжээг нэлээд бодитой нэмэгдүүлэх, түүнчлэн уг сангийн хөрөнгийг аль болох бүрэн дүүрэн ашиглахад чиглэсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх,
- Орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн сацуу боломжтой гэж үзсэн газар бүрт орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх үүднээс хөдөлмөр шингээлт ихтэй ажлын байр бий болгох стратегийг иргэдийн оролцоотойгоор боловсруулан хэрэгжүүлэх,
- Малчдыг бизнес эрхлэгч хэмээн үзэж дэмжих үүднээс сумын төвд жижиг бизнесийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хөдөө аж ахуйн явуулын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр туршилтын арга хэмжээг зохион байгуулах,
- Хөдөө, орон нутаг дахь хөдөлмөр эрхлэлт, олон нийтийг хамарсан ажил үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор төр-хувийн хэвшлийнхний энэ чиглэлийн хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих,

Ес дэх зөвлөмж:

Албан бус салбарыг албан болгох талаар

Эдийн засгийн албан бус сектор нь цомхотголд өртсөн, улирлын чанартай ажил эрхлэгчид, ажлын гараагаа шинээр эхлэгчид, дотооддоо шилжин суурьшигчид болон олон арван бусад хөдөлмөр эрхлэгчдэд боломж бололцоо олгож байснаараа шилжилтийн үеийн хүндрэл бэрхшээлийг даван туулахад маш чухал үүрэг гүйцэтгэсэн. Өндөр мэргэжлийн эмэгтэй, эрэгтэйчүүд өөрсдийн эзэмшсэн мэргэжил мэдлэгт тохирох ажил хөдөлмөр эрхлэх бололцоогүй байснаас ур чадвар сул хүмүүс эдийн засгийн албан секторт

ажил эрхлэхэд шаардлагатай ур чадвар-гүйн улмаас, жижиг бизнес эрхлэгчид болон шилжин суурьшигчид гэх мэтийн олон янзын бүлэг хүмүүс албан бус салбарт хүчээ сорин хөдөлмөр эрхэлж байна. Төр засгаас энэхүү салбарын талаар дараах хэдэн арга хэмжээ авахыг санал болгож байна. Үүнд:

- Эдийн засгийн албан бус салбарын үйл ажиллагааг нэгдсэн бодлого, гурван талт хамтын ажиллагаагаар дамжуулан зохицуулах төрийн өнөөгийн бодлого, арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх,
